In partnership with Canada

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

IDLO
Creating a Culture of Justice
International Development Law Organization

Мониторингийн тайлан: Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааны ажиглалт 2020

Зохиогчийн эрх © 2021 оны 8-р сар. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO).
Зохиогчийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан.

Энэхүү тайланд илэрхийлэгдсэн үзэл бодлыг зохиогчид бие даан боловсруулсан бөгөөд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, түүний гишүүд, Канад Улсын Засгийн газрын үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй болно. Энэхүү бүтээл нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан бөгөөд сургалтын зорилгоор ашиглах бол үнэ төлбөргүйгээр эх сурвалжийг дурдсаны үндсэн дээр дахин олшруулах боломжтой. Энэ тохиолдолд албан ёсны зөвшөөрөл авна. Үүнээс өөр зорилгоор олшруулах эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх бол зохиогчийн эрх эзэмшигчид мэдэгдэж, тодорхой төлбөр төлж, бичгээр зөвшөөрөл авна. Худалдан борлуулах зорилгоор хэвлэх хүсэлтийг Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагад гаргана.

Энэхүү тайлангийн Монгол хэл дээр хувилбар байгаа хэдий ч Англи хэл дээрх хувилбар нь албан ёсны бичиг баримтад тооцогдоно.

Товч танилцуулга

Монгол Улс дахь Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ) нь Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй "*Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх"* төслийн хүрээнд Монгол Улсын шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтыг 2020 онд хийж гүйцэтгэлээ.

Энэ тайланд уг ажиглалтын үйл ажиллагааны загвар, хэрэгжилт, судалгааны хүрээнд гарсан үр дүн болон зөвлөмжийг нарийвчлан тусгасан болно.

I. Загвар ба Хэрэгжилт

1-р хэсэгт шүүх хуралдааны ажиглалтын талаар ерөнхий мэдээллийг тусгасан бол **2-р хэсэгт** төслийн хүрээнд энэхүү ажиглалтын үйл ажиллагааны гүйцэтгэж буй үүргийн талаар дэлгэрэнгүй тусгав. Шүүх хуралдааны ажиглалтын зорилтыг **3-р хэсэгт,** мөн үндсэн үзэл баримтлал, судалгааны цар хүрээ, ажиглалт болон үнэлгээний зарчмыг **4-р хэсэгт** товч тусгасан бол **5-р хэсэгт** шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагааны хөтөлбөрийн төрөл, газар зүйн болон судлагдахуун болсон асуудлуудын цар хүрээг тусгав.

Уг ажиглалтын хүрээнд 2020 оны 2 дугаар сараас 5 дугаар сарын хооронд Хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээ, Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны карт (Justice Sector Service Delivery Scorecard), Шүүх хуралдааны ажиглагчийн гарын авлага болон Google маягтаас бүрдсэн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг нарийвчлан боловсруулсан болно.

Эдгээр хэрэглэгдэхүүн болон баримтлах арга зүйг **6-р хэсэгт** тайлбарлав. **7-р хэсэгт** төслийн хоёр зөвлөх эдгээр бүрэлдэхүүн хэсгүүдийн загвар (дизайн)-ыг боловсруулж, нөөц бололцоог хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлсэн талаар тусгасан. Иргэний нийгмийн төлөөлөгчид, өмгөөлөгчид болон хууль зүйн сургуулийн төгсөгч зэрэг 34 хүнээс бүрдсэн шүүх хуралдааны ажиглалтын улсын хэмжээний баг энд бүрдсэн.

Хэрэглэгдэхүүн болон аргачлалыг эцэслэн боловсруулсны дараа 2020 оны 6 дугаар сараас эхлэн 7 дугаар сар хүртэл 10 хэргийн шүүх хуралдаанд туршилтын ажиглалт явуулсны үндсэн дээр судалгааны хэрэглэгдэхүүн болон аргачлалаа сайжруулсан.

Туршилтын үе шат, түүнээс гарсан үр дүнг **8-р хэсэгт** товч танилцуулсан болно. Үүний дараагаар судалгааны хэрэглэгдэхүүн болон аргачлалыг эцэслэн боловсруулж, улмаар ажиглалтын үйл ажиллагааг албан ёсоор эхлүүлж, шүүх хуралдааны ажиглагчдыг сургасан тухай мэдээллийг **Хавсралт Ё**-оос үзнэ үү.

Улмаар туршилтын ажиглалтыг явуулж, хэрэглэгдэхүүнийг сайтар нягталсны үндсэн дээр эцэслэн баталсан загварын дагуу 2020 оны 8 дугаар сарын сүүлээс 11 дүгээр сарын хооронд шүүх хуралдааны ажиглалтыг хийж гүйцэтгэсэн тухай **9-р хэсэгт** танилцуулав.

II. Дүгнэлт

Туршилтын болон албан ёсны ажиглалтын хүрээнд нийт 57 (зөрчлийн 39, эрүүгийн 18) хэрэгт ажиглалт хийв. Шүүх хуралдааны ажиглалтыг Улаанбаатар хотын есөн дүүрэг, мөн таван аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр хийсэн болно.

Өгөгдлийн хязгаарлалт

Туршилтын үе шатны туршид боловсруулж, засан сайжруулсан аргачлалын дагуу судалгааны үнэн зөв, найдвартай, цаг хугацаатай уялдсан, оновчтой, баталгаатай өгөгдөл цугларсан боловч зарим нэг өгөгдлийн хязгаарлалт байгаа болохыг үндсэн үр дүнгээ танилцуулахаас өмнө дурдах нь зүйтэй.

10-р хэсэгт эдгээр хязгаарлалтууд нь түүвэрлэлтийн арга техник, энэхүү туршилтын мониторингийн хөтөлбөрийн хамтын ажиллагааны загвар, ажиглагчдын субьектив үнэлгээ, үйл ажиллагааны явцад Covid-19 цар тахлын улмаас үүссэн сорилт, хэргийн хүртээмжтэй холбоотой асуудлуудыг тусгасан.

Судлагдсан хэргүүдийн тухай

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний тусламжтайгаар ажиглалт хийсэн гэр бүлийн хүчирхийллийн 57 хэрэгтэй холбоотой цуглуулсан өгөгдөлд хийсэн дүн шинжилгээг **12-15 дугаар хэсэгт** тусгав. Ажиглалт хийх хэргийг сонгохдоо Улаанбаатар хот болон орон нутгаас хэрхэн жигд төлөөллийг хангасан тухай энэ хэсэгт дэлгэрэнгүй тусгасан болно. Ажиглалт явуулсан нийт хэргийн гуравны хоёр нь зөрчлийн хэрэг байсан бол үлдсэн хэсэг нь эрүүгийн хэрэг байв. Түүнчлэн ажиглалтыг анхан шатны шүүхийн шүүх хуралдаанаар хэлэлцсэн хэргийн хүрээнд хийсэн болно. Эдгээр хэргүүдийн хувьд дийлэнх тохиолдолд дан ганц хэрэгт холбогдуулан ялласан байсан бөгөөд ихэнхдээ бие махбодын ГБХ, үүний дотор нэн ялангуяа гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон зөрчлийн хэрэг, эсхүл бусдын бие махбодод санаатайгаар хөнгөн гэмтэл учруулах гэмт хэргүүд байв. Эдгээр хэргийн улмаас гурван хохирогч амь насаа алдсан байв. Ихэнх хэргийг нэг удаагийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн байна. Түүнчлэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогч бараг оролцдоггүй, зөрчлийн хэрэгт холбогдогч (цаашид “холбогдогч” гэх), шүүгдэгч болон хохирогч (ялангуяа) тал өмгөөлөгч, төлөөлөгчгүй байв.

Хохирогчдын ихэнх хувийг эмэгтэйчүүд эзэлж байсан бол шүүгдэгч, холбогдогчдын дийлэнх нь эрэгтэйчүүд байх бөгөөд ГБХ нь ихэнх тохиолдолд хамтран амьдардаг хүмүүсийн хүрээнд гэр хорооллын орчинд, гэр бүлийн харилцаатай хүмүүсийн хооронд голчлон үйлдэгдсэн байна. Хүчирхийлэл үйлдэгч болон хохирогч нь гол төлөв бүрэн дунд боловсролтой байсан боловч эрүүгийн хэргийн шүүгдэгчийн хувьд бүрэн бус дунд боловсролтой байх хандлагатай байв. Хөдөлмөрийн чадвартай шүүгдэгч, холбогдогчийн гуравны хоёр, хохирогчдын тал хувь нь ажил хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд ихэнх хэсэг, тэр дундаа шүүгдэгчдийн дийлэнх хэсэг нь эрүүгийн эсхүл зөрчлийн хэрэгт өмнө нь холбогдож байгаагүй байна.

Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үзүүлэлт – Үнэлгээний Онооны карт (Justice Sector Service Delivery Scorecard)

12-р хэсэгт ажиглалт явуулсан хэргүүдийн хүрээнд шүүхийн шударга ёсны үйлчилгээний үзүүлэлтийн талаар тоймлон танилцуулна. Ажиглалт хийсэн нийт хэргийн хохирогч, шүүгдэгч (холбогдогч)-ийн нийтлэг эрх болон эрх тус бүрийн хэрэгжилтийг онооны картаар үнэлэхэд медиан "Маш сайн" **(интервалын дундаж оноог)** авсан болохыг энэ хэсэгт тайлбарлав.

Ерөнхий дүн сайн гарснаас үл хамааран анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудлууд байв. Зөвхөн онооны картын үр дүнг авч үзэх нь нөхцөл байдлыг бүрэн илэрхийлэхгүй байх талтай ба энэ нь дараах гурван зүйлээс шалтгаалж байна. **Нэгдүгээрт,** судалгаанд тодорхой нэг эрхийг үнэлж буй бүрэлдэхүүн хэсгүүдийн ач холбогдлыг ижил түвшинд авч үзсэн байгаа бол бодит байдалд тэдгээрийн ач холбогдлын түвшин харилцан адилгүй байдаг. **Хоёрдугаарт,** Онооны карт нь үнэлгээний санал болгож буй тоон шкал (интервал)-д тулгуурлаж үнэлэгддэг. Судалгаанд авч үзсэн дийлэнх хэргүүд нь үнэлгээний шкалын хамгийн бага оноог авсан. **Гуравдугаарт**, өгөгдлийн тархалтын тэгш бус хэлбийлттэй холбоотойгоор уг тайланд **медиан** утгыг оруулж өгсөн. Гэвч өндөр оноотой кластер их байсан тул бага оноотой боловч ач холбогдол бүхий хэсэг бүлгийг далдалж байв.

Иймд онооны картын үр дүнг тухайн өгөгдлийг тодорхойлж, тайлбарласан нарийвчилсан дүн шинжилгээний хамтаар авч үзэх нь чухал юм. **(13-15 хэсэг)**

Хохирогчийн эрх

Хохирогчийн эдлэх эрхүүд дотроос хохирогчийн аюулгүй байдал нь хамгийн доогуур үнэлгээтэй байсан ч медиан "Маш сайн" үнэлгээ авчээ. **13.1-р хэсэгт** дэлгэрэнгүй үзүүлсэнчлэн, цагдаагийн алба хаагчийн Аюулын зэргийн үнэлгээг үндсэндээ бүх хэргүүд дээр хийж гүйцэтгэсэн бол нийгмийн ажилтнуудын нөхцөл байдлын үнэлгээг нийт хэргийн гуравны нэг хувьд л хийсэн байсан. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хааяа авч байсан ба энэ нь ихэнхдээ хохирогчийн хүсэлтээр хийгдсэн байна. Харин шүүхийн өмнөх шатанд сэтгэл зүйн туслалцааг тун ховор үзүүлсэн байна. Өөр нэгэн чухал дүгнэлт бол хохирогчид шүүх хуралдаанд оролцохгүй байхдаа тэд хамгийн аюулгүй байсан гэж үнэлэгдсэн бол онооны картын үнэлгээ нь "Сайн" руу буурчээ. Шүүх дээр оролцогчдыг тусдаа хаалгаар оруулах, аюулгүй байдлын шалгалт явуулах, аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын ажилтан дагалдуулсан нь тун ховор байсан боловч аюулгүй байдлыг сахин хангуулах цагдаагийн албан хаагчдын тоо ерөнхийдөө хангалттай байв. Бараг бүх хохирогч шүүгдэгч, холбогдогчдын хамт нэг хүлээлгийн танхимд байсан. Гэхдээ ихэнх хохирогчид аюулгүй байдлыг хангах, тусламж үзүүлэх арга хэмжээнүүдийн талаар сайн мэдэж байсан ба шүүх хуралдааны танхимд шүүгдэгч болон холбогдогч нараас тусдаа, зайтай сууж байв. Гэвч хохирогчдын дөрөвний нэгт хохирогчийг буруутгах, жендерийн хэвшмэл үзэлд тулгуурласан хандлагаар харилцах зэргээр хохирогч сэтгэл санааны дарамтад дахин өртөх байдал ажиглагдсан бөгөөд зарим шүүгчдийн зүгээс ч ийм байдлаар хандах тохиолдол гарсан. Ихэнх тохиолдолд шүүгдэгч, хохирогч нар шүүх хуралдааны танхимаас ээлжлэх бус, нэгэн зэрэг гарч байсан бөгөөд хохирогчийг аюулгүй байдал хариуцсан албан хаагч дагалдан хамгаалсан тохиолдол гарсангүй.

Зөрчлийн болон нөхөн төлбөрийн арга механизмуудын талаар мэдээлэл авах хохирогчийн эрхтэй холбоотой үр дүнг **13.2-р хэсэгт** оруулав. Медиан "Маш сайн" үнэлгээ авсан боловч нийт хэргийн гуравны нэгээс илүү хэсэг нь "Сайн"-аас "Муу"-ийн хооронд оноо авсан байна. Үүнийг тайлбарлахад ихэнх хохирогч өөрийн эдлэх эрх, хүлээх үүргийн тухай мэдээлэл болон тайлбарыг авсан гэж байгаа боловч тодорхой тооны хохирогчийн хувьд эрх, үүргийг нь мэдээлсэн, гэхдээ тайлбарлаж өгөөгүйтэй холбоотой байж болзошгүй. Нийтлэг байдлаар авч үзвэл хохирогчдод хууль зүйн туслалцаа авах эрхийнх нь талаар маш сайн мэдээлэл өгсөн бол

шүүхээс гарах цагаатгах болон шийтгэх тогтоолын хувийг гардан авах эрхийн талаар мэдээллийг муу өгчээ.

Хохирогчоор тооцогдсон этгээдүүд нь хууль, шүүхийн байгууллагад хандах үр нөлөөтэй, тэгш боломжоор хангуулах эрхээр маш сайн хангагдсан гэж дүгнэсэн бөгөөд хохирогчийн эдлэх эрх дотроос хамгийн өндөр хэмжээнд хангагдаж, бүх хэргүүдэд медиан "Маш сайн" үнэлгээ авсан. **13.3-р хэсэгт** авч үзсэнээр хохирогчдод шүүхийн хэлэлцүүлэг, хуралдааны товыг ерөнхийдөө мэдэгдсэн; гомдол, хүсэлт гаргах хангалттай боломжийг олгосон; мэдүүлэг/тайлбар гаргахдаа элдэв дарамт шахалтаас ангид байх нөхцөлөөр хангуулсан болох нь ажиглагдсан. Ихэнх шүүхийн шийдвэрийн хувьд хохирогчийн тайлбар/нотлох баримтыг хангалттай хэмжээнд судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гарсан байх (цөөн тооны хохирогчид тайлбар/нотлох баримт гаргасан) ба хохирогчид ямар нэг гэм хор, аюул учруулахуйц хандлагыг тусгаагүй байна. Гэвч шүүх хуралдаан дээр зарим хохирогч өөрийг нь буруутгах, эсхүл жендерийн хэвшмэл үзлээ тулгах зэрэг зохисгүй хандлагад өртсөн байна.

ГБХ-ийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нэхэмжлэлийг тун цөөн хохирогч гаргасан боловч хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй арга замаар, шуурхай нөхөн төлүүлэх эрхийг медиан "Маш сайн" үнэлгээ гарсныг **13.4 дүгээр хэсэгт** дэлгэрэнгүй танилцуулав. Хохирол нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл гаргаагүй нийт хэргийн дөрөвний нэгт хохирогч нь уг хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байсан ч ямар нөхөн төлбөр гаргуулж болох талаар мэдээлэлгүйн улмаас ийм хүсэлт гаргаагүй болох нь ажиглагдсан байна. Хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргасан хохирогч гол төлөв бие махбодод учруулсан гэмтэл, эдийн засгийн хувьд учирсан хохирол зэргийг нэхэмжилсэн байх бөгөөд ихэнх тохиолдолд хохирлыг бүрэн хэмжээгээр эсхүл бодит хохирлоос давсан хэмжээгээр олгохоор шийдвэрлэжээ. Харин эдгээрийн дотроос 30 орчим хувьд нь шүүгдэгч (холбогдогч)-ийг гэм буруутайд тооцсон боловч хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргаагүй байна.

Шүүх хуралдаанд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрх

Хуульд заасны дагуу байгуулагдаж, хараат бус, тал үл харах шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн талаар **14.1 дүгээр хэсэг**т авч үзсэн бөгөөд медиан "Маш сайн" үнэлгээг авч, шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилтээрээ гуравт эрэмбэлэгдсэн байна. Бараг бүх шүүгдэгч (холбогдогч) нарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхийг нь танилцуулсан бол цөөн хэдэн шүүгчийн зүгээс тэдэнтэй дарамт учруулах байдлаар харилцжээ. Шүүх хуралдааны явцад албан тушаалтан танхимыг орхин гарсан (хүндэтгэн үзэх шалтгаантайгаар) нэг тохиолдол тэмдэглэгдсэн. Харин зарим шүүх хуралдаан дээр гар утсыг голдуу шүүгч, улсын яллагч ашиглах байдал ажиглагдаж байв. Эцэст нь, зарим хэргүүдэд ял оногдуулахдаа ялын хэр хэмжээтэй харьцуулбал хэргийг хэлэлцсэн хугацаа харьцангуй богино байсан гэж ажиглагчид дүгнэсэн байна.

Нөгөөтэйгүүр, **14.2 дугаар хэсэгт** авч үзсэн нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт нь шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрхүүд дотроос хамгийн тааруу нь байсан хэдий ч медиан "Маш сайн" үнэлгээ авсан. Уг эрхийн хэрэгжилт тааруу байгаа нь шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдааны товыг нийтэд ил тод, нээлттэй байлгаагүйгээс шалтгаалсан бөгөөд ажиглалт хийсэн есөн шүүхэд ийм асуудал гарчээ. Гэхдээ ихэнх шүүх хуралдааны хувьд нээлттэй явагдсан. Ихэнх хэргүүд олон нийтэд нээлттэй байсан хэдий ч шүүх рүү нэвтэрч буй ихэнх хүмүүс аюулгүй байдлын аль нэгэн шалгалтад хамрагдаж байсан бөгөөд

ажиглагчид бол шүүхийн ажилтнуудаас зөвшөөрөл авсны үндсэн дээр ажиглалтыг хийж байлаа. Ихэнх шүүх хуралдаан боломжийн зай талбайтай шүүх хуралдааны танхимд явагдсан.

Шүүгдэгч (холбогдогч)-ийн гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэмт буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх эрхийн хувьд медиан "Маш сайн" үнэлгээ авсан ч хамгийн тааруу хэрэгжилттэй эрхийн нэг байсан. (**14.3-р хэсэг**). Тодруулбал, зарим цөөн тооны шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд гав, гинжтэй байлгасан нь тэднийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай мэт сэтгэгдэл төрүүлж байв. Шүүгдэгч (холбогдогч)-ид уг эрх болон бусад эдлэх эрхийнх нь талаар танилцуулж байсан боловч тайлбарыг нарийвчлан хийгээгүй байна. Гэхдээ ихэнх шүүгдэгч (холбогдогч) тэдэнд олгогдсон эрхүүдээс хамгийн багадаа нэг эрхийг эдэлсэн байв. Улсын яллагч эсхүл шүүгч шүүгдэгчийг дуугүй байх эрхээ эдэлснийх нь төлөө сөрөг дүгнэлт гаргасан тохиолдол байхгүй байсан боловч шүүхийн тогтоол гаргахаас өмнө шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон тайлбар мэдэгдлийг шүүгчийн зүгээс хийсэн хоёр тохиолдол гарчээ.

14.4 дүгээр хэсэгт авч үзсэн нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд үнэлүүлэх шүүгдэгчийн эрх нь медиан "Маш сайн" үнэлгээ авсан бөгөөд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх долоон эрхийн хувьд хэрэгжилтээрээ дундаж нь байв. Шүүх хуралдаанд ихэнхдээ хавтаст хэрэгт авагдсан баримт материалын агуулга, түүнчлэн шүүхийн өмнөх шатанд шүүгдэгч (холбогдогч)-ийн өгсөн мэдүүлгийг хэлэлцсэн бөгөөд нийт долоон шүүгдэгч (холбогдогч)-ийн өмнө нь өгснөөс зөрүүтэй мэдүүлгийг шүүх хуралдаан дээр өгсөн байв. Нотлох баримт гаргаж өгөхтэй холбоотойгоор шүүгдэгч (холбогдогч)-ид тэгш бусаар хандсан тохиолдол гараагүй ба ихэнх тохиолдолд өөрийгөө өмгөөлөх боломжийг шударгаар, нээлттэй олгож байв. Түүнчлэн ихэнх тохиолдолд мэдүүлэг өгч буй хохирогч/гэрчүүдэд эдлэх эрхийнх нь талаар мэдээлэл өгч, тайлбарлаж байсан бөгөөд эдгээр оролцогчид өөрийн эрхийг зохих ёсоор эдэлсэн. Шинжээчийн дүгнэлт хийх чиг үүрэг авсан нэг шинжээчид түүний эрх үүргийн талаар сайтар тайлбарласан байсан ба тэрбээр мэргэшсэн чиглэлийнхээ дагуу шүүх хуралдаанд мэдүүлгээ өгсөн байна.

14.5 дугаар хэсэгт авч үзсэн талуудын тэгш байдлыг хангах хүрээнд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрх нь медиан "Маш сайн" үнэлгээ авч шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрхүүдийн дунд хамгийн сайн хэрэгжилттэйд тооцогдов. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад процессын зөрчил, талуудын тэгш байдлыг хөндсөн тохиолдол бараг гараагүй бөгөөд эрүүгийн хоёр хэрэг (өөр өөр шүүхийн)-ийн шүүх хуралдаанд яллах тал нь шүүгчтэй илүү ойр сууж байсан байна. Шүүгдэгч (холбогдогч) эцсийн үгээ хэлэх эрхийг нь олгоогүй тохиолдол бараг гараагүй.

Шүүх хуралдаанд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрхүүдээс хамгийн өндөр оноо авсан эрх нь өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгч авах эрх бөгөөд энэ тухай **14.6 дугаар хэсэг**т авч үзсэн. Ерөнхийдөө ажиглагчид өөрөө өөрийгөө өмгөөлөх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхтэй холбоотойгоор цөөн хэдэн асуудлыг олж тогтоосон байсан ба эдгээр нь зөвхөн гурван хэрэгт тохиолдсон зөрчлүүд байв.
Аюулгүй байдлын үүднээс гурван шүүгдэгч (холбогдогч)-ийг шүүх хуралдааны танхимаас албадан гаргасан. Тэдгээрийн зөвхөн нэг нь биечлэн оролцоогүй ч гэсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухай бүрт оролцох боломжтой байлаа. Нийт шүүгдэгч (холбогдогч)-ийн ойролцоогоор дөрөвний гурав нь өмгөөлөгчгүй байсан. Өмгөөлөгчтэй оролцсон хуралдааны хувьд өмгөөлөгчид ихэнхдээ шүүгдэгч (холбогдогч)-той ойр суусан бөгөөд үйлчлүүлэгчидтэйгээ харилцахад бэрхшээлтэй байсан тохиолдол цөөн тооны байв. Өмгөөлөгч нь шүүгдэгч (холбогдогч)-ид асуудлыг хангалттай сайн хэмжээнд тайлбарлаж байгаа гэж үзэв.

Эцэст нь өөрт холбогдсон хэргээ үндэслэл бүхий шийдвэрээр шийдвэрлүүлэх, шүүхийн шийдвэр нь олон нийтэд нээлттэй байх эрхийн хувьд хэдийгээр медиан “Маш сайн” үнэлгээ авсан боловч шүүгдэгч (холбогдогч) эдлэх (**14.7-р хэсэг**) эрхийн хэрэгжилтээрээ доороосоо хоёрт эрэмбэлэгдэв. Бараг бүх хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл үйлдэгдэж, заримд нь аудио-видео бичлэг хийгдсэн бол цөөн хэдэн шүүхүүд тухайн бичлэгтэй танилцах эрхийг нь талуудад тайлбарласан байна. Шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн ихэнх нь шүүхийн тогтоолд өөрийн саналаа өгөх боломжтой байлаа. Цагаатгагдсан нэг шүүгдэгч (холбогдогч)-ид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс гаргасан хууль бус үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаар танилцуулаагүй. Хэргүүдийн зөвхөн гуравны нэгт нь шүүхээс гарсан тогтоолыг уншиж танилцуулсан байна. Шүүхээс гарч байгаа бичмэл тогтоол, шийдвэрийн хувьд харьцангуй асуудлыг бүрэн гүйцэд, эцсийн байдлаар тусгасан байдаг. Ажиглагчид ч шүүхийн тогтоол, шийдвэр хангалттай хэмжээнд тодорхой, ойлгомжтой, эргэлзээ төрүүлэхээргүй байсан гэж үнэлэв. Гэвч шүүхээс гаргасан шийдвэр, тогтоолуудыг нээлттэй байршуулах, танилцуулах нь ховор байсан бөгөөд хэргүүдийн бараг тал хувьд шийтгэх тогтоол, түүний товч агуулга зэргийг ил болгоогүй байна. Шүүхийн шийдвэрийн талаарх нэмэлт (оноогоор үнэлэгдээгүй) асуудлыг мөн энэ хэсэгт авч үзнэ.

Шүүхийн өмнөх шат болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Шүүхийн өмнөх шатанд эдлэх халдашгүй чөлөөтэй байх эрх, хараат бус байх, тал үл харах байдал, цагдан хорих арга хэмжээний хууль ёсны байдлын талаар гомдол гаргах шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн (**15.1-р хэсэг**) хувьд дундаж хэрэгжилттэй байсан бөгөөд медиан “Маш сайн” авсан. Ихэнх шүүгдэгч (холбогдогч) хуульд заасан үндэслэл, журмын дагуу баривчлагдсан байх ба эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татахтай холбоотой тогтоол шийдвэрийн талаар зохих ёсоор тэдэнд мэдэгдсэн байна. Шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авсан хэргүүдэд яллагдагч (холбогдогч)-ын талаас ялимгүй илүү хувь нь тухайн арга хэмжээг шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой байсан байна.

Ажиглалтын дүнд хэрэгжилтээрээ хамгийн өндөрт эрэмбэлэгдсэн шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх нь мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах эрх байсан бөгөөд уг эрхтэй холбоотой асуудлыг **15.2 дахь хэсэгт** авч үзнэ. Шүүхийн өмнөх шатанд баривчлагдсан ихэнх яллагдагч (холбогдогч)-ид эдлэх эрхийнх нь талаар нэн даруй бичгээр мэдэгдэж, тайлбарлажээ. Мөн тэдгээрийг баривчлагдсан тухай гэр бүлийн гишүүдэд нь цаг алдалгүй мэдэгджээ. Нэг яллагдагч (холбогдогч)-ид өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу эрүүл мэндийн туслалцаа үзүүлжээ.

15.3 дахь хэсэгт хийсэн дүн шинжилгээний хувьд шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч авах, өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэх хангалттай хугацаа, боломжоор хангуулах шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хувьд хэрэгжилтийн байдлаар сүүлээсээ хоёрт жагссан боловч ажиглалтад хамрагдсан хэргүүдийн хувьд медиан “Маш сайн” үнэлгээ авсан юм. Ихэнх яллагдагч (холбогдогч)-дыг баривчилсан даруйд нь өмгөөлөгч авах, өмгөөлүүлэх эрхийн талаар танилцуулж, шүүхийн өмнөх шатанд хавтаст хэрэгтэй танилцах хангалттай боломжоор хангасан. Нийт хэргийн дөрөвний нэгт нь энэхүү эрхээр хангасан талаар баримтжуулаагүй эсхүл тайлбарлаагүй байсан. Мөн зарим яллагдагч (холбогдогч) шүүхийн өмнөх шатанд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд хугацааны хувьд хүрэлцээтэй ба бололцоотой байж чадаагүй гэж ажиглагдав. Ихэнх яллагдагч (холбогдогч) өмгөөлөгч авах

эрхээсээ татгалзсан бөгөөд шүүх хуралдаанд заавал өмгөөлөгчтэй оролцохоор заасан шүүгдэгч (холбогдогч) байгаагүй байна. Харин өмгөөлөгчтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон нэг яллагдагч (холбогдогч)-ийн хувьд өмгөөлөгч авах хүсэлтээ гаргасан боловч өмгөөлөгчийг нь ирэхээс өмнө холбогдсон гэмт хэргийнх нь талаар тайлбар, мэдүүлэг авахаар ярилцаж эхэлсэн байв.

Шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах явцад эдлэх эрхийн талаар **15.4 дүгээр хэсэг**т авч үзсэн. Медиан "Маш сайн" үнэлгээ авсан ч шүүхийн өмнөх шатанд эдлэх эрхүүдээс хамгийн муу оноотой байсан бөгөөд зөрчлийн хэргүүд дээр эрүүгийн хэргээс муу үзүүлэлтэй байв.

Яллагдагч (холбогдогч)-ын дийлэнх хувь нь мэдүүлэг өгөхөөс өмнө өөрийн эрхийн талаар тайлбарлуулсан байсан ч өмгөөлөгчөө байлцуулах шаардлагатай байсан хоёр яллагдагч (холбогдогч)-аас өмгөөлөгч байлцуулалгүйгээр мэдүүлэг авсан. Хоёр яллагдагч (холбогдогч)-ид мэдүүлгийнх нь тэмдэглэлийн хувийг гардуулаагүй эсхүл уншиж танилцуулаагүй. Нийт хэргийн дөрөвний нэгт нь яллагдагч (холбогдогч) мэдүүлгийнхээ тэмдэглэлд засвар, эсхүл өөрчлөлт хийх боломжтой байсан эсэхийг тогтоох боломжгүй байлаа.

Энэ хэсгийн хүрээнд ажиглан судалсан эрхүүд дотроос сайн хэрэгжилттэй нь хүнлэг ёсоор харьцах, эрүүдэн шүүлтээс ангид байх эрх байв. **(15.5 дугаар хэсэг).** 52 хэрэгт хамгийн өндөр оноотой буюу медиан "Маш сайн" үнэлгээ авсан бөгөөд шүүгдэгч (холбогдогч)-той хүнлэг бус харьцсан эсхүл эрүү шүүлт тулгасан ямар нэгэн зүйл ажиглагдаагүй.

III. Зөвлөмж ба чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүн

Шүүх хуралдааны ажиглалтын үр дүнд үндэслэн Монгол улс дахь ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэх үр нөлөөг сайжруулахад өгөгдөлд суурилсан нарийвчлан зөвлөмжүүдийг шүүх эрх мэдлийн байгууллагуудад зориулан тусгалаа. **16.1-р хэсэгт** хохирогчийн эрх, харин **16.2 ба 16.3-р хэсэгт** шүүх хуралдаанд болон шүүх хуралдааны өмнөх, түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрхийн талаар тус тус авч үзсэн болно. Эдгээр зөвлөмжүүд нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлэх үеэр Монгол Улсын Засгийн газар хүлээн авч, биелүүлэх үүрэг амлалтаа өгсөн зөвлөмжүүдтэй нийцэж байна. Зөвлөмжийг энэхүү тайлангийн **Хавсралт А-**д оролцогч тал тус бүрд танилцуулсан болно.

Эцэст нь, шүүх хуралдааны ажиглалтын үр дүнд ажиглагчдын чадавхыг хэрхэн бэхжүүлсэн тухай үр дүнг тоймлон танилцуулснаар уг тайлан төгсөнө.

Бүх ажиглагчид шүүх хуралдааны ажиглалтад оролцох замаар чадавхаа дээшлүүлж, тодорхой мэдлэгийн хүрээ нь өргөжсөн талаар тэмдэглэж (**Хэсэг 17.1**), мэргэжлийн ур чадварыг гүнзгийрүүлсэн тухай тусгасан болно (**Хэсэг 17.2**). Шүүх хуралдааны ажиглагчдын зөвлөмжийг **Хавсралт Б-ээс** харна уу.

Гарчиг

Товч танилцуулга iii
Зураг, дүрс, хүснэгт, товчлол xii
ОУЭЗХБ-ын тухай xvi
ТАЛАРХАЛ xvi
БҮЛЭГ I. ЗАГВАР БА ХЭРЭГЖИЛТ 1
1. ТАНИЛЦУУЛГА 2
2. ТӨСӨЛД ГҮЙЦЭТГЭСЭН ҮҮРЭГ ОРОЛЦОО 3
3. ЗОРИЛТУУД 4
4. ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЦАР ХҮРЭЭ 6
4.1. Үндсэн зарчмууд 6
4.2. Ажиглалтын зарчмууд 6
4.3. Үнэлгээний зарчмууд 7
5. ХАМРАХ ХҮРЭЭ 9
5.1. Хөтөлбөрийн төрөл 9
5.2. Газар зүйн хамрах хүрээ 9
5.3. Сэдвийн хамрах хүрээ 10
6. АЖИГЛАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ 12
6.1. Ажиглалтын үйл явц 12
6.2. Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн 13
6.3. Хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээ 16
6.4. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны карт 17
6.5. Шүүхийн ажиглагчийн гарын авлага 20
6.6. Google маягт 20
7. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БАГ 21
8. ТУРШИЛТЫН ШАТ 24
8.1. Үндэслэл 24
8.2. Хамрах хүрээ 25
8.3. Сургалт 26
8.4. Туршилтын аргачлал 27
8.5. Үр дүн 28
9. АЖИГЛАЛТЫН БОЛОН ХЯНАЛТЫН ҮЙЛ ЯВЦ 30
9.1. Шүүх хуралдааны ажиглалтын үйл явц 30
9.2. Хяналтын ажиллагаа 32
БҮЛЭГ II. ДҮГНЭЛТ 35
10. ӨГӨГДЛИЙН ХЯЗГААРЛАЛТ 36
10.1. Сонгох үйл явц 36
10.2. Хамтын ажиллагааны загвар 36
10.3. Субъектив үнэлгээ 37
10.4. Ковид-19 37
10.5. Хэргийн хүртээмж 37
11. ХЭРГҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА 37
11.1. Шүүхийн харьяалал 38
11.2. Хэрэг, зөрчлүүд 39
11.3. ГБХ үйлдсэн шалтгаан 43

11.4. Шүүх хуралдааны үйл явцын талаар 44
11.5. Шүүх хуралдааны оролцогчдын талаар 45
11.6. Өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгч 46
11.7. Хохирогч, яллагдагчдын хүн ам зүйн үзүүлэлтүүд 47
12. ШҮҮХИЙН ШУДАРГА ЁСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ 53
13. ХОХИРОГЧИЙН ЭРХ 56
13.1. Хохирогчдын аюулгүй байдлын үнэлгээ 57
13.2. Хохирогчдын зөрчил болон эрх сэргээх механизмтай холбоотой шаардлагатай мэдээлэл авах хохирогчийн эрх 65
13.3. Эрх тэгш, үр нөлөөтэй хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй авах эрх 67
13.4. Хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй, нэн даруй нөхөн төлүүлэх эрх 71
14. ШҮҮХ ХУРАЛДААНД ШҮҮГДЭГЧ (ХОЛБОГДОГЧ)-ИЙН ЭДЛЭХ ЭРХ 73
14.1. Хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа эрхлэх чадамжтай, хараат бус ба бие даасан шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 75
14.2. Нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 77
14.3. Гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх 80
14.4. Нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд үнэлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 82
14.5. "Талуудын тэгш байдал" зарчмын хувьд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 86
14.6. Өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 87
14.7. Шүүхийн шийдвэр нийтэд ил тод байх, үндэслэл бүхий шийдвэр гаргуулах шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 90
15. ШҮҮХИЙН ӨМНӨХ БОЛОН БҮХ ШАТНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ЭДЛЭХ ЯЛЛАГДАГЧ (ХОЛБОГДОГЧ)-ИЙН ЭРХ 97
15.1. Халдашгүй чөлөөтэй байх эрх, хараат бус байх, тал үл харах байдал, цагдан хорих арга хэмжээний хууль ёсны эсэхэд гомдол гаргах шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 99
15.2. Мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах шүүгдэгч (холбогдогч)-эрх 102
15.3. Өмгөөлөгч авах, өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 103
15.4. Мөрдөн шалгах явцад эдлэх яллагдагч (холбогдогч)-ийн эрх 106
15.5. Хүнлэг нөхцөлөөр хангуулах ба эрүүдэн шүүлтээс ангид байх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 108
БҮЛЭГ III. ЗӨВЛӨМЖ БА ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН 109
16. ЗӨВЛӨМЖҮҮД (СЭДЭВ ТУС БҮРЭЭР) 110
а. Хохирогчийн эрх 111
б. Шүүх дээр эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх 117
в. Шүүхийн өмнөх болон бүх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх яллагдагч (холбогдогч)-ийн эрх 120
17. ЧАДАВХ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН 122
а. Нэмэгдсэн мэдлэг 122
б. Мэргэжлийн ур чадварыг гүнзгийрүүлсэн нь 123
БҮЛЭГ IV. ХАВСРАЛТУУД 126
ХАВСРАЛТ А. ОРОЛЦОГЧ ТАЛ ТУС БҮРД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ 127
Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл 127
Шүүгчид 130
Прокурор 135

Цагдаа **137**
Шүүхийн захиргааны ажилтнууд **141**
Хохирогчид **141**
Хохирогчийн өмгөөлөгчид **141**
Хохирогчийн төлөөлөгчид **143**
Холбогдогч (яллагдагч) **144**
Холбогдогч (яллагдагч)-ийн өмгөөлөгчид **145**
Холбогдогч (яллагдагч)-ийн төлөөлөгчид **146**
Нийгмийн ажилтнууд **146**
Холбогдох дэмжлэг үзүүлэх үйлчилгээ **147**
Эрүүлжүүлэх төвүүд **147**
ХАВСРАЛТ Б. ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАГЧДЫН СИСТЕМИЙН ТҮВШИНД САЙЖРУУЛАХ САНАЛ, ЗӨВЛӨМЖҮҮД **148**
Ерөнхий зөвлөмжүүд **148**
Дэлгэрэнгүй санал, зөвлөмж **149**
ХАВСРАЛТ В. ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТЫН ХЭРЭГЛЭГДЭХҮҮН **160**
ХАВСРАЛТ Г. ГАРЫН АВЛАГА: АЖИГЛАХ ГОЛ ЗҮЙЛС **201**
ХАВСРАЛТ Д. ГАРЫН АВЛАГА: ТЭМДЭГЛЭЛИЙН ХУУДАС **202**
ХАВСРАЛТ Е. ГАРЫН АВЛАГА: АЖИГЛАГЧДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДҮРЭМ **206**
ХАВСРАЛТ Ё. ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАГЧДЫН СУРГАЛТ **209**
1.1.Албан ёсны нээлт **209**
1.2 Шүүх хуралдааны ажиглагчдын сургалт **211**

Зураг, дүрс, хүснэгт, товчлол

Зураг

Зураг 1: Албан ёсны нээлтийн арга хэмжээ, 2020 оны 8-р сарын 11, Улаанбаатар хот, Монголын мэдээ агентлаг 3
Зураг 4: Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний сонголтын удирдамж 15
Зураг 5: Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хаалттай асуултын жишээ 15
Зураг 11: Сонголтын хэсэг дэх шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний оноог тооцох аргачлал 19
Зураг 14: Шүүхийн ажиглагчийн гарын авлага ба ажиглах гол асуудлуудын жагсаалт 20
Зураг 15: Google маягтын хэсгээс 20
Зураг 16: Албан ёсны шүүх хуралдааны ажиглалтын баг ба төслийн баг 23
Зураг 17: Туршилтын баг ба сургагч багш нар 25
Зураг 18: Туршилтад бэлтгэх сургалт, 2020 оны 6 сарын 02, Улаанбаатар хот 26
Зураг 19: Төв аймгийн шүүхтэй хийсэн танилцах уулзалт 27
Зураг 20: Туршилтын шатны багийн уулзалт 27
Зураг 21: Туршилтын шатны хэрэглэгдэхүүнийг сайжруулах явц 28
Зураг 22: Ховд аймгийн шүүхэд хийсэн айлчлал 30
Зураг 23: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн шүүх хурлын тов 31
Зураг 24: Ажиглагчдын фейсбүүк групп хуудас 32
Зураг 25: Албан ёсны ажиглалтын явцад хийсэн багийн хэлэлцүүлэг 33
Зураг 27: Тара Нийл, А.Жаргалан Б.Сарантуяа нар сургалтад үг хэлэв 209

Зураг 29: Канад Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Катрин Ивкоф 210
Зураг 30: Л.Нямгэрэл болон Э.Баярбаясгалан нар Монгол дахь жендерт суурилсан хүчирхийллийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг танилцуулав 210
Зураг 31: Ажиглагчид, шүүхийн ажилтнууд албан ёсны нээлт дээр санал бодлоо солилцов 210
Зураг 32: Албан ёсны ажиглалтын сургалт дээр танилцах арга хэмжээг хийв 211
Зураг 33: ДокторУ.Туяа ажиглалтын сургалтыг зааж тайлбарлав 211
Зураг 34: Албан ёсны ажиглалтын сургалтын үеэр гаргасан семинарын санаанууд 212

Дүрс

Дүрс 1: Үйл ажиллагаа ба өргөн хүрээний төсөл дэх түүний нийцэл 3
Дүрс 2: Үйл ажиллагаанд баримтлах зарчмууд 6
Дүрс 3: Үйл ажиллагааны ажиглалтын зарчмууд 7
Дүрс 4: Шүүх хуралдааны ажиглалтын үйл явц 13
Дүрс 5: Шүүх хуралдааны ажиглагчид: мэргэжил ба жендерээр 22
Дүрс 6: Шүүх хуралдааны ажиглалтын багын бүтэц 23
Дүрс 7: Шүүх хуралдааны ажиглагчид: нас ба жендер 24
Дүрс 8: Зөрчлийн шийтгэл оноосон тохиолдол, ЗХ-ийн холбогдох заалтуудаар 41
Дүрс 9: Эрүүгийн ял оноосон тохиолдол, ЭХ-ийн холбогдох зүйлээр 41
Дүрс 10. Хохирогчдын мэдүүлсэн ГБХ үйлдсэн шалтгаан 43
Дүрс 11: Хохирогчид насны бүлгээр 48
Дүрс 12: Яллагдагчид хүйсээр 48
Дүрс 13: Шүүгдэгч (холбогдогч)-ийн нас 49
Дүрс 14: Шүүгдэгч (холбогдогч) хүйсээр 49
Дүрс 15: ГБХ үйлдэх үед хохирогч, яллагдагч нар хамт амьдардаг байсан эсэх 50
Дүрс 16: Хүчирхийлэл үйлдэгчид өмнө нь ял, шийтгэл эдэлж байсан эсэх 52
Дүрс 17: Хохирогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор авсан арга хэмжээ 59
Дүрс 18: Шүүхийн өмнөх шатанд хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн туслалцаа 60
Дүрс 19: Хохирогчид шүүхийн байранд нэвтрэхэд хэрэгжүүлсэн аюулгүй байдлын шалгалт . 61
Дүрс 20: Хохирогчдод аюулгүй байдал, тусламжийн арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэсэн байдал 62
Дүрс 21: Хохирогчид сэтгэл санааны дарамтад дахин орохоос сэргийлэх арга хэмжээ шүүх дээр авсан байдал 63
Дүрс 22: Хохирогч ба шүүгдэгчийг шүүхээс ээлжлэн гаргах 64
Дүрс 23: Хохирогчдын эрх үүргийн талаар танилцуулж, тайлбарласан байдал 66
Дүрс 24: Шүүхийн шийдвэр гарахад хохирогчдын тайлбар, нотлох баримтыг шинжлэн судалсан байдал 68
Дүрс 25: Шүүхийн шийдвэрийн үр дүнд тавьж буй хохирогчдын хүлээлт, санал 70
Дүрс 26: Нөхөн төлбөр авахаар гаргасан хохирогчдын хүсэлтийг шийдвэрлэсэн байдал 72
Дүрс 27: Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгч (холбогдогч)-ид эдлэх эрхийн талаар шүүх танилцуулсан байдал 76
Дүрс 28: Шүүх дээр гар утас ашигласан байдал 77
Дүрс 29: Шүүх хуралдааны товын олон нийтэд ил тод, нээлттэй байдал 78
Дүрс 30: Шүүр хуралдаанд ороход олон нийтэд тавигдсан хязгаарлалтууд 79
Дүрс 31: Гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох яллагдагч/холбогдогчийн эрхийг шүүхэд танилцуулсан байдал 81

Дүрс 32: Шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүх хуралдааны ба шүүхийн өмнөх шатны мэдүүлгийн зөрүүтэй байдал 83
Дүрс 33: *Яллагдагч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх шударга боломжоор хангагдсан байдал* 84
Дүрс 34: Шүүх хуралдаанд эцсийн үгээ хэлэх боломж 87
Дүрс 35: Шүүгдэгч (холбогдогч) хэргийн материалтай танилцсан байдал 88
Дүрс 36: Ажигласан хэргүүдтэй холбоотойгоор гарсан шүүхийн тогтоолууд 92
Дүрс 37: Хохирогч мэдүүлгээсээ татгалзсан эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах хүсэлт гаргасан байдал 93
Дүрс 38: *Шүүгдэгч (холбогдогч)-ийг гэм буруутайд тооцон ял шийтгэхэд оногдуулсан хариуцлагын төрөл* 94
Дүрс 39: Шүүхийн шийдвэрийг шүүх дээр уншиж сонсгосон хэмжээ 96
Дүрс 41: Шүүхийн өмнөх шатанд баривчлагдсан шүүгдэгч (холбогдогч)-д баривчлах зөвшөөрлийг танилцуулсан байдал 100
Дүрс 43: Шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүхийн өмнөх шатны байцаалтын үеэр өмгөөлөгч байлцуулсан байдал 107
Дүрс 44: Байцаалтын ажиллагаа үргэлжилсэн хугацаа 107

Хүснэгт

Хүснэгт 1: Ажиглах хэргүүд (эрүүгийн, зөрчлийн хэргийн төрлөөр) 11
Хүснэгт 2: Үйл ажиллагааны хамрах хүрээнд багтсан эрүү, зөрчлийн хэргийн төрлүүд 12
Хүснэгт 3: Ажиглах хэргүүд (үе шатаар) 12
Хүснэгт 4: Шүүх хуралдааны ажиглагчдыг сонгон шалгаруулах үзүүлэлтүүд 22
Хүснэгт 5: Шүүх хуралдааны ажиглагчдын боловсрол, жендерийн мэдээлэл 24
Хүснэгт 6: Туршилтад хамрагдах шүүхийг сонгосон шалгуур үзүүлэлтүүд 25
Хүснэгт 7: Ажиглалтын явцад ГБХ-ийн үйлдэлд оноосон ял, шийтгэвэр 40
Хүснэгт 8: Ажиглалт явуулахаар төлөвлөсөн боловч ажиглах боломж гараагүй шүүх хурлууд: эрүүгийн ба зөрчлийн хэргээр 42
Хүснэгт 9: Хэргийг зөв зохистой шийдвэрлүүлэхэд шүүгдэгч (холбогдогч)-ид учирсан саад бэрхшээлүүд 89
Хүснэгт 10: Гэм буруутайд тооцон ял шийтгэл оногдсон шүүгдэгч (холбогдогч)-ийн хүлээсэн хариуцлагын төрөл, хэмжээ, дэлгэрэнгүй мэдээллүүд 94
Хүснэгт 11: Шүүхийн өмнөх шатанд яллагдагч (холбогдогч)-д авсан таслан сэргийлэх арга хэмжээ 102

Товчлол ба нэр томьёоны тодорхойлолт

ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
ОУЭЗХБ	Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага
ШЕЗ	Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөл
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага

Төсөл	Канад Улсын Гадаад харилцааны яамны санхүүжилтээр Монгол дахь ОУЭЗХБ-ын хэрэгжүүлж буй "*Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх"* төсөл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
UPR	НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг

ОУЭЗХБ-ын тухай

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ) нь тогтвортой хөгжил болон хууль дээдлэх ёсыг бий болгохын төлөө дагнан ажиллаж байгаа засгийн газар хоорондын цорын ганц байгууллага юм. ОУЭЗХБ нь эрх зүйн шинэтгэл хийх, институцыг бэхжүүлэх чиглэлээр засгийн газар болон иргэдийг чадавхжуулах замаар энх тайван, шударга ёс, тогтвортой хөгжил, эдийн засгийн боломжийг дэмжин ажилладаг. ОУЭЗХБ-ын төсөл хөтөлбөрүүд, судалгаа болон бодлогын нөлөөлөл зэрэг нь энх тайван, институцын хөгжил, нийгмийн хөгжил, эдийн засгийг сэргээхэд төвлөрч, хууль дээдлэх ёсыг тусгахад анхаарч, зөрчилдөөнөөс ардчилал руу тэмүүлж байгаа улс орнуудтай хамтран ажилладаг.

ТАЛАРХАЛ

Шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаа болон энэхүү тайлан нь Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүй дотоод хэргийн яамны хамтын ажиллагаа, Канад улсын Гадаад харилцааны яамнаас олгосон харамгүй санхүүжилтийн үр дүн билээ. Тус ажиглалтыг ОУЭЗХБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын хамт олны туслалцаа, дэмжлэг, Тара Нийл, Авхиагийн Жаргалан нарын чиглэл, Сүхбаатарын Одончимэгийн үнэлж барашгүй өдөр тутмын шууд зохицуулалттай гүйцэтгэсэн билээ. Төслийн Удирдах зөвлөл мөн үйл ажиллагааны ерөнхий загварыг гаргахад зөвлөгөө өгсөн билээ.

Дорин Чен болон Больхорлоогийн Сарантуяа нар шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн, аргачлал ба сургалтуудын загварыг гаргаж, тайлан боловсруулах зэргээр шүүхийн ажиглалтыг үйл ажиллагааг бүхэлд нь удирдаж, шүүх хуралдааны ажиглалтын багт дэмжлэг, туслалцаагаар хангаж ажилласан.

Түүнчлэн Монголын шүүх, эрх зүйн салбарын зарим төлөөлөгчид, тухайлбал, иргэний нийгмийн төлөөлөл, шүүгчид, прокурорууд, өмгөөлөгчид болон эрдэмтэд цаг заваа гарган үйл ажиллагааны анхны загвар дээр зөвлөгөө өгч цаг заваа харамгүй зориулав. Түүнчлэн, ОУЭЗХБ-ын сургалт, судалгаа, жендерийн болон бүс нутгийн нэгж, газрууд ялангуяа Лусия Савчик, Ралука Попа болон Кризел Малабанан нар энэхүү үйл ажиллагааны бүхий л хугацаанд мэргэжлийн үнэтэй зөвлөгөө өгч, туслалцаа үзүүллээ.

Төслийн зорилтот есөн шүүхийн ажилтнууд болон шүүгчид ажиглах хэлэлцүүлгийг сонгох, ажиглалт хийхэд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ хавтаст хэрэг, аудио/видео бичлэгтэй танилцах боломжоор хангав. Монгол Улсын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажилтнууд олон тооны статистик мэдээллээр хангаж ажилласан.

Эцэст нь гэр бүлийн хүчирхийллийн хэргүүдийн ажиглалтыг үндэсний хэмжээнд амжилттай гүйцэтгэхэд дараах хүмүүс нэн чухал үүрэг гүйцэтгэсэн болохыг цохон тэмдэглэх нь зүйтэй билээ. Үүнд: Амарбаярын Бодьбилэг, Аюушийн Долгор, Бадаубайн Серикбай, Батнасангийн Батсүх, Батсайханы Эрдэнэбат, Баянзулын Төгс-Оюун, Бэгзжавын Уянга, Чимэддоржийн Жадамба, Чимгээгийн Ариунгэрэл, Чойжилийн Сэмжидмаа, Дамарын Түвшинтогтох, Дашбумбын Орхонтуул, Дашзэвэгийн Насанжаргал, Доржийн Баасансүрэн, Доржпүрэвийн

Эрдэнэбүрэн, Элдэв-Очирын Мөнхзаяа, Энхтөрийн Долгор, Ган-Очирын Мөнхцэцэг, Ганболдын Мандахсайхан, Гомбын Болормаа, Жаргалын Өлзийсайхан, Лодойн Мөнхцэцэг, Машлайн Болормаа, Мөнгөний Ичинхорлоо, Сангишаравын Дондов, Сэрэмжидийн Азжаргал, Тэрхэмбийн Оюунчимэг, Цэдэвсүрэнгийн Алтанзул, Цэрэндоржийн Бадиа, Цэрэннанзадын Шийтэрчулуун, Төгрөгийн Ууган-эрдэнэ, Төмөрийн Хонгорзул, Төмөрбаатарын Аюушжав ба Юндэндоржийн Бадамханд нар юм.

Төслийн зүгээс доктор Ухнаагийн Туяа, Эрдэнэбаярын Баярбаясгалан, Ганчулууны Оюунболд, Нямдоржийн Одонтуул, Баттогтохын Доржпагма, Сүхээгийн Билгүүн болон Кателин Восен нарт талархлаа илэрхийлж байна.

Тайланг Англи хэл дээрээс Монгол хэл рүү орчуулах, орчуулгыг хянахад гүн туслалцаа үзүүлсэн Больхорлоогийн Сарантуяа, Батзоригийн Халиунаа болон Энхбаатарын Өлзийлхам нарт таларлал илэрхийлье.

Бүлэг I. Загвар ба хэрэгжилт

1. Танилцуулга

Монгол эмэгтэйчүүдийн ихэнх нь (57.9%) амьдралдаа ямар нэгэн байдлаар хамтран амьдрагчийн хүчирхийлэлд өртөж байсныг Монголын үндэсний статистикийн хорооны тайланд тусгагджээ. Тэдгээрийн 31.2% бие махбодын эсхүл бэлгийн хүчирхийлэлд нас, боловсрол, ажил эрхлэлт ба газар зүйн байршлыг[1] үл харгалзан өртдөг байна. Монгол улсад хүүхдүүд энэхүү хүчирхийллийн гэрч болох нь олонтоо бөгөөд улмаар тэднийг зан харилцааны асуудалтай болгож, цаашид гэр бүлийн хүчирхийллийн (ГБХ) үйлдэгч эсхүл хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.[2]

Урт хугацааны туршид үргэлжилсэн нөлөөллийн ажлын дараа 2016 оны 12 дугаар сард Монгол Улс ГБХ-ийг бууруулахад чиглэсэн хуулийн шинэчлэлийг хийв. Үр дүнд нь *Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль* (**ГБХТтХ**)-д нэмэлт өөрчлөлт оруулж, бие махбодын, сэтгэл зүйн, эдийн засгийн ба бэлгийн хүчирхийллийг анх удаа гэмт хэрэгт тооцсон билээ.[3] ГБХТТХ-д орсон нэмэлт өөрчлөлт 2017 оны 2 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн. Ийнхүү Канад Улсын Гадаад харилцааны яамны санхүүжилттэй Монгол дахь ОУЭЗХБ-аас хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх” төслийн Удирдах зөвлөлөөс хэрэгжээд гурван жил болж буй хуулийн үр нөлөөнд дүн шинжилгээ, үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасны дагуу шүүх хуралдааны ажиглалтыг хийсэн.

Энэхүү тайланд дурдагдсан шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаа нь ГБХ-тэй тэмцэх хууль эрх зүйн орчны шинэчлэлээс хойш ГБХ-ийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь процессын шаардлага хангаж буй эсэх, тухайлбал “шударга шүүх”-ээр шийдвэрлүүлэх эсвэл “процессын дагуу” явагдаж буй байдлыг үнэлэхийг зорьсон болно. Тус үйл ажиллагаагаар хууль зүйн шинэтгэлийг Монгол Улсын шүүх эрх мэдлийн байгууллагад хэрхэн хэрэгжүүлж байгаа, тогтолцооны түвшинд сайжруулах зорилгоор өгөгдөлд суурилсан зөвлөмж гарган гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн хамгаалалтыг шинэтгэх, шүүх хуралдааны ажиглагчдын чадавхыг бэхжүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Тус үйл ажиллагаагаар хуулийн шинэтгэлийг Монгол Улсын шүүхэд хэрхэн хэрэгжүүлж буйг судлах, ГБХ-ийн хохирогчдыг хамгаалах системийг сайжруулах чиглэлд өгөгдөлд суурилсан зөвлөмж боловсруулах, тус үйл ажиллагаанд хамрагдсан ажиглагчдын чадавхыг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн. Төслийн нэг оролцогч ШЕЗ нь зөвхөн иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэдэг гэр бүлийн төрөлжсөн шүүх байгуулахаар судалж байгаа ба энэ хүрээндээ гэр бүлийн хүчирхийллийн хэрэг маргаан зөвхөн тухайн шүүхээр харьяалагдан шийдвэрлэгдвэл зохих эсэх дээр үнэлгээ хийлгэхийг эрмэлзсэн.

---

[1] Монголын Үндэсний статистикийн хороо, *Тэгш эрхийн төлөө дуу хоолойгоо өргөх нь* (Монголын Үндэсний статистикийн хороо ба Монгол дахь Нэгдсэн Үндэстний байгууллагын хүн амын сан, 2018 он, Улаанбаатар хот), х. 13, 16.
[2] *Мөн адил* х. 15.
[3] Азийн сан, “Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд гэр бүлийн хүчирхийллйиг гэмт хэрэгт тооцов”, 2017, 2 дугаар сарын 8

2020 оны 2 дугаар сараас 5 дугаар сарын хооронд үйл ажиллагааны загвар, шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн, хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээ болон Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны карт зэргийг тусгайлан боловсруулсан. Харин 6, 7 дугаар саруудад туршилтын ажиглалтыг хийж, хэрэглэгдэхүүн ба аргачлалыг эцэслэн боловсруулсан. Үйл ажиллагааны нээлтийг 8 дугаар сард хийж, өмгөөлөгчид, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн 34 ажиглагчдыг сургав. Шүүхийн ажиглалтыг 2020 оны 8-11 дугаар сарын хооронд Улаанбаатарын хотын дөрвөн дүүрэг, таван аймгийн шүүхүүдэд хийв. Хэдийгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад Ковид-19 цар тахал гарч, улсын хэмжээнд хоёр ч сонгууль болсонтой холбоотойгоор хүндрэл бэрхшээлүүд гарсан ч 43 зөрчлийн, 14 эрүүгийн хэргийн шүүх хуралдаан буюу нийт 57 хэргийн шүүх хуралдаанд ажиглалтыг хийсэн. Ажиглагчид шүүх хуралдаанд ажиглалт хийж, хавтаст хэргүүдтэй танилцсанаар хэрэг тус бүрийг хэрэг бүртгэлийн шатнаас анхан шатны шүүхийн шийдвэр гаргаж буй үйл явцыг хянаж үзсэн билээ.

Зураг 1: *Албан ёсны нээлтийн арга хэмжээ, 2020 оны 8-р сарын 11, Улаанбаатар хот, Монголын мэдээ агентлаг*

Энэхүү тайланд үйл ажиллагааны загвар, хэрэгжилт, үр дүн болон зөвлөмжийг нарийвчлан тусгасан.

2. Төсөлд гүйцэтгэсэн үүрэг оролцоо

Шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаа нь Канад Улсын Гадаад харилцааны яамны санхүүжилтээр Монгол дахь ОУЭЗХБ-ын хэрэгжүүлж буй "Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх" олон талт төслийн (цаашид **"Төсөл"** гэх) бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ үйл ажиллагаа нь "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн хэрэгжилтийн үнэлгээ болон Монгол улсад хохирогч-төвтэй аргачлалыг нэвтрүүлэх нь" гэсэн суурь судалгаатай зэрэгцэн хэрэгжсэн.

Дүрс 1: *Үйл ажиллагаа ба өргөн хүрээний төсөл дэх түүний нийцэл*

Тодруулбал, шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаа нь төслийн нэг завсрын үр дүнд хувь нэмэр оруулахыг эрмэлзсэн бөгөөд түүний гурван үр дүнг бүрэн хариуцах болно. Үүнд:

Дунд шатны үр дүн 1110:	Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн салбарын оролцогчдын ГБХ-д үзүүлэх хариу үйлдэл сайжирна

Гүйцэтгэл 1111	Монголын ИНБ-ууд ГБХ-ийн хэргийн шүүх хуралдаанд хохирогч-төвтэй хандлагыг хэрэгжүүлэх тал дээр ажиглалт хийх арга зүйд суралцсан байна
Гүйцэтгэл 1112	ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааныг ажиглах гарын авлагыг боловсруулж, хэрэглэнэ
Гүйцэтгэл 1113	ИНБ-уудаас ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхэд ажиглалт хийнэ

Мөн шүүх хуралдааны ажиглалтын баг суурь судалгааны багтай бараг ижил газар зүйн хүрээ, цаашлаад сэдвийн хүрээнд ч ижилхэн гэмт хэргүүдийг сонгон ажиглалаа. Түүнчлэн энэ хоёр баг ялангуяа загварчлалын шатны үеэр хамтарч уулзалтуудад оролцож, үйл явцын мэдээллийг хоорондоо харилцан солилцсон байсан юм.

3. Зорилтууд

Шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаа нь дараах гурван зорилтоос бүрдсэн. Үүнд:

1. Судлах	**Монгол Улсын шүүхийн практикт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн шинэчлэлийг хэрхэн хэрэгжүүлж буй талаар судлах**

Нэгдүгээрт, шүүх хуралдааны ажиглалтаар Монгол Улсын шүүхэд ГБХ-ийн хувьд шударга ёсыг тогтоож буй байдал, эдгээр ажиллагаа нь нэмэлт, өөрчлөлт орсон ГБХ-ийн тухай хууль тогтоомжтой болон олон улсын эрх зүйн стандарттай хэрхэн нийцэж буйг тогтоох үүднээс эмпирик нотлох баримтыг цуглуулж ажиглах зорилготой байсан.

Төслийн холбогдох талууд Монгол Улсад ГБХ-ийг гэмт хэрэгт тооцсон байдал нь практикийн хувьд ээдрээ түвэгтэй байгааг хэлж байсан нь ач холбогдолтой зүйл байв.
Тодруулбал, ГБХТтХ-ийг дангаар нь шууд хэрэглэх боломжгүй билээ. Иймээс ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн хэргийг Зөрчлийн тухай хууль (зөрчилд хариуцлага тооцох), Эрүүгийн хууль (гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх) мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгах шаардлагатай байв. Эдгээр хуульд нэмэлт өөрчлөлт орж, 2020 оны эхээр хүчин төгөлдөр болсон. Цаашдаа, эдгээр хуулиудын талаар Монгол Улсын Дээд шүүхээс тайлбар гаргаж, тодорхой чиглэмж өгнө гэж харж байна.

2. Шинэчлэл	**ГБХ-ийн бүх хэлбэрээс хамгаалах Монгол Улсын эрх зүйн шинэчлэлийг системийн хэмжээнд сайжруулахад чиглэсэн өгөгдөлд суурилсан зөвлөмж боловсруулах**

Хоёрт, Монгол Улсын шүүхээс ГБХ-ийн хэргийг шийдвэрлэж буй байдлын давуу болон сул талыг эмпирик нотолгоонд үндэслэж, өгөгдөлд суурилсан дүн шинжилгээ хийж танилцуулахыг зорьсон. Энэ нь шүүх, эрх мэдлийн салбарын оролцогч талуудад Монгол Улсаас өөрийн иргэдийн ГБХ дэх эрх зүйн хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээний зөвлөмж (16-р хэсэгт заасан)-ийг гаргах үндэс болсон юм. Ялангуяа энэхүү зорилго нь сүүлийн, UPR-ийн

гуравдугаар илтгэлийн хэлэлцүүлгийн үеэр Монгол Улс нь ГБХ-ээс хамгаалах хууль эрх зүйн үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн хэд хэдэн Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн зөвлөмжийг хүлээн авч, биелүүлэх үүрэг амлалтаа өгсөн үед улам их ач холбогдолтой юм.[4]

3. Бэхжүүлэх	Ажиглагчдын чадавхыг бэхжүүлэх

Гуравдугаарт, энэ үйл ажиллагаа нь шүүхийн ажиглалт хийх хүмүүсийн чадавхыг бэхжүүлэх суурь болоход чиглэгдсэн. Шүүх хуралдааны ажиглагчид бол ГБХ, жендерт суурилсан хүчирхийлэл, эсхүл хүний эрхийн чиглэлээр идэвхтэй ажиллаж буй болон эдгээр асуудлаар идэвхтэй ажилладаг, эсхүл шударга шүүх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, гэр бүлийн тухай хууль тогтоомжийг сонирхдог эрх зүйч мэргэжлээр төгссөн хүмүүс юм.

Үүнтэй холбоотой хоёрдугаар зорилго бол эдгээр ажиглагчид нь цаашид ГБХ эсхүл ойролцоо салбарт ажилласаар байх бөгөөд ирээдүйд шударга ёсыг сахин хангуулах салбарын зүгээс ГБХ-ийн хэрэг, зөрчилд өгөх хариу арга хэмжээг цогц, боловсронгуй болгож, улмаар төслийн урт хугацааны нөлөөллийг бий болгоно гэж үзэж байна.

---

[4]. UPR Зөвлөмж **116.10:** “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх” (Израиль);
116.11: “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг үргэлжүүлэн хэрэгжүүлэх” (Израиль);
116.123: “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр төрөөс хууль эрх зүйн хамгаалалт, үйлчилгээ үзүүлэх, мэдээллийн хүртээмжтэй байдал, олон нийтэд хүргэх чиглэлээр ахиц дэвшил гаргахыг үргэлжлүүлэх” (Чили);
116.124: “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн дарамттай тэмцэхэд чиглэсэн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг бүрэн, үр дүнтэй хэрэгжүүлэх” (Италь);
116.126: “Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалахад чиглэсэн арга хэмжээг бэхжүүлэх” (Сенегал);
116.127: “Охид, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн авах” (Энэтхэг);
116.128: “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түгээмэл хэлбэр, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, хохирогчдод зохих дэмжлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх” (Чех);
116.129: “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ авах, үүний дотор цагдаагийн алба хаагчдыг хохирогч төвтэй аюул заналхийллийн үнэлгээг хэрхэн үр дүнтэй хийх талаар сургаж дадлагажуулах” (Дани);
116.130: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, ялангуяа хууль сахиулах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, хөрөнгө хуваарилах, түүнчлэн хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүсийн хамгаалалт болон үйлчилгээ авах нөхцөл боломжийг сайжруулах” (Канад);
116.132: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээний талаарх хууль сахиулах байгууллагын ажилтнууд, хуульчид, шүүгчдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авах” (Фижи);
116.133: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод зохих дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хамгаалалтын механизмыг улам бэхжүүлэх” (Филиппин);
116.134: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах, парламент болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог улам бүр нэмэгдүүлэх чиглэлээр хүчин чармайлтаа үргэлжлүүлэх” (БНСУ);
116.135: “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, бүх хохирогчийг хамгаалах чиглэлээрх үндэсний механизмуудыг улам бүр бэхжүүлэх” (Киргиз);
116.136: Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг үргэлжлүүлэн авах (Непал);

4. Үзэл баримтлалын цар хүрээ

4.1. Үндсэн зарчмууд

Дүрс 2: *Үйл ажиллагаанд баримтлах зарчмууд*

2-р дүрсэд харуулсанчлан, гурван үндсэн, хоорондоо огтлолцсон зарчмуудын үндсэн дээр шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагааг боловсруулж, хэрэгжүүлсэн. Юуны түрүүнд, шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагааны үндсэн аргачлал нь хохирогч төвтэй хандлага байсан.[5] Тус аргачлалын хүрээнд хохирогчдын (буюу даван туулагчид) нэр төр, хэрэгцээ, тулгамдсан асуудлууд болоод эрхийг нь нэн түрүүнд чухалчилсан. Энэ бол аливаа шүүмжлэлээс ангид байх тухай ойлголт юм. Мөн төслийг хэрэгжүүлэхдээ хохирогчдын сэтгэл санааны байдалд мэдрэмжтэй хандахын зэрэгцээ дахин сэтгэл санааны дарамтад орохоос сэргийлэх зорилгыг агуулсан. Энэ хандлагыг зөвхөн шүүх хуралдааны ажиглалт төдийгүй нийт төслийн хүрээнд Канад Улсын Гадаад харилцааны яамны баримтлах үнэт зүйлстэй нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Үүнээс гадна уг үйл ажиллагаа нь ОУЭЗХБ-ын үнэт эрхэм зүйлсэд[6] нийцэж байгаа боловч хамгийн чухал хоёр үнэт зүйлсийг энд онцлон тэмдэглэж байна. ОУЭЗХБ-ын хувьд, жендерийн мэдрэмжтэй, хариуцлагатай байх зарчим нь төслийн бүхий л хэсэг жендерийн талаар сайн ойлголттой, жендерийн асуудалд хариуцлагатай хандахыг шаарддаг билээ. Эцэст нь олон нийтийн дэмжлэгийн зарчмын хүрээнд ОУЭЗХБ-ын туслалцааг тухайн орон нутгийн эрхэм зүйлстэй уялдуулж, орон нутгийн түншүүдтэй нягт ажиллахыг зорьдог. Тус үйл ажиллагааны хувьд, үйл ажиллагаа, гол шийдвэрүүд дээр Монгол Улсын манлайллыг чухалчлах, Монгол улсад буй нөөц бололцоо, боловсон хүчний туршлагыг ашиглан үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бөгөөд ингэснээр үйл ажиллагааны үр нөлөөг цаашид тогтвортой байлгахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

4.2. Ажиглалтын зарчмууд

[5] Энд заасан нэр томьёоны тодорхойлолтыг АНУ-ын Хууль зүйн яамны үзэл баримтлалын хүрээнээс иш татав. АНУ-ын Хууль зүйн яамны Гэмт хэргийн хохирогчдын хэлтсийн “Хохирогч төвтэй хандлага”.
[6] IDLO, “About IDLO: Our Values”, 2015.

Дүрс 3: *Үйл ажиллагааны ажиглалтын зарчмууд*

Шүүх хуралдааны ажиглалтын аргачлалыг үндсэндээ Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын (ЕАБХАБ) Шүүх хуралдааны ажиглалтын загварт тулгуурлаж боловсруулсан. Үүний дагуу ЕАБХАБ-ын ажиглалтын зарчмуудыг тус аргачлалын арга зүйд **Дүрс 3**-т заасны дагуу тусгасан болно. Түүнчлэн Монгол Улсын шүүхийн хараат бус байдалд хөндлөнгөөс оролцохгүй, нөлөөлөхгүй байх зарчмыг хангаж ажилласан. Энэ нь үнэн зөв, бодит мэдээллийг цуглуулах, ажиглалтыг төвийг сахисан хандлагаар явуулах замаар бодит байдлыг баталгаажуулах зорилготой байв. Эцэст нь ШЕЗ-тэй байгуулсан санамж бичгийн хүрээнд Монгол Улс дахь ОУЭЗХБ-д дараах дэмжлэгийг үзүүлж ажилласан. Үүнд: холбогдох журмыг баримтлан шүүхийн ажиглагчдыг шүүхэд нэвтрүүлэх, хэргийн материал, мэдээлэлтэй танилцах, мөн боловсон хүчний дэмжлэг үзүүлэв.[7]

4.3. Үнэлгээний зарчмууд

Шүүх хуралдааны ажиглалтын зорилго нь ГБХ-ийг шийдвэрлэхэд гарсан хуулийн шинэчлэлээс хойш Монгол Улсад ГБХ-ийн хэргийг хууль сахиулах, шүүх эрх мэдлийн салбарт шийдвэрлэх ажиллагаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шаардлага, Монгол Улсад болон олон улсад заавал мөрдөх зарчмууд, эрх зүйн хэм хэмжээний дагуу хийгдэж буйг үнэлэхэд оршино. Иймд цаашид **6.2-р хэсэгт** доор дурдсаны дагуу Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний асуултуудыг тухайн үнэлгээг хийхэд ашигласан оноотой болон нэмэлт шаардлагатай мэдээлэл цуглуулах оноогүй асуултууд гэж 2 хуваасан. Оноотой асуултуудыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын хууль тогтоомж болон эсхүл Олон улсын гэрээгээр Монгол Улсын хүлээсэн үүрэг дээр үндэслэсэн байхаар анхаарч ажилласан.

Шүүх хуралдааны ажиглалтын хүрээнд яллагдагч (холбогдогч)-ид эрх зүйн зайлшгүй процессын ажиллагааг хийх буюу шударга шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрхийг үнэлэхийн тулд тус эрхийг хамгаалсан эрх зүйн үндсэн баримт бичиг болох “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт” (ИБУТЭТОУП)-ын 14-р зүйлийг ашиглав. Эдүгээ Монгол улс ИБУТЭТОУП-д нэгдсэнээс хойш 50 гаруй жил өнгөрсөн бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн дагуу тус конвенц хэрэгжиж байна. Түүнчлэн, НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс 14-р зүйлийг хэрэглэх тухай тайлбар буюу 32 дугаар Ерөнхий тайлбарыг[8] гаргасан. Иймээс шударга шүүхээр шүүлгэх эрхийн хэрэгжилтийг үнэлэхдэ 32 дугаар Ерөнхий тайлбарын зарчим, номлолыг өөрийн үзэл баримтлалын хүрээ болгон ажиллав.

Харин хохирогчийн эрхийг энэ үе шатанд зохицуулсан олон улсын заавал дагаж мөрдөх шинжтэй гэрээ хэлцэл байдаггүй. Иймээс үүний оронд олон улсын эрх зүйн заавал дагаж мөрдөх зарчмуудаас бүрдэх агуулга болон Ерөнхий Ассамблейн тогтоолын хэсэг болсон Олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн хохирогчийн хамгаалуулах эрхийн талаарх суурь зарчмуудын үзэл баримтлал, хамрах хүрээ зэргийг ажиглалтын үйл

[7] ЕАБХАБ, Шүүх хуралдааны ажиглалт: Гүйцэтгэгчид зориулсан гарын авлага, засварласан хэвлэл (ЕАБХАБ, 2012, Варшав хот,), х. 18-20.

[8] НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, 32-р Ерөнхий Тайлбар: 14-р зүйл: Шүүхийн өмнө эрх тэгш байх ба хэргээ шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрх, НҮБ-ын баримт бичгийн дугаар: CCPR/C/GC/32, 2007 оны 8-р сарын 23

ажиллагаанд авч хэрэглэв. Үүнээс гадна Монгол улс энэхүү үйл ажиллагааг дэмжиж, хамтарч ажиллаж байгаа нь ГБХ-ийн хохирогчдын эрхийг хамгаалах арга хэмжээг боловсронгуй болгохоор зорьж ажиллаж байгааг илтгэх ба тус үйл ажиллагаанд хууль, шүүхийн байгууллагуудад үнэлгээ хийхдээ зөвхөн хохирогчийн эрхээр аль болох хязгаарлахгүй байхыг хичээлээ. Гэвч энэхүү хязгаарлалт нь гагцхүү хохирогчдын аюулгүй байдалтай холбоотой асуултууд байв.

5. Хамрах хүрээ

5.1. Хөтөлбөрийн төрөл

Уг үйл ажиллагаа нь зөвхөн тодорхой агуулгын хүрээ (ГБХ)-ний хэргийг сонгож, сэдэвчилсэн шүүх хуралдааны ажиглалтын хөтөлбөрийг [9] хэрэгжүүлэв. Үүнээс гадна уг үйл ажиллагаа нь өөрийн боломжит шүүх хуралдааны ажиглалтын хугацаанд багтаан хэргүүдийг хууль, шүүхийн байгууллагуудын бүхий л ажиллагааны үе шатанд дагаж ажиглалтыг хийх шаардлагатай байсан учраас **системчилсэн** ажиглалтын бүрэлдэхүүн хэсгийг бүрдүүлж ажиллалаа. Энэ хөтөлбөрийг төслийн Удирдах зөвлөлийн гишүүн байгууллага болох Монгол Улсын ШЕЗ-тэй байгуулсан **Санамж бичгийн** дагуу хийж гүйцэтгэлээ. ШЕЗ-өөс холбогдох дүрэм журмыг мөрдөх нөхцөлтэйгөөр шүүхийн ажиглагчдыг шүүх хуралдаанд оролцож, хавтаст хэрэг, аудио-видео бичлэг, статистик тоо мэдээтэй танилцах, шаардлагатай боловсон хүчнээс тусламж дэмжлэг авах боломжоор хангасан.

5.2. Газар зүйн хамрах хүрээ

Төслийн анхны загварын дагуу шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагааг зөвхөн Улаанбаатар хотноо хийхээр төлөвлөж байв. Гэвч энэ үйл ажиллагааг боловсруулах үеэр Улаанбаатар хот болон орон нутагт шийдвэрлэж буй хэргүүдийн тэнцвэртэй байдлыг ханган аймгуудыг ч мөн адил хамруулснаар тус ажиглалтын үйл ажиллагаанд төлөөллийг хангах, илүү бодитой, үр дүнтэй болгосон гэж үзэж байна Хяналт шинжилгээнд хамрагдсан тохиолдлуудын газарзүйн тархалтыг дор дурдсан **Хэсэг 11.1** –т авч үзсэн болно.

Түүнчлэн илүү өргөн хүрээтэй харьцуулалтыг хийх судалгааны сан бий болгох үүднээс судалгааны хамрах хүрээг авч үзэхдээ газар зүйн хүрээг харгалзан тусгахыг эрмэлзсэн. Судалгааны ажлын багийн зүгээс газарзүйн хамрах хүрээг сонгохдоо ГБХ-ийн хэргийн төрөл, давтамж; нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал; ГБХ-тэй тэмцэх сайн болон бэрхшээлтэй туршлага байгаа эсэх; хот/хөдөөгийн ялгаа; хүн ам, яс үндэстний онцлог зэргийг харгалзан үзсэн.
Мөн төслийн Удирдах зөвлөлийн төлөөлөгчдийн хувьд ч газарзүйн хамрах хүрээний талаар зөвлөгөө өгөхдөө шүүх хуралдааны ажиглалт, судалгааны үйл ажиллагааг хөндлөнгийн дэмжлэг туслалцаа авах, энэхүү дэмжлэг туслалцааг цаашид Монгол Улсын нутаг дэвсгэрт бодитой, тэгш хуваарилж хүргэх нь зүйтэй гэсэн байр суурийг илэрхийлж байлаа.

[9] ЕАБХАБ, *Шүүх хуралдааны ажиглалт: Гүйцэтгэгчид зориулсан гарын авлага*, х. 21; Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн дээд зөвлөл, “Хууль, шүүхийн байгууллагуудын шүүх хуралдааны ажиглалт”, “Хүний эрхийн ажиглалт”, засварласан хэвлэл (Нэгдсэн үндэстний байгууллага, 2011 он, Женев хот), х. 3.

Зураг 2: *Үйл ажиллагааны газар зүйн хамрах хүрээнд багтсан Улаанбаатар хотын дүүргүүд*

Зураг 3: *Үйл ажиллагааны хамрах хүрээнд багтсан аймгууд*

Эцсийн үр дүнд шүүх хуралдааны ажиглалтыг Улаанбаатар хотын Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан болон Чингэлтэй дүүргүүдэд (**Зураг 2**) мөн Төв, Архангай, Дорноговь, Ховд ба Өвөрхангай *аймгуудад* ажиглалтыг хэрэгжүүлсэн болохыг **Зураг 3**-с харж болно.

Судалгааны баг энэ газарзүйн хамрах хүрээг төслийн оролцогч талуудын саналыг харгалзан сонгосон ч Өвөрхангай *аймаг* ГБХ-ийн хэрэг их хэмжээгээр гардаг бөгөөд энэ нь ажиглалт хийхэд үр дүн өгнө хэмээн нэмж оруулсан билээ.

5.3. Сэдвийн хамрах хүрээ

Дээр дурдсанчлан, 2016 оны сүүлд батлагдсан ГБХТТХ-ийг дангаар нь шууд хэрэгжүүлэх боломжгүй билээ. ГБХ-ийн гэмт хэргүүдийг Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан байдаг. Гэр бүлийн хүчирхийллийн зөрчлийг Зөрчлийн тухай хуульд тусгай зүйл заалтад (5.4-р зүйл) заасан бол хүнд гэмт хэргийг Эрүүгийн хуулиар зохицуулдаг. ГБХ-ийн гэмт хэргийг зөвхөн тодорхой гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 11.7-р зүйл) гэж тодорхойлохоос гадна хэд хэдэн гэмт хэргийн хүндрүүлэх хүчин зүйл болдог байна[10]. Энэ үйл ажиллагааны хүрээнд ажиглалт хийх хэргүүдийг гэмт хэргийн төрлөөр ангилсныг доорх **Хүснэгт** 1-д заасан.

Ажиглах хэргүүд (эрүүгийн, зөрчлийн хэргүүдийн төрлөөр)	**Бүх багуудын зайлшгүй ажиглах хэргүүд**		**Ажиглабал зохих хэргүүд**	
	ГБХ-д хамаарах зөрчлүүд (бага хэмжээний зөрчил)	ГБХ-д хамаарах гэмт хэргүүд (хүнд хэмжээний)	ГБХ хүндрүүлэх нөхцөл болсон бусад гэмт хэргүүд	ГБХ-тэй хамааралтай бусад гэмт хэргүүд

[10] Монгол улсын Эрүүгийн хуулийн 10.1-р зүйл (Хүнийг алах), 10.4-р зүйл (Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх), 11.1-р зүйл (Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах), 11.4-р зүйл (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах), 11.5-р зүйл (Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах), 11.6-р зүйл (Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах), 12.1-р зүйл (Хүчиндэх).

Хүснэгт 1: *Ажиглах хэргүүд (эрүүгийн, зөрчлийн хэргийн төрлөөр)*

Суурь судалгааны баг болон үйл ажиллагааны загварт зөвлөгөө өгсөн оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр нийт 18 хэргийг ажиглахаар зорьсныг **Хүснэгт 2**-т харууллаа.

ГБХ-ийн зөрчлүүд (*Зөрчлийн тухай хуулийн зүйл заалт*)	**Гэмт хэргүүд**		
	ГБХ-ийн гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл заалт*)	**ГБХ хүндрүүлэх нөхцөл болсон бусад гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл заалт*)**	**ГБХ-тэй хамааралтай гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл заалт*)**
• Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй (5.4.1) • Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн (5.4.2) • Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан (5.4.3) • Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон (5.4.4.1) • Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан (5.4.4.2) • Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг бусадтай харилцахыг хязгаарласан (5.4.4.3) • Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан(5.4.4.4)	• Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд байнга халдсан (11.7.1.3) • Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан (11.7.1.2) • Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд байнга халдсан (11.7.1.3) • ГБХ-ийн гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн (11.7.2.1) • ГБХ-ийн гэмт хэргийг асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн (11.7.2.2) • ГБХ-ийн гэмт хэргийг таслан зогсоох гэсэн хүнийг	• Хүнийг алах (10.1) • Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах (11.1) • Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах (11.4) • Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах (11.6) • Хүчиндэх (12.1)	• Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4) • Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2)

ГБХ-ийн зөрчлүүд (*Зөрчлийн тухай хуулийн зүйл заалт*)	Гэмт хэргүүд		
	ГБХ-ийн гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл заалт*)	ГБХ хүндрүүлэх нөхцөл болсон бусад гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл заалт*)	ГБХ-тэй хамааралтай гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл заалт*)
	эсэргүүцэж үйлдсэн (11.7.2.3)		

Хүснэгт 2: *Үйл ажиллагааны хамрах хүрээнд багтсан эрүү, зөрчлийн хэргийн төрлүүд*

Ажиглалтын хамрах хүрээнд ГБХ-ийн зөрчил, гэмт хэргүүдээр хэргүүдийн цар хүрээ, хэр хэмжээг бүрэн илэрхийлэхийг эрмэлзсэн ба үүнд бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийллийн хэлбэрүүдийг аль аль нь мөн бага хэмжээний зөрчлөөс эхлэн хамгийн хүнд хэлбэрийн гэмт хэргүүд багтсан. Ажиглах боломжтой байсан зөрчил, эрүүгийн хэргүүдийн төрлийг **11.2.2**-**11.2.4 хэсэгт** дэлгэрэнгүй танилцуулав.

Эцэст нь, ажиглах хэргүүдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатлалаар ангилсныг **Хүснэгт 3**-т харуулав.

Ажиглах хэргүүд (холбогдох ажиллагааны үе шатаар)	Бүх багуудын зайлшгүй ажиглах хэргүүд		Ажиглавал зохих хэргүүд	
	Анхан шатны шүүх хуралдаанууд		Давж заалдах шатны шүүх хуралдаанууд	
	Зөрчлийн хэргүүд	Эрүүгийн хэргүүд	Давж заалдах шатны шүүхүүдэд (Зөрчлийн эсхүл эрүүгийн хэргүүд)	Дээд шүүх (Зөрчлийн эсхүл эрүүгийн хэргүүд)

Хүснэгт 3: *Ажиглах хэргүүд (үе шатаар)*

6. Ажиглалтын хэрэглэгдэхүүн ба арга зүй

6.1. Ажиглалтын үйл явц

Шүүх хуралдааны ажиглагчид **Дүрс 4**-т зургаан алхмаар мэдээллийг цуглуулсныг илэрхийлэв.

Дүрс 4: Шүүх хуралдааны ажиглалтын үйл явц

Дүрс 4-т танилцуулсан төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийг дор дэлгэрэнгүй тайлбарласан.

6.2. Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн

6.2.1. Аргачлал

Төслийн ерөнхий зорилгын дагуу шүүх хуралдааны шатанд эдлэх эрхүүд болон хохирогчийн аюулгүй байдал үнэлэх хэрэглэгдэхүүнийг болон шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картыг боловсруулсан. Эдгээрийг хамтад нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн гэх бөгөөд нь **Хавсралт В**-д бүтнээр нь оруулсан болно.

Одоогийн жишээн дээр тулгуурлан шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг Монгол Улсын хууль тогтоомжийн онцлог болон тус улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенцийн зохицуулалтыг харгалзан Монголын агуулгад тохируулсан билээ[11]. Мөн **Хэсэг 4,3-т**

[11] Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж хэрэгжүүлэхдээ нэн ялангуяа Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага болон НҮБ-ийн Хүний эрхийн дээд зөвлөлийн одоогийн хүчин төгөлдөр

заасанчлан, тус хэрэглэгдэхүүн хэрэг тус бүрийн хувьд зайлшгүй хэрэгжүүлэх хууль зүйн үүрэг болон хэрэгжүүлж болохуйц үйл ажиллагааны талаарх өгөгдлийг цуглуулах, ГБХ-ийн хэргийн шүүх хуралдаантай холбоотой өгөгдлийн багцыг арвин их хэмжээгээр нэгтгэж, бүрдүүлэх боломжтой байх хэлбэрээр хэрэглэгдэхүүнүүдийг боловсруулаа. Энэхүү хандлагын дагуу хэрэг тус бүрийн гүйцэтгэлийг албан ёсоор үнэлж буй шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны карт нь зөвхөн хууль ёсны үүргийн талаарх мэдээллийг үнэлсэн.
Ажиглагчид шүүх хуралдааны үеэр болон хавтаст хэрэгтэй танилцах үедээ Шүүх хуралдааны ажиглалтын хэвлэмэл хэрэглэгдэхүүнийг бөглөх шаардлагатай байв. Дараа нь тэд тус өгөгдлийг үүлэн технологид суурилсан Google маягтад оруулж, харин түүнийг (дор **Хэсэг 6.6**-т заасанчлан) нь төвөөс түүвэрлэсэн загваруудын бүх өгөгдлийг хүлээн авч, нэвтрэх боломжтой байхаар зохицуулсан. Гэхдээ гарч болзошгүй алдаа, эрсдэлээс сэргийлэх зорилгоор шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хэвлэмэл хуудас дээрх өгөгдлийг Google маягтад оруулах нэг ажилтныг ажиллуулсан.

6.2.2. Агуулга

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн нь таван хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- **I – Үндсэн мэдээлэл:** хэргийг тодорхойлох ерөнхий мэдээлэл болон үндсэн өгөгдлийг цуглуулах;
- **II – Хохирогчийн эрх**: шүүхийн өмнөх шатаас эхлэн шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд тухайн хэргийн хохирогчийн холбогдох мэдээллийг цуглуулж үнэлгээ өгөх;
- **III – шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх (Анхан шат болон давж заалдах шатны шүүх хуралдаан)**: анхан шатны болон давж заалдах шатны шүүх хуралдааны явцад олж авсан шүүгдэгч (холбогдогч)-ийн талаарх мэдээллийг цуглуулж үнэлгээ өгөх;
- **IV – Яллагдагч шүүгдэгч/холбогдогчийн эрх (Шүүхийн өмнөх болон бүх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа)**: шүүхийн өмнөх болон бүх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад олж авсан шүүгдэгч (холбогдогч)-ийн туршлагын талаарх мэдээллийг цуглуулж үнэлгээ өгөх; болон
- **V – Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны карт**: өмнөх хэсгүүдэд цуглуулсан оноотой өгөгдөлд суурилан тухайн хэрэгт үнэлгээ өгөх.

Цаашлаад энэ таван хэсгүүд тус бүрчлэн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч эсхүл шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх төрөл бүрийн эрхийн хэрэгжилтийг үнэлсэн 19 бүлэгт хуваагдсан болно. Ажиглагчдад ерөнхийдөө бүх асуултуудыг хэсэгчлэн бөглөх шаардлага тавьсан байсан. Гэхдээ шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний зарим бүлгүүдэд зөвхөн тухайн хэргийн нөхцөл байдалд хамаарч байгаа тохиолдолд л бөглөх асуултууд байсан. **Зураг 2**-ийн жишээн дээр ямар тохиолдолд тухайн хувилбарт асуултуудад хариулах зааварчилгааг харуулсан.

мөрдөгдөж буй шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг ашигласан ба хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээ нь дэлхий дахинаа энэ асуудлыг шийдвэрлэсэн шилдэг жишгийг түгээх зорилтыг хэрэгжүүлэхээр зорьдог бол Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картыг боловсруулахад Дэлхийн шударга ёсны төслийн жилийн “Эрх зүйт төр” индексийг ашигласан болно.

COMPLETE IF AT LEAST ONE VICTIM ATTENDED THE COURT HEARINGS: / ХОХИРОГЧ (БАГАДАА НЭГ ХОХИРОГЧ) ШҮҮХИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ОРОЛЦСОН БОЛ БӨГЛӨНӨ:
SECTION B: VICTIM'S ACCESS TO JUSTICE IN COURT / ХЭСЭГ Б: ШҮҮХ ДЭЭР ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХ ХОХИРОГЧИЙН ЭРХ

Зураг 2: *Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний сонголтын удирдамж*

6.2.3. Асуултын хэлбэрүүд

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнд нээлттэй ба хаалттай асуултууд багтсан. Хаалттай асуултын хувьд ажиглагчид боломжит хариултуудаас зөвхөн нэг хариултыг сонгох шаардлагатай байв.

2.11. Security Checks / Аюулгүй байдлын шалгалт	**Were there security checks performed on all parties arriving at the court, including weapons screening? / Шүүх дээр ирж буй бүхий л талуудыг аюулгүй байдлын шалгалтаар, мөн зэвсгийн зүйлийн шалгалтаар оруулсан уу?**	☐ Yes *[2 points] / Тийм [2 оноо]*	☐ There are checks, but no weapons screening *[1 point] /* Аюулгүй байдлын шалгалт хийгдсэн гэхдээ зэвсгийн чанартай зүйл шалгаагүй *[1 оноо]*	☐ No *[0 points] / Үгүй [0 оноо]*

Зураг 3: *Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хаалттай асуултын жишээ*

Зарим хаалттай асуултуудад "хамаарахгүй" сонголтыг оруулсан бөгөөд гагцхүү шаардлагатай тохиолдолд бөглөх байсан. Нэгэнт хянан шийдвэрлэх ажиллагаанд хамааралгүй байсны улмаас шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэлийн үнэлгээг бууруулах нь оновчгүй гэж үзсэний үндсэн дээр "хамаарахгүй" сонголтыг хийсэн тохиолдолд бүтэн оноог өгөхөөр зохицуулсан. Гэхдээ энэ сонголтыг аль болохоор хязгаарлахыг зорьсон учир дараа дараагийн өгөгдлийг гажуудуулж болзошгүй (энэ нь тохиолдсон ба **12-р хэсэгт** доор авч үзсэн болно) мөн ажиглагчид өөр сонголт илүү тохиромжтой байсан ч эргэлзэж байвал тэд зүгээр л "хамааралгүй" гэсэн хариултыг сонгож хялбарчлах магадлалтай байсан.

If the court took sufficient steps or some insufficient steps to prevent or punish such behavior, describe what occurred: / Шүүхийн зүгээс арга хэмжээ авсан эсвэл үүнээс сэргийлэхээр авсан арга хэмжээ нь хангалтгүй байсан бол юу болсон тухай тайлбарлан бичнэ үү:	

Зураг 6: *Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний нээлттэй асуулт*

Зураг 6 дээр харуулсан нээлттэй асуултуудад ажиглагчид дэлгэрэнгүй хариултыг өгөх ёстой байсан. Эдгээр асуултуудаар дамжуулан хязгаарлагдах боломжгүй өөр өөр төрлийн хариултуудыг олж мэдэхээс гадна тухайн өгөгдлийг зөв зүйтэй ойлгож тодорхойлох, шалгах, дүн шинжилгээ хийхэд тохиромжтой, субъектив үнэлгээг тайлбарлахыг зорьсон билээ.

6.3. Хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээ

IDLO Mongolia DV Trial Monitoring Tool (Logbook) : ОУХЗЗБ Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэгсэл (Бүртгэлийн хуудас)

Case Code / Хэргийн код | Team Code / Багийн код

II – VICTIM'S RIGHTS / ХОХИРОГЧИЙН ЭРХ

Part / Бүлэг 2. Safety Assessment / Аюулгүй байдлын үнэлгээ

COMPLETE FOR ALL CASES / БҮХ ХЭРЭГ ДЭЭР БӨГЛӨНӨ:
SECTION A: ALL VICTIMS' SAFETY / ХЭСЭГ А: БҮХ ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

VICTIM SAFETY GENERALLY / ХОХИРОГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ- ЕРӨНХИЙ					SCORE / ОНОО	NOTES / ТЭМДЭГЛЭЛ
2.1. Risk/Threat Assessment / Аюулын эрсдэлийн үнэлгээ	Did a police officer conduct an assessment to evaluate the possible risks to the life, health and security of the victim(s)? / Цагдаагийн ажилтан хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлийг үнэлгээ хийсэн үү?		☐ Yes (2 points) / Тийм (2 оноо)	☐ No (0 points) / Үгүй (0 оноо)	☐ 2 ☐ 0	
2.2. Situational Assessment / Нөхцөл байдлын үнэлгээ	Did a social worker conduct a situational assessment to assess the risk of domestic violence, other forms of violence, other negative consequences incurred or expected by the victim(s), and the need for victim services? / Нийгмийн ажилтан гэр бүлийн хүчирхийлэл, бусад торгийн хүчирхийлэл болон өөр бусад сөрөг үр дагаварт хохирогчид бий болох аюулын эрсдэлийг үнэлгээ хийж гүнзгий, ялгуусан ажлаа гүйцэтгэсэн эсэх?	☐ Yes (2 points) / Тийм (2 оноо)	☐ No, not applicable in this case due to low/medium risk level, or victim did not give permission (2 points) / Үгүй, Хэрэгт өндөр эрсдэлтэй биш, эсвэл хохирогч зөвшөөрөгөөгүй тул хамаатай биш (2 оноо)	☐ No, despite there being a need in this case due to high risk level (0 points) / Үгүй, Эрсдэлтэй тулд гэрээ бүлийн хүчирхийлэл (0 оноо)	☐ 2 ☐ 0	
2.3. Safety Measures / Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ	At any time during the case, including immediately upon its conclusion, did the authorities impose any safety measures for the protection of the victim(s) and, if necessary, relatives of the victim(s)? / Хэрэг хянан шийдвэрлэх аль ч үе шатанд, бүхэл шүүхэр хэргийг шийдвэрлэсний дараа хамгаалах байгуулгаас, эсвэл туслалцаа, дэмжлэгтэй холбогдуулж хохирогчийн гэрэл садны хамгаалах талаар аюулгүй байдлын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн үү?	☐ Yes – select all that apply (2 points) / Тийм – хамаарах бүх зүйлийг сонгоно уу (2 оноо) ☐ Warning the accused / Шүүгдэгчид сануулах ☐ Limiting the accused's actions / Шүүгдэгчийн хөдлөлийг хязгаарлах ☐ Providing physical protection / Биеийн хамгаалалт гаргах арга хэмжээ ☐ Ensuring confidentiality of information e.g. victim's whereabouts / Мэдээлэлтэй холбогдуулан нууцлах, хохирогчийн байрлал гэх мэт ☐ Supplying personal protective equipment / Биеийн хамгаалах хэрэгсэл гаргах ☐ Temporary use of a safe house / Аюулгүй газар түр байрлуулах ☐ Relocation / Нүүлгэн шилжүүлэх ☐ Changing assets to documents / Хөрөнгөтэй холбогдуулан бичгийн баримт бичиг ☐ Changing victim's appearance (plastic surgery) / Хохирогчийн гадаад төрхийг өөрчлөх (пластик мэс засал хийх)	☐ Yes (specifically in this case – no threat to victim's safety) (2 points) / Тийм, хэрэгтэй холбогдуулан аюулгүй байдлын шаардлагатай (2 оноо)	☐ No, and there did appear to be a threat to the victim's safety (0 points) / Үгүй, хохирогчийн аюулгүй байдлыг шаардлагатай (0 оноо)	☐ 2 ☐ 0	

II – VICTIM'S RIGHTS / ХОХИРОГЧИЙН ЭРХ | Part / Бүлэг 2: Safety Assessment – Аюулгүй байдлын үнэлгээ | Page 12

Зураг 7: *Хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээний хэсгийн эхний хуудас*

Хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээ нь шүүх хуралдааны ажиглалтын 2 дугаар хэсэгт орсон бөгөөд эхний хуудсыг **Зураг 7**-т байрлуулсан. ГБХ-ийн тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтууд тухайн үнэлгээний суурь нь болсон. **Хэсэг 4.3-т** дурдсанчлан шилдэг туршлагад тулгуурлаж, эрх зүйн хийдэл, алдааг тогтоохыг зорив. Үүнд: Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Европын зөвлөлийн Истанбулын конвенц *болон* олон улсын иргэний нийгмийн болон эрдэмтдийн туршлага багтана. **Хавсралт В-д** заасанчлан тус Хохирогчийн аюулгүй байдлыг дараах байдлаар үнэлнэ. Үүнд:

- **Хохирогчийн аюулгүй байдлын ерөнхий дүр зураг**, үүнд эрсдэлийн болон нөхцөл байдлын үнэлгээ, аюулгүй байдлын арга хэмжээ ба хохирогчид учруулсан хохирол хамаарна;
- **Шүүхийн өмнөх шатны аюулгүй байдал**, үүнд мэдээллийн нууцлал, сэтгэл зүйн туслалцаа, шүүхийн өмнөх шатанд орсон сэтгэл санааны дарамтад дахин орох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ эсхүл зохих шийтгэл хүлээлгэх болон хохирогч биечлэн оролцох зэрэг асуудлууд хамаарна;
- **Шүүх дээр ирэх үеийн хохирогчийн аюулгүй байдал**, үүнд тусдаа хаалгаар оруулах, аюулгүй байдлын шалгалт, аюулгүй байдлын дагалдах ажилтнууд, байрны аюулгүй байдал, хүлээлгийн хэсгүүд, туслах, дагалдах хүмүүс, хамаарал бүхий хүмүүс ба аюулгүй байдлын мэдээлэл хамаарна;

- **Шүүх хуралдааны үеийн хохирогчийн аюулгүй байдал**, үүнд тусдаа өрөөнд мэдүүлэг өгөх, шүүх хурлын суудлын зохион байгуулалт, харц тулгарах, шүүх дээр сэтгэл санааны дарамтад дахин орох, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болон зохих шийтгэл хүлээлгэх, гэр бүлийн гишүүдийн талаар асуултуудад хариулах болон таслан сэргийлэх арга хэмжээг зөрчих хамаарна; мөн
- **Шүүхээс гарах үеийн хохирогчийн аюулгүй байдал**, үүнд ээлжлэн гаргах, гарахаас өмнөх хугацаа болон тухайн хугацааг биелүүлэх болон хохирогчийг хамгаалах аюулгүй байдлын дагалдах ажилтан.

6.4. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны карт

V – JUSTICE SECTOR SERVICE DELIVERY SCORECARD / ШҮҮХИЙН ШУДАРГА ЁСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ОНООНЫ КАРТ

Part / Бүлэг 19. Justice Sector Service Delivery Scorecard / Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны карт

VICTIMS RIGHTS / ХОХИРОГЧИЙН ЭРХ

Part / Хэсэг	Right / Эрх	Overall Grade Achieved / Нийт авсан үнэлгээ: Very Good / Маш сайн (4 points/оноо)	Good / Сайн (3 points/оноо)	Poor / Муу (2 points/оноо)	Very Poor / Маш муу (1 point/оноо)	Score/ Оноо (1-4)
2	Safety Assessment / Аюулгүй байдлын үнэлгээ	☐	☐	☐	☐	
3	Right to Relevant Information Concerning Violations and Reparation Mechanisms / Хаяг шаардах эрх, дүрэм зөрчих болон эрх сэргээлтийн механизмтай холбогдох мэдээлэл авах эрх	☐	☐	☐	☐	
4	Right to Equal and Effective Justice / Хууль, шүүхийн бойтгэлгүйгээр ур нөлөөгүй, тэгш хандах эрх	☐	☐	☐	☐	
5	Right to Adequate, Effective, and Prompt Reparation for Harm Suffered / Хүрээлэн хамгаалах хэмжээнд, ур дүнтэй арга замаар, нарийтай нөхөн төлөгдөх эрх	☐	☐	☐	☐	
					Total Score (out of 16) / Нийт оноо (max 16)	

OVERALL GRADE / НИЙТ ОНОО VICTIM'S RIGHTS / ХОХИРОГЧИЙН ЭРХ	☐ Very Good / Маш сайн (13-16 points/оноо)	☐ Good / Сайн (9-12 points/оноо)	☐ Poor / Муу (5-8 points/оноо)	☐ Very Poor / Маш муу (0-4 points/оноо)

Зураг 8: *Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картын эхний хуудас*

Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картын харагдах хэлбэрийг **Зураг 8**-д дээр байрлуулсан. Үүгээр ГБХ-ийн зөрчлийн болон эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны шинж, хэлбэрийг Монгол Улсын болон олон улсын хууль тогтоомжийн стандарт, эсхүл хохирогчдын аюулгүй байдлыг хангах шилдэг туршлагад нийцэж буй эсэхийг онооны системээр үнэлсэн. Хэргийн аспект тус бүр хэргийг хянан шийдвэрлэсэн хууль зүйн салбарын үйлчилгээний нийт чанарт өөр өөр үр дүн үзүүлж болзошгүй боловч тухайн аспект тус бүрд өгч болох оноонуудыг ижилхэн жигнэлээ. Ингэсэн шалтгаан нь нэг хэргийн аспект тус бүрд өөр өөр оноо өгч, үнэлгээг хийсэн бол үйл ажиллагааны цаг хугацаа, нөөц бололцоо нь хүрэлцэхгүй, үйл ажиллагаа нь илүү нарийн түвэгтэй болох байв. Энэ аргачлалыг гүйцэтгэхэд тулгарсан саад бэрхшээл, үр нөлөөг дор **Хэсэг 12**-т нарийвчлан тусгалаа.

Оноонуудыг зөвхөн хаалттай асуултуудад өгөхөөр зохицуулсан. Асуултын сонголт тус бүрд, тухайн асуултад өгч болох оноонуудыг хажууд нь заасан. Ажиглагчид холбогдох хариултыг сонгоод баруун гар талын баганад байгаа онооны хайрцагт тэмдэглэнэ. (**Зураг 9**)

COMPOSITION OF THE COURT / ШҮҮХ БҮРЭЛДЭХҮҮН				SCORE / ОНОО
6.1. Right to Challenge Composition / Шүүх бүрэлдэхүүнээс татгалзах эрх	Was the accused's right to challenge the composition of the judges explained by one of the judges? / Шүүх бүрэлдэхүүнээс татгалзаж болох яллагдагчийн эрхийг шүүгчдийн зүгээс тайлбарлаж өгсөн үү?	☑ Yes [2 points] / Тийм [2 оноо]	☐ No [0 points] / Үгүй [0 оноо]	☐ 2 ☑ 0

Зураг 9: Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний онооны асуулт

Асуудал тус бүрд зөвхөн нэг удаа оноо өгнө. Тиймээс, тухайн асуудлын талаарх нэмэлт мэдээлэл лавласан хяналтын асуултад оноо өгөөгүй билээ. **(Зураг 10).**

10.4. Requests in Court / Шүүхэд хүсэлт гаргах	Was anything said during the hearing, or did anything happen, to suggest that the defense or prosecution was denied the opportunity to make requests in court? / Хэлэлцүүлгийн үеэр яллах болон емгөөлөх талын зүгээс шүүхэд хүсэлт гаргах эрхийг хязгаарласан гэх зүйл яригдсан эсвэл тохиолдсон уу?	☐ No [2 points] / Үгүй [2 оноо]	☐ Yes (select which parties had this opportunity denied): [0 points] / Тийм (Хүсэлтээ хязгаарлуулсан талыг сонгоно уу): [0 оноо] ☐ Prosecutor / Яллах тал ☐ Defense / Яллагдагчийн емгөөлөгч	☐ 2 ☐ 0
	What was said or what happened: / Юу гэж тайлбарласан, юу тохиолдсон:	Select all that apply: / Хамаарах хариултыг сонгоно уу: ☐ The judge announced that one or more parties would not have such opportunity or did not provide such opportunity / Шүүгчийн зүгээс аль нэг талд энэхүү боломж хаалттай хэмээн зарласан эсвэл тухайн боломжийг хангаж өгөөгүй ☐ A party's application to make a request was denied / Хүсэлт гаргах талын хүсэлтийн хангаагүй ☐ A party commented on the inability to make requests / Оролцогч талын зүгээс хүсэлт гаргах боломжгүй бүй талаар тайлбар гаргасан ☐ Other – please specify / Бусад – дурдана уу		

Зураг 10: Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний оноогүй хяналтын асуултууд

Ажиглагчид шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний оноотой асуулттай хэсгийн төгсгөлд тухайн хэсэгт өгсөн оноонуудын нийлбэрийг тооцоолж гаргах ёстой байв. Эдгээр оноонуудыг нэн ялангуяа олон хэсгүүдтэй эсхүл тухайн хэргийн нөхцөлөөс хамаарч зөвхөн заримыг нь бөглөх ёстой бол хэрхэн тооцож бодох талаар нарийвчилсан зааврыг өгсөн. Үүнийг доор **Зураг 11**-т танилцуулав.

Mongolia DV Trial Monitoring Tool (Logbook) / Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (Бүртгэлийн хуудас)

Case Code / Хэргийн код | Team Code / Багийн код

JUSTICE SECTOR SERVICE DELIVERY SCORECARD CALCULATION / ШҮҮХИЙН ШУДАРГА ЕСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ОНООНЫ КАРТЫН ТООЦООЛОЛ						
Victim's Right to Equal and Effective Access to Justice / Хууль, шүүхийн байгууллагад тэгш бөгөөд үр нөлөөтэй хандах эрх						
If the victim did not attend the court hearing, complete only Score A. If the victim attended the court hearing, complete Score A and Score B. / Хэрэг хохирогч нь шүүх хуралдаанд оролцоогүй бол зөвхөн Оноо А-г бөглөнө. Хэрэг хохирогч шүүх хуралд оролцсон бол Оноо А болон Б-г бөглөнө.						
Score A / Оноо А Section A: Victim's Access to Justice Generally (All Cases) / Хэсэг А: Хууль, шүүхийн байгууллагад хандах хохирогчийн эрх (Бүх хэрэг дээр) (out of 16): / (Нийт 16 оноо):		Score B / Оноо Б Section B: Victim's Access to Justice in Court / Хэсэг Б: Шүүх дээр шударга ёсны үйчилгээ авах хохирогчийн эрх (out of 24): / (Нийт 24 оноо):		☐ Not applicable / Хамаарагүй		
If the victim attended the court hearing, complete Option 1. If the victim did not attend the court hearing, complete only Option 2. / Хэрэг хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт оролцсон бол Сонголт 1-ыг бөглөнө. Хэрэг хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт биечлэн оролцоогүй бол зөвхөн Сонголт 2-ыг бөглөнө.						
OPTION 1: TOTAL SCORE / СОНГОЛТ 1: НИЙТ ОНОО YES, VICTIM(S) DID ATTEND COURT / ТИЙМ, ХОХИРОГЧ ШҮҮХ ХУРАЛД ОРОЛЦСОН						
Total Score = A+B / Нийт оноо = A + B (out of 40): / (Нийт 40 оноо):		Grade: / Үнэлгээ:	☐ Very Good / Маш сайн (31-40 points / оноо)	☐ Good / Сайн (21-30 points / оноо)	☐ Poor / Муу (11-20 points / оноо)	☐ Very Poor / Маш муу (0-10 points / оноо)
OPTION 2: TOTAL SCORE / СОНГОЛТ 2: НИЙТ ОНОО NO, VICTIM(S) DID NOT ATTEND COURT / ҮГҮЙ, ХОХИРОГЧ ШҮҮХ ХУРАЛД ОРОЛЦООГҮЙ						
Total Score = A / Нийт оноо = A (out of 16): / (Нийт 16 оноо):		Grade: / Үнэлгээ:	☐ Very Good / Маш сайн (12-16 points / оноо)	☐ Good / Сайн (9-12 points / оноо)	☐ Poor / Муу (5-8 points / оноо)	☐ Very Poor / Маш муу (0-4 points / оноо)

Зураг 4: *Сонголтын хэсэг дэх шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний оноог тооцох аргачлал*

Ажиглагчид нийт оноог тооцсоны дараа ажигласан хэргийн тухайн хэсэгт өгөх үнэлгээг тэмдэглэх ёстой байв. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрх тус бүрд үнэлгээ өгөхөд “Маш сайн”, “Сайн”, “Муу” ба “Маш муу“гэсэн дөрвөн үнэлгээний хувилбарт хэмжүүрийг ашигласан болно. Тодорхой эрхэд хамаарах үнэлгээг нийт тооцсон оноогоор шууд бодсон бөгөөд эрх тус бүрийн нийт оноог 4-т хуваахад боломжтой байхаар хийсэн бөгөөд эдгээр дөрвөн үнэлгээ бүр нь бүх боломжит онооны дөрөвний нэгийг илэрхийлнэ. Тухайлбал, дор үзүүлж буй **Зураг 12**-т 27 оноо авсан бол энэ нь 21-30 оноонд хамаарах тул “Сайн” үнэлгээг авах юм.

Total Score = A+B / Нийт оноо = А + Б (out of 40): / (Нийт 32 оноо):	27	Grade: / Үнэлгээ:	☐ Very Good / Маш сайн (31-40 points / оноо)	☑ Good / Сайн (21-30 points / оноо)	☐ Poor / Муу (11-20 points / оноо)	☐ Very Poor / Маш муу (0-10 points / оноо)

Зураг 12: *Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний картын үнэлгээг тооцох аргачлал*

Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар бүх хохирогчийн эрхийн болоод шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилтийн нийт үнэлгээг гаргасан. Эдгээр үнэлгээг шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний туршид эрх тус бүрд өгсөн үнэлгээний функц болгон шууд ашигласан. Үүнийг дор **Зураг 13**-т Хохирогчийн эрхийн жишээ болгон харуулав.

VICTIM'S RIGHTS / ХОХИРОГЧИЙН ЭРХ						
Part / Хэсэг	Right / Эрх	Overall Grade Achieved / Нийт авсан үнэлгээ				Score/ Оноо (1-4)
		Very Good / Маш сайн [4 points/ оноо]	Good / Сайн [3 points/ оноо]	Poor / Муу [2 points/ оноо]	Very Poor / Маш муу [1 point/ оноо]	
2	Safety Assessment / Аюулгүй байдлын үнэлгээ	☐	☐	☐	☐	
3	Right to Relevant Information Concerning Violations and Reparation Mechanisms / Хэрэг шалгах явц дахь зөрчил болон арга хэмжээний механизмуудын талаарх мэдээлэл авах хохирогчийн эрх	☐	☐	☐	☐	
4	Right to Equal and Effective Justice /Хууль зүйн туслалцаа авах эрх	☐	☐	☐	☐	
5	Right to Adequate, Effective, and Prompt Reparation for Harm Suffered / Учруулсан хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй арга замаар, яаралтай нөхөн төлүүлэх эрх	☐	☐	☐	☐	
					Total Score (out of 16) / Нийт оноо (нийт 16)	

OVERALL GRADE: / Нийт оноо VICTIM'S RIGHTS / ХОХИРОГЧИЙН ЭРХ	☐ Very Good / Маш сайн (13-16 points/оноо)	☐ Good / Сайн (9-12 points/оноо)	☐ Poor / Муу (5-8 points/оноо)	☐ Very Poor / Маш муу (0-4 points/оноо)

Зураг 13: *Хохирогчийн нийт эрхийн хэрэгжилтийн үнэлгээний онооны нэгтгэл*

6.5. Шүүхийн ажиглагчийн гарын авлага

Сургалтын үеэр хэрэглэх Монгол хэл дээрх Шүүхийн ажиглагчийн гарын авлагыг ажиглагчдад тараасан. Тус гарын авлага нь дараах зүйлээс бүрдсэн. Үүнд: ажиглалтын аргачлал, хэрэглэгдэхүүний тайлбар, ажиглах явцад анхаарах зүйлс (**Хавсралт Г**), тэмдэглэл хийх загвар (**Хавсралт Д**), ажиглагчийн ёс зүйн дүрэм (**Хавсралт Е**) болон олон улсын эрх зүйн актын холбогдох зүйл заалтууд юм. Эдгээр эрх зүйн баримт бичигт ИБУТЭТОУП-ын 14-р зүйл болон тус зүйл заалтыг тайлбарласан НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 32-р *Ерөнхий Тайлбар* багтаж байна.

Зураг 14: *Гарын авлага, ажиглалт хийх зүйлсийн жагсаалт*

Үүнээс гадна ажиглагчдад зөвхөн Монгол хэл дээр Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хэвлэмэл хувилбарыг ажлыг хэрэгцээнд зориулж өгсөн.

6.6. Google маягт

Зураг 6: *Google маягтын хэсгээс*

Google маягтыг Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хэвлэмэл хувилбарын агуулгатай ижилхэн байхаар боловсруулж, цахимаар үүлэн технологид суурилсан хэлбэрт оруулсан билээ. Google маягт нь түүвэрлэсэн загваруудын бүх өгөгдлийг төвөөс нэвтэрч авах зориулалттай хийгдсэн бөгөөд ингэхдээ өгөгдлийн багцын нийлбэрт дүн шинжилгээ, харьцуулалтыг хийх боломжийг олгох юм. Ажиглагчид бөглөсөн ажиглалтын хэрэглэгдэхүүний хэвлэмэл хувилбарыг хүлээлгэн өгсний дараа өгөгдөл оруулах ажилтан бүх өгөгдлийг Google маягтад оруулж, шүүх хуралдааны ажиглалтын багуудаас шаардлагатай тохиолдолд тодруулга авч байсан билээ.

Google маягтын үзүүлэлтүүд нь өгөгдлийг илүү үнэн зөв, баталгаатай болгоход чиглэсэн тодорхой загварын үзүүлэлтүүдийг нэмж оруулах үйлдэлтэйгээр хийгдлээ. Тодруулбал, зайлшгүй хариулах асуултуудыг тодорхойлох аль эсхүл илүү баталгаатай өгөгдлийг хадгалах,

өгөгдөл алдагдах, мөн өгөгдөл оруулахад алдаа гарахаас сэргийлэхтэй холбоотойгоор хариулахад шаардлагатай нэмэлт нөхцөлтэй асуултуудыг тогтоох зэрэг үйлдлүүд багтана. Цаашлаад түүний цахим хэлбэр нь шаардлагатай тохиолдолд өгөгдлийг шинэчлэх ажлыг хялбаршуулсан.

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний бүх асуултууд болон бүх хаалттай хариултын хувилбаруудыг хоёр хэл дээр Google маягтад жагсааж оруулснаар үйл ажиллагааны баг дараачийн өгөгдлийг ашиглах явцад мэдээллийг орчуулах шаардлагыг багасгаж, хугацаа алдахаас сэргийлэхийн зэрэгцээ буруу зөрүү орчуулгын улмаас өгөгдөл алдагдахаас хамгаалж чадсан билээ. Үүний нээлттэй асуултын хариултуудыг хоёр хэлтэй өгөгдлийг оруулах хүн орчуулж оруулсан юм.

Харамсалтай нь Google маягтын загвар хязгаарлалттай байсан тул шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг бүхэлд нь нэг хэлбэрт оруулах боломжгүй байв. Улмаар шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн нь нарийн түвэгтэй, урт учраас таван Google маягтыг үүсгэх шаардлага гарсан юм.

7. Үйл ажиллагааны баг

Шүүх хуралдааны ажиглагчид

Төсөл хэрэгжүүлэх нэгж болон үндэсний ахлах зөвлөхийн хамтаар иргэний нийгмийн төлөөлөгчдөөс гадна өмгөөлөгчид, хуулийн салбарын төлөөлөгчид (үүний дотор хуульчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй эрх зүйчид багтана), хууль зүйн сургуулийн төгсөгчдөөс бүрдсэн нийт 34 ажиглагчдыг сонгон шалгаруулав. Шүүх хуралдааны ажиглагчдыг **Хүснэгт 4**-д заасан сонгон шалгаруулалтын шалгуурын дагуу сонгосон болно.

ИНБ-ын төлөөлөгчид	Өмгөөлөгчид, хуулийн салбарын төлөөлөгчид ба хууль зүйн сургуулийн төгсөгчид

• Жендерт суурилсан хүчирхийлэл/ГБХ болон ойролцоо чиглэлээр үйл ажиллагаа идэвхтэй явуулдаг, Улсын бүртгэлтэй иргэний нийгмийн байгууллагад ажилладаг; • Жендерт суурилсан хүчирхийлэл/ГБХ болон ойролцоо чиглэлд 2 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай; • 20 ажлын хоног буюу 2020 оны 5-р сараас 11-р сарын хооронд ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийг шүүхэд хянан шийдвэрлэх 4 шүүх хуралдаанд ажиглалт хийж, шүүхэд тогтсон цагт очиж ажиллах боломжтой байх; • Шаардлагын дагуу богино хугацаанд, үр бүтээлтэй ажиллах чадвартай байх; • Багаар ажиллах сонирхолтой бөгөөд туршлагатай байх; • Бичгийн болон харилцааны өндөр чадвартай байх.	• Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн; • Жендерт суурилсан хүчирхийлэл/ГБХ, хүний эрх эсхүл эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйн чиглэлээр сонирхолтой, энэ чиглэлээр үйл ажиллагаанд хамрагдаж байсан; • 20 ажлын хоног буюу 2020 оны 5-р сараас 11-р сарын хооронд ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийг шүүхэд хянан шийдвэрлэх 4 шүүх хуралдаанд ажиглалт хийж, шүүхэд тогтсон цагт очиж ажиллах боломжтой байх; • Хууль зүйн клиникийн туршлагатай бол давуу тал болно; • Шаардлагын дагуу богино хугацаанд, үр бүтээлтэй ажиллах чадвартай байх; • Багаар ажиллах сонирхолтой бөгөөд туршлагатай байх; • Бичгийн болон харилцааны өндөр чадвартай байх. • Microsoft болон имэйлийн программыг сайтар эзэмшсэн байх.

Хүснэгт 4: *Шүүх хуралдааны ажиглагчдыг сонгон шалгаруулах үзүүлэлтүүд*

Ийнхүү тус баг 15 өмгөөлөгчид, хуулийн салбарын төлөөлөгчид, хууль зүйн сургуулийн 2 шинэхэн төгсөгчид (нэг нь мэдээлэл технологийн чадвар, англи хэлний маш сайн мэдлэгтэй, нөгөө нь казак үндэстэн тул казакуудын оролцсон, Казак хэл дээр явагдсан шүүх хуралдаануудыг ажиглах боломжтой гэх шалтгаанаар сонгогдсон); бөгөөд ГБХ, жендерт суурилсан хүчирхийлэл ба эрүүгийн эрх зүйн мэдлэг, туршлагад нь үндэслэн сонгосон иргэний нийгмийн байгууллагуудын 17 төлөөлөгчөөс бүрдсэн. Ажиглагчдын мэргэжил, хүйсийн мэдээллийг **Дүрс 5**-д харуулав.

Дүрс 5: *Шүүх хуралдааны ажиглагчид: мэргэжил ба жендерээр*

Үйл ажиллагааны анхны загварын дагуу хэрвээ сонгогдсон ажиглагч ажиллах боломжгүй эсхүл хангалтгүй ажилласан тохиолдолд орлуулах боломжтой шүүх хуралдааны ажиглагчдын нөөц бүрдүүлэхээр төлөвлөж байсан. Шүүх хуралдааны ажиглагчдад цалин хөлс өгөх шийдвэрийг гаргасан тул төсөв нь хязгаарлагдмал болохын зэрэгцээ ийм их нэр дэвшигчдээс сонгон шалгаруулалт хийхэд зохион байгуулалтын хувьд боломж хомс, мөн аймгуудад шалгуурыг хангахуйц зохих туршлага, мэдлэгтэй нэр дэвшигчдийг олоход хүндрэлтэй байсан тул энэ

санааг орхисон билээ. Ийм ч учраас нийт 34 шүүх хуралдааны ажиглагчдыг (Зураг 16) оролцуулахаар шийдвэрлэсэн бөгөөд өөр нөөц байхгүй байв.

Зураг 7: *Албан ёсны шүүх хуралдааны ажиглалтын баг ба төслийн баг*

Ажиглагчдыг 17 багт хуваах, нэг багт нэг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгч, нэг эрх зүйч буюу нийтдээ 2 хүний бүрэлдэхүүнтэй байхаар зохион байгуулав. Дээр нарийвчлан тайлбарласанчлан баг тус бүрд төлөөллийг хангах үүднээс мэдлэг ур чадвар, ажил мэргэжлийн туршлагыг нь харгалзан үзсэн. **Дүрс 6**-д шүүх хуралдааны ажиглалтын багуудыг улсын хэмжээнд ажиглалт хийхэд хэрхэн хуваарилж зохицуулсныг харж болно.

Дүрс 6: *Шүүх хуралдааны ажиглалтын багын бүтэц*

Жендерийн тэнцвэрийн хувьд, сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчид болон төслийн багийн эмэгтэйчүүдийн тоо хавьгүй их буюу 25 эмэгтэйчүүд байсан бол нийт 9 эрэгтэйчүүд байсан. Тал хувь нь 40-өөс доош насны байсан бол үлдсэн нь 41-ээс 60 насны хооронд байв. Энэ харьцуулалтыг дор **Дүрс 7** -т харуулж байна.

Дүрс 7: *Шүүх хуралдааны ажиглагчид: нас ба жендер*

Нийт 34 ажиглагчдын 44 хувь нь дээд боловсролтой, 50 хувь нь магистр эсхүл түүнтэй адилтгах зэрэг хамгаалсан байгаа бол 6 хувь нь доктор ба түүнтэй адилтгах зэрэгтэй байна. Шүүх хуралдааны ажиглагчдыг боловсролын хамгийн өндөр түвшингээс нь эхлэн жендерээр ангилан жагсаасныг **Хүснэгт 5** –т харуулав.

	Хамгийн өндөр боловсролын түвшин							
	Их дээд сургууль	**Бакалавр эсхүл түүнтэй тэнцэх зэрэг**		**Магистр эсхүл түүнтэй тэнцэх зэрэг**		**Доктор эсхүл түүнтэй тэнцэх зэрэг**		
Зэргийн төрөл		Хууль тогтоомж	Бусад	Хууль тогтоомж	Бусад	Хууль тогтоомж	Бусад	**Нийт**
Жендер								
Эм	0	6	4	5	8	2	0	**25**
Эр	0	4	1	2	2	0	0	**9**
Нийт	0	10	5	10	7	2	0	**34**
Нийт хувь	**0 (0%)**	**15 (44%)**		**17 (50%)**		**2 (6%)**		

Хүснэгт 5: *Шүүх хуралдааны ажиглагчдын боловсрол, жендерийн мэдээлэл*

8. Туршилтын шат

8.1. Үндэслэл

Ажиглалтын хэрэглэгдэхүүн ба аргачлалыг тусгайлан боловсруулж, туршиж үзээгүй байсан тул түүнийг шалгахаар туршилтын үе шатыг эхлүүлсэн юм. Туршилтын зорилго нь тухайн ажиглалтын хэрэглэгдэхүүн, түүний аргачлал болоод сургалтын аргачлалын загварт шаардлагатай засвар, нэмэлт өөрчлөлтийг оруулж, улмаар цуглуулах албан ёсны өгөгдлийг чанартай, найдвартай, цаг үеэ олсон, нарийн тодорхой, үнэн зөв байх байдлыг нэмэгдүүлэхэд оршиж байсан.

8.2. Хамрах хүрээ

Төслийн зорилтот шүүхүүдээс дараах гурван шүүхийг сонгож, туршилт хийхээр болсон. Үүнд: Улаанбаатар хотын Баянзүрх, Налайх дүүргийн шүүхүүд болон Төв аймгийн шүүх. **Хүснэгт 6**-д сонгож авсан үндэслэлийг харна уу.

Газар зүйн байрлал	Улаанбаатар ба аймгаас (орон нутаг) сонгогдсон шүүхүүд нь үйл ажиллагааны хосолмол зорилгыг илэрхийлсэн.
Бат бэх хамтын ажиллагаа	ОУЭЗХБ болон туршилтын шүүхүүдийн ажилтнуудын хооронд өмнө тогтсон харилцаа нь (зарим нь ОУЭЗХБ-ын сургагч багш) шүүхүүдийг сонгоход нөлөөлсөн ба ингэхдээ оролцогч байгууллагуудтай үйл ажиллагаанд баримтлах зарчмыг харилцан тохирч хийв.[12]
Хүн ам зүй	Тус шүүхүүдийг сонгосноор нийт хамрах хүрээний хэмжээнд эдийн засгийн давуу болон сул тал, үндэстний цөөнхийн төлөөлөл зэрэг хүн ам зүйн хэд хэдэн үзүүлэлтийг хамрах боломж бүрдсэн. Жич.: Налайх дүүрэгт Казак үндэстнүүд нэлээд их бий.
Логистик/төсөв	Сонгогдсон шүүхүүд бүгд Улаанбаатар хот дахь ОУЭЗХБ-ын оффистой харьцангуй ойрхон байсан тул тухайн шүүхүүдэд төслийн ажилтнууд ба ажиглагчид удаа дараа очих, туршилтын багийн ойр ойрхон биечлэн уулзах боломжийг олгосон.

Хүснэгт 6: *Туршилтад хамрагдах шүүхийг сонгосон шалгуур үзүүлэлтүүд*

Туршилтын багийн бүрэлдэхүүнд шүүх хуралдааны ажиглалт хийх нэр дэвшигчдээс найман хүнийг сонгосон бөгөөд тэд төслийн албан ёсны шүүх хуралдааны ажиглагчдаар мөн ажилласан. 2020 оны 6 дугаар сарын 16-наас 7 дугаар сарын эхэн хүртэл (нэг шүүх хуралдаан нь 8 дугаар сарын эхээр дууссан), тухайн багууд туршилтын шүүхүүд дэх зөрчил болон эрүүгийн шүүх хуралдаануудад ажиглалт хийв. ГБХ-ийн хэрэгтэй танилцахад гарах саад бэрхшээлүүд болон шүүхүүд дэх ГБХ-ийн хэргийн тоо хязгаарлагдмал байсны улмаас зөвхөн хоёр хэргийн шүүх хуралдааныг биечлэн очиж ажиглахаас илүүтэйгээр хуралдааны видео бичлэгийг үзэх аргаар зайнаас ажиглалт хийсэн.

Зураг 8: *Туршилтын баг ба сургагч багш нар*

Туршилтад давж заалдах шатны хуралдааны ажиглалтыг төлөвлөөгүй, учир нь давж заалдах шатны шүүхүүдтэй ажиллахад нэмэлт цаг хугацаа шаардагдах байсан билээ. Түүнчлэн тухайн үйл ажиллагааны хүрээнд ажигласан хэрэгт ГБХ-ийн хэргийн бүх л хүрээг бүрэн төлөөлж чадна гэсэн баталгаа байгаагүй. Энэ нь нэг талаараа хамрах хүрээнд их хэмжээний ГБХ-ийн хэргүүд хамаарч байсан, нөгөөтэйгүүр туршилт хийх хугацаа нь Улсын их хурлын сонгуулийн

[12] Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, *Шүүх хуралдааны ажиглалт: Гүйцэтгэгчид зориулсан гарын авлага*, засварласан хэвлэл (Варшав хот, ЕАБХАБ, 2012), х. 18-20.

хугацаатай яг таарч байна гэх шалтгаанаар гурван туршилтын шүүхүүд дэх хянан шийдвэрлэх ГБХ-ийн хэргүүдийн тоо нэлээд их буурсантай холбоотой юм.

8.3. Сургалт

Туршилтын ажиглагчид 2020 оны 6 дугаар сарын 2-3-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо бэлтгэл ажлын сургалтад оролцсон. Хэдийгээр албан ёсны сургалтыг гурван өдрийн хугацаатай зохион байгуулахаар төлөвлөж байсан ч сургалтыг ердөө хоёр өдөрт зохион байгуулав. Үүний шалтгаан нь цаг хугацааны хязгаарлагдмал байдал, туршилтын багийн туршлага, мэдлэг, ур чадвар болон ажиглалтын хэрэглэгдэхүүнийг төдийгүй сургалтын аргачлалыг сайжруулах зэрэг туршилтын өөрийнх үндсэн зорилгод оршино.

Ажиглагчдыг бэлтгэх сургалт нь ЖСХ болон ГБХ-ийн талаарх түгээмэл ойлголтыг өгөх, Монгол Улсын ГБХ-ийн асуудалд хохирогч-төвтэй болон жендерийн мэдрэмжтэй хандлагыг бий болгох зорилготой байсан**.** Бэлтгэл сургалтын зорилго нь ажиглагч нарт ГБХ, ЖСХ-ийн талаар нэгдмэл ойлголт өгөх, Монголд үйлдэгдэж буй ЖСХ-ийн нөхцөл байдалд тохирсон хохирогч төвтэй, жендерийн мэдрэмжтэй хүлээн зөвшөөрөгдсөн хандлага, арга замыг бий болгохыг зорьсон юм.

Энэхүү сургалтаар ГБХ-тэй тэмцэхэд хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, оролцоог судалсан. Мөн ажиглагчдад хэрэглэгдэхүүний нэр томьёоны тодорхойлолт, онооны шалгуур болон эрх зүйн үндэслэл мөн хэрхэн ойлгож хэрэглэх түүнчлэн засаж сайжруулахад өөрсдийн санал зөвлөмжийг өгөх боломжийг олгосон. Үүнээс гадна ажиглагчид нийт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны алхмуудын зураглалыг гаргаснаар нэгдсэн ойлголттой болохоос гадна бүх 34 ажиглагчдад тараах сургалтын материалын нэг хэсэг болсон юм.
Туршилтын сургалтад насанд хүрэгсдийг сургах аргачлалыг баримталж, ажиглагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар дээр үндэслэн “хамтран заах” аргачлалыг ашигласан болно. Сургалтад багийн ажил, багийн хэлэлцүүлэг, мини лекц, бие даалт, санал асуулга, тэмдэглэл унших болон асуулт хариулт зэрэг тодорхой аргуудыг ашигласан.

Зураг 9: *Туршилтад бэлтгэх сургалт, 2020 оны 6 сарын 02, Улаанбаатар хот*

ОУЭЗХБ-ын боловсролын чиглэлээр докторын зэрэгтэй арга зүйн зөвлөх үндэсний ахлах зөвлөхийн хамтаар нийт сургалтын үйл ажиллагааг хариуцаж ажилласан. Сургалтын модулийг хүний эрхийн хуульч, цагдаагийн газрын ГБХ-тэй тэмцэх хэлтсийн дарга, прокурор болон нэг туршилтын шүүхийн Ерөнхий шүүгч гэсэн дөрвөн мэргэжилтэн нар боловсруулсан. Долоон сургагч багш, зохион байгуулагчдаас тав нь эмэгтэй, хоёр нь эрэгтэй байсан.
Сургалтыг бүхэлд нь монгол хэл дээр явуулж, олон улсын зөвлөхийн сургалтын видео бичлэг, материалыг англи хэлнээс урьдчилаад орчуулсан байсан бөгөөд ОУЭЗХБ-ын суурин төлөөлөгчийн мэндчилгээг мөн оролцогчдод орчуулж хүргэсэн.

8.4. Туршилтын аргачлал

Зураг 10: Төв аймгийн шүүхтэй хийсэн танилцах уулзалт

Төслийн зөвлөхүүд болон ажиглагчид ажиглалтыг эхлэхээс өмнө туршилтын шүүх тус бүр дээр очиж, шүүхийн ажилтнуудтай танилцах уулзалтыг хийсэн. Ажиглагчид анх цахимд байршуулсан шүүх хурлын товыг харж байгаад хэргүүдээ сонгох оролдлого хийсэн боловч мэдээллийн бүрэн бус байдлын улмаас шүүхүүдтэй тогтмол харьцахаас өөр аргагүйд хүрчээ. Зарим ажиглагчид Зөрчлийн хэргийн хуралдаан болдог өдрүүдэд ажиглалт хийх боломжийг таамаглан очиж байсан. Хэдийгээр шүүхийн зүгээс ажиглагчдад туслах зорилгоор шүүх хуралдааны товыг мэдэгдэж байсан ч тэдний зүгээс ажиглалт хийх хэргийг сонгох шийдвэрт нөлөөлөл үзүүлээгүй нь ач холбогдолтой байсан.

Ажиглагчид хамгийн анх хэрэгтэйгээ шүүхийн хуралдаан дээр танилцсан. Зайнаас ажигласан хэргүүдийн хувьд, шүүх шийдвэрээ гаргаснаас хойш, ажиглагчдад шүүх дээр очиж, хавтаст хэрэг, видео бичлэгтэй танилцах боломж нээгдсэн юм.

Туршилтын үеэр ажиглагч тус бүр монгол/англи хэл дээрх хэвлэмэл шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг бөглөсөн. Мөн 2 хүний бүрэлдэхүүнтэй баг өөрсдийн хариултуудыг нэгтгэхийн тулд тэмдэглэлээ харьцуулж ажилласан. Сургалтын арга зүйн зөвлөх болон үндэсний ахлах зөвлөх ажиглалтын үе шат бүрийн дараа ажиглагчдын туршлага солилцох уулзалтыг зохион байгуулсан. Тэд эдгээр хуралдаанд оролцож, өөрсдийн санал, туршлагаа харилцан солилцож, нэг нэгэндээ зөвлөгөө өгч ажилласан.

Зураг 11: Туршилтын шатны багийн уулзалт

Түүнчлэн ажиглагчид үнэлгээний аргачлалуудтай нийцүүлэн хариултуудыг засаж залруулах, талбарын туршилт дээр үндэслэн хэрэглэгдэхүүн болон арга зүйд оруулах нэмэлт өөрчлөлтүүдийг санал болгож ажиллав. Ийнхүү хэрэглэгдэхүүн ба аргачлалыг нэн даруй шинэчилж, ажиглах дараагийн хэргүүд дээр дахин туршилт хийж, дараа дараагийн хэлэлцүүлэгт илүү боловсронгуй болгох ажлуудыг хийж байлаа. Бүх хэргүүдийг ажиглаж, хэрэглэгдэхүүнд оруулах өөрчлөлтүүдийг харилцан тохирч, хэрэгжүүлсний дараагаар ажиглагчид бүх хэргүүдийн өгөгдлийг Google маягтад оруулсан юм.

Олон улсын зөвлөх нь тодорхой эсхүл сэжигтэй алдааг олж тогтоохын тулд туршилтын өгөгдлийн санд эхний чанарын хяналтыг хийж гүйцэтгэсэн. Үүний дараа тус хяналтын үр дүнгийн талаар ажиглагчид үндэсний ахлах зөвлөхтэй хэлэлцээд өөрсдийн бөглөсөн хэрэглэгдэхүүнийг өгч, түүний дагуу зөвлөх Google маягтад шаардлагатай засварыг оруулах боломжтой болсон. Тэрбээр нэмэлт алдааг засаж, чанарын хяналтын хоёр дахь шалгалтыг нэгэн зэрэг хийжээ. Оруулсан өгөгдлийг боловсруулах явцад зарим өгөгдлийг алдаатай оруулсан нь тогтоогдож, үндэсний ахлах зөвлөх ба олон улсын зөвлөх гурав дахь удаагийн

хяналтыг хамтран гүйцэтгэсэн. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх явцад оруулсан мэдээлэлд зөрүү ажиглагдахад үндэсний ахлах зөвлөх, олон улсын шинжээч нар гурав дахь удаагийн хяналтыг хийсэн.

Түүнчлэн туршилтын багийн гишүүд туршилтын шатад цаг тухайд нь өөрсдийн саналыг өгөхөөс гадна багийн гишүүн тус бүр туршилтын үйл ажиллагааны үр дүн, ашигласан хэрэглэгдэхүүний талаар санал бодлоо бичгээр илэрхийлсэн. Үүнээс гадна тэд ОУЭЗХБ-ын TIMS сургалтын үнэлгээний хэрэглэгдэхүүнийг ашиглан сургалтын модуль тус бүрийн талаар өөрсдийн дэлгэрэнгүй үнэлгээг өгсөн.

8.5. Үр дүн

8.5.1. Ажиглалтын зорилтууд

Хэдийгээр товлогдсон шүүх хуралдааныг ажиглах үйл ажиллагаанд тодорхой саад бэрхшээлүүд үүсэж байсан боловч (туршилтын хугацаанд Улсын их хурлын сонгууль болсон), ажиглагчид зургаан зөрчил болон дөрвөн эрүүгийн хэргийн гээд нийт 10 хэргийг амжилттай ажиглаж чадсан билээ. Энэ нь анх зорьж байсан найман хэргээс давсан үзүүлэлт юм. Ажиглалтын баг тус бүр, багууд хоорондоо, зорилтот шүүхийн ажилтнуудтай гайхалтай сайн хамтарч ажилласан гэж дүгнэж болно.

8.5.2. Хэрэглэгдэхүүн ба аргачлал

Хэрэглэгдэхүүнд туршилт хийсний үр дүнд дөрвөн төрлийн сайжруулалтыг хийсэн.

Зураг 12: *Туршилтын шатны хэрэглэгдэхүүнийг сайжруулах явц*

1. Хэрэглэгдэхүүний **монгол хэл дээрх орчуулгыг** зөвлөхөөр хянуулж, бүх хууль зүйн нэр томьёоны тодорхойлолт төдийгүй асуултуудыг илүү ойлгомжтой болгохын тулд өгүүлбэрийн бүтцийг ч гэсэн нарийвчлан хянаж зассан.
2. **Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг** нэмж оруулав. Төслийн оролцогч талууд төслийн загвар боловсруулах үеэр тус хуулийг харгалзаж үзээгүй байсан боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн маш олон (бүгд биш ч гэсэн) зохицуулалтууд зөрчилд хамаарч байгаа тул оруулахаар шийдвэрлэв.
3. **“Хамааралгүй”** сонголтын хувилбарыг хэд хэдэн нэмэлт асуултуудад ажиглагчдын хүсэлтээр нэмсэн бөгөөд ингэхдээ зөвхөн тухайн нөхцөлд огт хамаарахгүй байна гэж ажиглагчдын зүгээс үзсэн тохиолдолд л бөглөх байдлаар оруулаа. “**Хамааралгүй**” хувилбартай холбоотойгоор гарсан хүндрэлийг дээд талын **6.2.3**-р **Хэсэгт** дэлгэрэнгүй оруулав**.**
4. **Хэрэглэгдэхүүний загварыг цэгцлэх**. Тухайлбал, туршилтын ажиглагчид ажиглалт хийхдээ хоёр хэл дээр бичсэн нүсэр бүртгэлийн хуудсыг ашиглаж байсан (**Хавсралт А**) бол ойлгож хэрэглэхэд хялбар байх үүднээс албан ёсны ажиглалтад зөвхөн Монгол хэл

дээр болгож ашиглахаар болов. Зөвхөн тодорхой нөхцөл байдалд хувилбарт асуултууд нь яг хаана байгааг илүү ойлгомжтой, тодорхой харуулах байдлаар шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний загварыг өөрчилж зассан**.**

Түүнчлэн туршилтын ажиглалтын үр дүнд таван арга зүйн сайжруулалтыг хийсэн. Үүнд:

1. **Холбогдох мэдээллийг цахимаар байршуулаагүй тохиолдолд хэргүүдийг тодорхойлохоор ажиглагчид шүүхүүд дээр очиж, уулзалт хийлээ**. Ингэхдээ баг тус бүр ажиглалт хийхээс өмнө бүх шүүхүүд дээр очиж, танилцах уулзалт хийхийн зэрэгцээ шүүхийн ажилтнуудтай ажиглалтын үйл ажиллагааны талаар нэгдмэл ойлголттой болж, найрсаг харилцаа тогтоох зорилгоор шүүхийн төлөөллийг албан ёсны ажиглалтын сургалтын эхний өдрийн албан ёсны нээлтийн арга хэмжээнд урьсан.
2. **Ажиглагчдад албан ёсны сургалтын үеэр ажлын төлөвлөгөө боловсруулж,** уялдаа холбоог хангаж ажиллах шүүхийн ажилтныг томилох үүргийг даалгасан юм. Энэ нь ажиглагчид өөрсдөд байгаа хязгаарлагдмал цаг хугацааг үр ашигтай ашиглаж, ажиглах хэргүүдийг зөв тодорхойлж, баталгаажуулах бүх нөөц бололцоог ашиглахад чиглэсэн даалгавар болно. Зарим туршилтын ажиглагчид шүүх дээр холбогдох хэргүүд байхгүй байна, азнаад хүлээж байна гээд өөрсдөө шүүхтэй холбоо тогтоохгүйгээр цаг алдаж байсан, ажиглалтыг хоцроож, хойшлуулж асуудлыг шийдвэрлэхийн тулд энэ арга хэмжээг авах болсон билээ.
3. **Ажиглагчид үндэсний ахлах зөвлөхийн удирдлага дор ажиллах** бөгөөд тус зөвлөх нь багуудын үйл ажиллагааг идэвхтэй удирдаж, шаардлагатай хяналтыг тавьж, холбогдох туслалцааг үзүүлж ажиллах үүрэгтэй байв.
4. **Үндэсний ахлах зөвлөх нь ажиглагчдаас бүртгэлийн хуудсыг нь хүлээн авсныхаа дараа тэдгээрийн оруулсан өгөгдлийг хянаж нягтална.**
5. **Ажиглагчид зорилтот шүүхүүд дээр албан ёсны ажиглалтын өмнө туршилтын ажиглалт хийнэ.** Учир нь туршилтын ажиглалт нь үйл ажиллагааны үндэслэл ба аргачлалын талаарх мэдлэг, ур чадвар бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байсан гэсэн дүгнэлт хийсэн байсан.

Харин санал болгосон дараах хоёр арга зүйд тохируулга хийсэнгүй. Үүнд:

1. **Хавтаст хэрэгтэй урьдчилан танилцах.** Зарим туршилтын ажиглагчид өөрсдийн саналаар шүүхийн ажилтнуудтай холбоо тогтоож, хавтаст хэрэгтэй танилцах хүсэлтийг өгсөн ч гэсэн тухайн хэргүүд ид хянан шийдвэрлэх шатанд байсан бөгөөд ажиглагчид хэрэгт оролцож, нөлөөлж буй мэт сэтгэгдэл төрүүлэх эрсдэлтэй байсан тул хүсэлтийг хангах боломж байгаагүй болно.
2. **“Хамааралгүй” хариултын сонголттой асуултуудыг оноогүй асуулт болгох.** Энэ саналыг хэрэгжүүлсэн бол Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний картын гүйцэтгэлд өгөх үнэлгээ нь аливаа хөөрөгдөлгүйгээр үнэн зөв, оновчтой байх байсан ч (дээрх **Хэсэг 6.2.3**-р хэсэгт болон доор **Хэсэг 12-р хэсэгт** тайлбарласанчлан) шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хэсэг тус бүр ямар асуултад хамаарч байгаагаасаа хамааран харилцан адилгүй өөр өөр үнэлгээг гаргахаар байлаа. Үйл ажиллагаанд хэрэглэж болох хэрэглэгдэхүүний төрлүүд нь өөр өөр, мөн аль асуултад хэрхэн яаж хариулах, дараа нь хариултуудыг хэрхэн бодож тооцохтой холбоотой алдаа дутагдал өмнө илэрч байсан болохоор дээрх саналыг хүлээж авч хэрэгжүүлэхэд өгөгдлийн эцсийн үнэлгээг баталгаатай, найдвартай болгоход ноцтой асуудлууд үүсэж болзошгүй байсан билээ.

9. Ажиглалтын болон хяналтын үйл явц

9.1. Шүүх хуралдааны ажиглалтын үйл явц

Зураг 13: Ховд аймгийн шүүхэд хийсэн айлчлал

9.1.1. Шүүхүүдтэй хамтран ажилласан нь

ШЕЗ-өөс ажиглагчдад шаардлагатай туслалцаа үзүүлж ажиллахыг зорилтот шүүхүүдэд тусгайлан чиглэл өгсөн бөгөөд энэхүү дэмжлэг туслалцааны үр дүнд тухайн ажиллагаа амжилттай хэрэгжсэн.

Энэхүү хамтын ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд төслийн зөвлөх болон ажиглагчид ажиглалт эхлэхээс өмнө зорилтот шүүх тус бүр дээр очиж, шүүхийн ажилтнуудтай уулзсан. Эдгээр уулзалтууд нь төслийн нээлтийн арга хэмжээний үеэр шүүхийн албан хаагчидтай тогтоосон харилцаа холбоог бэхжүүлж, шаардлагатай тусламжийн талаар харилцан тохиролцох боломжийг олгов. Ажиглалтын багууд нээлтийн арга хэмжээний үеэр шүүхийн захиргааны ажилтнуудтай хамтран боловсруулсан ажлын төлөвлөгөөг танилцуулж, эцэслэсэн. **(Хавсралт Ё).** Шүүх тус бүрээс тухайн багтай холбоотой ажиллах хүнийг томилж, шүүхээр хэлэлцэх хэргүүдийн талаарх мэдээллийг ажиглалтын багийн хүсэлтийн дагуу гаргаж өгөх, ажиглагчдыг хуралдаанд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг хүлээж байсан. Бүгд биш ч гэсэн зарим ажиглагчид шүүхтэй танилцах явцдаа ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааныг туршилтын журмаар ажигласан.

Эцэст нь ихэнх ажиглагчид шүүхийн ажилтнуудтай маш сайн хамтарч ажилласан тухай мэдээлсэн бол цөөн хэдэн нь тодорхой хэмжээгээр хүндрэлтэй байсан гэж тайлагнасан болохыг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, тэд ажиглагчдад хавтаст хэргүүдтэй танилцуулахаас татгалзах эсхүл ШЕЗ-ийн чиглэлийг үл биелүүлэн, ажиглагчдыг албан тушаалтнуудаас нэмэлт зөвшөөрөл авах шаардлагыг тавьж байлаа.

9.1.2. Ажиглагчдын үүрэг

Хэсэг 4.2-т заасанчлан, ажиглалтын үндсэн зарчим бол шүүхийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хүндэтгэх явдал юм. Ажиглагчдын үүрэг бол шүүх хуралдааны өмнө ба түүний явцад ажиглалт хийж, ажигласнаа тэмдэглэх юм. Шүүх хуралдааны дараа ажиглагчид хуралдаан тус бүрийн ажиглалтын хэвлэмэл хэрэглэгдэхүүнийг бөглөж байсан. Үүнийг хийж гүйцэтгэхийн тулд ажиглагчдад хавтаст хэрэг, мөн шүүхийн бичлэгтэй танилцах эрхийг олгосон билээ. Баг тус бүр ГБХ-ийн хэргийн эрүүгийн нэг, зөрчлийн хоёр шүүх хуралдааны ажиглалтыг хийх үүрэг хүлээсэн байсан. Түүнчлэн зарим багууд давж заалдах шатны шүүх хуралдаанд ажиглалт хийхийг зорьсон ч шүүх хуралдааны ажиглалтын хугацаанд ажиглах боломж олдсонгүй.

9.1.3. Ажиглалтын хугацаа

Хэдийгээр шүүх хуралдааны ажиглалтын анхны үргэлжлэх хугацаа нь 8 дугаар сарын эхээс 11 дүгээр сарын сүүл хүртэл байсан ч ажиглагчдыг боломжтой бол 11 дүгээр сарын 1-ний өдрийн дотор дуусгахыг зөвлөсөн. Ийм шийдвэр гаргасан шалтгаан нь туршилтын ажиглалтын явцад Улсын их хурлын сонгууль болж шүүх хуралдааны тов тогтооход нөлөөлж, улмаар шүүхүүдэд ердийн бус хугацаагаар зогсонги байдлыг бий болгож байсан туршлагаас үүдэлтэй юм. Орон нутгийн сонгууль 2020 оны 10 дугаар сард болсон бөгөөд тус сонгууль болон Ковид-19 цар тахлын улмаас үүсэх хүндрэлүүд нь шүүхийн ажиглалт хийх, хэрэг олоход эрсдэл дагуулна гэж тооцоолсон. Эцсийн дүнд ажиглагчид 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд буюу Монгол Улсад Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио тогтоосон үе хүртэл анх төлөвлөсөн хэргийн 92 хувьд нь ажиглалт хийсэн.

9.1.4. Хэргийн сонголт

Ажиглагчид үйл ажиллагааны хараат бус байдлыг аль болох хадгалахын тулд эрүүгийн хэргийг онлайн шүүхийн товоос сонгохыг оролдов. Гэсэн хэдий ч ажиглалтад хамрагдсан 57 хэргээс эцсийн дүнд зөвхөн 6 тохиолдол (10.5 хувь)-д боломжтой байсан. Дараагийн 7 хэрэгт (12.2 хувь) ажиглагчид шүүх хуралдааны хуваарийг түшиглэж байсан ч ажиглах хэргийг сонгохдоо шүүхийн ажилтнуудтай зөвлөлдсөн байна. Үүнээс гадна зөвлөлдөж сонгосон хэргүүдийн зөвхөн 3 хэргийн тов цахимаар байрлуулсан байсан бөгөөд эдгээр нь Улаанбаатар хотын Баянзүрх, Чингэлтэй, Налайх дүүргийн шүүх тус бүрт байсныг тэмдэглэх нь зүйтэй. Бусад есөн хэргүүдийн хувьд шүүх хуралдааны товыг зөвхөн шүүхийн байрны самбар дээрээс л харах боломжтой байлаа.

Зураг 14: *Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн шүүх хурлын тов*

Үүнээс гадна, ажиглагчид ажиглах хэргүүдийг шүүх хурлын товоос харж сонгосон эсэхээс үл хамааран, бараг бүх ажиглагчид хэргүүдээ сонгохдоо (51 хэргүүд буюу 89.5 хувь нь) ямар нэгэн байдлаар шүүхийн ажилтантай холбогдож зөвлөлдсөн байна. Тодруулбал, 40 хэргийг (70.2 хувь) зөвхөн шүүхийн ажилтнуудаас лавлаж тодруулсны үндсэн дээр сонгосон байна. Ихэнх тохиолдолд хэргийн талаарх холбогдох мэдээллийг хүргэсэн ажилтан нь шүүхийн захиргааны ажилтан (47 хэргүүд буюу 82.4 хувь) байсан ажээ. Мөн шүүгчид ч гэсэн мэдээлсэн буюу гурван хэргийн (5.3 хувь) талаар мэдээлэл өгсөн бол төслийн оролцогч ИНБ-ын өмгөөлөгч нэг хэргийн талаар мэдээлж, хэргийг сонгоход тусалсан (1.8 хувь).

Эрүүгийн хэргийн хувьд, дараах хоёр шалтгааны улмаас шүүхийн ажилтнуудтай холбоо тогтоож, харилцах шаардлагатай байлаа. Үүнд:

1. Хэргүүд нь олон нийтэд нээлттэй эсхүл хаалттай эсэхийг олж тогтоох; нууцлалын зэрэг болон хамгаалалтын арга хэмжээнээс хамаарч ажиглагчид хаалттай хэргүүдийг ажиглах боломжгүй байсан.

2. Шүүх хурлын товууд нь төрөл бүрийн форматтай байсан бөгөөд зарим тохиолдолд яг ямар хэрэг хянан шийдвэрлэгдэх гэж байгаа тухай мэдээлэл хангалтгүй байсан. Иймээс ажиглагчид шүүгчийн туслахуудтай уулзаж, нэмэлт мэдээллийг авсны үндсэн дээр тухайн хэрэг ГБХ-тай холбоотой эсэхийг тодруулж байсан.

Зөрчлийн хэргийн шүүх хуралдааны хувьд зөрчлийн хэргийн шүүх хуралдааны тодорхой товууд нь ер олдоогүй тул ажиглагчид шүүхийн ажилтнуудтай холбогдож, зөвлөлдөх шаардлагатай байсан. Харин шүүхүүд ихэнхдээ зөрчлийн хэргийн шүүхийн хуралдааны тодорхой өдрүүдийг тогтоосон байдаг байна. Иймээс шүүхийн ажилтнуудтай зөвлөлдөхгүйгээр зөрчлийн хэргийн товыг мэдэх боломжгүй юм. Ажиглагчид төрөл бүрийн арга хэрэглэсэн. Багууд зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн хуралдаантай өдрүүдэд шүүх хуралдааны ажиглалт хийнэ гэсэн найдвар тээж шүүх дээр очиж байсан бөгөөд өөрөөр хэлбэл тэд зарим үед нэг талдаа бараг 100 км явж очсоны эцэст ямар ч шүүх хуралдаан байхгүй гэдгийг олж мэдэж байлаа. Түүнчлэн, ажиглагчид замдаа ГБХ-ийн зөрчлийн эсхүл эрүүгийн хэргүүдийн талаар цагдаа болон прокурорын газруудаас лавлаж асуух аль эсхүл Зөрчлийн хэргийн шүүх хуралдаантай таарч магад гээд тухайн газрууд руу шууд очих тохиолдол гарч байлаа. Хамгийн чухал нь хэдийгээр шүүхийнхэн ажиглагчдад хэргийн товын талаар мэдээлж байсан ч тэд ажиглах хэргүүдийг сонгох шийдвэрт нөлөөлж байгаагүйг онцлох хэрэгтэй билээ.

Шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаа нь хохирогч төвтэй хандлагыг баримталж байсан болохоор ажиглагчид хохирогч оролцсон шүүх хуралдааныг ажиглахыг зөвлөж ажилласан. Харин ийм төрлийн хэргүүдийг ажиглах боломж хязгаарлагдмал байсан бөгөөд хохирогчдын зөвхөн тавны хоёр нь (26 хэрэг буюу 42.6 хувь) шүүх хуралдаанд оролцож байсан юм. Эцсийн дүнд ажиглагчид ямар ч тохиолдол байсан ажиглах ёстой байв.

Шүүх хуралдааны ажиглалтын хүрээнд давж заалдах шатны шүүх хуралдааныг багтаасан байсан бөгөөд үндэсний ахлах зөвлөх Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч болон түүний туслахтай холбогдож байсан. Гэсэн хэдий ч шүүх хуралдааны ажиглалтын хугацаанд давж заалдах шатны ГБХ-ийн эрүүгийн хэргийн нээлттэй шүүх хурал болоогүй. Харамсалтай нь тэр хугацаанд зөрчлийн цөөн тооны хуралдаан болсон байна.

9.2. Хяналтын ажиллагаа

9.2.1. Хамтын ажиллагаа болон хяналт

Зураг 15: *Ажиглагчдын фейсбүүк групп хуудас*

Албан ёсны ажиглалтын сургалтын үеэр ажиглагчдын хоорондоо харилцаж, мэдээлэл солилцох боломжтой хаалттай Фейсбүүк групп нээх саналыг ажиглагчид гаргаж, ТХН тус саналыг хэрэгжүүлсэн. Хэдийгээр энэ групп нь төслийн загварт урьдчилан тусгагдаагүй байсан ч үндэсний ахлах зөвлөх, ТХН болон ажиглалтын багуудын хоорондмэдээлэл солилцох, 7 хоногийн үйл явцаа тайлагнах болон Шүүх хуралдааны ажиглалтын

хэрэглэгдэхүүнд орсон өөрчлөлт эсхүл болох гэж буй хурал, уулзалтын талаар зарлан мэдээлэх гол платформ болсон юм.
Хамтын ажиллагааны уялдаа холбоог боломжтой болгосон энэхүү платформоос гадна үндэсний ахлах зөвлөх нь шүүх хуралдааны бүх ажиглалтын багуудыг удирдаж, утас, и-мэйл ба Фейсбүүк группээр дамжуулж тогтмол харилцаатай байж, багуудын боловсруулсан ажлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажилласан. Энэ нь ихэнх тохиолдолд үр дүнтэй байсан боловч зарим багуудын аль нэг гишүүний идэвхгүй байдлаас болж голдуу хүндрэл гарч байсан юм.

9.2.2. Багийн хэлэлцүүлгүүд

Зураг 16–т харуулсанчлан багийн хэлэлцүүлгийг тогтмол явуулахаар төслийн загварт оруулсан байсан бөгөөд туршилтын шатанд амжилттай хийсэн шиг албан ёсны ажиглалтын хугацааны туршид мөн адил үр дүнтэй зохион байгуулж чадсан. Эдгээр хэлэлцүүлгүүдийг үндэсний ахлах зөвлөх болон сургалтын арга зүйч нартай хамтран зохион байгуулж ажилласан.

Зураг 16: *Албан ёсны ажиглалтын явцад хийсэн багийн хэлэлцүүлэг*

Зураг 26: *Ажиглагчдын зөвлөмжийн онлайн хэлэлцүүлэг*

Яг Фейсбүүк групп шиг, тус багийн хэлэлцүүлгүүдээр дамжуулан ажиглагчид өөрсдийн суусан шүүх хуралдааны ажиглалт, шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хэвлэмэл бүртгэлийг бөглөсөн туршлагыг хуваалцах боломжийг олгож байлаа. Мөн энэ хэлэлцүүлгүүдийн тусламжтайгаар ажиглагчид хэрэглэгдэхүүн засах боломжтой орчуулгын алдаануудыг төслийн багт хэлж мөн өөрсдийн туршлага дээр үндэслэн ГБХ-ийн хэргүүдийн талаарх өөрсдийн санал бодлыг хэлж, хамтдаа ярилцаж, зөвлөлдөх боломжийг бүрдүүлсэн билээ. Монгол Улсын өргөн уудам нутаг дэвсгэрээс ажиглагчдыг биечлэн цуглуулж уулзалт зохион байгуулахад логистик, төсөв болоод Ковид-19 цар тахлын хөл хорио зэрэг асуудлыг шийдвэрлэхийн тулд багийн хэлэлцүүлгийг Zoom платформыг ашиглан онлайнаар хийсэн.

9.2.3. Бүртгэлийн хуудаснуудыг хүлээлгэн өгөх, хянах болон боловсруулах

Хэвлэмэл бүртгэлийг бөглөж дууссан даруйд тэдгээрийг Google маягтад оруулах зөвшөөрөл авахаасаа өмнө ажиглагчид үндэсний ахлах зөвлөхөд хянуулж, батлуулахаар хүлээлгэн өгсөн. Үндэсний ахлах зөвлөх нь хэвлэмэл бүртгэлийг хянаад ямарваа нэгэн алдаа илрүүлбэл засуулахаар багуудад буцаан өгч байв. Гол алдаанууд нь онооны тооцооллын алдаа эсхүл хувилбарыг буруу сонгосны улмаас ерөнхий тооцооллын зөрүү гарсан байсан юм.

Харамсалтай нь бүх багуудаас алдаа илэрсэн билээ. Иймээс хэрэв ажиглагчид өгөгдлийг шууд Google маягтад оруулбал өгөгдлийн алдаа, зөрүүтэй байдлууд маш их гарч болзошгүй гэж үндэсний ахлах зөвлөх үзэж, энэ эрсдэлийг бууруулах үүднээс нийгмийн шинжлэх ухааны

чиглэлээр төгссөн, өгөгдлийг оруулж, хяналт тавих туршлагатай хүнийг авсан нь зүйтэй гэж шийдвэрлэсэн болно. Ийм ч учраас үндэсний ахлах зөвлөхийн заавар, саналын дагуу ажиглагчдын засаж өөрчилсөн бүртгэлийн эцсийн хувилбарыг шалгасны дараагаар бүгдийг нь өгөгдлийг оруулах хүнд хүлээлгэн өгсөн.

9.2.4. Эцсийн хяналт

Олон улсын зөвлөх энэхүү тайланг бэлтгэх явцдаа Google маягтад оруулсан өгөгдлийг эцсийн байдлаар хянасан билээ. Өгөгдөлд зөрүү ажиглагдсан эсхүл хэргийн нөхцөл байдлын талаар сайн ойлгоход нэмэлт мэдээлэл шаардлагатай тохиолдолд олон улсын зөвлөх нь өгөгдлийг оруулсан ажилтан болон үндэсний ахлах зөвлөхөд мэдэгдэж байсан. Харин тэдгээр нь тодруулга эсхүл нэмэлт мэдээлэл авахаар багуудтай холбогдож, зөрүүг арилгасны дараа багуудын өгөгдлийг Google маягтад оруулж байсан юм.

Бүлэг II. Дүгнэлт

10. Өгөгдлийн хязгаарлалт

10.1. Сонгох үйл явц

Уг үйл ажиллагааны өгөгдөл нь 39 зөрчлийн болон 18 эрүүгийн хэргийн шүүх хуралдаан буюу харьцангуй хязгаарлагдмал түүвэр (sample) болох нийт 57 хэргүүдэд тулгуурласан. Илүү ойлгомжтой тайлбарлах үүднээс нэг жишээ татахад, үйл ажиллагааны явцад ажиглах хэргүүдийг тодорхойлоход тулгарсан хүндрэл бэрхшээлийг үл харгалзан ажиглалт хийгдсэн 39 зөрчлийн хэргийн шүүх хуралдаанууд нь 2020 онд зорилтот есөн шүүхүүдэд хянан шийдвэрлэгдсэн нийт 20,885 зөрчлийн хэргийн дөнгөж 0.18 хувийг эзэлж байгаа ажээ.[13]

Бага түүврийн хэмжээ нь өгөгдлийн уялдаа холбоог нэмэгдүүлж, түүний утгыг хязгаарладаг. Тухайлбал, ажиглагчид зөвхөн 18 эрүүгийн хэргийг ажиглах боломжтой байсан ба үүнээс 11 нь ГБХ-ийн бие махбодын бус хүчирхийллийн хэлбэрийг агуулж байсан. Түүнчлэн, хэдийгээр ШЕЗ-тэй хэлэлцсэн байсан ч нууцлалын зэрэг эсхүл хамгаалалтын шалтгааны улмаас ажиглагчид хаалттай шүүх хуралдаанаар хэлэлцэгдэж байсан хэргүүдтэй танилцах боломж олдоогүй. Уг үйл ажиллагааны хүрээнд хохирогчийн аюулгүй байдалд онцгойлон анхаарч байсан тул хаалттай шүүх хуралдаанд ажиглалт хийх боломжгүй байсан нь хамгийн ихээр сонирхол татаж байсан хэргүүд буюу эмзэг бүлгийн хохирогч эсхүл яллагдагчтай хэргийн шүүх хуралдааны мэдээлэл өгөгдлийн багцад байхгүй билээ. Түүнчлэн, хэдийгээр ажиглагчид маш их чармайлт гаргасан ч **Хэсэг 9.1.4**.-т дурдсанчлан давж заалдах шатны шүүх хуралдаанд ажиглалт хийж чадаагүй билээ. Үүнээс улбаалан өгөгдлийн багц нь зөвхөн анхан шатны шүүхийн шийдвэрүүдээс бүрдэж, хяналтын журмаар эцэслэн шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэр тусгагдаагүй юм.

10.2. Хамтын ажиллагааны загвар

Шүүх хуралдааны ажиглалтыг ШЕЗ-ийн дэмжлэг, зорилтот шүүхүүдийн хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжүүлсэн. Иймд бүх ажигласан шүүх хуралдаанд оролцож буй эрх бүхий албан тушаалтнууд нь тус шүүх хуралдаанд ажиглагчид оролцож буйг болон мөн зорилгыг мэдэж байснаас гадна шүүх бүрд шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хувийг өгсөн байсан юм. Ийнхүү мэдээлэлтэй байсан нь шүүх хуралдаанд оролцож буй албан тушаалтнууд ердийнхөөсөө илүү процессын ажиллагааг нягт мөрдөх гэх мэтээр зан үйлд нь болон шүүн таслах ажиллагааны эцсийн дүнд нөлөөлж, өгөгдлийн бодит байдалд асуудал учруулсан байж болзошгүй юм. Нөгөөтэйгүүр зарим шүүхүүд ажиглаж болох шүүх хуралдаануудын талаар ажиглагчдад идэвхтэй мэдээлэл өгч байлаа. Энэ нь мөн адил ажиглах хэргүүдийг сонгоход эрсдэлийг бий болгож байв.

[13] Тус өгөгдлийг ШЕЗ-с авав

10.3. Субьектив үнэлгээ

Шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаанд ГБХ-ийн өмгөөлөл, хүний эрх болон холбогдох чиглэлээр идэвхтэй ажилладаг хүмүүсийг шүүх хуралдааны ажиглагчдаар зориуд сонгон шалгаруулсан билээ. Ингэснээр тэд шүүх хуралдааны ажиглалтын судлахууныг ижилхэн эсхүл ойролцоо чиглэлийн салбарт дахин ашиглах ба улмаар Монгол Улс дахь ГБХ-тэй тэмцэх үйл ажиллагааг шууд бус аргаар бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах юм. Мөн ажиглагчдын хувьд зайлшгүй нэг зүйл бол тухайн үйл ажиллагааг өөрсдийн итгэл үнэмшил, туршлагаас олсон ойлголттой хэрэгжүүлсэн гэсэн үг. Ажиглагчид шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг бөглөхдөө субъектив хандлагаар хариулах нөхцөлийг хязгаарлаж, улмаар өгөгдлийн гажуудлын эрсдэлийг бууруулах зорилгоор багийн хуралдаанаар дамжуулан байнга мэдээлэл өгөх, гуравдагч хүн мэдээллийг оруулах, мэдээллийг хянах зэрэг үйл ажиллагааг дизайнд тусгасан байсан билээ. Гэсэн хэдий ч тухайн хувь хүний өмнө хуримтлуулсан туршлага нь субъектив үнэлгээ гаргахад бага ч гэсэн нөлөөлдөг.

10.4. Ковид-19

Нийт шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаа нь дэлхий дахинаа тархсан Ковид-19 цар тахлын үеэр болсон билээ. Энэ нь шүүх түр зуур хаах, шүүхэд нэвтрэхэд хязгаарлалттай болох зэргээр шүүхийн үйл ажиллагааг тасалдуулсан. Мөн бусад улс орнуудад шиг Монгол улсад хөдөлгөөнийг хязгаарлаж, хүүхдүүдийг түр хугацаагаар гэрээр хичээллэдэг болгохын зэрэгцээ хөдөлмөр эрхлэлтэд гарч болзошгүй өөрчлөлтүүд, байнгын тодорхойгүй байдал зэрэг нэмэлт стресст ихээхэн өртөж байлаа. Энэ бүгд нийлээд ГБХ-ийн гаралт, шинж чанарт нөлөөлж, Монгол улс дахь ГБХ үйлдэгддэг ерөнхий байдлын талаар ажиглаж, судлах зорилготой өгөгдөлд өөрчлөлт, хязгаарлалт үүсгэж болзошгүй нөхцөлд хүргэсэн юм.

10.5. Хэргийн хүртээмж

Маш олон тохиолдолд шүүх хуралдаан товлогдоогүй байсан учраас ажиглагчид ямар шүүх хуралдаанд ажиглалт хийхээ тодорхойлоход дахин хүндрэл учруулж байв. 2020 оны 6- 7 дугаар саруудад туршилтын ажиглалтын хугацаа нь Улсын их хурлын сонгуультай давхацсан. Гэтэл албан ёсны ажиглалтын үеэр яг тодорхой шалтгаан байхгүй ч хязгаарлагдмал тооны хуралдаанууд байсан. Гэхдээ энэ нь ердийн логистик арга хэмжээний хувьд Ковид-19 цар тахлын улмаас үзүүлсэн нөлөөлөлтэй холбоотой байж магадгүй. Ямартаа ч эдгээр нөхцөл байдал нь эргээд бидний ажиглаж дүгнэхээр зорьсон ГБХ-ийн хэрэг, мөн шүүх хуралдааны ерөнхий дүр төрх буюу энэ ажиглалтын хүрээнд цуглуулсан өгөгдөлд нөлөөлөх магадлал бий.

11. Хэргүүдийн танилцуулга

Шүүх хуралдааны ажиглалтын хүрээнд явуулсан үйл ажиллагааны дүгнэлтүүдийг дараах таван хэсэгт ангилан танилцуулж байна. Энэ хэсэгт оруулсан мэдээллүүд нь энэхүү судалгааны тайлангийн дээрх **3-р хэсэгт** дурдсан эхний зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн болно.

1. Судлах	**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжид оруулсан шинэчлэлийг Монгол Улсын шүүхийн практикт хэрхэн хэрэгжүүлж байгааг судлах нь**

Энэ үйл ажиллагааны бусад хоёр зорилтын үр дүнг **16-р Хэсэгт** танилцуулсан.

Доорх хэсэгт ажиглалт хийсэн 57 хэрийн талаар танилцуулж байна. Үүнд холбогдох зөрчил, гэмт хэрэг, ГБХ үйлдэгдэх болсон шалтгаан, хэргийн шүүхийн харьяалал ба шүүх хуралдааны шинж чанарын тухай дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан болно. Цаашлаад хохирогч ба яллагдагчдын хүн ам зүйн мэдээлэл, жендер, нас, харилцаа, орон сууцны нөхцөл, боловсрол, ажил эрхлэлт, мөн яллагдагч (холбогдогч)-ийн хувьд өмнө холбогдож эсхүл яллагдаж байсан гэмт хэргийн түүхийг багтаав. Энэ хэсэг нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (**Хасралт В)**-ийн 1-р Бүлгийн 1-р хэсгийн дагуу цуглуулсан өгөгдөлд тулгуурлаж байна.

Энэхүү судалгаанд Улаанбаатар хотод ажиглалт хийх шүүх хуралдааны тоо нь судалгаанд хамруулсан аймгуудынхтай ижил хувь хэмжээтэй байхаар түүврийн хэмжээг сонгосон. Түүвэрлэсэн хэргүүдийн гуравны хоёр нь зөрчлийн хэрэг, үлдсэн нь эрүүгийн хэрэг байсан ба эдгээр нь бүгд анхан шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн хэргүүд билээ. Эдгээр хэргийн дийлэнх нь зөвхөн нэг хэрэгт холбогдож яллагдсан тохиолдлууд байснаас ихэнхдээ бие махбодын ГБХ, үүнээс тухайлан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон зөрчил болон санаатайгаар хөнгөн гэмтэл учруулсан гэмт хэргүүд байв. Сонгосон хэргүүдээс гурван хохирогч нь нас барсан байна. Мөн ихэнх хэргийн хохирогчид нь шүүх хуралдаанд биечлэн оролцоогүй бөгөөд яллагдагч болон хохирогч талын аль аль нь ихэвчлэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцоогүй, зөвхөн нэг удаагийн шүүхийн хэлэлцүүлгээр хэргийг хянан шийдвэрлэсэн хэргүүд нийтлэг байлаа. Хохирогчдын олонх нь эмэгтэйчүүд байсан бол хүчирхийлэл үйлдэгчдийн дийлэнх хувь нь эрэгтэйчүүд байх бөгөөд хамт амьдардаг, гэр бүлийн харилцаатай хүн нь ихэвчлэн гэр хорооллын орчинд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байсан нь нийтлэг ажиглагдлаа. Хохирогч ба яллагдагч талуудын аль аль нь голдуу бүрэн дунд боловсролтой байсан боловч гэмт хэрэгт холбогдсон яллагдагчид зөвхөн бүрэн бус дунд боловсролтой байх тохиолдол илүү олон байв. Хөдөлмөрийн насны яллагдагчдын гуравны хоёр нь харин энэ насны хохирогчдын тал хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэг байсан бол, хүчирхийлэл үйлдэн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон бүх хүмүүсийн талаас дөнгөж илүү хэсэг нь эрүүгийн хэрэгт яллагдаж байгаа яллагдагчдын ихэнх нь урьд нь ял, шийтгэл эдэлж байгаагүй хүмүүс байв.

11.1. Шүүхийн харьяалал

Шүүх хурлын ажиглалт хийсэн бүх 57 хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн буюу анхан шатны журмаар гэмт хэргийн шүүгдэгч, зөрчлийн хэргийн холбогдогчийн гэм бурууг

тогтоож ял, шийтгэл оногдуулах шүүх хуралдаан байсан юм. Харин энэхүү тайланг бичих үед ажигласан хэргүүдийн хамгийн багадаа дөрөв нь Монгол Улсын Дээд шүүхэд хяналтын шатны хуралдаанд орохоор байсан боловч энэхүү судалгааг гүйцэтгэх хугацаанд давж заалдах шатны нэг ч шүүх хуралдаанд ажиглалт хийх боломжгүй байсныг энд тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

Нийслэл Улаанбаатар хотод ажигласан хэргүүд болон *аймгуудад* (хөдөө орон нутаг) ажигласан хэргүүдийн тоо бараг ижил хэмжээтэй буюу түүврийн хэмжээг хангаж чадсан гэж үзэж байна. Тодруулбал Улаанбаатар хотод 31 шүүх хурал (54.4 хувь), харин *аймгуудад* 26 шүүх хуралд (45.6 хувь) ажиглалт явууллаа.

Улаанбаатар хотын хувьд Баянзүрх (13 хэрэг), Налайх (8), Сонгинохайрхан (5) болон Чингэлтэй (5) гэсэн дөрвөн дүүргийн анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэргүүдийг сонгосон. *Аймгуудын хувьд* бүх хэргийг аймаг дахь *сум* (хотын хувьд дүүргүүд) бүрээс хэргүүдийг нэгтгэн, *аймгийн* төвд хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий сум дундын анхан шатны шүүхүүдэд хянан хэлэлцсэн хэргүүдийг сонгосон юм. *Аймгийн* шүүх хуралдааны ажиглалтыг Төв (8 хэрэг), Архангай (5), Дорноговь (5), Ховд (5) ба Өвөрхангай (3) аймгуудад хийлээ.

11.2. Хэрэг, зөрчлүүд

Судалгаанд хамруулсан ГБХ-ийн тохиолдлуудаас бараг гуравны нэгийг (18 хэрэг буюу 31.6 хувь) нь *Эрүүгийн хууль*-д заасан гэмт хэргүүд эзэлж байна. Харин үлдсэн 39 хэрэг (68.4 хувь) нь *Зөрчлийн тухай хууль*-д заасан нийгмийн хор аюул арай багатай хэрэг (Зөрчлийн хэрэг) байв.

11.2.1. Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрүүд

Шүүх хуралдаанд ажиглалт хийхдээ бие махбодын болон бусад төрлийн гэр бүлийн хүчирхийлэлд холбогдсон зөрчил, гэмт хэргийг аль болох өргөн хүрээнд хамруулан хуульд заасан ГБХ-ийн шинжтэй зөрчил, гэмт хэргүүдийг бүгдийг нь судалж харуулахаар хичээсэн боловч практик дээр ажигласан бүх хэргээс дийлэнх нь буюу 80.7 хувь (46 хэрэг) нь бие махбодын хүчирхийлэл үйлдсэн хэргүүд байлаа. Харин ажигласан нийт хэргээс 10 (буюу 17.5 хувь) нь бие махбодын бус хүчирхийлэл буюу эд хөрөнгийг нь устгах, хулгайлах, хураан авах зэрэг эдийн засгийн хүчирхийллийн шинжтэй эсвэл заналхийлэл, бусадтай харилцахыг хязгаарлах гэх мэт сэтгэл зүйн хүчирхийллийн шинжтэй үйлдлийг хянан хэлэлцсэн байв. Прокурорууд ерөнхийдөө бие махбодын аль эсхүл сэтгэл санааны хүчирхийллийн аль нэг хэлбэрт нь л хүчирхийлэл үйлдэгчийг холбогдуулан шалгаж байгаа байдал ажиглагдаж байлаа. Судалгаанд хамруулсан ГБХ-ийн бүх тохиолдлоос бие махбодын хүчирхийлэл болон бие махбодын бус хүчирхийллийн аль алийг нь агуулсан шинжтэй үйлдэлд яллагдсан тохиолдол нэг (1.8 хувь) л байсан юм.

11.2.2. Ял, шийтгэлийн төрлүүд

Судалгааг төлөвлөхдөө шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагаагаар дамжуулж ГБХ-ийн үйлдэлд оноох 20 өөр ял, шийтгэлийн төрлүүдийг ажиглалтад хамруулахаар төлөвлөсөн боловч бодитоор нийт 12 төрлийн (төлөвлөснөөс 60 хувь) ял, шийтгэлийг шүүхээс оноох үйл

явцад ажиглалт хийж чадлаа. Доорх **Хүснэгт 7**-д ажиглах боломжтой байсан шүүх хуралдаануудаар оноосон ял, шийтгэлийн төрлүүдийг тухайн ял, шийтгэлийг оноосон шүүх хуралдааны тоонд харгалзуулсан дэлгэрэнгүй мэдээллийг харууллаа.

Холбогдох хууль тогтоомж	Ял шийтгэлийн төрөл	Хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт	Тодорхой гэмт хэрэг/зөрчлүүд	Ажигласан шүүх хуралдаануудын тоо
Зөрчлийн тухай хууль	ГБХ-тэй тэмцэх тухай хууль зөрчсөн зөрчилд оноох шийтгэл	5.4.1	Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх үүргээ биелүүлээгүй	1
		5.4.4.1	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон	29
		5.4.4.2	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан	5
		5.4.4.3	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг бусадтай харилцахыг хязгаарласан	2
		5.4.4.4	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	3
Эрүүгийн хууль	ЭХ-д ГБХ нь хүндрүүлэх нөхцөл байхаар заасан гэмт хэргүүдэд оноох ял	11.7.1.1	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон	3
		11.7.1.2	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга хargис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан	2
		11.7.2.1	ГБХ-ийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн;	2
	ЭХ-д ГБХ нь хүндрүүлэх нөхцөл байхаар заасан гэмт хэргүүдэд оноох ял	10.1	Хүнийг алах	2
		11.1	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	2
		11.4	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах	2
		11.6	Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	14

Хүснэгт 7: *Ажиглалтын явцад ГБХ-ийн үйлдэлд оноосон ял, шийтгэвэр*

Ажиглалт хийсэн шүүх хуралдаануудаас зөрчлийн шийтгэл оноож шийдвэрлэсэн тухай мэдээллийг доорх **Дүрс 8**-д, эрүүгийн ял оноосон тухай мэдээллийг **Дүрс 9**-д Зөрчлийн *тухай хууль* болон *Эрүүгийн хуулийн* холбогдох зүйл, заалтаар ангилан тус тус харуулсан болно.

Дүрс 8: *Зөрчлийн шийтгэл оноосон тохиолдол, ЗХ-ийн холбогдох заалтуудаар*

Дүрс 9: *Эрүүгийн ял оноосон тохиолдол, ЭХ-ийн холбогдох зүйлээр*

Хэдийгээр ажиглагчид ажиглах хэргүүдийн сонголтыг хамгийн боломжит хэмжээгээр өргөжүүлэхийг маш их хичээсэн боловч үйл ажиллагааны анхдагч хамрах хүрээнд багтсан гэмт хэрэг, зөрчлийн найман төрлүүдийг ажиглаж чадаагүй билээ.
Эдгээр хасагдсан хэргүүдийг **Хүснэгт 8**-с харна уу.

ГБХ-тэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлүүд (*Зөрчлийн тухай хуулийн зүйл, заалтаар*)	Гэмт хэргүүд		
	ГБХ үйлдэх гэмт хэрэг (*Эрүүгийн хуулийн зүйл, заалтаар*)	ГБХ хүндрүүлэх нөхцөл байхаар заасан бусад гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл, заалтаар*)	ГБХ-ийн шинжтэй бусад гэмт хэргүүд (*Эрүүгийн хуулийн зүйл, заалтаар*)
• Түр хамгаалах байрны журам зөрчиж нэвтэрсэн (5.4.2) • Түр хамгаалах байрны зориулалтыг өөрчилсөн, эсхүл хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан (5.4.3)	• Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд байнга халдсан эрх (11.7.1.3) • ГБХ-ийн гэмт хэргийг асрамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагын ажилтан үйлдсэн(11.7.2.2) • ГБХ-ийн гэмт хэргийг таслан зогсоох гэсэн хүнийг эсэргүүцэж үйлдсэн (11.7.2.3)	• Хүчиндэх (12.1)	• Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх (10.4) • Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах (12.2)

Хүснэгт 8: *Ажиглалт явуулахаар төлөвлөсөн боловч ажиглах боломж гараагүй шүүх хурлууд: эрүүгийн ба зөрчлийн хэргээр*

11.2.3. Оногдуулсан ял, шийтгэлийн тоо

Ажиглалт хийсэн шүүх хуралдаануудаар эрүү, зөрчлийн 57 хэргийн нийт 68 үйлдэлд ял, шийтгэл оногдуулснаас судалгааны хамрах хүрээнд багтаагүй ял ногдуулсан нэг үйлдэл байсан юм. Ихэнх тохиолдол (50 хэрэг буюу 87.7 хувь)-д зөвхөн нэг гэмт хэрэг эсхүл зөрчлийн нэг хэрэгт ял, шийтгэл оноож байлаа. Нэгээс илүү үйлдэлд ял, шийтгэл оногдуулсан найман хэрэг байснаас дийлэнх (7 хэрэг буюу 87.5 хувь) нь эрүүгийн хэрэг, харин зөрчлийн нэг л хэрэг байлаа.

11.2.4. Нийтлэг оноодог ял, шийтгэл

Ажиглалт хийсэн шүүх хуралдаануудаар оноосон нийт ял, шийтгэлүүдийн дотор гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон зөрчилд шийтгэл оноосон тохиолдол хамгийн олон байв. Тухайн зөрчилд шийтгэл оноосон тоо нь ял, шийтгэл оноосон бүх үйлдлийн 42.6 хувийг эзэлж байсан бөгөөд түүвэрлэн сонгож ажигласан зөрчлийн бүх хэргүүдээс тооцож үзэхэд талаас илүү (50.8) хувь, дээрх **Дүрс 8**-д харуулсанчлан Зөрчлийн хуулийн холбогдох заалтуудаар ангилж үзвэл судалгаанд хамруулсан зөрчлийн бүх хэргийн 72.5 хувийг тус тус эзэлж байна. Үүний дараа Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах эрүүгийн хэрэгт ял оноосон тохиолдол хоёр дахь өндөр үзүүлэлт байсан бөгөөд энэхүү гэмт хэрэгт ГБХ нь хүндрүүлэх нөхцөл байхаар хуульчилсан байна. Энэ үзүүлэлт нь ял, шийтгэл оноосон бүх

үйлдлийн 20.6 хувийг, харин дээрх **Дүрс 9**-д харуулсанчлан ЭХ-ийн холбогдох зүйлүүдээр ангилж үзвэл судалгаанд хамруулсан эрүүгийн хэргүүдийн 52 хувийг тус тус эзэлж байна. Эрүүгийн болон зөрчлийн хэргийн үлдсэн 10 төрлүүдэд ял, шийтгэл оногдуулсан нь харьцангуй цөөн буюу төрөл бүрт ял, шийтгэл оноосон тоо хэмжээ нь 1-ээс 5-ын хооронд (1.8 - 8.8 хувь) байна.

11.3. ГБХ үйлдсэн шалтгаан

Ажиглалтын судалгааны явцад хавтаст хэрэгт бүртгэгдсэн болон шүүх хуралдааны үеэр хохирогчдын мэдүүлсэн ГБХ-ийн шалтгаануудыг тэмдэглэж авсан юм. Ихэнх тохиолдолд хохирогч нь нэгээс илүү шалтгаан хэлсэн бөгөөд ийнхүү ГБХ-ийн 61 хохирогч нийт 75 шалтгааныг мэдээлснийг тэмдэглэн авчээ. Хохирогчдын өгсөн хариултуудыг **Дүрс 10**-д нарийвчлан харуулсан болно.

***Дүрс 10**. Хохирогчдын мэдүүлсэн ГБХ үйлдсэн шалтгаан*

Согтууруулах үндаа хэтрүүлэн хэрэглэсэн гэх шалтгаан нь ГБХ үйлдсэн бусад шалтгаануудаас хамаагүй өндөр хувь хэмжээтэй, хамгийн нийтлэг шалтгаан байв. Судалгаанд оролцсон хохирогчдын бараг тэн хагас (49.2 хувь) нь үүнийг ГБХ үйлдэгдэх болсон цор ганц шалтгаан гэж үзжээ. Судалгаанд нийт 61 хохирогч оролцсоноос дөрөвний гурав орчим (45 хүн буюу бүх хохирогчдын 73.8 хувь) нь согтууруулах үндаа хэтрүүлэн хэрэглэсэн нь ГБХ үйлдэх шалтгаан болсон гэж хариулсан байна. ГБХ-тэй холбоотой гэмт хэрэг үйлдсэн хамгийн түгээмэл шалтгаан

нь мөн адил согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн гэсэн шалтгаан байсан бөгөөд гэмт хэргийн хохирогчдын 15 (буюу 75 хувь) нь ийнхүү хариулсан юм.

Хохирогчдын мэдүүлсэн ГБХ-ийн хоёр дахь хамгийн түгээмэл шалтгаан нь хардалт байлаа. Хохирогчдын гуравны нэг орчим (19 хүн буюу 31.1 хувь) нь хардалтаас болж ГБХ үйлдэгдсэн гэж мэдүүлжээ. Ийнхүү хариулсан хохирогчдын 13 (21.3 хувь) нь согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн болон хардсан аль аль шалтгаанаар ГБХ үйлдэгдсэн гэжээ. Үүнээс гадна 10 хохирогч тутмын нэг (зургаан хохирогч буюу 9.8 хувь) нь гэр бүлийн орлоготой холбоотой маргаанаас шалтгаалан ГБХ үйлдсэн гэж үзжээ. Үлдсэн зургаан хохирогч (9.8 хувь) нь ГБХ өөр төрлийн маргаанаас үүдэлтэй байсан гэж мэдүүлсэн бөгөөд эдгээр нь хүчирхийлэл үйлдэгчээс гэр бүлээ цуцлуулахаар хүсэлт гаргасан, эцэг эх нь салсны дараа охин нь аавынхаа гэр бүлтэй очиж уулзахыг хүссэн, бага насны хүүхэд оройн хоолоо идээгүй, эхнэр нь халуун тосонд түлэгдсэнээс болж хэрүүл үүссэн, эмээгийнх нь эм дуусан гэдгийг нагац ахдаа үеэл дүү нь хэлээгүй гэсэн шалтгаанууд байв.

11.4. Шүүх хуралдааны үйл явцын талаар

11.4.1. Шүүх бүрэлдэхүүн хуралдсан тоо

Ихэнх хэргийг (50 хэрэг буюу 87.7 хувь) зөвхөн нэг удаагийн шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн байна. Шүүх бүрэлдэхүүн нэгээс олон удаа хуралдаж шийдвэрлэсэн долоон хэргийн зургааг (нийт хэргийн 10.5 хувь) нь хоёр удаагийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн бөгөөд эдгээрийн тэн хагас нь эрүүгийн, үлдсэн хагас нь зөрчлийн хэргүүд байлаа. Шүүх бүрэлдэхүүн гурван удаа хуралдсан нэг л (эрүүгийн) хэрэг байв. Энэ хэргийн яллагдагч нь өндөр настай эхийгээ түлхэж унагаасны улмаас эхийнх нь биеийн байдал эрчимтэй муудсаар шүүх хуралдааны явцад нас барсан юм.

11.4.2. Шүүх хуралдаан үргэлжилсэн хугацаа ба эхэлсэн, дуусан цаг

Ажиглалт явуулсан шүүх хуралдаануудад шүүх хуралдааны хугацаа нь харилцан адилгүй байлаа. Хамгийн богино зөрчлийн хэргийн шүүх хуралдаан нийт есөн минут үргэлжилсэн нь хамгийн удаан буюу нийт 81 минут үргэлжилсэн зөрчлийн хэргийн шүүх хуралдаанаас 9 дахин богино үзүүлэлт байв. Хамгийн богино эрүүгийн хэргийн шүүх хуралдаан 24 минут үргэлжилсэн бол хамгийн удаан нь (хэдийгээр яллагдагч хэргээ хүлээсэн байсан ч) түүнээс 18 дахин урт хугацаанд буюу нийт 7 цаг 13 минут (433 минут) үргэлжилжээ. Бусад шүүх хуралдаануудтай харьцуулахад энэхүү шүүх хурал маш удаан үргэлжилсэн бөгөөд хоёр дахь хамгийн урт үргэлжилсэн эрүүгийн хэргийн шүүх хуралдаан түүнээс хоёр дахин богино хугацаанд буюу 3 цаг, 37 минут (217 минут) үргэлжилсэн байв. Шүүх хуралдаан үргэлжилсэн медиан хугацаа зөрчлийн хэрэгт 25 минут байсан бол эрүүгийн хэрэгт 1 цаг болон 43.5 минут (103.5 минут) байлаа.

Түүнчлэн шүүх хуралдаан эхэлсэн, дуусан хугацааг тэмдэглэж авахад гурван хэргийн шүүх хуралдаан нь шүүхийн ажиллах хуваарийг хэтрүүлэн 18:25, 19:40, 20:55 цагуудад дуусан болохыг энд тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж байна.

11.4.3. Шүүхийн хэлэлцүүлгийг хойшлуулсан тохиолдол

Шүүх бүрэлдэхүүн нэгээс олон хуралдсан нийт долоон тохиолдол байсан бөгөөд бүх тохиолдолд шүүхийн эхний хуралдааны явцад оролцогч тал эсхүл албан тушаалтны хүсэлтээр хойшлуулсан. Харин шүүх бүрэлдэхүүн гурван удаа хуралдсан нэг хэргийн хувьд эхний хоёр хэлэлцүүлгийг хийсний дараа шүүх хуралдааныг дахин хойшлуулсан юм. Шүүгч, улсын яллагч, яллагдагч болон түүний өмгөөлөгчийн зүгээс дараах үндэслэл, шалтгаанаар шүүх хуралдааныг хойшлуулсан байна. Үүнд:

- хохирогч хүрэлцэн ирээгүй;
- шүүгдэгчийн өмгөөлөгч хүрэлцэн ирээгүй;
- өмгөөлөгч авах хүсэлт гаргасан;
- нэмэлт дүн шинжилгээ, туршилт эсхүл үзлэг хийлгэхээр шүүх хуралдааныг хойшлуулсан хоёр тохиолдол байснаас нэгийг нь шүүхийн санаачилгаар, нөгөөг нь шүүгдэгчийн өмгөөлөгчийн хүсэлтээр хойшлуулсан;
- шүүгдэгч хохирлыг нөхөн төлөх санал гаргасан;
- хоёр өөр хуралдааны яллагдагч нь шүүх хуралдаанд согтуу ирсэн.

Шүүх хуралдаануудыг 5-аас 58 хүртэл хоногоор хойшлуулсан байв. Нэгэн хэргийн шүүх хуралдааныг эхний шүүхийн хуралдааны дараа 58 хоногоор, хоёр дахь хуралдааны дараа 42 хоногоор тус тус хойшлуулсан нь ажиглалт явуулсан бусад хэргүүдээс хамаагүй урт хугацаагаар хойшлуулсан тохиолдол байв. Тухайн хэргийн эхний хэлэлцүүлгээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан бол дараагийн хэлэлцүүлгээс өмнө хохирогч нас барсан тул хуралдаан эхлэхээс өмнө цогцост шинжилгээ хийлгэх хүсэлтэд үндэслэн шүүх хуралдааныг хойшлуулсан байна. Энэ онцгой тохиолдлыг эс тооцвол шүүх хуралдааныг дунджаар долоо хоногийн хугацаагаар хойшлуулж байв.

Яллагдагч нь шүүх хуралдаанд согтуу ирсний улмаас хойшлогдсон хоёр шүүх хуралдааны үеэр яллагдагчийг дараагийн шүүхийн хэлэлцүүлгээс өмнө 24 цаг эрүүлжүүлэх байранд байлгахыг шүүхийн зүгээс даалгасан байна.

11.5. Шүүх хуралдааны оролцогчдын талаар

11.5.1. Хохирогчид

Таван хохирогч тутмын хоёр (26 хохирогч буюу 42.6 хувь) нь холбогдох хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаанд бүрэн биечлэн оролцсон. Хохирогчдын 57.4 хувь (35 хохирогч) нь шүүх хуралдаанд биечлэн оролцоогүйгээс хоёр эмэгтэй болон нэг хүү буюу нийт гурван хохирогч нас барсан тул оролцоогүй бөгөөд шүүхээс эдгээр хэргүүдэд ГБХ үйлдэгч нь хохирогчийн үхэлд гэм буруутай хэмээн тус бүр шийдвэрлэсэн байна. Хохирогчид шүүх хуралдаанд биечлэн оролцсон эсэх талаар дэлгэрэнгүй мэдээллийг доорх **Хэсэг 13.1**-ээс үзнэ үү.

11.5.2. Шүүх бүрэлдэхүүн

Бараг бүх хэргийг (52 хэрэг буюу 91.2 хувь) нэг шүүгч дангаараа шийдвэрлэв. Үлдсэн таван хэрэг буюу 8.8 хувь нь гурван шүүгчдийн бүрэлдэхүүнтэй шийдвэрлэсэн эрүүгийн хэргүүд байлаа. Түүврийн дагуу ажиглалт хийсэн шүүх хуралдаануудад шүүгчдийн дийлэнх нь эрэгтэй шүүгчид байв. Тодруулбал нийт 66 шүүгчээс ойролцоогоор гуравны хоёр (41 шүүгч эсхүл 62.1 хувь) нь эрэгтэй, 25 (37.9 хувь) нь эмэгтэй шүүгч байлаа. Ажиглалт явуулсан хэргүүдийн талаас илүү хувийг (35 хэрэг буюу 61.4 хувь) нь эрэгтэй шүүгч дангаараа хянан шийдвэрлэсэн байв. Ажиглалт явуулсан шүүхүүдийн бараг тал хувьд (44.4 хувь) эмэгтэй шүүгч хэргийг хянан шийдвэрлэсэн тохиолдол гараагүй, нэрлэвэл Улаанбаатар хотын Чингэлтэй, Сонгинохайрхан, Налайх дүүргийн болон Ховд аймгийн шүүх орно.

11.5.3. Улсын яллагч

Нийт 57 шүүх хуралдаанд ажиглалт хийхэд бараг тэн хагаст (27 хэрэг буюу 47.4 хувьд) нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавьж байгаагүй прокурор оролцсон юм. Ажиглалт хийсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуралдаануудын гуравны нэгээс илүү хувьд (18 хуралдаанаас 7 буюу 38.9 хувьд) нь, зөрчлийн хэргүүдийн талаас дээш хувьд (20 хэрэг буюу 51.3 хувьд) нь, мөн Өвөрхангай аймгийн шүүхээс бусад бүх шүүхэд энэ байдал ажиглагдсан. Иймд үүнийг улсын хэмжээнд зөвшөөрөгдсөн практик гэж үзлээ. Гэтэл прокурорын чиг үүргийг ийнхүү шүүх хуралдаанд яллах чиг үүрэгтэй, хяналт тавих чиг үүрэгтэй байхаар хоёр хувааж байгаа нь хэрэгтэй танилцах хангалттай хугацаа байгаагүй бол яллах чиг үүрэгтэй прокурор хэргийг шударгаар хянан шийдвэрлэж, шударга ёсыг тогтоохдоо алдаа гаргах эрсдэлийг дагуулна гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй. Үнэхээр ийм тал гарч байгаа нь шүүх хуралдааны ажиглалтын явцад ч ажиглагдсан бөгөөд зарим тохиолдолд улсын яллагч (түүний ялласны дагуу шүүгч) хянан шийдвэрлэж байгаа хэрэгт ач холбогдолтой байж болох асуудлыг харгалзаж үзэхгүй өнгөрүүлж байсан юм.

Ажиглалт явуулсан 57 шүүх хуралдааны шүүхийн өмнөх шат, шүүх хуралдааны шат аль эсхүл аль алинд нь нийт 86 прокурор оролцсон ажээ. Прокуроруудын гуравны хоёр буюу 60 нь эмэгтэй, үлдсэн 26 нь эрэгтэй прокурор байв. ГБХ-тэй холбоотой эрүү, зөрчлийн хэргийн шүүхийн өмнөх болон шүүхийн аль ч шатанд эмэгтэй прокуроруд илүү оролцож байгаа нь шүүх хуралдааны ажиглалт хийсэн нийт шүүхүүдийн дийлэнхэд (8 шүүх буюу 88.9 хувьд) нь ажиглагдлаа. Ажиглалт явуулсан шүүхүүдээс зөвхөн Архангай *аймгийн* шүүхэд эрэгтэй прокуроруудын оролцоо давамгай байв.

11.6. Өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгч

11.6.1. Хохирогчийн өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч

Хохирогчдын дийлэнх (86.9 хувь) нь шүүх хуралдаанд өмгөөлөгчгүй оролцсон. Нийт 61 хохирогч байснаас найман хохирогч л өмгөөлөгчтэй оролцсон бөгөөд зөрчлийн хэргээс илүүтэйгээр буюу өмгөөлөгчтэй оролцсон найман хохирогчдын долоо нь эрүүгийн хэргийн шүүх хуралд оролцсон байв. Хохирогчийн талын өмгөөлөгчид эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийг ижил тэнцүү хувиар төлөөлсөн байлаа.

Хохирогчийг өмгөөлөгчөөс бусад этгээд (асран хамгаалагч) төлөөлсөн таван тохиолдол байсан бол Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хохирогчийг төлөөлж оролцсон гурван тохиолдол байлаа. Гэвч нэг талаараа хохирогчид өмгөөлөгч авсан ч хууль ёсны төлөөлөгчөөр эрх ашгаа давхар төлөөлүүлэх явдал нийтлэг ажиглагдлаа. Үүнд таван хохирогчдын дөрөв нь өмгөөлөгч болон хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан шүүх хуралд оролцсоныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Эсрэгээрээ таван хохирогч тутмын дөрөв (80.3 хувь) нь өмгөөлөгчгүйн зэрэгцээ хууль ёсны төлөөлөгчөөр төлөөлүүлэхгүй шүүх хуралдаанд өөрөө оролцсон байв. Иймд хохирогчдын зарим нь хууль зүйн төлөөллийн олон хэлбэрээр төлөөлүүлж, хууль зүйн туслалцаа авч чаддаг байхад үлдсэн хэсэг нь огт төлөөлөлгүй, хууль зүйн туслалцаагүйгээр шүүх хуралд оролцох хандлагатай гэж дүгнэж байна.

11.6.2. Шүүгдэгчийн өмгөөлөгч

Нийт яллагдагч, шүүгдэгчдийн ойролцоогоор дөрөвний гурав (71.9 хувь) нь шүүх хуралдаанд өмгөөлөгчгүй оролцсоноос үзэхэд хохирогчдоос илүү гэмт хэрэг, зөрчилд холбогдогч тал нь өмгөөлөгч авах нь нийтлэг байдаг гэж дүгнэж болохоор байна. Нийт 57 холбогдогчийн 16 (буюу 28.1 хувь) нь шүүх хуралдаанд өмгөөлөгчтэй оролцсон бол эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд яллагдагч нь хоёр өмгөөлөгчтэй оролцсон хоёр тохиолдол байлаа. Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон хүмүүсийн өмгөөлөгчдийн дөрөвний гурав (12 өмгөөлөгч буюу 75 хувь) нь тухайн холбогдогч өөрөө эсхүл гэр бүлийнхэн нь хөлслөн авсан өмгөөлөгч байсан бол дөрвөн холбогдогч шүүх хуралдаанд томилогдсон өмгөөлөгчтэй оролцсон байна. Эрэгтэй өмгөөлөгчдийн тоо эмэгтэй өмгөөлөгчдөөс хоёр дахин их буюу нийт 12 эрэгтэй, 6 эмэгтэй өмгөөлөгч шүүгдэгчийн өмгөөлөгчөөр шүүх хуралдаанд оролцжээ.

11.7. Хохирогч, яллагдагчдын хүн ам зүйн үзүүлэлтүүд

11.7.1. Жендер болон насны үзүүлэлтүүд

Ажиглалт явуулсан шүүх хуралдаануудад ГБХ-ийн хохирогчид нь ерөнхийдөө эмэгтэй хүмүүс байв. Хохирогчид бараг бүгдээрээ буюу нийт 61 хохирогчийн 91.8 хувь (56 хохирогч) нь эмэгтэйчүүд байсан билээ. Эдгээр 56 эмэгтэй хохирогч нь төрөл бүрийн насны бүлгийн төлөөллийг хамарсан байв. Тухайлбал тэдний дотор 8, 9, 13 настай охид, 60-аас дээш насны таван эмэгтэй байсан бол хамгийн ахмад нь 84 настай эмэгтэй байлаа. Харин насанд хүрсэн эмэгтэй хохирогчдын хувьд 20-39 насны бүлгийнхэн хамгийн олон байсан бөгөөд нийт эмэгтэй хохирогчдын медиан нас нь 33.5 байсан юм. Ерөнхийдөө таван хохирогч тутмын хоёр нь 30-39 насны хүмүүс байсныг доорх **Дүрс 11**-ээс харж болохоор байна.

Дүрс 11: *Хохирогчид насны бүлгээр*

Харин судалгаанд хамрагдсан яллагдагчид нь бүгд насанд хүрсэн буюу 19-65 насны хүмүүс байв. Нийт яллагдагчдын медиан нас 35 байсан бол тэдний бараг тэн хагас нь 25-34 насныхан байсныг доорх **Дүрс 13**-аас харж болохоор байна.

Дүрс 12: *Яллагдагчид хүйсээр*

Харин судалгаанд хамрагдсан яллагдагчид нь бүгд насанд хүрсэн буюу 19-65 насны хүмүүс байв. Нийт яллагдагчдын голч нас 35 нас байсан бол тэдний бараг тэн хагас нь 25-34 насныхан байсныг доорх **Дүрс 13**-аас харж болно.

Дүрс 13: *Шүүгдэгч (холбогдогч)-ийн нас*

Түүнчлэн 8 настай охиноо зодсон хэрэгт холбогдон нэг эмэгтэй яллагдагчаас бусад нь бүгд (56 яллагдагч буюу 98.2 хувь) эрэгтэй яллагдагчид байсныг доорх **Дүрс 14**-т харууллаа.

Дүрс 14: *Шүүгдэгч (холбогдогч) хүйсээр*

11.7.2. Хохирогч, яллагдагчдын хоорондын харилцаа, хамаарлын үзүүлэлтүүд

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид нь голдуу (43 хохирогч буюу 70.5 хувь нь) өөрсдийн эхнэр, нөхөр, эсвэл хамтран амьдрагчийн хүчирхийлэлд өртсөн байх бөгөөд судалгаанд хамрагдсан хосууд бүгд хетеросексуаль буюу эсрэг хүйстэндээ татагдах бэлгийн чиг баримжаатай байлаа. Гэр бүлийн бусад төрлийн харилцан хамаарлыг авч үзвэл бусад хохирогчдын дийлэнх нь яллагдагчийн хүүхэд эсвэл эцэг эхийн нэг (хүүхэд, эцэг эх тус бүр 6 хохирогч буюу тус бүр 9.8 хувь) нь байна. Эдгээрээс бусад хохирогчид нь яллагдагчдын хуучин эхнэр эсвэл нөхөр, дотно харилцаатай хамтран амьдрагч, ахан дүүсийн холбоотой (энд дурдсан хохирогчид тус бүр 1.6 хувийг эзэлнэ) байна. Түүнчлэн бидэнд өгсөн мэдээллээс хохирогч, ГБХ үйлдэгч нар хоорондоо хууль ёсны эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эсвэл бэлгийн хамтрагчийн аль төрлийн харилцаатай болохыг тогтоох боломжгүй хоёр тохиолдол гарсан.

11.7.3. Орон сууцын нөхцөл байдал

ГБХ-ийн нийт 61 хохирогчоос дийлэнх (55 хохирогчид буюу 90.2 хувь) нь яллагдагчтай хамт амьдардаг байхдаа хүчирхийлэлд өртжээ.

Дүрс 15: *ГБХ үйлдэх үед хохирогч, яллагдагч нар хамт амьдардаг байсан эсэх*

Хүчирхийлэл үйлдэгчтэй нэг гэрт амьдарч байсан хохирогчдын гуравны хоёр (37 хохирогч буюу 67.3 хувь) нь *гэр хорооло*лд амьдардаг байжээ. Түүнчлэн түүвэрт багтсан аймгуудад ч хохирогчид нь *гэр хорооло*лд амьдардаг байсан тохиолдол маш нийтлэг байв. Тодруулбал түүвэрт багтсан аймгуудад ГБХ үйлдсэн этгээдтэй нэг гэрт амьдарч байсан бараг л бүх хохирогч (27 хохирогчдын 24 нь буюу 88.9 хувь) нь *гэрт* амьдарч байсан байна. Үүнийг Улаанбаатар хотод амьдардаг хохирогчидтой харьцуулж үзэхэд нийслэлд амьдардаг 34 хохирогчийн 13 (39.2 хувь) нь л *гэр хорооло*д амьдардаг байв. *Гэр хорооллоос бусад* орон сууцны нөхцөлүүдийг авч үзвэл ГБХ үйлдэгдсэн орчин нөхцөлийн хамгийн түгээмэл хоёр дахь хэлбэр нийтийн орон сууцны байшин (12 хохирогч буюу 21.8 хувь) байсан бол үүний дараа сууцны тусдаа байшин (5 хохирогч буюу 9.1 хувь) орсон байна.

Сууцны тусдаа байшинд амьдардаг хүмүүс ГБХ-ийн ноцтой хэрэг үйлдэх эсхүл ийм хэрэгт өртөх нь бага байгаа нөхцөл байдал ажиглагдлаа. Тодруулбал сууцны тусдаа байшинд хохирогч, холбогдогч нар нь хамт амьдардаг нөхцөлд үйлдэгдсэн ГХБ-ийн таван тохиолдлын нэгт нь л хүнд гэмт хэргээр ял оногдуулсан давтамж харагдаж байна. Орон сууцын нөхцөл болон үйлдсэн хэрэг, ногдуулсан ял шийтгэлийн хэмжээний хооронд өөр мэдэгдэхүйц харилцан хамаарал ажиглагдаагүй болно.

11.7.4. Боловсролын үзүүлэлтүүд

Бидэнд өгсөн мэдээлэлд үндэслэн насанд хүрсэн 56 хохирогчийн болон бүх яллагдагчдын боловсролын түвшинг нь тогтоох боломжтой байсан бөгөөд хохирогч, яллагдагчдын аль аль бүлгийнх нь хамгийн өндөр боловсролын медиан түвшин бүрэн дунд боловсрол байлаа. Мөн хохирогчдын медиан бүлэг эмэгтэй байсан бол яллагдагчдын медиан бүлэг эрэгтэйчүүд байх агаад аль аль бүлгийн хувьд хамгийн өндөр боловсролын медиан түвшин нь мөн л бүрэн дунд боловсрол байх ажээ. Харин насанд хүрсэн цорын ганц эрэгтэй хохирогч болох 67 настай эрэгтэй нь дээд боловсрол эзэмшсэн байсан бол насанд хүрсэн ганц эмэгтэй яллагдагч байсан нь бүрэн бус дунд боловсролтой байлаа.

Яллагдагчдын хувьд тэдний боловсрол нь гэмт хэрэг үйлдэж учруулсан хор аюулын хэр хэмжээтэй урвуу хамааралтай байна. Өөрөөр хэлбэл яллагдагчийн үйлдсэн хүчирхийллийн нийгмийн хор аюулын хэр хэмжээ их байх тусам боловсролын түвшин доогуур байх ажээ. Үүний зэрэгцээ зөрчлийн хэрэгт шийтгэгдсэн хүчирхийлэл үйлдэгчдийн эзэмшсэн хамгийн өндөр боловсролын голч түвшин нь бүрэн дунд боловсрол байсан бол гэмт хэрэгт яллагдагчдын хувьд энэ үзүүлэлт бүрэн бус дунд боловсрол болж багассан нь ажиглагдсан. Харин хохирогчдын боловсролын түвшин хүчирхийллийн хор аюулын хэр хэмжээтэй аливаа байдлаар холбоогүй байх бөгөөд үйлдэгдсэн хүчирхийлэл нь зөрчлийн эсвэл гэмт хэргийн шинжтэй байсан эсэхээс үл хамаарч эзэмшсэн хамгийн өндөр боловсролын медиан түвшин нь нэгэн ижил бүрэн дунд боловсрол гэж гарч байсан юм.

11.7.5. Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

Энэхүү судалгааны түүвэрт багтсан шүүх хуралдаануудын оролцогчдоос хөдөлмөрийн насны хүмүүсийн дэд бүлгийг сонгохдоо одоогийн Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн насны доод хязгаар болох 16 нас аль эсхүл эцэг эх

зөвшөөрсний үндсэн дээр 15 нас[14] гэсэн зохицуулалт болон хүний төрсөн жил, хүйсээр нь шатлан өөрчлөгдөх байдлаар ангилсан тэтгэврийн насыг тодорхойлсон[15] зохицуулалтад тус тус үндэслэн сонгосон болно. Түүврээс дэд бүлгийг ийнхүү тооцож үзэхэд хууль тогтоомжид заасан хөдөлмөрийн насны 48 хохирогч (78.7 хувь), гэмт хэрэг, зөрчлийн 55 холбогдогч (96.5 хувь) байлаа. Ажил хөдөлмөр эрхлэх насанд хүрээгүй долоон хохирогч, харин тэтгэврийн насны зургаан хохирогч болон хоёр яллагдагч байв.

Хөдөлмөрийн насны хохирогчдын бараг тал (24 хохирогч) нь ГБХ үйлдэгдэх үед хөдөлмөр эрхэлж байсан байна. Харин ажил хөдөлмөр эрхэлж байсан хүчирхийлэл үйлдэгчдийн тоо нь хөдөлмөр эрхэлж байсан хохирогчдын тооноос илүү буюу хуульд заасан хөдөлмөрийн насны хүчирхийлэл үйлдэгчдийн гуравны хоёр орчим (37 яллагдагч буюу 67.3 хувь) нь ажил хийдэг байсан.

Хохирогчдын ажил эрхлэлт нь ГБХ-ийн нийгмийн хор аюулын хэр хэмжээтэй эерэг харилцан хамааралтай байсан нь ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, ажил хийдэг хохирогчид зөрчлийн хэргийн золиос болох (зөрчлийн хэрэгт хохирсон хөдөлмөрийн насныхны 45.4 хувь)-оос илүүтэйгээр ГБХ-ийн шинжтэй гэмт хэрэгт хохирсон (эрүүгийн хэрэгт хохирсон хөдөлмөрийн насны хохирогчдын 53.3 хувь) нь илүү нийтлэг байв. Нөгөөтэйгүүр хүчирхийлэл үйлдэгчдийн ажил эрхлэх байдал нь тэдний үйлдсэн хүчирхийллийн нийгмийн хор аюулын хэр хэмжээтэй төдийлөн хамааралгүй байгаа нь ажиглагдсан. Тодруулбал хөдөлмөрийн насны нийт холбогдогчдын 64.7 хувь нь эрүүгийн хэрэгт холбогдсон бол үүнтэй ойролцоо буюу 66.7 хувь нь зөрчлийн хэрэгт холбогдон шалгагдсан байлаа.

Харин ажилгүйдэлтэй холбоотой харилцан хамаарлыг судалж үзэхэд судалгаанд хамруулсан хүчирхийллийн нийт тохиолдлуудаас 22.8 хувь (13 хэрэг)-д нь ГБХ-ийн хүчирхийлэл үйлдэгдэх үед хосын харилцаатай хамт амьдарч байсан хохирогч, яллагдагчийн аль аль нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй байсан болохыг энд дурдах нь зүйтэй байна. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн насны хохирогч ажилгүй байсан тохиолдлуудад ихэвчлэн хүчирхийлэл үйлдэгчтэй хамт амьдардаггүй байсан нь ажиглагдсан бөгөөд тэд мөн адил ажил эрхэлдэггүй гэр бүлийн харилцаатай хүний ГБХ-ийн үйлдэлд хохирсон нь илүү нийтлэг (хөдөлмөрийн насны ажилгүй хохирогчдын 54.2 хувь) байлаа. Түүнчлэн ийм нөхцөлд байсан бүх хосуудын эмэгтэй нь хохирч, эрэгтэй нь хүчирхийлэл үйлдсэн байв.

Судалгаанд хамрагдсан хохирогч, яллагдагчдын ажилгүйдлийн хувь хэмжээ нь Монгол Улсын ажилгүйдлийн ерөнхий түвшнээс хамаагүй өндөр байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Ажилгүйдлийн ерөнхий түвшин улсын хэмжээнд 6.6 хувьтай байсан[16] бол судалгаанд хамрагдсан хохирогчдын 50 хувь, хүчирхийлэл үйлдэгчдийн 33.7 хувь нь тус тус ажилгүй байсан юм. Судалгаанд хамрагдсан хүчирхийлэл үйлдэгч, хохирогчдын аль аль нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй байгаа байдал нь улсын ажилгүйдлийн түвшнээс хамаагүй өндөр болох нь үүнээс харагдаж байна.

---

[14] *Хөдөлмөрийн тухай хуулийн 108.1-р болон 108.2-р зүйлүүд*
[15] *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн* 2-р зүйл
[16] Монголын Үндэсний статистикийн хороо.

11.7.6. Гэмт хэргийн түүх

Энэхүү судалгаанд хамрагдсан нийт хүчирхийлэл үйлдэгчдээс 51 хүний өмнө нь зөрчил эсхүл гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг нь судалж тогтоох боломжтой байв. Өмнө нь ял, шийтгэл эдэлж байсан болон байгаагүй хүмүүсийн хувь хэмжээ нь хоорондоо маш бага ялгаатай байлаа. Судалгааны явцад ГБХ-ийн шинжтэй гэмт хэрэг, зөрчилд холбогдон шүүгдэж байсан эдгээр хүмүүсийн 49.1 хувь нь өмнө нь ял, шийтгэл эдэлж байсан бол урьд нь ял, шийтгэл эдэлж байгаагүй хүмүүсийн эзлэх хувь хэмжээ арай бага буюу 40.4 хувь байсан болохыг доорх **Дүрс 16**-аас харж болно.

Дүрс 16: *Хүчирхийлэл үйлдэгчид өмнө нь ял, шийтгэл эдэлж байсан эсэх*

Нэгэн тохиолдолд хүчирхийлэл үйлдэгч өмнө нь нийт 32 удаа эрүүлжүүлэх байранд саатуулагдаж байсан бол өөр нэг тохиолдолд холбогдогч нь тухайн хүчирхийллийг үйлдэхээсээ нэг сарын л өмнө ГБХ-ийн өөр нэг үйлдэлдээ зөрчлийн шийтгэл эдэлж дууссан байв. Түүнчлэн өмнө нь хэд хэдэн удаа ГБХ үйлдэж эхнэр, хүүхдүүдээ хохироож байсан этгээд анх удаа ГБХ-ээр шалгагдаж байгаа тохиолдол ч гарсан юм.

Судлаачид ГБХ-ийг үйлдсэн этгээдийн үйлдэл нийгмийн хор аюулын хэр хэмжээгээр илүү их байх тусам тухайн этгээд өмнө нь зөрчил, гэмт хэрэг үйлдэж байсан байх магадлал өндөртэй гэж таамаглаж байсан боловч бодит байдал дээр яг эсрэгээрээ байсан юм. Судалгаанд хамрагдсан хүчирхийлэл үйлдэгчдийн хувьд тэдний ял, шийтгэл эдэлж байсан байдал болон тэдэнд холбогдуулан шалгаж байгаа зөрчил, гэмт хэргийн нийгмийн аюулын хэр хэмжээний хооронд урвуу харилцан хамаарал байгаа нь ажиглагдсан юм. Тодруулбал, өмнө нь ял, шийтгэл эдэлж байсан этгээдүүд эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдах (эрүүгийн хэргийн яллагдагчдын 47 хувь)-аас илүүтэйгээр зөрчлийн хэрэгт шалгагдсан (зөрчлийн хэрэгт холбогдогчдын 58.8 хувь) нь нийтлэг байлаа. Гэтэл эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан хүмүүсийн ихэнх (52.9 хувь) нь өмнө нь ял, шийтгэл эдэлж байгаагүй хүмүүс байсан юм.

Шүүх хуралдаанд ажиглалт хийх энэхүү судалгааны загварыг боловсруулахаар зөвлөлдөж байхад Монгол Улсын Дээд шүүхээс ГБХ-ийн ижил үйлдэлтэй зөрчилд 3 удаа шийтгэл хүлээсэн этгээдийг ГБХ үйлдэх гэмт хэрэг үйлдсэнд тооцож ял оногдуулж шийдвэрлэх жишгийг гаргасан талаар мэдээлж байсан юм. Тухайлбал, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон гэмт үйлдэлд ял оногдуулахад тухайн этгээд өмнө нь гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон гурван үйлдэлдээ зөрчлийн шийтгэл эдэлсэн байхыг шаарддаг байна.

Ажиглалт явуулсан шүүх хурлуудаас ч практик дээр энэхүү жишгийг бодитоор хэрэглэж байгаа нь ажиглагдсан юм. Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан ГБХ үйлдэх гэмт хэргийн таван шүүх хуралдаанд ажиглалт хийхэд дөрвөн хэргийнх нь яллагдагчдын өмнө нь ял, шийтгэл эдэлж байсан эсэхийг тогтоох боломжтой байсан. Хэдийгээр бидэнд өгсөн мэдээлэлд ижил үйлдэлтэй зөрчлийн хэрэгт өмнө шийтгэл эдэлж байсан гэж шууд тэмдэглээгүй байсан ч энэ таван тохиолдлын олонход (гурван хэрэг буюу 75 хувьд) нь яллагдагч урьд нь ял, шийтгэл эдэлж байсан болох нь тогтоогдсон юм. Харин Өвөрхангай аймагт шийдвэрлэсэн нэгэн гэмт хэргийн яллагдагч өмнө нь ял, шийтгэл эдэлж байгаагүй боловч Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ГБХ үйлдэх гэмт хэрэгт яллагдсан бөгөөд тухайн этгээд эмзэг бүлгийн хүн (хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн)-ий эсрэг ГБХ үйлдсэн байсан юм.

12. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үзүүлэлт

Шүүх хуралдааны ажиглалтын судалгааны хэрэглэгдэхүүн нь таван хэсэгтэй бөгөөд эдгээрээс дараах гурван хэсэг нь гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх үйл ажиллагаанд хуульд заасан шаардлагуудыг хэрхэн хэрэгжүүлж байгааг шалган үнэлэхэд чиглэсэн байлаа. Үүнд: Хохирогчийн эрхийг хангасан эсэхийг үнэлэх **(Хэсэг II)**, Шүүх хуралдааны явцад шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийг хангасан эсэхийг үнэлэх **(Хэсэг III)** болон Шүүхийн өмнөх шатанд болон гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх бүх шатны үйл ажиллагаанд гэмт хэргийн яллагдагч эсвэл зөрчлийн холбогдогчийн эрхийг хангасан эсэхийг үнэлэх **(Хэсэг IV)** хэсгүүд хамаарна. Хэсэг тус бүр гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх явцад хохирогчийн болон гэмт хэргийн яллагдагч эсвэл зөрчлийн холбогдогчийн тусгайлан эдлэх ёстой эрхүүдийг нь хангаж хэрэгжүүлсэн байдлыг үнэлэх хэд хэдэн бүлгүүдээс бүрдэж байгаа болно. Жишээлбэл: Шүүх хуралдааны ажиглалтын судалгааны хэрэглэгдэхүүний **Хэсэг II**-ын Бүлэг IV-өөр хохирогчдын хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хэрэгжилтийг үнэлсэн юм.

Шүүх хуралдааны ажиглалтын судалгааны хэрэглэгдэхүүнийг ашиглан үнэлсэн эрх тус бүрийн хэрэгжилтийг нэг бүрчлэн бодож үнэлгээг гаргасан бөгөөд үүний дараа гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд өгөх үнэлгээний үзүүлэлтүүд (Шүүх хуралдааны ажиглалтын судалгааны хэрэглэгдэхүүний Хэсэг V)-ийн дагуу тусад нь гаргасан үнэлгээнүүдийг нэгтгэж, ГБХ-ийн тохиолдол тус бүрийн хувьд нэгдсэн үнэлгээг тооцож гаргасан болно. Ингэснээр эцэст нь хохирогчийн эрхийн хэрэгжилт, хүчирхийлэл үйлдэгчийн эрхийн хэрэгжилт гэсэн хоёр төрлийн нэгдсэн үнэлгээг тооцож гаргасан бөгөөд өмнө дурдсанчлан хүчирхийлэл үйлдэгчийн эрхийн хэрэгжилтийг шүүхийн өмнөх шат болон гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх бүх шатыг хамруулсан байдлаар үнэлсэн болно.

Судалгааны энэхүү хэсэгт хохирогчийн болон гэмт хэргийн яллагдагч эсвэл зөрчлийн холбогдогчийн тусгайлан эдлэх ёстой эрхүүдийг нь хангаж хэрэгжүүлсэн байдлыг ГБХ-ийн тохиолдол бүрээр ангилан танилцуулна. Харин энэхүү судалгааны тайлангийн сүүлийн хэсгүүдэд эрх тус бүрийн хэрэгжилтийн үнэлгээнүүдийг тусад нь дэлгэрэнгүй тайлбарласан болно.

ГБХ үйлдэгдсэн тохиолдлоор нь ангилж үзвэл хохирогчийн эдлэх эрхүүдийг хангасан байдлын нэгдсэн үнэлгээний медиан нь судалсан 57 тохиолдлын хувьд “Маш сайн” гэсэн үнэлгээ авсан. Шүүхээр шийдэгдсэн эдгээр хэргүүд бараг бүгд (53 хэрэг буюу 93 хувь) хохирогчийн эрхийг

хангасан үзүүлэлтээрээ нэгдсэн үнэлгээний боломжит хамгийн өндөр түвшин болох “Маш сайн” үнэлгээнд хүрсэн бол үлдсэн дөрвөн хэрэг (бүх тохиолдлоос 7 хувь) нь “Сайн” гэсэн үнэлгээг авсан юм. Хохирогчийн эдлэх эрхийг хангасан байдлаар нь ГБХ-ийн тохиолдлуудыг ангилж үзвэл бүх үе шатанд мөн л медиан “Маш сайн” гэж гарсан. Гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд өгөх үнэлгээ ерөнхийдөө “Маш сайн”-аас “Маш муу” хүртэлх 5 шатлалт үнэлгээ байсан бөгөөд хохирогчийн эрхийн хэрэгжилт нэлээн доогуур буюу “Муу” гэж үнэлэгдсэн нэг л тохиолдол байсан гэдгийн дурдах нь зүйтэй байх.

Түүнчлэн ГБХ-ийн шинжтэй эрүү, зөрчлийн 57 хэргийг шийдвэрлэх явцад яллагдагч (холбогдогч)-ийн эдлэх эрхийг хангасан байдлыг үнэлж үзэхэд эрх тус бүрээр нь ангилж үзсэн ч, ГБХ-ийн тохиолдол бүрээр нь ангилж үзсэн ч эрхүүдийн хэрэгжилт медиан “Маш сайн” гэсэн үнэлгээг авсан. Яллагдагч (холбогдогч)-ийн эрхийг хангасан байдал нэлээн доогуур буюу “Муу” гэж үнэлэгдсэн нэг л тохиолдол мөн адил байсан болно.

Нэгдсэн үнэлгээ ерөнхийдөө маш өндөр гарч байсан нь сайн хэрэг боловч хохирогчдын болоод яллагдагч (холбогдогч)-ийн эрхтэй холбоотой анхаарвал зохих хэд хэдэн асуудал байсан юм. Гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд өгөх үнэлгээний үзүүлэлтүүдийн дагуу зөвхөн нэгдсэн үнэлгээ гаргаад л орхичихсон бол эдгээр асуудлуудыг анзаарахгүй өнгөрч болох байлаа. Энэ асуудлууд ил харагдахгүй байсан нь үнэлгээг тооцоолон бодсон аргачлалтай холбоотой доор дурдсан дөрвөн хүчин зүйлсээс шалтгаалсан гэж үзээд тухайн хүчин зүйлсийг доор тайлбарласан болно.

Юуны өмнө хувь хүний эдлэх эрх тус бүрд өгсөн үнэлгээг олон хүчин зүйлсэд тулгуурлан тооцсон. Шүүх хуралдааны ажиглалтын судалгааг хийхдээ эдгээр эрхүүдийн бүрэлдэхүүн тус бүрийг үнэлэхдээ хамгийн сайнаас эхлэн хамгийн муу хэрэгжилтээр шатлан дараалсан байдлаар яг ижилхэн оноогоор үнэлж дүгнэсэн юм. Гэвч энэ нь тухайн эрхийн хэрэгжилтийг нарийн тодорхой үнэлэх хэрэгсэл болж чадаагүй. Учир нь бодит байдал дээр дэд бүрэлдэхүүн хэсгүүд нь бүгд яг ижил ач холбогдолтой байгаагүй юм. Тиймээс тэдгээрийг тэнцүү жигнэх нь хэргийн зарим нөхцөл байдлыг хэт үнэлэх, мөн дутуу үнэлэхэд хүргэж байв. Тухайлбал, эрүү, зөрчлийн хэргийн шүүгдэгч (холбогдогч)-ийг эрүүдэн шүүсэн бөгөөд түүнийг залруулах эрхтэй болохыг нь таниулан тайлбарласан гэж үзвэл хэдийгээр эрүүдэн шүүлт нь хүний эрхийн хамгийн ноцтой зөрчлүүдийн нэг учир “Маш муу” гэж үнэлэх ёстой байсан ч шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний дагуу үнэлэхэд эрхийг нь тайлбарлаж өгсөн тул “Сайн” гэсэн үнэлгээг өгөхөөр байв. Үүний зэрэгцээ энэхүү хязгаарлагдмал байдлыг шийдвэрлэхийн тулд хэрэглэгдэхүүн дэх асуулт тус бүрт өөр өөр оноо өгч жигнэн харьцуулах шаардлага гарах байсан бөгөөд хэрэв тийм байдлаар хэрэглэгдэхүүнийг өөрчилсөн бол уг судалгаа нь дэндүү их ажиллагаатай, хэт их хугацаа шаардсан судалгаа болж хувирахаар байсан тул хэрэглэгдэхүүнийг өөрчлөөгүй юм.

Хоёрдугаарт, судалгааны хэрэглэгдэхүүний бөглөх үзүүлэлтүүд нь зарим хэрэгт тохиромжгүй байх тохиолдол гарч эргэлзээ үүсгэж байсан юм. Шүүх хуралдааны ажиглалтын явцад ажиглагчдыг аль болох зөвхөн тухайн хэргийн нөхцөл байдалд хамааралтай асуултуудыг л бөглөхөөр даалгасан. Гэвч ажиглагчдад тодорхой асуултуудыг хэзээ яаж бөглөх тухай хэт олон төрлийн зааварчилгааг өгвөл эргэлзээ төрж, алдаа гарах эрсдэлтэй гэж эмээсэн юм. Практик дээр ч гэсэн ажиглагчид алдаа гаргахаас айж, улмаар харин ч өгөгдлийн алдаа гаргаж байсан нь анзаарагдсан билээ. Энэ эрсдэлийг бууруулахын тулд хэрэглэгдэхүүний загварын зарим хэсэгт ажиглагчид “Хамааралгүй” гэж хариулж болохоор оноотой асуултуудыг оруулсан бөгөөд “Хамааралгүй” гэж хариулсан бол, тухайн асуултад бүрэн оноог өгч дүгнэсэн юм. Аргачлалыг

өөрчилснөөр ажиглагчид алдаа гаргахаас сэргийлэх боломжтой гэж үзсэн боловч ийм байдлаар өгсөн оноонууд нь өгөгдлийн дүн шинжилгээний явцад оноо болон үнэлгээг хиймлээр нэмэгдүүлэх эрсдэл үүсгэж байв.

Гуравдугаарт дурдах өөр нэгэн хүчин зүйл нь үнэлгээний оноог тодорхой шатлалд хуваан үзсэн явдал байлаа. Үүнээс шалтгаалан эрүүгийн эсвэл зөрчлийн аль нэг хэргийг шийдвэрлэх явцад хүний эрхийг хангасан байдал нь “Маш сайн” гэж үнэлэгдсэн байж болох ч яг нарийн тооцоолж үзэхэд “Маш сайн” гэсэн үнэлгээний интервалд багтах хамгийн бага оноог авсан байх ч боломжтой (угтаа, ийм тохиолдол түгээмэл гарч байсан) байв.

Эцэст нь, энэхүү тайлан нь нийт үр дүнг **дунджаар** биш **медиан** үнэлгээ болон оноогоор үнэлсэн билээ. Энэ үйл ажиллагаанд өгөгдлийн тархалт хэлбийлттэй байгаа нь сайн туршлагатай нийцэж байна. Ийнхүү медиан үнэлгээгээр тооцоолсон ч хамгийн сайн, өндөр оноотой баруун тийш хэлбийлттэй кластерын зэрэгцээ ач холбогдол бүхий бага оноотой хэсэг нь ажиглагдахгүй байх тохиолдлууд үүсч байв.

Хэдийгээр шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картын үзүүлэлт чухал бөгөөд сайшаалтай ч өгөгдлийн нарийн ялгааг тодорхойлж, тайлбарласан нарийвчилсан дүн шинжилгээг хамтад нь авч үзэх нь чухал юм. (**13-аас 15 дугаар Хэсгүүд)**

13. Хохирогчийн эрх

Энэ хэсэгт нийт ажигласан хэргүүдэд оролцсон хохирогчдын талаарх **судалгааны үр дүнг** танилцуулж байна. Энд аюулгүй байх, зөрчил болон нөхөн сэргээх арга механизмтай холбоотой мэдээлэл авах эрх, холбогдох мэдээлэлтэй танилцах, тэгш болон үр нөлөөтэй шүүх дээр эрх зүйн туслалцаа авах, мөн өөрт учирсан хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй ба шуурхай нөхөн төлүүлэхтэй холбоотой хохирогчийн эрхүүдэд дүн шинжилгээ хийсэн юм. Тус дүн шинжилгээ нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний Хэсэг II-рт цугласан өгөгдөлд суурилсан болно. (**Хавсралт В**).

Хохирогчийн эдлэх эрхүүд дотроос аюулгүй байдал нь хамгийн доогуур үнэлгээтэй байсан хэдий ч медиан “Маш сайн” гэсэн үнэлгээ авсан. Нэгдүгээрт цагдаагийн ажилтнууд эрсдэлийн үнэлгээг бараг бүх тохиолдолд гүйцэтгэсэн байхад нийгмийн ажилтнуудын нөхцөл байдлын үнэлгээг зөвхөн гуравны нэгт нь хийсэн байв (**Хэсэг 13.1**-р). Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хааяа авч байсан ба энэ нь ихэнхдээ хохирогчийн хүсэлтээр хийгдсэн байна. Харин шүүхийн өмнөх шатанд сэтгэл зүйн туслалцааг тун ховор үзүүлсэн. Өөр нэгэн чухал дүгнэлт бол хохирогчид шүүх хуралдаанд оролцохгүй байхдаа тэд хамгийн аюулгүй байсан гэж үнэлсэн бол онооны картын үнэлгээгээр “Сайн” руу буурсан. Шүүх дээр оролцогчдыг тусдаа хаалгаар оруулах, аюулгүй байдлын шалгалт явуулах, аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын ажилтан дагалдуулсан нь тун ховор байсан боловч аюулгүй байдлыг сахин хангуулах цагдаагийн алба хаагчдын тоо ерөнхийдөө хангалттай байв.

Бараг бүх хохирогч нь шүүгдэгч, холбогдогчдын хамтаар нэг хүлээлгийн танхимд хамтдаа байсан. Гэхдээ ихэнх хохирогчид нь аюулгүй байдлыг хангах, тусламж үзүүлэх арга хэмжээнүүдийн талаар сайн мэдэж байсан ба шүүх хуралдааны танхимд шүүгдэгч болон холбогдогч нараас тусдаа, зайтай сууж байв. Гэвч хохирогчдын дөрөвний нэг хувь нь хохирогчийг буруутгах, жендерийн хэвшмэл үзэлд тулгуурласан хандлагаар харилцах зэргээр сэтгэл санааны дарамтад дахин өртөх байдал ажиглагдсан бөгөөд зарим шүүгчдийн зүгээс ч ийм байдлаар хандах байдал гарсан. Ихэнх тохиолдолд шүүгдэгч, хохирогч нар нь шүүх хуралдааны танхимаас ээлжлэн бус нэгэн зэрэг гарч байсан бөгөөд аль ч хохирогчийг аюулгүй байдал хариуцсан албан хаагч дагалдан хамгаалж яваагүй.

Зөрчил болон нөхөн төлбөрийн арга механизмуудын талаар мэдээлэл авах хохирогчийн эрхтэй холбоотой үр дүнг **13.2-р хэсэгт** оруулав. Медиан “Маш сайн” үнэлгээ авсан боловч нийт хэргийн гуравны нэгээс илүү хэсэг нь “сайн”-аас “муу”-ийн хооронд оноо авсан байна. Ихэнх хохирогч нь өөрийн эдлэх эрх, хүлээх үүргийн тухай мэдээлэл болон тэдгээрийг тайлбарлуулан авсан бол тодорхой тооны хохирогчийн хувьд эрх, үүргийн талаар мэдсэн боловч тэдгээрийг тайлбарлаж өгөөгүйтэй холбоотой байж болзошгүй. Нийтлэг байдлаар авч үзвэл хохирогчдод хууль зүйн туслалцаа авах эрхийнх нь талаар маш сайн мэдээлэл өгсөн бол шүүхээс гарах цагаатгах болон шийтгэх тогтоолын хувийг гардан авах эрхийн талаар мэдээллийг муу өгчээ.

13.3-р хэсэгт авч үзсэнээр хохирогчид шүүхийн хэлэлцүүлэг, хуралдааны товыг ерөнхийдөө мэдэгдсэн; гомдол, хүсэлт гаргах хангалттай боломж нь олгогдсон; мэдүүлэг/тайлбар гаргахдаа элдэв дарамт шахалтаас ангид байх нөхцөлөөр хангуулсан болох нь ажиглагдсан.

Хохирогчоор тооцогдсон этгээдүүд нь хууль, шүүхийн байгууллагад хандах үр нөлөөтэй, тэгш боломжоор хангуулах эрхээр маш сайн хангагдсан гэж дүгнэсэн бөгөөд хохирогчийн эдлэх эрх дотроос хамгийн өндөр хэмжээнд хангагдаж, бүх хэргүүдэд медиан "Маш сайн" оноо авсан. **13.3-р хэсэгт** авч үзсэнээр хохирогчид шүүхийн хэлэлцүүлэг, хуралдааны товыг ерөнхийдөө мэдэгдсэн; гомдол, хүсэлт гаргах хангалттай боломж нь олгогдсон; мэдүүлэг/тайлбар гаргахдаа элдэв дарамт шахалтаас ангид байх нөхцөлөөр хангуулсан болох нь ажиглагдсан. Ихэнх шүүхийн шийдвэрийн хувьд хохирогчийн тайлбар/нотлох баримтыг хангалттай хэмжээнд судалж, дүн шинжилгээ хийсний үндсэн дээр гарсан байх (цөөн тооны хохирогчид тайлбар/нотлох баримт гаргасан) ба хохирогчид ямар нэг гэм хор, аюул учруулахуйц хандлагыг тусгаагүй байна. Гэвч шүүх хуралдаанд өөрийг нь буруутгах, эсхүл жендерийн хэвшмэл үзлээ тулгах зэрэг зохисгүй хандлагаар зарим хохирогчтой харилцсан бөгөөд ийм хандлага шүүгч нарын зүгээс хүртэл гарсан байв.

ГБХ-ийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нэхэмжлэлийг тун цөөн хохирогч гаргасан боловч хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй арга замаар, шуурхай нөхөн төлүүлэх эрхийг медиан "Маш сайн" үнэлгээ гарсныг **13.4 дүгээр хэсэгт** дэлгэрэнгүй танилцуулав. Хохирол нөхөн төлүүлэх талаар нэхэмжлэл гаргаагүй нийт хэргийн дөрөвний нэгт хохирогч нь уг хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байсан, ямар нөхөн төлбөр гаргуулж болох талаар мэдээлэлгүйн улмаас ийм хүсэлт гаргаагүй болох нь ажиглагдсан байна. Хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргасан хохирогч нь гол төлөв бие махбодод учруулсан гэмтэл, эдийн засгийн хувьд учирсан хохирол зэргийг нэхэмжилсэн байх бөгөөд ихэнх тохиолдолд хохирлыг бүрэн хэмжээгээр эсхүл бодит хохирлоос давсан хэмжээгээр олгохоор шийдвэрлэжээ. Харин эдгээрийн дотроос 30 орчим хувьд нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон боловч хохирлыг нөхөн төлүүлэх талаар шийдвэр гаргаагүй байна.

13.1. Хохирогчдын аюулгүй байдлын үнэлгээ

Энэ хэсэг нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 2-р Бүлгийн Хэсэг II (Аюулгүй байдлын үнэлгээ)-ийн дагуу цуглуулсан өгөгдөлд суурилсан болно. (**Хавсралт В)**

13.1.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэлийн үзүүлэлт

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний тусламжтайгаар хохирогчийн дөрвөн эрхийн хэрэгжилтийг үнэлснээс хохирогчийн аюулгүй байдлын эрх нь онооны картын хамгийн доод үнэлгээг авчээ. Хэдийгээр хохирогчийн аюулгүй байдалд нийтдээ "Маш сайн" үнэлгээгийн интервалын хамгийн өндөр оноо авсан ч хохирогчийн аюулгүй байдлын медиан оноо нь "Маш сайн" гэсэн үнэлгээний хамгийн доод шатлал байв. (76.4 хувь).

Түүвэрлэсэн хэргүүдийн ихэнх тохиолдолд (55.6 хувь) хохирогчид шүүх хуралдаанд оролцоогүй байхдаа хамгийн аюулгүй байсан. Хохирогчид шүүхэд хүрэлцэн ирээгүй үед тэдгээрийн аюулгүй байдлын үнэлгээ нь медиан "Маш сайн" буюу 87.5 хувь байна. Хохирогчид өөрсдийн хэргийн шүүх хуралдаанд оролцсон бол оноо 20 хувиар буурч, 65.4 хувь болж улмаар "Сайн" гэсэн үнэлгээ рүү буусан.

Аюулгүй байдлын хувьд хачирхалтай нь эрүүгийн хэргийн хохирогчдод учирч болзошгүй аюул нь зөрчлийн хэргийн хохирогчдоос бага гэж үнэлэгдсэн. Гэмт хэргийн хохирогчдын аюулгүй байдлын үнэлгээ нь медиан “Маш сайн” буюу 76.9 хувь байсан бол зөрчлийн хохирогчдынх 71.2 хувь буюу “Сайн” үнэлгээтэй гарсан. Гэвч шүүх хуралдаанд оролцсон эрүүгийн хэргийн хохирогчид хамгийн эрсдэлтэй бүлэг нь байсан. Тэдгээрийн аюулгүй байдал 55.8 хувь байж, үнэлгээ “Сайн” гэсэн доод хэмжээнд үнэлэгдсэн. Үүний зэрэгцээ эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд оролцоогүй хохирогчидтой харьцуулбал аюулгүй байдлын хувьд даруй 30 хувиар бага үзүүлэлт билээ (Шүүх хуралдаанд оролцоогүй хохирогчдын хувьд 87.5 хувийн оноотойгоор “Маш сайн” үнэлэгдсэн).

13.1.2. Хохирогчийн аюулгүй байдлын ерөнхий асуудлууд

ГБХТтХ-д цагдаагийн алба хаагч ГБХ-ийн аюулын зэргийн үнэлгээг, харин нийгмийн ажилтнууд нөхцөл байдлын үнэлгээ хийх тодорхой нөхцөлүүдийг тодорхойлсон байдаг. Ажиглагчид эдгээр үнэлгээг хийсэн эсэх, хэзээ хийсэн зэргийг үнэлэх оролдлого хийсэн. Цагдаагийн албан хаагчид үндсэндээ бүх хэргүүдэд (55 хэргүүд буюу 96.5 хувь) хохирогчоор тогтоогдсон этгээдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд аюулын зэргийн үнэлгээг хийсэн байна. Гэвч үүнээс хоёр хэрэгт, нэг нь яллагдагч хүүхдүүдийнх нь нүдэн дээр эхнэрээ зодож хөнөөсөн, нөгөө нь гэмтэл авсан байхад үнэлгээг хийгээгүй байв. Энэ хэрэгт аюулын зэргийн үнэлгээ хийх нь тодорхой мэт санагдана.

Ихэнх тохиолдолд (32 хэрэг буюу 56.1 хувь) нийгмийн ажилтнууд ГБХ, бусад хүчирхийлэл аль эсхүл бусад сөрөг үр дагаврын эрсдэлийг тооцохоор нөхцөл байдлын үнэлгээг хийгээгүй нь нэг талаараа эрсдэлийн түвшин нь бага эсхүл дунд байсан, нөгөөтэйгүүр хохирогчид үүнийг зөвшөөрөөгүй байх магадлалтай. Энэ нь ГБХТтХ-д заасан шаардлагуудтай нийцэж байв. Гэхдээ ажиглагчид ГБХТтХ-ийн дагуу зайлшгүй үнэлгээ хийх ёстой, эрсдэлийн түвшин өндөр байсан зургаан хэрэгт (10.5 хувь) нөхцөл байдлын үнэлгээ хийгдээгүйг илрүүлсэн юм. Үүнийг эс тооцвол, нөхцөл байдлын үнэлгээг бүх хэргүүдийн (19 хэрэг буюу 33.3 хувь) **гуравны нэгт** хийсэн байна.

Дүрс 17-т хохирогчоор тогтоогдсон этгээдийг хамгаалахаар аюулгүй байдлын арга хэмжээ авсан 11 хэргийг дэлгэрэнгүй танилцуулж байна. Тухайн арга хэмжээнүүдийн **арвыг** нь хохирогчдын хүсэлтээр хийсэн байна. Эдгээр арга хэмжээ нь юуны өмнө яллагдагч (холбогдогч)-ийг шүүхийн өмнөх шатанд үйлдлийг нь хязгаарлах зорилгоор нийт долоон хэрэгт (63.6 хувь) цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна. Бусад шүүхийн өмнөх шатны аюулгүй байдлын арга хэмжээнд хохирогчийг түр хамгаалах байранд байлгах эсхүл нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ багтжээ. Хохирогчийн байрлаж буй газрыг нууцалж, шүүгдэгчийг түүнтэй уулзахыг хориглосон шийдвэрийг шүүх хуралдааны явцад гаргасан тохиолдол гарсан. Өөр нэг хэрэгт шүүгч “хохирогч ахиж айдас түгшүүрт автаж, ямарваа нэгэн байдлаар хохирох ёсгүй” гэж үзэн, шүүх хуралдааны үеэр өөрийн санаачилгаар шүүгдэгч (холбогдогч)-ид сануулга өгсөн байв.

Дүрс 17: *Хохирогчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор авсан арга хэмжээ*

Нөгөөтэйгүүр, нийт найман хэргийн (17.5 хувь) хохирогчдод шүүхийн өмнөх шатанд аюул учирч болзошгүй байсан ч аюулгүй байдлын арга хэмжээ аваагүй гэж ажиглагчид үзсэн байна. Харин **золоор** тухайн ажигласан хэргүүдэд яллагдагч (холбогдогч) аль эсхүл түүний хамсаатны зүгээс хохирогчид заналхийлсэн эсхүл бодитой хохирол учруулсан ямарваа нэгэн зүйл тохиолдоогүй гэдгийг ажиглагчид тэмдэглэсэн болно.

13.1.3. Шүүхийн өмнөх шатны аюулгүй байдал

Түүнчлэн хохирогчид ба шүүгдэгч (холбогдогч) тусдаа амьдардаг хэрнээ шүүхийн өмнөх шатанд яллагдагч хохирогчийн оршин сууж буй байршлын талаар нууцалсан мэдээллийг олж мэдэх боломжтой **дөрвөн хэрэг** байсныг ажиглагчид тайлагналаа. Ажиглагчид тухайн мэдээллийг олж авсан аргыг дэлгэрэнгүй тайлбарлаагүй ч гэсэн хавтаст хэрэг дэх мэдээллийг хангалттай хязгаарлалт байдаггүйтэй холбоотой байж болзошгүй гэж үзсэн байна

Дүрс 18-т дэлгэрэнгүй танилцуулснаар, таван хэрэг тутмын хоёрт нь (24 хэрэг буюу 42.1 хувь) шүүхийн өмнөх шатанд хохирогчид сэтгэл зүйн туслалцаа авах боломжгүй байсан гэж ажиглагчид тэмдэглэв. Угтаа энэ асуулт нь нэгэнт учирсан сэтгэл санааны гэм хорыг арилгах тусламж дэмжлэгийн тухай бус, харин ийм гэм хор учрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай байсан. Гэвч хохирогчдыг сэтгэл санааны хувьд дахин дарамтад орсон удаа байхгүй тул энэ төрлийн засал, үйлчилгээг шаардлагагүй гэж үзсэн ажиглагчдын үнэлгээтэй энэ нь холбоотой гэж үзэж байна. “Шүүгдэгчийг харахад сэтгэл чинь тавгүйрхэж болзошгүй” гэж улсын яллагч хохирогчид болгоомжлон сануулах гэх мэт хэлбэрээр сэтгэл зүйн туслалцааг хүргэсэн зөвхөн гурван хэргийг (5.3 хувь) ажиглагчид илрүүлсэн байна. Үлдсэн хэргүүдийн 52.6 хувьд шүүхийн өмнөх шатны сэтгэл зүйн туслалцааг үзүүлээгүй байна.

Дүрс 18: *Шүүхийн өмнөх шатанд хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн туслалцаа*

Шүүхийн өмнөх шатанд сэтгэл санааны дарамтад дахин орох явдал зөвхөн нэг хэрэгт гарсан. Үүнд: хохирогч нэг шүүгдэгч (холбогдогч)-ийн найз нөхөд хохирогчоос удаа дараа мөнгө нэхэж шаардсан. Ажиглагчийн мэдээлснээр холбогдох эрх бүхий байгууллагууд тухайн үйлдлээс урьдчилан сэргийлэх эсхүл зохих шийтгэлийн арга хэмжээ аваагүй байна.

13.1.4. Шүүх дээр ирэх үеийн хохирогчийн аюулгүй байдал

13.1.4-с 13.1.6 хүртэлх хэсгүүдэд зөвхөн хохирогчоор тогтоогдсон этгээд шүүх хуралдаанд оролцсон хэргүүдийг танилцуулсан болно Түүвэрлэгдсэн 57 хэргээс 24 (42.1 хувь)-т энэ төрлийн хэрэг байжээ. Зарим хэрэгт олон хохирогч тогтоогдсон бөгөөд шүүх хуралдаанд нийт 26 хохирогч оролцсон байна. Түүвэрлэгдсэн 57 хэргээс 24 (42.1 хувь)-т энэ төрлийн хэрэг байжээ.

Хохирогчид оролцсон нийт 24 шүүх хуралдаанаас зөвхөн хоёрт (бүх хэргүүдийн 8.3 хувь) нь буюу Дорноговь болон Өвөрхангай аймгуудад хохирогчид шүүхийн байранд орохдоо шүүгдэгчээс (холбогдогч) тусдаа өөр хаалгаар нэвтэрч байсан.

Нийт хэргийн дөрөвний нэгт (зургаан хэрэг буюу 25 хувь) урьдчилсан хорих ангиас шүүхэд ирж буй яллагдагчийг шүүх хуралдаан эхлэхээс өмнө тусдаа хаалгаар оруулсан байна. Үлдсэн хохирогчид буюу гуравны хоёр (66.7 хувь) нь шүүх рүү тусдаа орж, гарах хаалга байхгүй байсан учраас шүүгдэгч (холбогдогч)-тэй хамт нэг хаалгыг ашиглахаас өөр аргагүй байжээ.

Шүүхийн аюулгүй байдлын шалгалтыг харьцангуй ховор буюу тодруулбал, хохирогчид өөрийн биеэр шүүх хуралдаанд оролцсон нийт хэргийн талаас бага хувьд (10 хэрэг буюу 41.7 хувь) нь хийсэн байна. Аюулгүй байдлыг шалгалтыг хийсэн ч эдгээр тохиолдлын **гуравт нь** (12.5 хувь) аюулгүй байдлын шалгалт нь зэвсгийн үзлэгийг багтаагүй болохыг ажиглагчид тэмдэглэсэн байна. Үүнээс гадна, хохирогчдын биечлэн оролцсон ихэнх шүүх хуралдаанд (14 хэрэг буюу 58.3 хувь) аюулгүй байдлын ямар нэгэн шалгалтыг хийгээгүй байна. Үүнийг дор **Дүрс 19**-т тусгав.

Дүрс 19: *Хохирогчид шүүхийн байранд нэвтрэхэд хэрэгжүүлсэн аюулгүй байдлын шалгалт*

Нийт таван хэрэгт (20.8 хувь), Өвөрхангай, Төв болон Дорноговь *аймгууд*, мөн Улаанбаатар хотын Налайх дүүрэгт хохирогчид аюулгүй байдлыг хангах дагалдах цагдаагийн ажилтны хамтаар шүүх хуралдааны танхим руу орж, гарч байсан нь ажиглагдсан байна.

Өөр хоёр хэрэгт (8.3 хувь), хохирогчид аюулгүй байдлын хангах дагалдах цагдаагийн ажилтантай хамт шүүхийн танхимд орох хүсэлт гаргах эрх нь нээлттэй байсан ч тус эрхээ хэрэгжүүлээгүй байна. Ямартаа ч аюулгүй байдлыг хангах ажилтнууд ховор байсан бөгөөд Улаанбаатар хотын дүүргүүд, аймгуудад хянан шийдвэрлэсэн нийт хэргийн гуравны хоёрт нь (17 хэрэг буюу 70.8 хувь) хохирогчдод ийм боломж байгаагүй байна.

Ажиглагчид шүүхийн байранд хохирогчид болон шүүгдэгч (холбогдогч)-ийн хооронд зөрчил үүсвэл түүнийг зохицуулж, аюулгүй байдлыг хангах цагдаагийн ажилтан ерөнхийдөө хангалттай байсан гэж үзсэн байна (13 хэрэг буюу 54.2 хувь). Өөр зургаан хэрэгт (25 хувь) эдгээр ажилтнуудын тоо хангалттай байгаагүй гэж ажиглагчид тэмдэглэжээ. Харин үлдсэн (таван хэрэг буюу 20.8 хувь) хэргүүдийн хувьд, ажиглагчид аюулгүй байдлыг хангах ажилтнуудын тухай мэдээллийг бүртгэж аваагүй байна.

Шүүх хуралдаанд оролцсон **зургаан** хохирогч тутмын **тав нь** шүүгдэгч (холбогдогч)-тэй хамт хүлээлгийн хэсэгт (20 хэрэг буюу 83.3 хувь) байсан байна. Хэргүүдийн зөвхөн 16.7 хувьд нь буюу Өвөрхангай аймгийн сум дундын шүүх болон Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн шүүхэд тусдаа хүлээлгийн өрөөнд байсан.

Түүнчлэн шүүхэд хохирогчид өмгөөлөгчөөс өөр дагалдах (дэмжлэг үзүүлэх) хүнтэй ирэх нь ховор байсан. Ийм тохиолдол зөвхөн таван хэрэгт (20.8 хувь) гарсан бөгөөд тэдгээр хүмүүс найз нөхөд эсхүл төрөл садангийн хүмүүс нь байх шиг байсан гэж ажиглагчид мэдээлсэн. Шүүгдэгч цагдан хоригдсон нэг хэрэгт байсан хохирогч дагалдах хүний хамт байлцсан нь боломжит эрсдэлийг бууруулах зорилготой байсан байх гэж ажиглагчид таамагласан байна.

Хохирогчид шүүх хуралдаанд оролцсон бүх хэргүүдийн бараг гуравны хоёрт нь (14 хэрэг буюу 58.3 хувь) хохирогчид тэдэнд авч болох аюулгүй байдлын хамгаалалт болон тусламжийн арга хэмжээнүүдийн талаар мэдээлэлтэй байсан нь ажиглагдсан байна. Эдгээр хэргүүдийн хоёрт нь (8.3 хувь) энэ мэдээллийг системтэй танилцуулж өгдөггүй, харин гагцхүү нэг цэгийн

үйлчилгээнд хамрагдсан эсхүл ИНБ болон хуульчийн дэмжлэг авсан хохирогчид л авах боломжтой гэж ажиглагчид дүгнэсэн байв. Гэвч үлдсэн 10 хэргийн (41.7 хувь) хохирогчид аюулгүй байдлын болон тусламжийн арга хэмжээнүүдийн сонголтын талаар огт мэдээлэл аваагүй гэж ажиглагдсан байна. (**Дүрс 20**–д нарийвчлан тусгасан).

Дүрс 20: *Хохирогчдод аюулгүй байдал, тусламжийн арга хэмжээний талаарх мэдээллийг хүргэсэн байдал*

13.1.5. Шүүх хуралдааны үеийн хохирогчийн аюулгүй байдал

Ихэнх тохиолдолд шүүх хуралдааны танхимд шүүгдэгч (холбогдогч)-ээс тусдаа өрөөнд мэдүүлэг өгөх эрхийн талаар хохирогчид мэдэгдэх шаардлага хэрэгцээ байгаагүй (15 хэргүүд буюу 62.5 хувь) гэж ажиглагчид үзжээ. Хохирогчдод энэ талаар танилцуулсан тохиолдол ердөө **зургаан** хэрэгт (25 хувь) гарсан. Хохирогчид тусдаа өрөөнд мэдүүлэг өгсөн нэг ч тохиолдол гараагүй. Хэргүүдийн бараг талаас дээш хувьд нь (15 хэргүүд буюу 62.5 хувь) шүүх хуралдаанд оролцсон хохирогчид шүүгдэгч (холбогдогч)-ээс тусдаа газар сууж байсан байна. Нийт хугацааны хагаст нь хохирогч шүүгдэгч (холбогдогч)-ийн хооронд эсхүл хохирогчийн дэргэд цагдаагийн ажилтан байсан бол нэг хохирогч яг улсын яллагчийн дэргэд сууж байсан байна. Ажиглагчид ерөнхийдөө хохирогчид болон шүүгдэгч (холбогдогч)-ийн хооронд хангалттай зай байсан гэж үзжээ. Ажиглагчдын дүгнэснээр нийт хохирогч оролцсон шүүх хуралдааны бараг талаас дээш хувьд (13 хэргүүд буюу 54.2 хувь), шүүгдэгч (холбогдогч) хохирогчидтой харц тулгарахгүй, дарамт учруулахааргүй нөхцөлийг хангах байдлаар суудлын зохион байгуулалтыг хийсэн байв.

Хэдийгээр төрөл бүрийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан ч шүүх хуралдаанд оролцсон бүх хохирогчдын дөрөвний нэгтэй тэнцэх хэрэгт (6 хэрэг буюу 25 хувь) хохирогчид сэтгэл санааны дарамтад дахин орох эрсдэлд өртсөн байна. (**Дүрс 21**).

Дүрс 21: *Хохирогчид сэтгэл санааны дарамтад дахин орохоос сэргийлэх арга хэмжээ шүүх дээр авсан байдал*

Ажиглагчдаас өгсөн дэлгэрэнгүй мэдээллээр хохирогчийг болсон үйл явдалд буруутгах, зүй зохистой зан үйлийн талаарх жендерийн хэвшмэл үзлээ тулгах хэлбэрээр сэтгэл санааны дарамтад дахин орох эрсдэлийг бий болгосон байна. Хэдийгээр доод тал нь хоёр шүүгдэгч хэрэгт болж өнгөрсөн бүх зүйлд хохирогчийг илтэд буруутгаж байсан боловч энэ нь хохирогчийг зөвхөн яллагдагч, шүүгдэгч буруутгасан ердийн нэг асуудал биш юм. Хамгийн багадаа гурван хэрэгт хуулийн болон шүүхийн байгууллагуудын ажилтнууд өөрсдийн жендерийн хэвшмэл үзлээ тулгах замаар хохирогчдыг буруутгах хандлага ажиглагдсан (12.5 хувь) байна. Нэг хэрэгт гэхэд өмгөөлөгч хохирогчийг “эмэгтэй юм байж архи уусан” гэж буруутгасан. Өөр нэг хэрэгт хохирогчийг худалдаа наймаа эрхлэхээр гэрээ орхиж явснаас ГБХ болсон гэж улсын яллагч хэлсэн тохиолдол байна. Харин гурав дах хэрэгт, хоол хийх нь эмэгтэй хүний үүрэг шүү гэж шүүгч хэлжээ.

Шүүгчид эдгээр үйлдлийг ерөнхийд нь таслан зогсоох үүднээс шүүх хуралдааны танхимд хуралдааны дэгийг сахиулах арга хэмжээ авах, дэг сануулах, бичгээр мэдүүлэг өгөхийг хохирогчид зөвшөөрөх зэрэг арга хэмжээ авч байв. Гэхдээ хохирогчийг хоол хийсэнгүй гэж буруутгасан шүүгчийн зүгээс хэргийн шийдвэрт нөлөөлсөн зүйл ажиглагдаагүй болно. Гэвч тодорхой нэг хэрэгт хохирогчийг хоол хийгээгүй байсны төлөө шүүгч өөрөө буруутгасан өнгө аясаар харьцсан бөгөөд энэ үйлдлийг шүүхийн зүгээс таслан зогсоох ямар нэг арга хэмжээ авагдаагүй байна. Ихэнх хохирогчдод өөрсдийн гэр бүлийн гишүүд, эцэг эх, хүүхдүүд аль эсхүл төрөл садангийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь танилцуулж тайлбарласан байна (20 хэрэг буюу 83.3 хувь). Гэвч хохирогчид болон шүүгдэгч (холбогдогч)-ийн хоорондын бүх төрлийн харилцаа нь дээрх **Хэсэг 11.7.2-**т дурдсан харилцааны олон төрөлд багтаж байгааг харж болохоор байна. Яагаад шүүх хуралд оролцсон бүх хохирогчдод энэ талаар зөвлөгөө өгөөгүй шалтгаан нь тодорхой бус байна.

Таслан сэргийлэх арга хэмжээг цөөн тохиолдолд авсан байх ба 10 хохирогчийн ердөө ганцаас бусдад нь тухайн арга хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хуульд заасан хариуцлагын талаар танилцуулаагүй байв.

13.1.6. Шүүхээс гарах үеийн хохирогчийн аюулгүй байдал

Шүүх хуралдаанд оролцсон бүх хохирогчдын дөрөвний нэг нь шүүхийн хэлэлцүүлгийг орхихдоо шүүхээс хийсэн зохицуулалтын дагуу шүүгдэгч (холбогдогч)-оос тусдаа гарах боломжтой байсан (зургаан хэрэг буюу 25 хувь). (**Дүрс 22**)

Дүрс 22: *Хохирогч ба шүүгдэгчийг шүүхээс ээлжлэн гаргах*

Эдгээр хэргүүдийн зөвхөн нэгт нь хамгийн сайн туршлага ажиглагдсан нь шүүгдэгч (холбогдогч) хохирогчийг дагаж явах боломжгүй болгох үүднээс шүүгдэгч (холбогдогч)-ийг 15 минут эсхүл түүнээс ч удаан хугацаанд хүлээлгэж байгаад тусад нь гаргасан явдал байв. Таван хэргийн гуравт нь шүүгдэгч (холбогдогч) 15 минут хүрэхгүй хугацаанд хүлээсэн бол үлдэх хоёр хэрэгт нь шүүгдэгч (холбогдогч) танхимаас түрүүлж гарсан. Энэ нь шүүгдэгч (холбогдогч) шүүхийн байр болон гадаа талбайд хохирогчийг хүлээж байгаад уулзах, харилцах боломжийг олгож байх тул аюулгүй байдлын хувьд зөв зүйтэй гэж үздэггүй. Түүнчлэн, таван хэргийн зөвхөн гуравт нь шүүхийн ажилтан шүүхийн танхимыг орхиж гарах зааварчилгааг сахиж биелүүлэхийг талуудад анхааруулж, хянаж байсан юм.

Өндөр эрсдэлтэй гэж ажиглагчдын зүгээс үзсэн дөрвөн хэрэгт хохирогчдын нэгийг нь ч шүүх хуралдааны танхимаас гарахад нь аюулгүй байдлыг нь хангах ажилтан дагалдаж гараагүй тухай тэмдэглэжээ.

Эцэст нь Монголын шүүхүүдэд өмнө нь хохирогчоор тогтоогдсон хүмүүсийн аюулгүй байдлыг хангадаг байсан тахарын алба шүүх хуралдааны ажиглалт эхлэхээс өмнө татан буугдсан байлаа. Шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагааны үр дүн нь зөвхөн ажиглалтын явцад цуглуулсан өгөгдөл дээр тулгуурлаж байгаа тул энэхүү тайлан нь тахарын албыг татан буулгаснаас хойш хохирогчдын аюулгүй байдал сайжирсан эсхүл муудсан эсэх талаар мэдээлэл өгөх боломжгүй билээ.

13.2. Хохирогчдын зөрчил болон эрх сэргээх механизмтай холбоотой шаардлагатай мэдээлэл авах хохирогчийн эрх

Энэ хэсэг нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 3-р Бүлэг, Хэсэг II-т цуглуулсан өгөгдөлд суурилсан. (Хэрэг шалгах явц дахь зөрчил болон эрх сэргээх механизмуудын талаарх мэдээлэл авах хохирогчийн эрх) (**Хавсралт В**).

13.2.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үзүүлэлт

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хүрээнд хохирогчийн эдлэх эрхийн хэрэгжилт нь нийт дүнгээр боломжийн үнэлгээ авсан хэдий ч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил болон эрх сэргээх арга хэмжээний талаарх мэдээлэл авах эрхийн хэрэгжилт нь шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар медиан “Маш сайн” (90 хувь) үнэлгээг авч, хамгийн доод үзүүлэлтээс хоёрт жагсжээ. Бодит байдал дээр нийт хэргийн дөнгөж талаас дээш хувьд нь (52.6 хувь) 90-100 хүртэлх оноог авч, “Маш сайн” гэсэн үнэлгээ гарсан юм. Түүнчлэн, ач холбогдол бүхий нийт 20 хэрэг (35.1 хувь)-ийн үнэлгээ нь “Сайн” үнэлгээний интервалд багтаж, онооны хэлбэлзэл нь тухайн интервалын хамгийн доод түвшин болох 60 хувьд хүрч байв. Үүнээс гадна нийт гурван хэрэг 35-50 хувийн оноо авч “Муу” үнэлгээтэй гарчээ.

13.2.2. Хохирогчийн эрх

Ажиглагчид хохирогчдын мэдэх ёстой үндсэн найман хууль ёсны эрх, үүргийн талаар мэдээлэл авсан эсэхийг шалгах ёстой байв. Үүнд:

- хууль зүйн туслалцаа авах;
- нотлох баримт гарган өгөх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, нотлох баримтыг шинжлэн судлуулах ба хавтаст хэрэгт цугласан хамааралтай бүхий л баримт материалтай танилцах;
- шүүх хуралдаанд оролцох, үүний дотор яллагдагч, гэрч ба шинжээчээс асуулт асуух эрх;
- хэрэг бүртгэгч, мөрдөгч, улсын яллагч болон шүүхэд хандан тодорхой арга хэмжээ авах, шийдвэр гаргуулах тухай хүсэлт гаргах;
- шүүгч, улсын яллагч, мөрдөгч, орчуулагч, хэлмэрч, шинжээч эсхүл шүүхийн ажилтнаас татгалзан гаргах;
- шүүхээс гаргасан цагаатгах эсхүл шийтгэх тогтоолын хувийг гардан авах;
- хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс үйлдсэн гэмт хэрэг эсхүл хийсэн хууль бус үйлдэлд нөхөн төлбөр авах; болон
- өөрийн эх хэлээр ярих аль эсхүл орчуулагч/хэлмэрчээр дамжуулж өөр хэлээр мэдүүлэг өгөх.

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний хүрээнд ажиглагчид эрх тус бүрд хохирогчид өөрийн ойлголтод нийцүүлж мэдээлэл, тайлбарыг бүрэн авсан эсэх, дагалдах тайлбарыг

өгөөгүй ч гэсэн хохирогчдод тэдгээрийн эрхийн талаар танилцуулсан эсэх, эсхүл тэдэнд эрхийг нь танилцуулаагүй ч үгүй, тайлбарлаагүй ч үгүй байсан эсэх зэрэг хохирогчдод танилцуулсан хэмжээний талаар тэмдэглэж авах үүрэг хүлээсэн болно. Эдгээр үзүүлэлтийн талаарх мэдээллийг доор **Дүрс 23** –д харуулж байна.

Дүрс 23: *Хохирогчдын эрх үүргийн талаар танилцуулж, тайлбарласан байдал*

Ихэнх хохирогчид өөрсдийн эрх үүргийн талаар мэдээлэл болон тайлбарын аль алиныг нь авсан тухай ажиглагчид тэмдэглэсэн байна. Түүвэр доторх 57 хэргийн олон төрлийн эрх болон үүргийн хувьд эрх тус бүрд өгсөн үнэлгээний үзүүлэлт нь 50.8 хувиас 68.4 хувийн хооронд хэлбэлзэж байна. Түүнчлэн цөөнгүй тооны хохирогч нь эрх, үүргийнхээ талаарх мэдээллийг ямар нэг хэмжээнд авсан бөгөөд эрхийг нь тайлбарлаж өгөөгүй ба үүний үнэлгээ нь 24.6-33.3 хувийн хооронд хэлбэлзэж байна. Үлдсэн бусад эрх, үүргийн хувьд, мэдээлэл эсхүл тайлбар аваагүй цөөн тооны хохирогчид байсан юм. Тодруулбал, дөнгөж 3.5 хувьд (2 хохирогч) нь нотлох баримт гарган өгөх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хүсэлт гаргах, нотлох баримтыг шинжлэн судлуулах, хавтаст хэрэгт цугласан баримт материалтай танилцах эрхийг нь танилцуулж, тайлбарлаагүй бол тус үзүүлэлтийн хамгийн өндөрт нь буюу 24.6 хувьд (14 хохирогчид) нь шүүхээс гаргасан шийтгэх болон цагаатгах тогтоолын хувийг гардан авах эрх орсон байна.

Хохирогчид хууль зүйн туслалцаа авах эрхийнхээ талаар хамгийн сайн мэдээлэл авсан байв. Бүх найман эрхүүдийг харьцуулахад, маш олон тохиолдолд энэ эрхийн талаар хохирогчдод танилцуулж, тайлбарласан байв. (39 хэрэг буюу 68.4 хувь). Түүнчлэн, түүвэрт багтсан бүх хохирогчид энэ эрхийн талаар тайлбар аваагүй ч гэсэн тодорхой мэдээлэл авч байсан байна (үлдсэн 18 хэрэг эсвэл 31.6 хувь). Харин хохирогчдод ерөнхийдөө хамгийн бага танилцуулсан эрх бол *шүүхээс гаргасан цагаатгах эсхүл шийтгэх тогтоолын хувийг гардан авах эрх* байв. Цөөн тооны хэрэгт энэ эрхтэй холбоотой мэдээлэл, тайлбарыг хохирогчдод өгсөн бол хамгийн

их тооны хэргүүдэд тус эрхийн талаар хохирогчдод ямар ч мэдээлэл эсхүл тайлбар өгөөгүй байна.

Дээр **Хэсэг 13.2.1**-т тэмдэглэсэнчлэн, “Муу” гэсэн ерөнхий үнэлгээ авсан түүврийн гурван хэргийн хоёр нь Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг болон нөгөө нэг нь Архангай аймагт байна. Энэ гурван хэргүүдэд бага оноо өгсөн шалтгаан нь хохирогчдод хамаарах эрх, үүргийн талаар хангалттай мэдээлэл эсхүл тайлбарыг өгөөгүйтэй холбоотой билээ. Тус гурван хэргийн хоёрт нь (Баянзүрх дүүргийн) хохирогчид тэдгээрийн найман эрх, үүргээс дөрөв, таван эрхийн талаар ямар ч мэдээлэл өгөөгүй байна. Энэ гурван хэрэгт ихэнхдээ мэдээлэл өгөхдөө зөвхөн үндсэн мэдээллийг хохирогчид ойлгогдохуйц хэмжээний ямар ч дагалдах тайлбаргүйгээр өгсөн байна.

13.2.3. Хохирогчийн мэдээлэл авах эрх

Ажигласан хэргүүдийн нэгэнд нь ч хохирогч мэдээлэл авах эрхтэй холбоотойгоор асуудал гараагүй гэж ажиглагчид тайлагнасан. Тодруулбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хавтаст хэргийн материалтай бүтнээр нь эсхүл хэсэгчлэн судалж танилцах хохирогчийн хүсэлтийг хангаагүй тохиолдол огт гараагүй байна. Яг үүнтэй адилхан, хохирогч эсхүл түүний өмгөөлөгчид хавтаст хэргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн танилцуулаагүй, аль эсхүл хавтаст хэргээс шаардлагатай хэсгээ хуулбарлан авахад нь саад учруулсан гэж үзэх тохиолдол гараагүй болно.

13.3. Эрх тэгш, үр нөлөөтэй хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй авах эрх

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 4-р Бүлгийн Хэсэг II-т (Хууль, шүүхийн байгууллагын өмнө үр нөлөөтэй, тэгш хандах эрх) цугласан өгөгдөлд тулгуурласан болно. (**Хавсралт В-г харна уу**).

13.3.1 Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үзүүлэлт

Хохирогчийн эрх тэгш, үр нөлөөтэй хууль зүйн үйлчилгээг хүртээмжтэй авах эрх нь нийт эрхүүдээс хамгийн сайн хэрэгжилттэйд тооцогдсон. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар энэхүү эрхийн хэрэгжилт нийт 57 хэргийн хувьд “Маш сайн” гэсэн үнэлгээ авсан. Угтаа дундаж үнэлгээгээр 100 хувь авч байгаа нь шүүхэд хандах талаарх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан холбогдох шаардлагыг бүрэн хэмжээнд биелүүлэн ажилласныг илтгэнэ. Нийт хэргийн 66.7 хувь (38 хэрэг) нь хамгийн өндөр оноо авчээ. Түүнчлэн, нэг ч хэрэг 80-аас доош хувь үнэлэгдээгүй тул бүх хэргийн үнэлгээ нь “Маш сайн” үнэлгээний интервалд багтаж байв.

Түүнчлэн үүний үр дүнд хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт биечлэн оролцох, түүнчлэн зөрчил болон хэргийн хэр хэмжээ зэрэг нь нөлөө үзүүлэхээргүй байсан болно. Шүүх хуралдаанд хохирогч оролцсон эсэхээс үл хамаарч медиан 100 хувь хэвээр байсны зэрэгцээ зөрчил болон эрүүгийн хэргийн медиан нь 97.9 хувьтай байсан.

Энэ үр дүнд хохирогч шүүхийн хэлэлцүүлэгт биечлэн оролцох, түүнчлэн зөрчил болон гэмт хэргийн хэр хэмжээ, зэрэг нь нөлөө үзүүлэхээргүй байсан болно. Шүүх хуралдаанд хохирогч оролцсон эсэхээс үл хамаарч медиан 100 хувь хэвээр байсны зэрэгцээ зөрчил болон эрүүгийн хэргийн медиан нь 97.9 хувьтай байсан.

13.3.2 Хохирогчдын шүүх дээр эрх зүйн туслалцаа авах ерөнхий эрх

Ихэнх хэрэгт (53 хэрэг эсхүл 93 хувь) шүүх хуралдааны товыг хохирогчид мэдэгдээгүй гэж үзэх ямар нэг үндэслэл ажиглагдаагүй. Зөвхөн дөрвөн хэрэгт (7 хувь) хохирогч шүүх хуралдааны товыг мэдээгүй байж болзошгүй байна. Зөрчлийн хоёр хэргийн шүүх хуралдааны товыг хохирогч мэдээгүй байсан гэж ажиглагчид мэдээлсэн ч бусад зөрчлийн хэргийн хувьд хохирогчид нь шүүх хуралдааны талаар мэдээлэлтэй байсан тул дээрх нь алдаатай мэдээлэл байж болзошгүй.

Үүнээс гадна, хэргийн аль ч шатанд хохирогчид эсхүл түүний өмгөөлөгчид гомдол гаргах эрхийг нь хангаагүй байж болзошгүй тохиолдол гараагүй байна. Хохирогч өөрийн гомдол хүсэлтийг зохих ёсоор гаргаж чадаагүй нэг л тохиолдол байсан тухай ажиглагчид дурдсан. Түүнчлэн хохирогчид шүүх дээрх өөрсдийн мэдүүлэг эсхүл хэрэг бүртгэл, мөрдөн шалгах ажиллагааны шатны мэдүүлэг өгөхөд ямарваа нэгэн байдлаар бусдын дарамт шахалт, албадлага эсхүл нөлөөлөлд өртсөн гэх ямар ч зүйл ажиглагдаагүй байна.

Дүрс 24 –д шүүхийн шийдвэрт хохирогчдын тайлбар, нотлох баримтыг шинжлэн судалсан байдлын (шүүх дээр танилцуулсан эсэхээс үл хамаарч) талаарх ажиглагчдын үнэлгээг танилцуулж байна. Энд харуулж байгаачлан, зургаан шүүхийн шийдвэр тутмын тавд нь хангалттай хэмжээнд судлан шинжилсэн гэж үзсэн байна. Гэхдээ цөөн хэдэн хэргүүдэд хохирогчдын тайлбар, нотлох баримтад хангалттай дүн шинжилгээ хийгээгүй гэж тодорхойлохоос гадна нэг хэрэгт бүхэлдээ ямар ч дүн шинжилгээ хийгээгүй ажээ.

Дүрс 24: *Шүүхийн шийдвэр гарахад хохирогчдын тайлбар, нотлох баримтыг шинжлэн судалсан байдал*

Шүүхийн нэг ч шийдвэрт жендерийн хэвшмэл үзлээ тулгах эсхүл хохирогчийг буруутгах зэрэг хохирогчийн эсрэг сөрөг, хор нөлөөтэй хандлага эсхүл үг хэллэг агуулагдаагүй байна. Гэвч дээр **13.1.5-р Хэсэгт** тэмдэглэсэнчлэн, дор **13.3.3-р Хэсэг**-т ийм хандлага цөөн хэдэн шүүх хуралдаан дээр гарч, үүний дотор хурлын шүүгчээс гарсан тохиолдол байсныг дэлгэрэнгүй

тайлбарласан. Иймээс тухайн хэрэгт энэ хандлага нь шүүхийн шийдвэрийн агуулгад шууд бусаар ч гэсэн нөлөөлсөн байх магадлалтай.

Түүвэр судалгаанд хамрагдсан шүүгдэгч (холбогдогч)-дэд хэлмэрч эсхүл орчуулагчийн шаардлага байгаагүй. Харин хоёр хэргийн хохирогчид монгол хэлээр чөлөөтэй ярьдаггүй эсхүл харааны, сонсголын, хэл ярианы бэрхшээлтэй байсан гэж ажиглагчид тэмдэглэсэн байна. Эдгээр хэргүүдийн нэгт нь хохирогчид бичгэн орчуулгыг бүтнээр нь хийж өгсөн бол нөгөө хэрэгт нь хохирогч хэргийн материалыг ахиухан орчуулуулах хүсэлтэй байсан ч гэсэн түүнд зөвхөн зарим хэсгийнх нь орчуулгыг бичгээр өгчээ. Гэхдээ эдгээр хохирогчдын аль нь ч өөр хэлээр эсвэл орчуулагчаар дамжуулан харилцах шаардлагагүй байсан бололтой.

13.3.3 Хохирогчдын шүүх дээр эрх зүйн туслалцаа авах хохирогчийн эрх

Ажиглагчдын тайлагнаснаар нийт 24 хэргийн шүүх хуралдааны ихэнх тохиолдолд (21 хэрэг эсхүл 87.5 хувь) хохирогчоор тогтоосон этгээдүүд өөрсдийн хэргийг бүрэн танилцуулахад ямар ч хүндрэл тохиолдоогүй байна. Харин нэг хохирогчийн асуултууд/үндэслэлүүдийг тасалж эсхүл түргэн хугацаанд яриулж байсан (4.2 хувь) бол өөр хоёр хэрэгт (8.3 хувь) шүүгчид зохисгүй хандлага гаргаж байсан гэж ажиглагчид тайлагнасан. Эдгээр хэргүүдийн нэгт нь шүүгч хоол хийх нь эмэгтэйчүүдийн үүрэг, харин эрэгтэйчүүд хааяадаа архи уухад зүгээр гэж тайлбарлаж байсан бол (энэ тухай **Хэсэг 13.1.5**). Нөгөө хэрэгт нь шүүгч хохирогчийг буруутгах шинжтэй үг хэллэг ашигласан тухай ажиглагчид тайлагнав. Энэ хоёр тохиолдолд шүүгчид ялгаварлан гадуурхсан тайлбар хийсэн бөгөөд ялангуяа жендерийн хэвшмэл ойлголтыг дурдсан тухай ажиглагчид тэмдэглэсэн байсан.

Гэсэн хэдий ч ажиглагчдын үнэлгээгээр баримт гаргах, тайлбар үндэслэлээ хэлэх нөхцөл, боломжийг нь хязгаарласан нэг ч хохирогч байхгүй байна. Харин нэг хэрэгт (4.2 хувь) хохирогч нь хууль зүйн хувьд боломжгүй эсхүл илтэд үндэслэл муутай боломж бололцоог хүссэн байна. Мөн хохирогчийн эсрэг ёс зүйгүй тайлбарыг хэлж, зүй бус зан авир гаргасан тохиолдол гараагүй (18 хэрэг эсхүл 75 хувь) бөгөөд шүүх хуралдааны явцад (зургаан хэрэг эсхүл 25 хувь) шуурхай таслан зогсоох арга хэмжээг авсан гэж ажиглагчид тайлагнасан. Гэхдээ дээр дурдсанчлан шүүгчдийн зүгээс ялгаварлан гадуурхсан тайлбар, үг хэллэг нь ёс зүйгүй үйлдэл гэдэгт эргэлзэх зүйлгүй тул ажиглагчдад ийм өндөр үнэлгээ өгөхдөө дэндүү өгөөмөр хандсан гэж харагдаж байна.

Хохирогчид нь шүүх хуралдаанд оролцсон хэргүүдийн гуравны хоёрт (16 хэрэг эсхүл 66.7 хувь) нь хохирогчид нь үр дүнд хүрэхийн тулд ямарваа нэгэн тайлбар, мэдэгдэл гаргаж өөрсдийн хэрэгт шударга ёсыг тогтоолгоход оролцох оролцоо нь хязгаарлагдмал байсан.(**Дүрс 25**).

Дүрс 25: *Шүүхийн шийдвэрийн үр дүнд тавьж буй хохирогчдын хүлээлт, санал*

Хохирогчид үр дүнд нөлөөлөхүйц ямар ч тайлбар, мэдэгдэл хийсэн хэргүүдийн хувьд ихэнх (4 хэрэг буюу 16.7 хувь) нь шүүгдэгч (холбогдогч)–ид зөвхөн торгууль оногдуулахыг хүссэн байна. Харин шүүгдэгч (холбогдогч)–д ял шийтгэл, тэр дундаа болж өгвөл хорих ял оногдуулахыг хүссэн нэг л хохирогч байв (4.2 хувь). Өөр нэг хохирогч шүүгдэгч (холбогдогч)-ийг архинаас гаргах албадан эмчилгээнд хамруулахыг хүссэн бол өөр хоёр хохирогчид ГБХ-ийн улмаас гаргасан эмчилгээний зардлыг нөхөн төлүүлэх хүсэлтийг гаргажээ.

Ерөнхийдөө шүүгчид тогтоолын үндэслэлийг хохирогчдод (23 хэрэг буюу 95.8 хувь) сайн тайлбарласан гэж ажиглагчдад дүгнэсэн. Харин тэдний ажигласнаар гурван хэрэгт энэ тайлбар нь хангалтгүй (12.5 хувь) байсан гэж үзжээ. Нэг хэрэгт шүүхийн шийдвэр, тогтоолыг хохирогчид огтхон ч тайлбарлаагүй байна. Үүний адилаар шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрсөн тохиолдолд давж заалдах гомдол гаргах эрхийг тайлбарлаагүй нэг тохиолдол (4 хувь) байсан бол уг эрхийг хангалттай сайн тайлбарлаж өгөөгүй мөн нэг тохиолдол (4 хувь) гарсан гэж ажиглагчид үзсэн байна. Бусад бүх тохиолдолд хохирогчдод уг эрхийг нь хангалттай тайлбарлаж өгсөн, эсхүл хохирогчийн талд шүүхийн шийдвэр гарсан тул энэ талаар тайлбар гаргах шаардлагагүй байсан байна.

Түүнчлэн хохирогчидтой харилцах ерөнхий байдлын хувьд зөвхөн нэг хэрэгт шүүх хуралдааны үеэр хохирогч болон түүний өмгөөлөгчийн хоорондох харилцаа хязгаарлагдмал байсан гэж ажиглагчид тайлагнасан. Ийнхүү хоорондоо хязгаарлагдмал харилцаж байсан нь хохирогчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцоогүйгээс болсон ажээ. Үүнээс гадна, шүүхийн ажилтнууд хохирогчидтой ерөнхийдөө эелдэг бас хүндэтгэлтэй харьцаж байсан гэж ажиглагчид дүгнэлээ. Гэвч хохирогчдын шүүх хуралдаанд оролцсон (8 хэрэг буюу 36 хувь) хэргүүдийн гуравны нэгт харилцааны зүй бус хандлага ажиглагдсан гэж үзжээ. Үүнд:

- нэг улсын яллагч, нэг шүүгч соёлгүй (бүдүүлэг) авир гаргасан;
- нэг улсын яллагч, хоёр шүүгч ба нэг шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгч хохирогчийн эсрэг жендерийн хэвшмэл үзлээ илэрхийлсэн;
- нэг улсын яллагч, хоёр шүүгч, хоёр шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгчид болон нэг шүүхийн ажилтан хохирогчийг буруутгасан; болон
- нэг улсын яллагч хохирогчийг үл ойшоосон.

13.4. Хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй, нэн даруй нөхөн төлүүлэх эрх

Энэ хэсэг нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 5-р Бүлгийн Хэсэг II-т цугласан (Хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй, нэн даруй нөхөн төлүүлэх эрх) өгөгдөлд суурилсан болно. **(Хавсралт В).**

13.4.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй, нэн даруй нөхөн төлүүлэх хохирогчийн эрхийн хэрэгжилтийг медиан “Маш сайн”, 100 хувь гэж үнэлжээ. Дундаж оноо нь 87.9 хувиас доогуур байсан ч энэ нь “Маш сайн” гэсэн үнэлгээний интервалд багтаж байна.

Нийт дүнгээр авч үзвэл хэдийгээр цөөн тооны хохирогч хохирлоо барагдуулах талаар хүсэлт гаргасан боловч энэ эрх нь хэрэгжилтийн байдлаараа дээрээс хоёрдугаарт орсон ба шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний асуултуудад (Ийм учир дор дурдсан дүн шинжилгээнд оруулсан) “нөхөн төлбөр” авах гэж тодорхойлогдсон эрх байсан юм. Ийм үзүүлэлт гарахад хоёр хүчин зүйлс нөлөөлөв. Нэгдүгээрт, үнэлгээ нь зарим талаараа хохирогчид энэ эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаа вэ гэхээс илүүтэйгээр тэд энэ эрхээ ер нь мэддэг эсэхэд анхаарсан болно. Хоёрдугаарт энэ хэсэгт нөхөн төлбөр гаргуулах хүсэлтийг гаргасан эсэх асуудлыг үнэлэхдээ ийм хүсэлт гаргаагүй тохиолдолд оноо суутгаж тооцоогүй бөгөөд учир нь хохирогч өөрөө хүсэлт гараагүйн улмаас шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээ буурах ёсгүй гэж үзсэн билээ. Ийм ч учраас хэдийгээр ихэнх хохирогчид хохирлыг нөхөн төлүүлэх хүсэлт гаргаагүй ч хүсэлт гаргахтай холбоотой үнэлгээнд бүтэн оноо өгсний дүнд нийт оноо нь өсөж гарсан.

Хамгийн өндөр оноо авсан 36 хэргээс бүрдсэн кластер (нийт хэргийн 63.2 хувь) дах хэрэг тус бүрийн үр дүнгийн хэлбийлттэй тархалтаас улбаалж ийнхүү ерөнхий үзүүлэлт нь өндөр гарахад нөлөөлжээ. Энэхүү кластер нь нийт хэргийн дөрөвний нэг орчим нь “Сайн”-аас (хэргүүдийн 19.3 хувь) “Муу”-ийн (хэргүүдийн 8.8 хувь нь) хоорондүнэлэгдэж, мэдэгдэхүйц доогуур түвшний гүйцэтгэлтэй байсныг далдалсан гэж үзэж болно. Ийм доогуур үнэлгээ авсан нь гэмт хэргийн ангилал, гэмт хэрэг үйлдсэн газар (жич. Улаанбаатар эсхүл *аймаг*), нөхөн төлбөр авах хүсэлт гаргасан эсэх, аль эсхүл хохирогч өмгөөлөгч эсхүл бусад хууль ёсны төлөөлөгчөөр төлөөлүүлж байсан эсэх асуудлаас хамааралгүй байсан гэж харагдаж байна. Харин ч ихэнх хохирогчид өөрсдийн нөхөн төлүүлж болох хохирлынхоо хэмжээ болон нөхөн төлбөрийн төрлүүдийн талаар мэдэхгүй байгаатай холбоотой гэж санагдаж байна.

13.4.2 Хохирогчийн нөхөн төлбөрийн асуудал

Хохирогчийн нөхөн төлбөртэй холбоотой зургаан хэргийн зөвхөн нэгт (10 хэрэг буюу 17.5 хувь) нь хохирогчид ГБХ-ийн улмаас учирсан хохирлоо ямар нэгэн байдлаар нөхөн төлүүлэхийг хүссэн байна. Дийлэнх нэхэмжлэлд бие махбодын гэмтлийг (70 хувь) дурдсан байсан бол нийт нэхэмжлэлийн хагаст нь оршуулгын зардал, эмнэлгийн болон сэтгэлзүйн эмчилгээ, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны улмаас алдсан ашиг орлого зэрэг эдийн засгийн хохирлыг заасан байв. Зөвхөн ганц хохирогч сэтгэл зүйн хохирлыг нэхэмжилсэн. Ер нь нөхөн төлбөр

авахыг хүсэж, нэхэмжлэл гаргасан хохирогчдын дунд доод талдаа хоёр хүн нөхөн төлбөр авах боломжтой хохирлын бүх төрлүүдийг төдийлөн сайн мэдэхгүй байсан байна. Сэтгэл зүйн хохирол ба түүний нөхөн төлбөрийн талаар ерөөсөө ярьж зөвлөдөггүй болохыг ажиглагчид онцолсон. Түүнчлэн өөр гурван хохирогч нэхэмжилж болох нөхөн төлбөрийн төрлүүдийн талаар ойлголтгүй байсан бол тэдний нэг нь эмчилгээний зардлыг нөхөн төлүүлж болох эсэхийг асуусан байна.

Үүнээс гадна хохирогчид нөхөн олговрын талаар огт хүсэлт гаргаагүй 47 тохиолдлын бараг дөрөвний нэгт нь (11 тохиолдол буюу 23.4 хувь) хохирогчид гаргуулж болох нөхөн төлбөрийн хэмжээ, төрлүүдийн аль алиных нь талаар мэдэхгүй байсан гэж ажиглагчид мэдээлсэн. Ажиглагчдын үзэж байгаагаар энэ нь нэг талаараа хохирогчид өөрсдөө хайнга хандаж аль эсхүл идэвхгүй байсантай холбоотой бол нөгөөтэйгүүр хохирогчид нөхөн төлбөр авахыг ерөөсөө хүсэхгүй байгаагаа илт илэрхийлж байна.

Тухайлбал:

- Хоёр хохирогч эрүүл мэндийн үзлэг хийлгэж, холбогдох хохирлыг тогтоолгохоос татгалзсан;
- Хоёр хохирогч холбогдох хор уршгийг тогтоосон эмнэлгийн үзлэгээс татгалзсан;
- Нэг хохирогчийн ар гэрийнхэн түүнийг нөхөн төлбөр нэхэмжлэхгүй байхыг шахаж шаардсан бололтой;
- Нэг хохирогч яллагдагчийн торгуулийг төлсөн бөгөөд энэ дүнг нэхэмжлээгүй;
- Нэг хохирогч гомдол саналгүй гэж хэлсэн; болон
- Нэг хохирогч нөхөн төлбөр шаардлагагүй гэж хэлсэн.

Нөхөн төлбөр нэхэмжилсэн хохирогчдын 10 хүсэлтийг шийдвэрлэсэн байдлыг доор **Дүрс 26**-т харуулав.

Дүрс 26: *Нөхөн төлбөр авахаар гаргасан хохирогчдын хүсэлтийг шийдвэрлэсэн байдал*

Ийнхүү хэргүүдийн ихэнх хувьд хохирогчдын нэхэмжлэлийг хангаж, нөхөн төлбөрийг бүрэн эсхүл талаас арай илүү хувийг (60 хувь) гаргуулсан байна. Гэвч хэргүүдийн бараг гуравны нэгт (3 хэргүүд) нь хэдийгээр шүүгдэгч (холбогдогч)-д ял оногдуулж, хохирогчид хохирлоо нөхөн төлүүлэхийг хүссэн ч хохирогчдод ямар нэгэн нөхөн төлбөр аваагүй байна. Сүүлчийн нэг хэрэгт хохирогчийн нэхэмжлэлийг зөвхөн хэсэгчлэн хангаж биелүүлсэн байна. Ажиглагчид шүүхийн шийдвэрийг нөхөн төлбөртэй холбоотой шийдвэрт харьцуулан үнэлгээ өгөхдөө тодорхой, ойлгомжтой, эргэлзээ төрүүлэхээргүй, түүнчлэн нотлогдсон үндэслэлд нийцсэн байдлаар нь голчлон үнэлсэн. Харин хоёр хэрэгт нөхөн төлбөр авах хүсэлт нь үндэслэл бүхий, хуулийн шаардлага нийцсэн байсан ч шүүгчийн зүгээс хангаагүйн зэрэгцээ шүүгч нэг хэрэгт шийдвэрээ хангалттай сайн тайлбарлаж чадаагүй бол нөгөө нэг хэрэгт нь ямарваа нэгэн тайлбарыг огт хийгээгүй байна. Нөхөн төлбөр олгохтой холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг **14.7.3-р Хэсэгт** харуулав.

14. Шүүх хуралдаанд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрх

Энэ хэсэгт ажигласан хэргүүд дэх шүүгдэгч (холбогдогч)-ийн талаарх мэдээллийг танилцуулж байна. Энд ажигласан бүх зөрчлийн болон эрүүгийн шүүх хуралдаанд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрхүүдийн хэрэгжилтийг судалсан болно. Үүнд дараах эрхүүд хамаарна: хуулийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа эрхлэх чадамжтай, хараат бус ба бие даасан шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрх, гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрх, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх эрх, нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд үнэлүүлэх эрх, талуудын тэгш байх эрх, өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх болон шүүхийн шийдвэр олон нийтэд ил тод, үндэслэл бүхий байх эрх хамаарна. Энэ нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний Хэсэг III-т цугласан өгөгдөлд тулгуурласан болно. (**Хавсралт B**)

Түүнчлэн энэ хэсэгт орчуулагч, хэлмэрч авах эрхийн талаарх мэдээлэл байгаа ч ажигласан хэргүүдэд нэг ч шүүгдэгч (холбогдогч) орчуулагч, хэлмэрчийн туслалцаа шаардлагагүй байсан учраас үүнтэй холбоотой өгөгдөл үүсээгүй. Үүнээс гадна энэ хэсэгт орсон эрхүүд нь онолын хувьд давж заалдах шатны шүүхэд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ид ижил хэмжээгээр үйлчилнэ. Гэхдээ бүх ажигласан хэргүүд зөвхөн анхан шатны шүүхийн журмаар хянан шийдвэрлэсэн хэргүүд байсан билээ.

Хуульд заасны дагуу байгуулагдаж, хараат бус, тал үл харах шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн талаар **14.1 дүгээр хэсэг**т авч үзсэн бөгөөд медиан “Маш сайн” үнэлгээ авч, шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилтээрээ гуравт эрэмбэлэгдсэн байна. Бараг бүх шүүгдэгч (холбогдогч)-ид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхийг нь танилцуулсан бол цөөн хэдэн шүүгчийн зүгээс тэдэнтэй дарамт учруулах байдлаар харьцжээ. Шүүх хуралдааны явцад албан тушаалтан танхимыг орхин гарсан (хүндэтгэн үзэх шалтгаантайгаар) нэг тохиолдол тэмдэглэгдсэн. Харин зарим шүүх хуралдаан дээр гар утсыг голдуу шүүгч, прокуророууд ашиглах байдал ажиглагдаж байв. Эцэст нь, зарим хэргүүдэд оногдуулах ялын хэр хэмжээтэй харьцуулбал түүнийг хэлэлцсэн хугацаа харьцангуй богино байсан гэж ажиглагчид дүгнэсэн байна.

Нөгөөтэйгүүр, **14.2 дугаар хэсэгт** авч үзсэн нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт нь шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрхүүд дотроос хамгийн тааруу нь байсан хэдий ч медиан “Маш сайн” үнэлгээ авсан. Уг эрхийн хэрэгжилт тааруу байгаа нь шүүх хуралдааны товыг нийтэд ил тод, нээлттэй байлгаагүйгээс шалтгаалсан бөгөөд ажиглалт хийсэн есөн шүүхэд ийм асуудал гарчээ. Гэхдээ ихэнх шүүх хуралдааны хувьд нээлттэй явагдсан. Аюулгүй байдлын үүднээс ажиглагчдыг дор хаяж нэг удаа шалган нэвтрүүлж байсан бөгөөд шүүхийн ажилтнуудаас зөвшөөрөл авсны үндсэн дээр ажиглалтыг хийж байлаа. Ихэнх шүүх хуралдаан боломжийн зай, талбайтай шүүх хуралдааны танхимд явагдсан.

Шүүгдэгчийн гэм буруу нь тогтоогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх эрхийн хувьд медиан “Маш сайн” гэж үнэлэгдсэн ч хамгийн тааруу хэрэгжилттэй эрхийн нэг байсан. (**14.3-р хэсэг**). Тодруулбал, зарим цөөн тооны шүүгдэгчийг шүүх хуралдааны танхимд гавтай байлгасан нь тэднийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай мэт сэтгэгдэл төрүүлж байв. Шүүгдэгч (холбогдогч)-ид уг эрх болон бусад эдлэх эрхийнх нь талаар танилцуулж байсан боловч тайлбарыг нарийвчлан хийгээгүй байна. Ямартай ч ихэнх шүүгдэгч/холбогдогч нь тэдэнд олгогдсон эрхийн дор хаяж нэгийг нь эдэлсэн байв. Прокуроруд эсхүл шүүгчид шүүгдэгчийг дуугүй байх эрхээ эдэлснийх нь төлөө сөрөг дүгнэлт гаргасан тохиолдол байхгүй боловч шүүхийн тогтоол гаргахаас өмнө шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон тайлбар мэдэгдлийг шүүгчийн зүгээс хийсэн хоёр тохиолдол гарав.

14.4 дүгээр хэсэгт авч үзсэн нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд үнэлүүлэх шүүгдэгчийн эрх нь медиан “Маш сайн” үнэлгээг авсан бөгөөд шүүгдэгчийн эдлэх долоон эрхийн хувьд хэрэгжилтээрээ дундаж нь байв. Шүүх хуралдаанд голчлон хавтаст хэрэгт авагдсан баримт материалын агуулга, түүнчлэн шүүхийн өмнөх шатанд шүүгдэгч (холбогдогч)-ийн өгсөн мэдүүлгийг хэлэлцсэн бөгөөд нийт долоон шүүгдэгч нь өмнө өгснөөс зөрүүтэй мэдүүлгийг шүүх хуралдаан дээр өгсөн байв. Нотлох баримт гаргаж өгөхтэй холбоотойгоор шүүгдэгч (холбогдогч)-ид тэгш бусаар хандсан тохиолдол гараагүй ба ихэнхэд нь өөрийгөө өмгөөлөх боломжийг шударгаар, нээлттэй олгож байв. Ихэнх тохиолдолд мэдүүлэг өгч буй хохирогч/гэрчүүдэд эдлэх эрхийнх нь талаар мэдээлэл өгч, тайлбарлаж байсан бөгөөд эдгээр оролцогчид өөрийн эрхийг зохих ёсоор эдэлсэн. Шинжээчийн дүгнэлт хийх чиг үүрэг авсан нэг шинжээчид түүний эрх үүргийн талаар сайтар тайлбарласан байсан ба тэрбээр мэргэшсэн чиглэлийн дагуу шүүх хуралдаанд мэдүүлгээ өгсөн байна.

14.5 дугаар хэсэгт авч үзсэн талуудын тэгш байдлыг хангах хүрээнд шүүгдэгчийн эдлэх эрх нь медиан “Маш сайн” үнэлгээ авч шүүгдэгчийн эдлэх эрхүүдийн дунд хамгийн сайн хэрэгжилттэйд тооцогдов. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад процессын зөрчил, хэвийн бус байдал, талуудын тэгш байдлыг хөндсөн тохиолдол бараг гараагүй бөгөөд эрүүгийн хоёр хэрэг (өөр өөр шүүхийн)-ийн шүүх хуралдаанд яллах тал нь шүүгчтэй илүү ойр сууж байсан байна. Шүүгдэгч (холбогдогч)-ийн эцсийн үгээ хэлэх эрхийг нь олгоогүй тохиолдол бараг гараагүй.

Шүүх хуралдаанд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх эрхүүдээс хамгийн өндөр оноо авсан эрх нь өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгч авах эрх бөгөөд энэ тухай **14.6 дугаар хэсэг**т авч үзсэн. Ажиглагчдын зүгээс шүүгдэгч (холбогдогч) уг эрхээ эдлэхтэй холбоотой маш цөөн саад бэрхшээлийг тогтоосон бөгөөд нийтдээ гурван тохиолдолд процессын зөрчил ажиглагдсан байна. Аюулгүй байдлын үүднээс гурван шүүгдэгч (холбогдогч)-ийг шүүх хуралдааны танхимаас албадан гаргасан. Тэдгээрийн зөвхөн нэг нь биечлэн оролцоогүй ч гэсэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухай бүр оролцох боломжтой байлаа. Нийт шүүгдэгч (холбогдогч)-

ийн ойролцоогоор дөрөвний гурав нь өмгөөлөгчгүй байсан. Өмгөөлөгчтэй оролцсон хуралдааны хувьд өмгөөлөгчид ихэнхдээ шүүгдэгч (холбогдогч)-той ойр суусан бөгөөд үйлчлүүлэгчидтэйгээ харилцахад бэрхшээлтэй байсан тохиолдол цөөн тооны байв. Өмгөөлөгч нь шүүгдэгч (холбогдогч)-ид асуудлыг хангалттай сайн хэмжээнд тайлбарлаж байгаа гэж үзэв.

Эцэст нь, өөрт холбогдсон хэргээ үндэслэл бүхий шийдвэрээр шийдвэрлүүлэх, шүүхийн шийдвэр нь олон нийтэд нээлттэй байх эрхийн хувьд хэдийгээр медиан “Маш сайн” авсан боловч шүүгдэгч (холбогдогч)-ийн (**14.7-р хэсэг**) эдлэх эрхийн хэрэгжилтээрээ доороос хоёрт эрэмбэлэгдэв. Бараг бүх шүүхийн хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл үйлдэгдэж, заримд нь аудио-видео бичлэг хийгдсэн бол цөөн хэдэн шүүхүүд тухайн бичлэгтэй танилцах эрхийг нь талуудад тайлбарласан байна. Шүүх хуралдаанд оролцсон иргэдийн төлөөлөгчдийн ихэнх нь шүүхийн тогтоолд өөрийн саналаа өгөх боломжтой байлаа.

Цагаатгагдсан нэг шүүгдэгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс гаргасан хууль бус үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаар танилцуулаагүй. Хэргүүдийн зөвхөн гуравны нэгт нь шүүхээс гарсан тогтоолыг уншиж танилцуулсан байна. Шүүхээс гарч байгаа бичмэл тогтоол, шийдвэрийн хувьд харьцангуй асуудлыг бүрэн гүйцэд, эцсийн байдлаар тусгасан байдаг. Ажиглагчид шүүхийн тогтоол, шийдвэр хангалттай тодорхой, ойлгомжтой, эргэлзээ төрүүлэхээргүй байсан гэж үнэлэв. Гэвч шүүхээс гаргасан шийдвэр, тогтоолуудыг нээлттэй байршуулах, танилцуулах нь ховор байсан бөгөөд хэргүүдийн бараг тал хувьд шийтгэх тогтоол, түүний товч агуулга зэргийг ил болгоогүй байна. Шүүхийн шийдвэрийн талаарх нэмэлт (оноогоор үнэлэгдээгүй) асуудлыг мөн энэ хэсэгт авч үзнэ.

14.1. Хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа эрхлэх чадамжтай, хараат бус ба бие даасан шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн 6-р Бүлгийн Хэсэг III-т цугласан өгөгдөлд суурилсан болно. (Чадамжтай, хараат бус ба бие даасан шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх) (**Хавсралт В**).

14.1.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Хуульд заасны дагуу байгуулагдаж, хараат бус, тал үл харах шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх шүүгдэгч/ холбогдогчийн эрхийн биелэлт нь шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар медиан “Маш сайн” үнэлгээ буюу 95 хувийн оноо авч, шүүх дээр эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилтээрээ гуравт эрэмбэлэгдсэн байна. Эрүүгийн хэргүүд дэх эрхийн гүйцэтгэл зөрчлийн хэргүүдтэй харьцуулахад илүү сайн буюу нийт 100 хувийн медиан оноог авсан байна. Гэвч нийт хэргийн 12.3 хувь нь зөвхөн “Сайн” гэсэн үнэлгээ авсан бөгөөд медиан оноо 65-75 хувийн хооронд байв. Эдгээр хэргүүдийн ихэнхэд шүүгдэгч (холбогдогч)-ид эдэлж болох эрхүүдийн талаар хангалттай тайлбарлаагүй бөгөөд ихэнх нь Улаанбаатар хотын дүүргийн шүүхүүдэд гарчээ.

14.1.2. Шүүхийн бүрэлдэхүүн

Шүүгдэгч (холбогдогч)-ид шүүх хуралдаан даргалагчийг бүрэлдэхүүнээс татгалзан гаргах хүсэлт гаргаагүй байна. Тухайн эрхийн талаар бүх хуралдаан дээр тайлбарлаж өгч байсан хэдий ч зөрчлийн долоон шүүх хуралдаанд тухайн эрхийг тайлбарлаагүй бөгөөд үүний зургаан хэргийг Баянзүрх дүүргийн шүүх дээр хянан хэлэлцсэн байна.

14.1.3. Шүүхийн үйл ажиллагаа

Дүрс 27-д харуулснаар бараг бүх хэргүүдэд (98.2 хувь) шүүгдэгч (холбогдогч)-ид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхийг нь танилцуулжээ Үүнээс гадна шүүгдэгч (холбогдогч)-ийн бараг гуравны хоёрт (64.9 хувь) шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх эрхийг нь зөвхөн албан ёсоор танилцуулаад зогсохгүй холбогдох тайлбарыг хүртэл хийжээ. Мөн шүүгдэгч (холбогдогч)-ид эрхүүдийн талаар мэдээлэл болон өгсөн хэргүүдийн хоёроос бусад бүх тохиолдолд (бүх хэргүүдийн 61.4 хувь), шүүгчид тайлбар өгөхдөө тэдний нас, оюуны чадамж ба нөхцөл байдлыг сайтар харгалзан үзсэн гэж ажиглагчид үзжээ. Харин нэг шүүгдэгч (холбогдогч) (1.8 хувь) тус эрхийнхээ талаар мэдээлэл болоод тайлбарыг аваагүй байна.

Дүрс 27: *Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгдэгч (холбогдогч)-ид эдлэх эрхийн талаар шүүх танилцуулсан байдал*

Ажиглагчдын тайлагнаснаар шүүгчид гурван хэргийн шүүгдэгч (холбогдогч)-ид дарамт учруулах байдлаар харьцсан тохиолдол (5.3 хувь) гарсан байна. Бусад тохиолдолд ажигласан хэргүүдийн алинд нь ч шүүгч шүүгдэгч (холбогдогч)-ийг ялгаварлан гадуурхсан эсхүл алагчилсан байдлаар харьцсан эсхүл өөрсдөө болон бусдыг ёс зүйгүй үг хэллэг хэлэхийг зөвшөөрсөн тохиолдол гараагүй байна.

Шүүх хуралдааны явцад албан тушаалтан танхимыг орхин гарсан (хүндэтгэн үзэх шалтгаантайгаар) нэг тохиолдол тэмдэглэгдсэн. Харин доор **28-р дүрсэд** харуулсанчлан, 5 хуралдаан дээр (8.8 хувь) гар утас хэрэглэж байсан гэж тайлагнасан. Тухайн хэргүүдийн ихэнхэд нь (80 хувь) улсын яллагчид ба шүүгчид голдуу ашиглах байдал ажиглагдаж байв.

Дүрс 28: *Шүүх дээр гар утас ашигласан байдал*

Зургаан хэрэгт (10.5 хувь) оногдуулах ялын хэр хэмжээтэй харьцуулбал түүнийг хэлэлцсэн хугацаа харьцангуй богино байсан гэж ажиглагчид дүгнэсэн байна. Эдгээр хэргүүдийн тав нь зөрчлийн хэргийн шүүх хуралдаан байсан бөгөөд тэдний дөрөв нь 14-15 минут л үргэлжилснээр түүвэрлэсэн зөрчлийн хэргийн шүүх хуралдаануудын дундаж 25 минутаас хамаагүй богино байв. Хуралдааны хугацаа нь хангалтгүй байсан гэж үзсэн сүүлчийн хэрэг нь эрүүгийн хэргийн шүүх хуралдаан байсан бөгөөд нийт 55 минут үргэлжилж, эрүүгийн шүүх хуралдааны дундаж хугацаа болох 1 цаг болон 43.5 минутаас хоёр дахин богино байв.

14.2. Нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 7-р Бүлэг, Хэсэг III-т цугласан өгөгдөлд суурилсан болно. (Нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх) (**Хавсралт В**).

14.2.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Хэдийгээр нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх нь шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар медиан “Маш сайн” үнэлгээг авсан ч шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагааны хүрээнд үнэлэгдсэн бусад эрхүүдтэй харьцуулахад гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэмт буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх эрхийн гүйцэтгэлтэй ижил муу хэрэгжиж буй гэж тооцогдсон билээ. Ерөнхий медиан оноо нь 83.3 хувь байсан. Энэ эрхийн гүйцэтгэл нь хаалттай явагдах өндөр магадлалтай эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаас зөрчлийн хэргийн шүүх хуралдаанд илүү өндөр хэрэгжилттэй байна гэж төсөөлж байсан боловч бодит байдалд дээр эсрэгээрээ байв. Нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт эрүүгийн шүүх хуралдаануудад медиан 100 хувь байсан бол зөрчлийн хэргийн шүүх хуралдаануудын хувьд энэ нь 30 гаруй хувиар буурч, 66 хувь болж

“Сайн” үнэлгээ рүү буурчээ. Бодит байдал дээр зөрчлийн 10 хэрэгт (ажигласан хэргүүдийн 17.5 хувь) “Муу” гэсэн үнэлгээ авсан билээ. Ийм доогуур үзүүлэлттэй гарсан үндсэн шалтгаан бол шүүх хуралдааны тов хүртээмжгүй байсан явдал юм.

14.2.2. Нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх

29-р Дүрсэд харуулсанчлан, ажигласан хэргүүдийн бараг ихэнх хувьд (52.6 хувь) нь шүүх хуралдааны тов ба цагийг өөрсдийн шүүхийн цахим хуудас эсхүл шүүхийн байрны ил самбар дээр олон нийтэд хүртээмжтэй болгоогүй байна. Эдгээрээс 26 хэргийн (45.6 хувь) мэдээлэл ерөөсөө олдох боломжгүй байв. Бусад дөрөвт нь (7 хувь) мэдээлэллийг онолын хувьд олох боломжтой байсан боловч түүнийг түгээх платформ нь (*жич.*цахим хуудас эсхүл мэдээллийн самбар) шинэчлэгдээгүй, хоцорсон, боломжгүй эсхүл бүрэн бус байсан юм.

Дүрс 29: *Шүүх хуралдааны товын олон нийтэд ил тод, нээлттэй байдал*

Шүүх хуралдааны товыг олон нийтэд мэдээлж ил тод байлгаагүй эс үйлдэхүй нь тогтолцооны шинжтэй биш юм. Учир нь ажиглалт хийсэн есөн шүүхэд шүүх хуралдааны тов нийтэд нээлттэй байсныг ажиглагчид баталгаажуулсан. Гэхдээ шүүх хуралдааны тов болон хугацааг олж мэдэхэд боломжгүй байсан асуудал нь Улаанбаатарын дөрвөн дүүргийн шүүх мөн Өвөрхангай аймгийн шүүхээс бусад бүх аймгийн шүүхүүдэд удаа дараа гарч байв. Иймд уг мэдээллийг хүргэж буй арга зүй, эсхүл дамжуулж буй платформын найдваргүй байдалтай холбоотой байж болох юм.

Гэсэн ч хуралдаан болох талаар мэдсэн тохиолдолд ихэнх хуралдаанууд (51 хэрэг буюу 89.5 хувь) нийтэд нээлттэй байсан гэдгийг **Дүрс 30**-аас харж болно**.** Үлдсэн зургаан хэрэг тодорхой хэмжээний хязгаарлалттай байсныг шүүхийн тамгын ажилтнуудаас мэдсэн эсхүл ажиглагчид өөрсдөө анзаарсан байна. Эдгээр зургаан тохиолдлын хоёрт нь шүүхийн захиргааны ажилтнуудын хэлснээр хувийн нууцлалын үүднээс шүүгдэгч (холбогдогч)-ийн хамаатан садан төрөл, эсхүл найз нөхдийг шүүх хуралдаанд нэвтрүүлээгүй байна. Үүнээс гадна хоёр хэргийн шүүх хуралдаан нь ажиглагчдаас бусад сонирхогч гадны бүх хүнд хаалттай явагдсан бөгөөд энэ нь хохирогчийн өөрийнх нь хүсэлт, түүнчлэн гуравдагч этгээдийн зүгээс шүүх хуралдаанд оролцох талаар ямар нэг хүсэлт гаргаагүйтэй холбоотой юм. Эцэст нь хэдийгээр ажиглагчид бичлэгийг үзээд ажиглалт хийх боломжтой байсан ч Ковид-19 цар тахалтайгаар холбоотойгоор хоёр хэргийн шүүх хуралдааныг хаалттай явуулсан байна.

***Дүрс 30**: Шүүр хуралдаанд ороход олон нийтэд тавигдсан хязгаарлалтууд*

Шүүх хуралдаанд оролцох хүмүүст хязгаарлалт тогтоосон зургаан тохиолдлын нэгээс бусдад нь хууль зүйн үндэслэлтэй байсан гэж ажиглагчид мэдээлэв. Энэ нь нэг талаараа тухайн хэрэг нь төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой байсан, нөгөө талаар хэргийн оролцогчдын хувийн амьдрал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх ашгийг хамгаалахтай холбоотой байв. Харин нэг хэрэгт (бүх хэргүүдийн 1.8 хувь) хүмүүсийг оруулаагүй шалтгааныг ажиглагчид тодорхойлж чадаагүй юм.

Шүүх хуралдаанд нэвтрэхийн өмнө авдаг аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг ажиглагчид өөрсдийн туршлагад үндэслэн үнэлсэн. Нийт хэргүүдийн талаас илүү хувьд (52.7 хувь) нь дараах аюулгүй байдлын шалгалтын аль нэгийг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд: нэг бол биеийн байцаалт (бүх хэргийн 36.4 хувь), эсхүл оролцогчдын мэдээллийг бүртгэлийн дэвтэрт (хэргийн 16.4 хувь) бүртгэх зэрэг байна. Үлдсэн ихэнх тохиолдолд оролцогчдын биеийн байцаалт шалгаж мөн мэдээллийг нь бүртгэлийн дэвтэрт тэмдэглэж байсан байна.

ШЕЗ-тэй хамтын ажиллагааны хүрээнд хийгдсэн энэхүү шүүх хуралдааны ажиглалтын үйл ажиллагааны харилцан тохиролцооны хүрээнд **9.1.4-р Хэсэгт** заасанчлан ажиглагчдад шүүх хуралдааны танхимд орохоос өмнө зөвшөөрөл авах шаардлагыг тавьж байв. Ийнхүү ажиглагчид зөвшөөрлийг ихэнхдээ шүүгчид болон шүүхийн ажилтнуудаас (58.2 хувь) эсхүл бусад тохиолдолд зөвхөн шүүхийн ажилтан (21.8 хувь) эсхүл шүүгчдээс (20 хувь) авч байсан байна.

Ажиглагчдын үнэлснээр нийт шүүх хуралдааны тавны дөрөвт нь (78.9 хувь) хангалттай хэмжээтэй шүүх хуралдааны танхимд явагдсан байна. Гэвч 7 хэргийн (12.3 хувь) хувьд зарим шүүх хуралдаан нь хэтэрхий бага зай талбай бүхий танхимд явагдсан бол 5 хэргийн (8.8 хувь) хувьд шүүх хуралдаан нь бүгд хэт бага талбайтай танхимд болсон байна.

14.3. Гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх

Энэ хэсэг нь 8-р Бүлгийн Хэсэг III-д Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнээр дамжуулан цугласан өгөгдөлд тулгуурласан болно. (Гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэм буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх) (**Хавсралт В**).

14.3.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үйлчилгээний гүйцэтгэл

Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэмт буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилт 83.3 хувь буюу медиан “Маш сайн” үнэлгээ авсан байна. Гэвч нэлээд их буюу нийт 16 хэргүүдэд тухайн эрхийн хэрэгжилт 55.5-72.2 хувийн хооронд хэлбэлзэж, “Сайн” гэж үнэлэгджээ. Хэдийгээр энэ эрхийн гүйцэтгэл медиан “Маш сайн” үнэлгээ авсан ч шүүхийн шатанд шүүгдэгч (холбогдогч)-ийн эдлэх бүх эрхүүдээс “нээлттэй шүүх хуралдаанаар хэргээ хянан шийдвэрлүүлэх эрх”-ийн адил хамгийн доогуур гүйцэтгэлтэй хоёр эрхийн нэгээр тогтоогдсон. Ийнхүү доогуур үнэлгээ авсан нь шүүгдэгч (холбогдогч)-ид өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх, шүүхийн өмнөх шатанд цугларсан баримтад тулгуурлан гэм бурууг нь урьдчилан тогтоохгүй байх эрх ба дуугүй байх эрх зэрэг тодорхой эрхийнх нь талаар мэдээллийг хязгаарлагдмал байдлаар хүргэсэнтэй холбоотой юм.

14.3.2. Шүүгдэгч (холбогдогч)-ийн гадаад төрх

Ихэнх хэргүүдэд (93 хувь) шүүх дээрх шүүгдэгч (холбогдогч)-ийн гадаад төрх нь түүнийг гэм буруутай гэж харуулахад нөлөөлөх ямар нэг байдал ажиглагдаагүй байна. Гэвч ажиглагчид нийт дөрвөн хэрэг (7 хувь) дээр ийм ажиглалтыг хийсэн байна. Үүнд: гурван эрүүгийн хэрэг, нэг зөрчлийн хэрэг байна. Эдгээр хэргүүдийн дөрвөн шүүгдэгч шүүх дээр гавтай байжээ. Тэдний нэг нь хоригдлын хувцастай байсан байна.

14.3.3. Шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Дүрсэд 31-р харуулсанчлан таван хэрэг тутмын хоёрт нь (буюу 40.4-45.6 хүртэлх хувь), яллагдагч (холбогдогч)-дад гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэмт буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх эрхийн талаар зөвхөн танилцуулсан бөгөөд дэлгэрэнгүй тайлбарыг тусгайлан өгөөгүй байна. Эдгээр эрхүүдэд өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх ба өөрийн ойрын төрөл садангийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх, шүүхийн өмнөх шатанд цугларсан баримтад тулгуурлан гэм бурууг нь урьдчилан тогтоохгүй байх эрх болон дуугүй байх эрх хамаарна. Энэ гурван эрхийн дотроос шүүгдэгч (холбогдогч) мэдээлэлтэй байсан бөгөөд нийт шүүгдэгч (холбогдогч)-ийн дөрөвний нэгээс илүү хувь нь (28.1 хувь) энэ эрхийн талаар огт мэдэгдээгүй байна.

Дүрс 31: *Гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох яллагдагч/холбогдогчийн эрхийг шүүхэд танилцуулсан байдал*

Хамгийн хачирхалтай нь хэдийгээр шүүхүүд дээр гэм буруутайг нь эцэслэн тогтоох хүртэл гэмт буруугүйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулган шаардахаас ангид байх ерөнхий эрхийн талаар танилцуулсан эсэх талаар янз бүрийн тэмдэглэл хийгдсэн байсан ч шүүгдэгч (холбогдогч)-ийн 57.9 хувь нь эдгээр эрхүүдийн хамгийн багадаа нэгийг нь шүүх дээр эдэлсэн байна.

Шүүгдэгч (холбогдогч) өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх эсхүл өөрийн ойрын төрөл садангийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг (16 хэрэг буюу 28 хувь) хамгийн ихээр эдэлж байсан бол дараагийн сайн эдэлсэн эрх бол тэдгээрийн *дуугүй байх эрх* (13 хэрэг буюу 22.8 хувь) байв. Тухайлбал, энэ эрхээ эдэлсэн нийт яллагдагчдын талаас доош хувь (43.7 хувь) нь өмгөөлөгчтэй байв. Иймд, эдгээр эрхээ эдэлсэн эсэх нь шүүгдэгч (холбогдогч) хууль зүйн туслалцаа, зөвлөгөө авсан эсэхээс үл хамаарч байна.

14.3.4. Шүүгдэгч (холбогдогч)-тэй харьцах хандлага

Улсын яллагчид эсхүл шүүгчид шүүгдэгч (холбогдогч)-ийг дуугүй байх эрхээ эдэлснийх нь төлөө сөрөг дүгнэлт гаргасан тохиолдол байхгүй байна. Гэвч ажиглагчдын ажигласнаар зургаан хэрэгт (10.5 хувь) ихэнхдээ улсын яллагч шүүгдэгч (холбогдогч)-ээс түрэмгий байдлаар асуулт асуух хэлбэрээр дарамт шахалт үзүүлжээ. Энэ хандлагыг гол төлөв шүүгч, хохирогчийн өмгөөлөгч эсхүл тэдний хууль ёсны төлөөлөгч гаргажээ. Түүнчлэн нэг хэрэгт шүүгч эсхүл улсын яллагч шүүгдэгч (холбогдогч)-ийг гэм буруугаа хүлээх ёстой гэсэн санал гаргасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү түргэвчлэх эсхүл ял, шийтгэлийг хөнгөрүүлэхийг зорьсон байж магад юм.

14.3.5. Шүүгдэгч (холбогдогч)-ийн гэм буруугийн талаарх хувийн үзэл бодол

Нийт хэргийн хоёрт (3.5 хувь) нь шүүхийн шийдвэр гарахаас өмнө шүүгчид, шүүх эсхүл төрийн албан хаагч нь шүүгдэгч (холбогдогч)-ийг гэм буруутай мэт ярьж байсан байна. Харин энэ хоёр хэрэгт хоёуланд нь шүүгдэгч (холбогдогч)-ийг цагаатгасан бөгөөд үүний дараа ахиж ийм хандлага гаргаагүй байна.

14.4. Нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд үнэлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь 9-р Бүлгийн Хэсэг III-ийн Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнд цугласан өгөгдөлд тулгуурласан болно. (Нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд үнэлүүлэх эрх) **(Хавсралт B).**

14.4.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн гүйцэд үнэлүүлэх талаарх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхэд Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний картын дагуу өгсөн нийт үнэлгээ нь ажиглалтын явцад шүүхийн шатанд эдлэх **долоон эрхээс дундаж** үнэлгээ авчээ. Тус эрхийн хангалт 91.7 хувьтай буюу медиан “Маш сайн” үнэлгээ авчээ.

Энэхүү медиан үнэлгээ нь үндсэндээ зөрчлийн эсхүл эрүүгийн хэргээс үл хамаарч ижил байв. Шүүх хуралдаанд хамгийн багадаа нэг гэрч буюу хохирогч оролцсон ч медиан “Маш сайн” үнэлгээтэй буюу 91.7 хувьтай хэвээр байв. Гэтэл шүүх хуралдаанд гэрч, хохирогчид эсхүл шинжээч огт оролцоогүй тохиолдолд үзүүлэлт нь бага зэргээр буурсан буюу 89.3 хувь болж, “Маш сайн” үнэлгээний интервал дотроо буусан байв. Харин эсрэгээрээ нэг хэрэгт гэрч болон шинжээч аль аль нь мэдүүлэг өгсөн тохиолдолд ерөнхий оноо нь 75 хувь болж “Сайн” гэсэн үнэлгээ рүү буурсан байна.

14.4.2. Нотлох баримтын үнэлгээ

Бүх ажигласан 57 хэргийн хавтаст хэргийн агуулгыг шүүх дээр танилцуулсан байна. Харин ихэнх хэргүүдэд (54.4 хувь) зөвхөн товчхон хэлбэрээр танилцуулжээ. Мөн хэргийн газрын үзлэг, таньж олуулах ажиллагаа, мөрдөн байцаагчийн дүгнэлт, дээж авч туршилт хийх болон шинжээч томилох зэрэг шүүхийн шатанд танилцуулсан бүхий л нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагаа нь хуулиар тогтоосон журмын дагуу хийгдсэн эсэхтэй холбоотой нотлох баримтыг бүх тохиолдолд танилцуулсан байна.

Ихэнх хэрэгт (93 хувь) шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүхийн өмнөх шатанд өгсөн мэдүүлгийг иш татсан байх боловч нийт хэргийн бараг талд нь зөвхөн тодорхой тооны сонгосон хэсгийг эсхүл төлөөлөхүйц бус хэсгийг (нийт хэргийн 49.1 хувь) танилцуулсан гэж ажиглагчид үнэлгээ өгсөн байна.Үүнээс гадна, дөрвөн хэрэгт (7 хувь) шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүхийн өмнөх шатны мэдүүлгийг огтхон ч дурдаагүй байна. Түүнчлэн хамгийн чухал нь шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүхийн өмнөх шатанд өгсөн мэдүүлэг олон нийтэд нээлттэй болоогүй, ил тод хэлэлцэгдээгүй

бөгөөд тэдгээрийг ийнхүү хаалттай байлгах хуульд заасан үндэслэл, нийтийн эрх ашгийн шалтгаан байгаагүй гэж ажиглагчид дүгнэсэн байна. (13 хэрэг буюу 22.8 хувь).

32-р дүрсэд харуулсанчлан долоон шүүгдэгч (холбогдогч)-ийн (12.3 хувь) шүүхийн өмнөх шатанд өгсөн мэдүүлгээс шүүх хуралдаан дээр зөрүүтэй байсан. Ажиглагчдын үзсэнээр мэдүүлгийн хооронд үүссэн зөрүү нь ихэнхдээ бага эсхүл дунд зэрэг байсан бөгөөд энэ нь ерөнхийдөө шүүгдэгч (холбогдогч) өөрийн гэм буруугийн талаар шүүхийн өмнөх шатанд мэдүүлэг өгч байх үетэйгээ харьцуулбал шүүхийн шатан дээр илүү сайн ойлголттой болсонтой холбоотой байх магадлалтай юм.

Дүрс 32: *Шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүх хуралдааны ба шүүхийн өмнөх шатны мэдүүлгийн зөрүүтэй байдал*

Нотлох баримт гарган өгөх боломжийн хувьд яллах талд давуу байдал олгож, өмгөөлөх талд үндэслэлгүйгээр хязгаарлалт тогтоосон байдал ажиглагдаагүй бөгөөд өмгөөлөх талын зүгээс ч үүнтэй холбоотойгоор гомдол гаргасан тохиолдол гарсангүй. Үүний адилаар шүүхээс аливаа холбогдох нотлох баримтыг танилцуулаагүй, авч үзээгүй, хэрэгт хамааралтай нотлох баримтыг тооцоогүй тохиолдол бүртгэгдээгүй ч хоёр хэрэгт шүүхээс хэрэгт ач холбогдол бүхий асуултыг харгалзан үзэлгүй өнгөрөөсөн гэж ажиглагчид үзсэн байна. Эдгээр хэргийн нэгт нь (Төв аймагт) өмгөөлөх талын асуултуудыг харгалзаж үзээгүй гэж ажиглагдсан бөгөөд мөн уг хэрэгт шүүгч, улсын яллагчийн зүгээс шүүгдэгч (холбогдогч)-ид асуулт тавихдаа дарамт шахалт учруулсан гэж ажиглагчид тэмдэглэсэн. Өөр нэг тохиолдлын хувьд Сонгинохайрхан дүүрэгт болсон шүүх хуралдааны явцад эсрэгээрээ улсын яллагчийн зүгээс тавьсан ач холбогдол бүхий асуултыг авч үзэлгүй орхисон байна.

Ажигласан хэргүүдийн талаас дээш хувьд нь (32 хэрэг буюу 56.1 хувь) оролцогч талуудын аль нэг нь хамгийн багадаа хэрэгт хамааралгүй эсхүл үл хүлээн зөвшөөрөхүйц баримтыг танилцуулах гэж оролдож байсан юм. Түүнчлэн, эдгээр хэргийн талаас дээш хувьд нь шүүхийн зүгээс ийм төрлийн нотлох баримтыг хэлэлцүүлэхгүй байх талаар ямар нэгэн арга хэмжээ аваагүй, эсхүл авсан арга хэмжээ нь хангалтгүй байсан тухай ажиглагчид тайлагнасан (17 хэрэг

буюу бүх хэргүүдийн 53.1 хувьд хэрэгт хамааралгүй эсхүл ач холбогдолгүй нотлох баримтыг хүргүүлсэн байна).

Ажигласан хэргийн алинд нь ч сэтгэл зүйн болон бие махбодын дарамт шахалт, эрүүдэн шүүлт, зүй бус харьцаа, хүчирхийлэл, заналхийлэл, хууран мэхлэлт, бусад хууль бус арга замаар цуглуулсан ямар ч тохиолдол гаргаагүй болно.

14.4.3. Өмгөөлүүлэх эрх

33-р дүрс дээр ихэнх шүүгдэгч (холбогдогч)-ид улсын яллагчийн яллах дүгнэлтийг няцаах эрх (хэргүүдийн 64.9 хувь), бичгээр олон амаар ирүүлсэн баримт нотолгоонд тайлбар өгөх, гэрч/хохирогчид болон шинжээч нараас асуулт асуух, сөргүүлэн асуух (59.6 хувь), мөн нэн ялангуяа нотлох баримт гарган өгөх (87.7 хувь) болон шүүгдэгч (холбогдогч)-ийг өмгөөлөх үндэслэлээ танилцуулах (87.7 хувь) зэргээр өөрийгөө өмгөөлөх эрхээ тэгш бас нээлттэй эдэлж чадсан байна. Түүнчлэн ажиглагчдын дүгнэснээр таваас зургаан шүүгдэгч (холбогдогч) тутмын нэг нь (бүх хэргийн 12.3-21.1 хувь) өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх хуульд заасан эрхээ эдлэх боломжоор хангагдаагүй байна.

Дүрс 33: *Яллагдагч өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх шударга боломжоор хангагдсан байдал*

14.4.4. Гэрч буюу хохирогчдын мэдүүлгийг шалгах

Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний энэ хэсэгт шүүх хуралдаанд гэрч, хохирогчийн мэдүүлэгтэй танилцах, шалгах ажиллагааны шударга байдлыг авч үзсэн болно. Дээр дурдсанчлан, бүх ажигласан хэргүүдийн 24 хэрэгт буюу нийт 42.1 хувьд нь хохирогчид шүүх хуралдаанд биечлэн оролцжээ. Нөгөөтэйгүүр, гэрчүүд маш ховор байсан бөгөөд зөвхөн найман хэрэгт буюу бүх хэргүүдийн 14 хувьд нь л биечлэн оролцжээ. Гэрчүүд ерөнхийдөө хохирогчдын оролцсон хэргүүдэд биечлэн оролцох нь олонтоо байсан бөгөөд хохирогчид оролцоогүй ч гэсэн гэрч оролцсон нийт хоёр хэрэг (3.5 хувь) байв. Шүүх хуралдаанд оролцсон ихэнх гэрч, хохирогчид мэдүүлэг өгсөн байна. Харин нэг эрүүгийн шүүх хуралдаанд хохирогч оролцсон ч түүнээс мэдүүлэг аваагүй байна. Гэхдээ нийт 25 хэрэгт (бүх хэргийн 43.9 хувь) хохирогчид буюу гэрчээс шүүх хуралдаан дээр мэдүүлэг авсан байна.

Олон оролцогч мэдүүлэг өгсөн 10 хэргийн (олон хохирогч эсхүл хохирогчид болон гэрчүүд) зургаад нь аль нэг талаас мэдүүлэг авахдаа бусад мэдүүлэг өгөх хүмүүсийг танхимд байлцуулаагүй авсан байна. Гэвч гурван хэргийн шүүх хуралдааны хувьд мэдүүлэг өгч буй оролцогч нар бие биеийнхээ мэдүүлгийг сонсон хажууд нь байлцсан бол нэг хэргийн хувьд зарим оролцогчид нь бусдыгаа мэдүүлэг өгч байх үед байлцсан байна.

Ихэнх мэдүүлэг өгч буй хохирогчид эсхүл гэрчүүдэд мэдүүлэг өгөхтэй холбоотой эрхийн талаар мэдээлэл төдийгүй тайлбарыг бас өгсөн байна (17 хэрэг буюу бүх хэргүүдийн 68 хувьд нь мэдүүлэг өгсөн байна). Гэвч долоон хүнд (28 хувь) зөвхөн танилцуулсан боловч дэлгэрэнгүй тайлбарыг өгөөгүй бол нэг хохирогчид мэдээлэл, тайлбарын аль алиныг нь өгөөгүй байна (4 хувь). Ихэнхэд нь худал мэдүүлэг өгсний улмаас хүлээх эрүүгийн хариуцлагын талаар мэдээлэл болон тайлбарыг өгсөн байна (19 хэрэг буюу 76 хувьд). Гэхдээ эрхийнх нь талаар зөвхөн танилцуулаад тайлбарлаагүй зарим тохиолдол байхад (4 хэрэг буюу 16 хувь) гурван хэрэгт мэдээлэл ч өгөөгүй, тайлбар ч хийгээгүй байна (12 хувь).

Ажиглагчид зөвхөн нэг шүүх хуралдаан дээр гэрч, хохирогчоос мэдүүлэг өгөхөд нь асуултад тодорхой нэг хэлбэрээр хариулах, эсхүл тайлбар өгөх, эсвэл татгалзахыг шаардсан дарамттай тулгарсан гэж тэмдэглэжээ. Энэ хэрэгт гэрчийн мэдүүлэг өгсөн хүн хохирогч байсан бөгөөд шүүгчийн зүгээс хохирогчийг буруутгах хэлбэрээр дарамт шахалт үзүүлсэн.

Эцэст нь ихэнх хохирогчид болон гэрчүүд болсон үйл явдлын талаар яг ижилхэн мэдүүлэг өгч байсан бол (20 хэргүүд буюу 80 хувь) ажиглагчдын тайлагнаснаар таван хохирогч бага ба дунд зэргийн зөрүүтэй мэдүүлгийг өгсөн байв. Үүний дотор өөрийг нь зодсон гэх мэдүүлгээ дараа нь няцаасан хохирогчтой хоёр хэрэг байсан бөгөөд тэдний нэг нь шүүх дээр мэдүүлэг өгөхдөө ер нь бол алдаа гарсан байна гэсэн бол нөгөө хохирогч өмнө зодуулж, багалзуурдуулсан гэж мэдүүлсэн байсныгаа “намайг түлхсэн, тэвэрсэн” гэж өөрчилжээ.

14.4.5. Шинжээч нарын мэдүүлгийг шалгах

Шинжээч буюу шүүх эмнэлгийн шинжээч нь ажиглалт хийгдсэн 57 хэргийн зөвхөн нэгт нь (1.8 хувь) мэдүүлэг өгсөн. Тус хэрэгт ГБХ-ийн дараа хохирогчийн байдал дордож, улмаар нас баржээ. Ажиглагчдын тайлагнаснаар, шинжээчид эрх үүргийг танилцуулж, тайлбарласан байна. Шүүгдэгч (холбогдогч)-ид харин шинжээчээс татгалзах эрхийнх нь талаар мөн танилцуулж тайлбарласан байна. Шинжээч зөвхөн мэргэшсэн чиглэлийн хүрээнд хамаарах дүгнэлтийг танилцуулсан. Хохирогчийг нас барснаас хойш хоёр хоногийн дараа болсон шүүхийн хэлэлцүүлэгт шинжээч мэдүүлэг өгсний дараагаар хохирогчийн цогцост задлан шинжилгээ хийлгэхээр эмгэг судлаачийг томилох тухай хохирогчийн өмгөөлөгчийн хүсэлтийг шүүх хангажээ.

14.5. “Талуудын тэгш байдал” зарчмын хувьд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 10-р Бүлгийн Хэсэг III-т цугласан өгөгдөл (Талуудын тэгш байдал) **(Хавсралт B).**

Талуудын тэгш байдлын зарчим “хуульд үндэслэн обьектив бөгөөд зохих үндэслэлээр зөвтгөгдөх ялгамжтай зохицуулалтаас бусад тохиолдолд талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ижил тэгш эрхээр хангагдах”-ыг шаарддаг.”[17] Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн зөвхөн шүүгдэгч (холбогдогч) ба хохирогчдын нөхцөл байдлыг судалж үнэлгээ өгдөг бөгөөд үүнийг шүүгдэгчийн эрхэд хамааруулсан боловч тэгш байдлын зарчмын хувьд яллах талд ч хамаарах юм.

14.5.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Ажиглалтын хүрээнд шүүх дээр эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн бүх эрхүүдээс “Талуудын тэгш байдал”-ын эрхийн гүйцэттэл нь хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Тухайн эрхийн хэрэгжилтийг шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар үнэлэхэд 100 хувийн оноотойгоор медиан “Маш сайн” үнэлгээ авсан. Шүүх дээр эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхүүдээс бүх хэргүүдэд “Маш сайн” үнэлгээ авсан цорын ганц эрхийн гүйцэтгэл байв. Эдгээр хэргүүдээс гурван хэрэгт хамгийн өндөр оноо авчээ.

14.5.2. Өмгөөлөх болон яллах талуудын эдлэх эрх

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад алдаа зөрчил гарсан, талуудын тэгш байдлыг хангаагүй тохиолдол нэн ховор гарсан ба хоёр эрүүгийн хэрэгт (өөр өөр шүүхийн) тухайн хэргүүдийг шийдвэрлэсэн шүүх хуралдааны танхимд яллах тал нь шүүгдэгч (холбогдогч)-тэй харьцуулбал шүүгчтэй илүү ойрхон суусан байв. Түүнчлэн ажиглагчдад дараах эрхтэй холбоотойгоор яллах талд давуу байдал үүсгэсэн зүйл ер ажиглагдаагүй байна. Үүнд:

- нотлох баримт гарган өгөх;
- гэрч, хохирогчид буюу шинжээч нараас асуулт асуух (хамаарах бол);
- хэргийн материалтай бүтнээр нь эсхүл хэсэгчлэн танилцах;
- шүүхэд хүсэлт гаргах;
- шүүхийн өмнөх шатанд хүсэлт гаргах эсхүл гомдол гаргах; эсхүл
- шүүх дээр эцсийн үгээ хэлэх.

14.5.3. Өмгөөлөх (шүүгдэгч (хохирогч) талын эрх

Түүнчлэн өмгөөлөх (шүүгдэгч, хохирогч) талд ч гэсэн эцсийн үгээ хэлэх эрхийг нь олгоогүй тохиолдол бараг гарсангүй. Доор Дүрс 34-т танилцуулснаар энэ эрхийг зөрчсөн нэг хэрэг гарсан

[17] Нэгдсэн үндэстний байгууллагын Хүний эрхийн зөвлөл, 32-р *Ерөнхий тайлбар: 14-р зүйл: Шүүх, тусгай шүүхийн өмнө тэгш байх, шударгаар шүүлгэх эрх*, НҮБ-ын баримт бичгийн дугаар. CCPR/C/GC/32, 2007 оны 08 сарын 23, 13-рхэсэг.

нь (бүх хэргийн 1.8 хувь) зөрчлийн хэрэг байсан бөгөөд шүүгч шүүгдэгч (холбогдогч) талыг эцсийн үгээ хэлэх гэж байхад нь тасалсан билээ.

Дүрс 34: *Шүүх хуралдаанд эцсийн үгээ хэлэх боломж*

14.6. Өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 11-р Бүлгийн Хэсэг III-т цугласан өгөгдөлд тулгуурласан болно. (Өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх) (**Хавсралт В**).

14.6.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Шүүгдэгч (хохирогч)-ийн өөрийгөө өмгөөлөх эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилт шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар 100 хувь буюу медиан “Маш сайн” үнэлгээ авсан. Гэвч энэхүү үнэлгээ авахад өндөр онооны кластер нөлөөлсөн бөгөөд улмаар арай доогуур буюу “Сайн үнэлгээ” авсан есөн хэргийг болон “Муу үнэлгээ” авсан нэг хэргийг халхалсан байна.

Мөн ял шийтгэлийн хэмжээ болон өөрийгөө өмгөөлөх эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хооронд ямар нэгэн харилцан хамаарал ажиглагдаагүй (аль ч тохиолдолд медиан “Маш сайн” үнэлгээ буюу нийт 100 хувь авсан) байна. Харин шүүгдэгч (холбогдогч) нь өмгөөлөгчтэй байсан хэргүүдэд онооны картын үзүүлэлт буурч байсан. Шүүгдэгч (холбогдогч) хууль ёсны төлөөллөөр хангагдсанаар түүний эрхийн хамгаалалтыг сайжруулна гэсэн таамаглалтай зөрчилдөж байна. Үнэн хэрэгтээ өмгөөлөгчтэй шүүгдэгч (холбогдогч)-ийн хэргийн медиан оноо 87.5 хувь байсан бол өмгөөлөгчгүй шүүгдэгч (холбогдогч)-ийн хэргийн оноо 100 хувь байв. Өмгөөлөгчтэй байсан шүүгдэгч (холбогдогч)-ийг шүүх хуралдааны хуралдааны үеэр танхимаас гаргасан гурван хэрэгт үнэлгээний оноо нь буурч 66.7 хувьтайгаар медиан “Сайн” болжээ.

14.6.2. Өөрийгөө өмгөөлөх эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх шүүгдэгч

(холбогдогч)-ийн ерөнхий эрх

Ерөнхийдөө шүүгдэгч (холбогдогч)-ийн өөрийгөө өмгөөлөх эсхүл өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрхийн хэрэгжилтэд саад бэрхшээл цөөн байсан гэж ажиглагчид тодорхойлсон байна.
Шүүгдэгч (холбогдогч) бүх шүүх хуралдаанд оролцсон бөгөөд үүнээс гурван хэрэгт нь (5.3 хувь) цахим хуралдаанд оролцсон байна. Эдгээр гурван зөрчлийн хэргийн шүүх хуралдаан нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн шүүхэд болсон бөгөөд тухайн хуралдаанд хохирогчид оролцоогүй байна.

Доор **35-р Дүрсэд** тайлбарласанчлан, бүх шүүгдэгч (холбогдогч)-ид өөрсдийн холбогдсон хэргийн талаар ямар ч байсан тодорхой мэдээллийг авсан байв. Ихэнх (87.7 хувь) тохиолдолд мэдээллийг хангалттай хэмжээнд цаг тухайд нь авсан байсан бол долоон шүүгдэгч (холбогдогч)-ид (12.3 хувь) мэдээллийг хязгаарлагдмал байдлаар эсхүл хожуу өгсөн ажээ.

Дүрс 35: *Шүүгдэгч (холбогдогч) хэргийн материалтай танилцсан байдал*

Гурваас бусад хуралдаанд шүүгдэгч (холбогдогч) (54 хүн буюу 94.7 хувь) өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ бүрэн эдлэхэд ямар нэгэн асуудал тулгараагүй байна. Ажиглагчдын мэдээлснээр нөгөө гурван хэрэгт эрхээ эдлэхэд дараах асуудал илэрсэн байна. Үүнд:

Шүүх хуралдааны ажиглагчдын үзэж байгаагаар өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ бүрэн эдлэхэд үүссэн асуудал	Холбогдох шүүх хуралдааны тухай дэлгэрэнгүй мэдээлэл
• Шүүх шүүгдэгч (холбогдогч) -ийн гэм бурууг урьдчилан тогтоосон байсан юм шиг санагдсан	• ГБХ хүндрүүлэх нөхцөл болсон хүнийг алах гэмт хэрэгт холбогдох эрүүгийн шүүх хуралдаан • Хохирогч нь оройн хоолоо идэхийг хүсээгүй гэх үхтлээ зодуулсан 3 нас, 11 сартай хүүхэд • Шүүх “шүүгдэгч (холбогдогч) -тэй арай ширүүн харьцаж” байсан гэж ажиглагчид тодорхойлсон • Хэргийг гурван шүүгчдийн бүрэлдэхүүн хянан шийдвэрлэсэн • Шүүгдэгч (холбогдогч)-ид бүх насаар хоригдох ял оногдуулсан (ажигласан хэргүүд дунд оногдуулсан хамгийн хүнд ял) • Шүүх хуралдаан 1 цаг 42 минут үргэлжилсэн (ажигласан эрүүгийн шүүх хуралдаануудын шүүхийн хуралдааны медиан хугацаанаас 30 секундээр бага)

Шүүх хуралдааны ажиглагчдын үзэж байгаагаар өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ бүрэн эдлэхэд үүссэн асуудал	Холбогдох шүүх хуралдааны тухай дэлгэрэнгүй мэдээлэл
• Шүүх шүүгдэгч (холбогдогч)-ийн гэм буруу урьдчилан тогтоосон байсан юм шиг санагдсан • Шүүх хуралдаан хэт түргэн бас хэт богино явагдсан	• Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон зөрчлийн хэргийн шүүх хуралдаан • Шүүгдэгч (холбогдогч) өмнө ГБХ-ийн хэргээр ял шийтгүүлж байсан • Тухайн шүүхийн хуралдааны өдөр хянан хэлэлцэгдэхээр хүлээгдэж байсан маш олон тооны хэргүүд байсан тул тус хэргийн хуралдааныг хурдан явуулахад нөлөөлсөн байж болох юм гэж ажиглагчид тэмдэглэсэн • Шүүх хуралдаан ердөө 15 минут үргэлжилсэн байна (зөрчлийн хэргийн шүүхийн хуралдааны медиан хугацаа болох 24 минутаас 9 минутаар богинохон байв)
• Шүүх хуралдаан хэт түргэн бас хэт богино явагдсан	• Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон зөрчлийн хэргийн шүүх хуралдаан • Тухайн шүүхийн хуралдааны өдөр хянан хэлэлцэгдэхээр хүлээгдэж байсан маш олон тооны хэргүүд байсан тул тус хэргийн хуралдааныг хурдан явуулахад нөлөөлсөн байж болох юм гэж ажиглагчид тэмдэглэсэн • Шүүх хуралдаан ердөө 11 минут үргэлжилсэн байна (зөрчлийн хэргийн шүүхийн хуралдааны медиан хугацаа болох 24 минутын талаас богинохон)

Хүснэгт 9: *Хэргийг зөв зохистой шийдвэрлүүлэхэд шүүгдэгч (холбогдогч)-ид учирсан саад бэрхшээлүүд*

Бүх шүүгдэгч (холбогдогч)-д улсын яллагчийн зүгээс гаргаж танилцуулсан дүгнэлт эсхүл гаргаж өгсөн тайлбар нотлох баримттай танилцах зарим боломжоор хангагдсан байсан ч дөрвөн хэрэгт (7 хувь) энэ боломжийг хангалттай олгоогүй гэж ажиглагчид тэмдэглэсэн юм.

14.6.3. Шүүх хуралдаанд биечлэн оролцох эрх

Ажиглагчдын тайлагнаснаар шүүх хуралдаанд оролцон мэдүүлэг өгч буй гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор гурван шүүгдэгч (холбогдогч)-ийг (нийт шүүгдэгчийн 5.3 хувь) шүүх хуралдааны танхимаас гаргасан байна. Эдгээр гурван шүүгдэгч ял сонссон байв. Гэхдээ зөвхөн нэг л шүүгдэгчийн хувьд шүүх хуралдаанд өөр газраас аудио болон видео холболтоор оролцох, шүүх хуралдааны танхимыг орхихын өмнө хохирогч/гэрчийн талаар өмгөөлөгчтэйгээ зөвлөх, тэднээс асуулт асуух боломжтой байсан байна. Харин өөр хоёр шүүгдэгч эдгээр эрхийг огт эдлээгүйгээс гадна мэдүүлгийн хураангуйг аваагүй байна. Түүнчлэн, эдгээр гурван шүүгдэгчийн нэгийг нь шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх үеэр мөн хуралдааны танхимаас гаргажээ.

14.6.4. Өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Дээр **11.6.2-р Хэсэгт** дурдсанчлан бүх 57 шүүгдэгч (холбогдогч)-оос 16 (28.1 хувь) нь өмгөөлөгчтэй байсан буюу нийт хэргийн дөрөвний гуравт (71.9 хувь) нь өмгөөлөгчгүй оролцсон байсан. Нэг шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцоогүй байна. Шүүгдэгч (холбогдогч) хууль ёсны төлөөлөлтэй оролцсон хэргүүдийн гуравны хоёрт нь (11 хэргүүд буюу 68.7 хувь) өмгөөлөгчийг шүүгдэгч (холбогдогч) өөрсдөө эсхүл тэдгээрийн гэр бүлийн гишүүд авсан байв. Харин үлдсэн 5 хэрэгт нь шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгчдийг улсаас

томилжээ. Ихэнх шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгчид (хэргүүдийн 62.5 хувь) өөрсдийн үйлчлүүлэгчийг шүүхийн өмнөх шатнаас эхлэн төлөөлсөн байна. Харин гурван шүүгдэгч (холбогдогч) өмгөөлөгчийг зөвхөн мөрдөн шалгах ажиллагаанаас хойш авсан бол (18.7 хувь) бусад гурван шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгчдийн хувьд шүүх таслах ажиллагаа эхлэхэд (18.7 хувь) төлөөлж эхэлсэн байна.

Шүүх хуралдааны танхимд ихэнх шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгчид (хэргүүдийн 62.5 хувь) шүүгдэгч (холбогдогч)-тэй ойрхон сууж байсан байна. Ажиглагчид шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгчид болон тэдгээрийн үйлчлүүлэгчдийн хооронд харилцааны хувьд цөөн хэдэн асуудал байсныг тайлагнасан. Харин нэг хэрэгт тухайн хэргийн шүүх хуралдааны танхим дэндүү жижигхэн байснаас болж өмгөөлөгч шүүгдэгч (холбогдогч)-тэй ганцаарчлан ярилцах боломжгүй байсан гэж ажиглагчид үзжээ.

Шүүх хуралдаан дахь өмгөөлөгчдийн үйл ажиллагааг үнэлэх асуудлаар ажиглагчид нэг тохиолдлоос бусад бүх тохиолдолд (93.7 хувь) шүүгдэгч (холбогдогч)-ид асуудлыг хангалттай хэмжээнд тайлбарлаж, тэдэнд ойлголцохуйц байдлаар ярьж байсан гэж үзсэн байна. Гэвч нэг хэрэгт өмгөөлөгч нь шүүгдэгч (холбогдогч)-ийн асуудлыг хангалттай хэмжээнд тайлбарлаагүй гэж ажиглагчид тайлагнажээ. Харин харилцааны хувьд бүх шүүгдэгч (холбогдогч)-ийн өмгөөлөгчид өөрсдийн үйлчлүүлэгчидтэй эелдэг бас хүндэтгэлтэй харьцаж байсан гэж үнэлсэн байна. Гэсэн хэдий ч нэг тохиолдолд өмгөөлөгч шүүгдэгч (холбогдогч)-тэй огт харьцахгүй байсан гэж мэдээлжээ. Үүнээс гадна таван хэрэгт өмгөөлөгчид үйлчлүүлэгчдийнхээ хүсэлт, заавар чиглэлийг авч байгаа нь хангалтгүй, үйлчлүүлэгчдээ юу хийх талаар хэлж өгөхдөө илтэд хүндэтгэлгүй хандаж байсан гэж тэмдэглэгдсэн байна.

14.7. Шүүхийн шийдвэр нийтэд ил тод байх, үндэслэл бүхий шийдвэр гаргуулах шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 12-р Бүлгийн Хэсэг III-т цугласан өгөгдөлд суурилсан болно. (Шүүхийн шийдвэр нийтэд ил тод байх, үндэслэл бүхий шийдвэр гаргуулах эрх) (**Хавсралт В)**

14.7.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Хэдийгээр шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүх дээр эдлэх шүүхийн шийдвэр нийтэд ил тод байх, үндэслэл бүхий шийдвэр гаргуулах эрхийн хэрэгжилт шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар 84.4 хувь буюу медиан “Маш сайн” үнэлгээ авсан ч бусад эрхүүдийн хэрэгжилттэй харьцуулахад доороосоо хоёрт эрэмбэлэгдэв. Шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүх дээр эдлэх зарим эрхийн өндөр онооны үйцэтгэл бүхий олон тохиолдлын том кластертэй харьцуулахад шүүхийн шийдвэр нийтэд ил тод байх, үндэслэл бүхий шийдвэр гаргуулах эрхийн хэрэгжилт зөвхөн гурван хэрэгт л энэхүү өндөр үнэлгээ авч чаджээ. Ийнхүү шүүхийн шийдвэртэй холбоотой гарч буй цөөн тооны процессын алдаа, зөрчил нь тохиолдлын чанартай гэхээс илүүтэй нийтлэг гэж ойлгогдохоор байсан бөгөөд эрүүгийн хэрэгтэй харьцуулбал зөрчлийн хэрэгт илүү муу гүйцэтгэлтэй гарч байв. Эрүүгийн хэргийн хувьд хэргээ нээлттэй, үндэслэл бүхий шийдвэрээр шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилтийн медиан оноо нь 90.6 хувьтай байхад зөрчлийн хэргийн ойролцоогоор 10 хувиар бага буюу нийт 81.2 хувь байна.

14.7.2. Шүүх хуралдааны тэмдэглэл

Нэгээс бусад бүх ажигласан хэргийн шүүх хуралдааны тэмдэглэлийг компьютер (98.2 хувь) ашиглан бүрэн хэмжээгээр хийсэн байна. Үүний дотор гурван хэрэгт (5.3 хувь) нэмэлтээр гар тэмдэглэл хөтөлж байжээ. Харин тэмдэглэл бүрэн хийгдээгүй нэг хэрэг нь зөрчлийн хэрэг байсан бөгөөд ажиглагчдын тайлагнаснаар тэмдэглэлийг зөвхөн хэсэгчилсэн байдлаар компьютер дээр үйлдсэн байна. Шүүх хуралдааны аудио видео бичлэгийг мөн адил бараг бүх буюу хэргүүдийн 93 хувьд (53 хэргүүд) хийсэн бол дөрвөн хэрэгт ийм аудио-видео бичлэг огт хийгдээгүй. Энэ дөрвөн хэргүүдийн хоёр нь болох Ховд аймгийн зөрчлийн хэргийн шүүх хуралдаанд тоног төхөөрөмж нь байгаагүй эсхүл байсан ч ашиглаагүй гэж ажиглагчид тайлагнасан байна. Нөгөө хоёр хэрэг нь Төв аймагт болсон зөрчлийн хэргийн шүүх хуралдаанууд бөгөөд эдгээр бичлэгийг зөрчлийн хэргийн шүүх хуралдаануудад хийдэггүй хэмээн ажиглагчдад мэдээлжээ.

Нийт гуравны нэгээс бага хувьд (31.6 хувь) нь шүүхийн зүгээс шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах талуудын эрхийн талаар зөвхөн тайлбарлаад өнгөрсөн боловч шүүх хуралдааны тэмдэглэлийн агуулгын талаар нэг ч оролцогч гомдол, хүсэлт гаргаагүй байна.

14.7.3. Шийтгэх тогтоол ба түүнийг уншиж сонсгох

Эрүүгийн таван хэргийн шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон байна. Иргэдийн төлөөлөгч гэдэгт “шүүх эрх мэдлийн байгууллагад“ ил тод, нээлттэй байх зарчмыг бэхжүүлэх, шүүн таслах ажиллагаанд олон нийтийн зүгээс хяналт тавих тогтолцоог бий болгох” зорилгоор шүүн таслах ажиллагаанд оролцож байгаа жирийн иргэнийг”[18] ойлгоно. Иргэдийн төлөөлөгч нь анхан шатны эрүүгийн шүүх хуралдааны явцад талуудад асуулт тавих зэргээр нотлох баримтыг шинжлэн судлах эрхтэйгээр оролцохоос гадна шүүгдэгчийн гэм буруугийн талаарх шийдвэрт өөрсдийн санал бичих, уншиж сонсгох эрхийг эдэлдэг билээ.[19]

Шүүх хуралдаанд оролцсон таван иргэдийн төлөөлөгчдийн дөрөв нь шүүгдэгчийг гэм буруутайд тооцон ял шийтгэл оногдуулах саналыг хүргүүлсэн байна. Яллах тал нь мөн адил нийт 57 хэргийн хувьд шүүгдэгчийг гэм буруутайд тооцож, хорих болон бусад төрлийн ял шийтгэл тооцох зэрэг санал гаргаж байсан байна. Харин өмгөөлөх талын зүгээс авч үзвэл зөвхөн гурван шүүгдэгч өөрсдийгөө огт гэм буруугүй хэмээн мэдэгдсэн (5.3 хувь) байв. Нийт шүүгдэгчийн бараг тал хувь нь эрүүгийн хариуцлага хөнгөрүүлэх нөхцөл байдлын талаар тайлбар хүсэлт гаргаж байсан бол (49.1 хувь) таван шүүгдэгч тутмын хоёр нь (22 яллагдагч буюу 38.6 хувь) яллагдсан хэргийнхээ бүх эсхүл зарим үйлдэлд гэм буруугаа хүлээсэн, эсхүл харамсаж байгаагаа илэрхийлжээ.

Үндсэндээ бүх ажигласан хэргүүдэд шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон. **36-р Дүрсэд** харуулж байгаачлан 10 шүүгдэгч (холбогдогч) тутмын ес нь (89.5 хувь) холбогдсон зөрчил болон гэмт хэрэг үйлдсэнд тооцогдож, хариуцлага хүлээсэн бол нэг шүүгдэгч (холбогдогч)-ийн хувьд зөвхөн тодорхой хэрэгт буруутайд тооцогджээ (1.8 хувь). Мөн дөрвөн шүүгдэгчийн хувьд яллах дүгнэлтэд заасан зүйлчлэлийг өөрчилж ял оногдуулжээ (7 хувь). Харин нэг шүүгдэгч

[18] *Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн* 1.4.1.33-р зүйл
[19] *Монгол улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн* 3.4.2-р зүйл

(холбогдогч)-ийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан гэх хэрэгт цагаатгажээ.

Дүрс 36: *Ажигласан хэргүүдтэй холбоотойгоор гарсан шүүхийн тогтоолууд*

Уг үйл ажиллагааны загварыг тодорхойлох чиглэлээр хийсэн зөвлөлдөх уулзалтуудын үеэр зарим оролцогчид шүүх дээр мэдүүлэг өгсөн ихэнх нь биш гэхэд маш олон хохирогчид шүүгдэгч (холбогдогч)-ийн эсрэг өгсөн мэдүүлгээсээ татгалзах хандлагатай байдаг гэж хэлж байсан билээ.
Олон хохирогчийн зүгээс шүүгдэгч нь дахин хүчирхийлэл үйлдэж дарамтална, эсхүл гэр бүлийнх нь орлогын эх үүсвэр алдагдана гэхээс эмээж, түүнд ял шийтгэл оногдуулахгүй байх хүсэлтийг шүүхэд гаргасан тухай тэмдэглэгджээ. Иймээс энэхүү нөхцөл байдалд үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнд тодорхой асуулт (12.9-р асуулт, **Хавсралт В**-г харна уу)-ыг нэмж оруулахаар болсон билээ.

Ажиглагчдын тайлагнаснаар 11 хохирогч (18 хувь) шүүгдэгч (холбогдогч)-ийн хийсэн үйлдлийн тухай өгсөн өмнөх мэдүүлгээсээ татгалзаж, шүүгдэгч (холбогдогч)-ийн цагаатгахыг хүссэн эсхүл хэргийн хүссэн үр дүнгийн талаар ерөнхийдөө ямар ч маргаан гаргаагүй байна. Үнэн хэрэгтээ харьцангуй багаар тооцож үзэхэд таван хохирогч тутмын бараг нэг нь ийм хүсэлт гаргасан нь олон хохирогчдын хувьд шүүх хуралдаанд оролцохгүй байснаар тухайн хэргээсээ татгалзах санаа байж болох юм гэж ажиглагчид үзжээ. Харин **Дүрс 37**-т харуулж байгаачлан, шүүхүүд ихэнхдээ (7 хэрэг буюу 63.6 хувь) хохирогчдын мэдүүлгээсээ татгалзсаныг хүлээж аваагүй болно. Гэхдээ гурван шүүх дээр мэдүүлгээсээ татгалзсаныг тодорхой хэмжээнд хүлээн авсан, нэг хэрэг дээр ач холбогдол өгсөн хэдий ч гэм буруутайд тооцон ял шийтгэл оногдуулсан гэдгийг ажиглагчид тэмдэглэсэн юм.

Дүрс 37: *Хохирогч мэдүүлгээсээ татгалзсан эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгах хүсэлт гаргасан байдал*

Түүнчлэн, нийт 12 хэрэгт (нийт хэргийн 21.1 хувь) шүүгчид шийдвэр, тогтоол гаргахдаа хүндрүүлэх нөхцөл байдал байгаа эсэхийг мөн адил харгалзан үзэж байсан гэж ажиглагчид тайлагнав. Дөрвөн хэрэгт шүүгчид Эрүүгийн хуулийн дагуу хүнийг алах зэрэг ГБХ-ээс бусад тодорхой гэмт хэргийн хүндрүүлэх шинжид тусгагдсан ГБХ-ийн улмаас үйлдэгдсэн эсэхийг шинжлэн судалж байсан юм. Түүнчлэн шүүгчид ихэнхдээ шүүгдэгч (холбогдогч)-ийг согтуурсан үедээ зөрчил, гэмт хэрэг үйлдсэн (дөрвөн хэрэгт), хэн нэгэнд халдсан, эсхүл өмнөх гэмт хэргийн түүхтэй (гурван хэрэгт), хохирогчтой харгис хэрцгий байдлаар харьцсан эсэх (хоёр хэрэгт), аль эсхүл өмнө үйлдсэн зөрчил, гэмт хэргийнхээ төлөө ял шийтгэл хүлээж, түүнийгээ эдэлсэн эсэхийг (нэг хэрэгт) шалгаж, нягтлан хүндрүүлэх нөхцөл байдал болох эсэхийг тогтоосон байна.

Мөн үүнээс гадна, шүүгчид есөн хэрэгт (15.8 хувь) хөнгөрүүлэх нөхцөл байдал бий эсэхийг судалсан болно. Эдгээрээс хамгийн түгээмэл нь шүүгдэгч (холбогдогч)-ийн гэр бүлийн нөхцөл байдал эсхүл түүний хувийн нөхцөл байдал, жишээ нь түүний эрүүл мэндийн байдал, тухайн өрхийн тодорхой ажил үүргийг гүйцэтгэх цорын ганц хүн эсэх (дөрвөн хэрэгт) зэрэг байсан болно.
Шүүхийн зүгээс гурван хэрэгт шүүгдэгч (холбогдогч)-ийг анх удаа зөрчил, гэмт хэрэг үйлдсэн эсхүл тухайн хохирогчид анх удаа уг зөрчил, хэргийг үйлдсэн зэрэг нөхцөл байдлыг харгалзан үзэж ялыг хөнгөрүүлсэн байна. Мөн хоёр хэрэгт шүүгчид шүүгдэгч (холбогдогч)-ийн хийсэн хэрэгтээ маш ихэд харамсаж байгааг харгалзан үзсэн ба тухайн хэргүүдийн аль алинд нь шүүгчид оногдуулах ял шийтгэлийн тухай хохирогчийн санал болоод хохирогчид бие махбодын хохирол учруулаагүй гэх нөхцөлийг мөн адил харгалзан үзсэн билээ.

Шүүгдэгч (холбогдогч)-ийг цагаатгасан нэг хэрэгт шүүгч шүүгдэгч (холбогдогч)-ид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс гаргасан хууль бус үйлдэлд нөхөн төлбөр авах эрхийн талаар танилцуулаагүй болон тайлбарлаагүй болохыг ажиглагчид тайлагнажээ.

38-р Дүрс ба **11-р Хүснэгтэд** ял шийтгэл хүлээсэн шүүгдэгч (холбогдогч)-ид оногдуулсан ял шийтгэлийн төрөл, хэмжээ болон дэлгэрэнгүй мэдээллийг танилцуулсан болно.

Дүрс 38: *Шүүгдэгч (холбогдогч)-ийг гэм буруутайд тооцон ял шийтгэхэд оногдуулсан хариуцлагын төрөл*

	Зөрчлүүд			Гэмт хэргүүд		
Хариуцлагын төрөл	**Хариуцлага ногдуулсан хэргүүдийн тоо**	**Хүлээлгэсэн хариуцлагын хэмжээ**	**Медиан**	**Хариуцлага ногдуулсан хэргүүдийн тоо**	**Хүлээлгэсэн хариуцлагын хэмжээ**	**Медиан**
Хорих ял / баривчлах	34	7-156 хоног	10 хоног	9	7 сараас бүх насаар нь хорих ял	3.5 жил
Торгууль	5	100,000 төгрөгөөс (~35 ам.доллар) 300,000 төгрөг хүртэл (~105 ам.доллар)	100,000 төгрөг (~35 ам.доллар)	6	500,000 төгрөгөөс (~175 ам.доллар) 1,200,000 төгрөг хүртэл (~420 ам.доллар)	790,000 төгрөг (~275 ам.доллар)
Албадан сургалт	34	10-60 цаг	15 цаг	--	--	--
Нийтэд тустай ажил хийлгэх	--	--	--	6	240-720 цаг	500 цаг
Учруулсан хохирол нөхөн төлөх	--	--	--	4	750,000 төгрөгөөс (~263 ам.доллар) 2,871,336 төгрөг хүртэл (~1,006 ам.доллар)	1,894,202 төгрөг (~664 ам.доллар)

Хүснэгт 10: *Гэм буруутайд тооцон ял шийтгэл оногдсон шүүгдэгч (холбогдогч)-ийн хүлээсэн хариуцлагын төрөл, хэмжээ, дэлгэрэнгүй мэдээллүүд*

38-р Дүрс болон **Хүснэгт 11-р**т харуулсанчлан, зөрчлийн хэрэгт хариуцлага хүлээсэн ихэнх хүмүүст албадан сургалтад хамруулах арга хэмжээ авахын зэрэгцээ баривчлах шийтгэл (бүх хүмүүсийн 89.7 хувь) оноожээ. Сургалтын цагийн медиан нь 20 цаг байсан бол баривчлах

шийтгэлийн медиан хугацаа 10 хоног байв. Оногдуулсан баривчлах арга хэмжээ болон албадан сургалтын цагийн хувьд мэдэгдэхүйц нэг хэв шинж байгаагүй бөгөөд түүвэрлэгдсэн хэрэгт эдгээр нь харилцан адилгүй байв. Тухайлбал, ихэнх албадан сургалтад хамруулах тухай шийдвэрүүд (34 хэргээс 30 нь буюу 88.2 хувь) 23-56 цагийн албадан сургалтад хамруулах гэсэн Хууль зүй, дотоод хэргийн яамны журмыг зөрчсөн байна.[20] Тодруулбал, нийт 29 хэрэгт албадан сургалтын цаг (10-21 цаг) нь дээрх заасан хэмжээнээс бага байсан бол нэг хэрэгт 60 цагийн сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн байсан нь тусгайлан заасан цагийн хязгаарлалтыг давсан байлаа. Зөрчлийн хэрэгт шийтгэл оногдуулсан хүмүүсээс үлдэх хэсэгт (12.8 хувь) торгох шийтгэлийг дангаар нь, эсхүл албадан сургалтад хамрагдах болон баривчлах шийтгэлтэй давхар оногдуулсан байна.

Нөгөөтэйгүүр дээд талын **13.1.2-р Хэсэгт** дурдсан шүүхийн өмнөх шатанд авсан аюулгүй байдлын арга хэмжээнүүдийн хувьд, эцэслэн оногдуулсан ял шийтгэлийг харахад нэг ч шүүгдэгч (холбогдогч)-д зорчих эрхийг хязгаарласан эсхүл тодорхой хүмүүстэй уулзах, харилцахыг хязгаарласан, мөн тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлсэн эсхүл өөр бусад эрхийг хязгаарласан арга хэмжээ аваагүй болно. Үүнээс гадна нэг ч шүүгдэгч (холбогдогч) сэтгэцийн эсхүл өөр албадан эмчилгээнд хамрагдах шийдвэр гараагүй байна (одоогийн байдлаар Монгол улсад боломжтой хэмжээнд).

Гэм буруутайд тооцож ял шийтгүүлсэн шүүгдэгчдийн тэн хагас нь 7 сараас бүх насаараа хорих хүртэл ялаар шийтгүүлсэн бөгөөд хорих ялын дундаж хугацаа 3.5 жил байна. Тэдний гуравны нэгт нь (33.3 хувь) торгох (дунджаар 790,000 төгрөг), эсхүл нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл (дунджаар 500 цаг) ногдуулжээ. Эрүүгийн хэрэг үйлдэж гэм буруутайд тооцсон маш цөөн тооны этгээдүүдэд (хэргүүдийн 22.2 хувь) хохирол нөхөн төлүүлэх үүрэг хүлээлгэжээ. Нөхөн олговрын хэмжээ эрс ялгаатай байсан бөгөөд дунджаар 1,894,202 төгрөг байв.

Хэргүүдийн зөвхөн гуравны нэгт нь шүүхээс гарсан тогтоолыг бүтнээр нь уншиж танилцуулсан байна (33.3 хувь). Ихэнх хэрэгт (59.6 хувь) товчхон уншсан бол, хэргүүдийн 7 хувьд нь зөвхөн тогтоолыг танилцуулж, ямар нэгэн тайлбар үндэслэлийг өгөөгүй байна. Үүнийг дор **Дүрс 39-рт** харуулж байна.

[20] "Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журам" Хууль зүй, дотоод хэргийн яамны тогтоол №. А/73 (2017 оны 04 сарын 3), 2-р хавсралт, 9.2-р зүйл

Дүрс 39: *Шүүхийн шийдвэрийг шүүх дээр уншиж сонсгосон хэмжээ*

Гэсэн хэдий ч хэргүүдийн бараг гуравны хоёрт (63.2 хувь) шүүгчид шийтгэх тогтоол танилцуулсныхаа дараа шүүгдэгч (холбогдогч)-д үндэслэлийнх нь талаар сайн тайлбарлаж байсан гэж ажиглагчид үзсэн байна. Нөгөөтэйгүүр хэргүүдийн бараг гуравны нэгт нь эдгээр тайлбарыг хангалтгүй (33.3 хувь) байсан гэж ажиглагчид дүгнэсэн бөгөөд хоёр хэрэгт ямар ч тайлбар хийгдээгүй байна. Харин хэргүүдийн гуравны хоёрт (66.7 хувь) нь давж заалдах эрхийн талаар шүүгчдийн зүгээс шүүгдэгч (холбогдогч)-д хангалттай сайн тайлбарласан бол хэргүүдийн 31.6 хувьд тус тайлбар нь хангалтгүй байсан бол өөр нэг хэрэгт (шүүгдэгч (холбогдогч)-ийг цагаатгасан хэргээс өөр хэрэг) ямар ч тайлбар хийгээгүй байна.

14.7.4. Шүүхийн шийдвэр

Шүүхийн бичгэн шийдвэрүүдийг аман хэлбэртэй нь харьцуулахад харьцангуй дээгүүр үзүүлэлттэй байв. Нэгээс бусад бүх шийтгэвэр тогтоолууд (98.2 хувь) нь Монгол Улсын хуульд заасан шаардлагуудыг хангасан гэмт хэргийн товч агуулга, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг хугацааг гэх мэдээллийг багтаасан байсан байна. Түүнчлэн, бүх шийтгэвэр, тогтоолд шүүгдэгч (холбогдогч)-ийг гэм буруутайд тооцон ял шийтгэл оногдуулах эсхүл цагаатгахад үндэслэл болгосон холбогдох хуулийн зүйл заалтыг тусгасан байна. Цаашлаад доор **40-р Дүрсэд** тайлбарласанчлан, ихэнх шүүхийн бичгэн шийдвэрүүд нь улсын яллагч, шүүгдэгч (холбогдогч)--ийн зүгээс гаргаж өгсөн бүх тайлбар үндэслэл болоод нотлох баримтыг хангалттай сайн шинжлэн судалсан байсан гэж ажиглагчид үзжээ. Гэвч энэ тал дээр хангалтгүй байсан гэж тооцогдсон нийт дөрвөн хэргийн (7 хувь) гурав нь яллах талын тайлбар үндэслэлийг хангалттай сайн шинжлэн судалж, тусгаагүй байсан бол нэг хэрэгт өмгөөлөх талын тайлбар үндэслэлийг тусгаагүй гэж ажиглагчид үзжээ.

Дүрс 40: *Шүүхийн шийдвэр гаргахад талуудын тайлбар, нотлох баримтыг шинжлэн судалсан байдал*

Эцсийн дүнд ажиглагчид бүх шүүхийн шийдвэрийг (96.5 хувь) хангалттай тодорхой, ойлгомжтой ба эргэлзээ төрүүлэхээргүй байсан гэж үнэлэв. Харин хоёр хэрэгт тийм байгаагүй, учир нь нэг

хэрэгт нь л гэхэд (Зөрчлийн хэргийн шүүх хуралдаан) шийтгэвэр нь анх шүүх хуралдаанд уншиж танилцуулж байснаас өөр байсан гэж ажиглагчид дүгнэсэн билээ. Мөн ажиглагчдын зүгээс шүүхийн ихэнх тогтоол (хэргүүдийн 96.5 хувь)-ын тогтоох хэсэг нь үндэслэх хэсэгтэйгээ нийцсэн гэж үнэлжээ. Хоёр хэрэгт үндэслэх хэсэг нь хэсэгчлэн нийцсэн эсхүл нийцээгүй байсан гэжээ. Хэргүүдийн нэгт нь шүүгдэгч (холбогдогч)-ийн өмнө ГБХ-ийн хэрэг удаа дараа үйлдэж байсныг харгалзан үзэлгүй харьцангуй хөнгөн шийтгэл ногдуулсан гэж ажиглагчид үзжээ.

Хэргүүдийн гуравны нэгт (36.8 хувь) шүүхээс гаргасан шийтгэх тогтоолыг бүтнээр танилцуулсан байна. Харин хэргийн долоон хувьд нууцлал хадгалах шалтгааны улмаас зөвхөн тойм хэлбэрээр нээлттэй болгосон. Мөн долоон хувьд зөвхөн шүүхийн тогтоолыг товчлон танилцуулахдаа үндэслэлээ тайлбарлаагүй байна. Үүнээс гадна, хэргүүдийн бараг тал хувьд нь (49.1 хувь) шүүхээс гаргасан шийтгэх тогтоол, түүний хураангуйлсан агуулгын аль алиныг нь танилцуулаагүй байна. Эцэст нь ихэнх шүүхийн шийтгэвэр, тогтоолууд (93 хувь) тогтоосон хугацаандаа гарсан бол дөрвөн хэрэгт (7 хувь) хугацаа нь хэтэрчээ.

15. Шүүхийн өмнөх болон бүх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх яллагдагч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэгт ажигласан хэргүүд дэх шүүгдэгч (холбогдогч)-тай холбоотой дүгнэлтийг танилцуулж байна. Ингэхдээ ажиглалт хийсэн бүх зөрчлийн болон эрүүгийн шүүх хуралдаанууд дахь шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилтийн талаар танилцуулж байна. Ийнхүү шүүхийн өмнөх шатанд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн дараах эрхийн талаар үнэлгээ өгсөн болно. Үүнд: халдашгүй чөлөөтэй байх эрх, хараат бус байдал, тал үр харах байдал, цагдан хорих арга хэмжээний хууль ёсны эсэхэд гомдол гаргах, мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах; өмгөөлөгч авах, өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэх хангалттай хугацаа, боломжоор хангуулах эрх (шүүхийн өмнөх шатанд) болон байцаалтын үеэр эдлэх эрхүүд хамаарна. Үүнээс гадна, энэ хэсэгт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хамаарах хүнлэг нөхцөлөөр хангуулах болон эрүүдэн шүүлтээс ангид байх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийг мөн адил судалсан билээ. Тус хэсэг нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний Хэсэг IV-т **(Хавсралт B)** цугласан өгөгдөлд тулгуурласан болно. Шүүх хуралдааны ажиглалтын аргачлалын дагуу хэргүүдийг шүүхийн шатанд сонгосон бөгөөд энэ хэсэгт ажиглалт хийсэн хэргийн мэдээллийг тухайн хавтаст хэрэг болон шүүхийн хэлэлцүүлэг, хуралдааны явцад хэлэлцсэн байдлаас цуглуулсан болно.

Шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх нь шүүхийн өмнөх эсхүл бүх шатанд ажигласан шүүгдэгч (холбогдогч)-ийн бүх эрхүүдээс шүүхийн өмнөх шатанд халдашгүй чөлөөтэй байх эрх, хараат бус байх байдал ба бие даасан байх болон цагдан хорих арга хэмжээ хууль ёсны эсэхэд гомдол гаргах эрхийн хэрэгжилт (**15.1-р Хэсэг**), яллагдагчийн эрх нь шүүхийн өмнөх эсхүл бүх шатанд шалгасан яллагдагч (холбогдогч)-ийн эрхүүд дундаж гүйцэтгэлтэй медиан “Маш сайн” гэх үнэлгээг авсан. Ихэнх шүүгдэгч (холбогдогч)-ийг хуульд заасны дагуу баривчилж, хэргийг нь шалгаж, яллах дүгнэлт үйлдэх тухай шаардлагатай тохиолдолд тэдэнд мэдэгдсэн байна. Шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авсан хэргүүдэд тухайн шийдвэр гаргах үед шүүгдэгч (холбогдогч)-ийн талаас дөнгөж илүү хэсэг нь оролцох боломжтой байжээ.

Ажигласан хэргүүдийн мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах шүүхийн өмнөх шатанд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилт (**15.2-р Хэсэг**) нь шүүхийн өмнөх шатанд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн бүх эрхүүдээс гүйцэтгэлээрээ хамгийн сайн үнэлгээ авсан байна. Шүүхийн өмнөх шатанд баривчлагдсан ихэнх шүүгдэгч (холбогдогч)-ид баривчлан саатуулагдсаны даруйд тэдгээрийн эрхийн талаар бичгээр мэдэгдэж, тайлбар өгч, баривчилсан тухай мэдэгдлийг гэр бүлийн гишүүнд цаг тухайд нь хийсэн байна. Нэг шүүгдэгч (холбогдогч)-ийн хүсэлтээр эрүүл мэндийн туслалцаа үзүүлжээ.

Ажигласан хэргүүд хэдийгээр медиан “Маш сайн” үнэлгээтэй байсан ч шүүхийн өмнөх шатанд эдлэх өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөхөд бэлтгэх хангалттай хугацаа эсхүл боломжоор хангуулах шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх (**Хэсэг 15.3**) ажигласан эрхүүдээс доороосоо хоёрт жагссан юм. Ихэнх яллагдагч (холбогдогч)-ид баривчлах арга хэмжээ авсны дараа өмгөөлүүлэх эрхийнх нь талаар танилцуулж, хавтаст хэрэгтэй шүүхийн өмнөх шатанд танилцах хангалттай боломжоор хангасан хэдий ч ажиглагчдын тэмдэглэснээр хэргүүдийн дөрөвний нэгт нь тухайн эрхийн талаар мэдэхгүй байсан эсхүл эрхээ ашиглах боломжийг олгосон эсэх талаар баримтжуулсан зүйл байхгүй байна. Мөн зарим шүүгдэгч (холбогдогч) шүүхийн өмнөх шатанд өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд бэлтгэх хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байж чадаагүй гэж ажиглагдав. Ихэнх яллагдагч (холбогдогч) өмгөөлөгч авах хүсэлт гаргах эрхээсээ татгалзсан ч тэдний дунд зайлшгүй өмгөөлөгч авах төрлийн шүүгдэгч (холбогдогч) байгаагүй билээ. Харин өмгөөлөгчтэй шүүгдэгч (холбогдогч)-ийн хэргүүдийн дунд өмгөөлөгч авах хүсэлт гаргасны дараа түүний өмгөөлөгч нь ирэхээс өмнө үйлдсэн хэргийнх талаар мэдүүлэг авсан нэг хэрэг гарсан байна.

Шүүхийн өмнөх шатны мэдүүлэг өгөх үеийн шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхийн хэрэгжилтийн үнэлгээ (**15.4-р Хэсэг)** медиан “Маш сайн” байсан ч шүүхийн өмнөх шатны бүх эрхүүдийн хэрэгжилтээс хамгийн муу оноо авсан бөгөөд ингэхдээ зөрчлийн хэргүүдийн гүйцэтгэл эрүүгийн хэргээс нэлээд муу үзүүлэлтэй гарчээ. Шүүгдэгч (холбогдогч)-ийн дийлэнх хувьд мэдүүлэг өгөхөөс өмнө эрхийнхээ талаар тайлбарлуулсан байсан ч байцаалтын үеэр өмгөөлөгчөө байлцуулах шаардлагатай байсан хоёр шүүгдэгч (холбогдогч) өмгөөлөгчгүйгээр мэдүүлгээ өгчээ. Хоёр шүүгдэгч (холбогдогч)-д байцаалтын тэмдэглэлийн хувийг өгөөгүй эсхүл уншиж танилцуулаагүй байсан бол нийт хэргүүдийн дөрөвний нэгт нь шүүгдэгч (холбогдогч)-ийн зүгээс байцаалтын тэмдэглэлд засвар эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах боломжтой байсан эсэхийг ажиглагчид байгаа мэдээллээс тогтоох боломжгүй байжээ.

Энэ хэсэгт шалгасан бүх эрхийн хамгийн сайн гүйцэтгэлтэй нь бүх шатанд хамаарах эрх буюу Хүнлэг нөхцөлөөр хангуулах болон эрүүдэн шүүлтээс ангид байх эрх байв (**15.5-р Хэсэг**). 52 хэрэгт тухайн эрхийн хэрэгжилт медиан “Маш сайн” гэсэн үнэлгээ авсан бөгөөд ажигласан аль ч хэрэгт яллагдагч (холбогдогч)-ийг хүнлэг бус нөхцөлд оруулж эсхүл эрүү шүүлт тулгасан ямар нэгэн зүйл ажиглагдаагүй болно.

15.1. Халдашгүй чөлөөтэй байх эрх, хараат бус байх, тал үл харах байдал, цагдан хорих арга хэмжээний хууль ёсны эсэхэд гомдол гаргах шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 14-р Бүлгийн Хэсэг IV-т цугласан өгөгдөлд тулгуурласан болно. (Халдашгүй чөлөөтэй байх, хараат бус байх ба бие даасан байдал ба Цагдан хорих арга хэмжээ хууль ёсны эсэхэд гомдол гаргах) (**Хавсралт В).** Нэг талаараа энэ хэсэг нь ижил төстэй мэт боловч шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 6-р Бүлгийн Хэсэг III-т (хуулийн дагуу байгуулагдаж, үйл ажиллагаа эрхлэх чадамжтай, хараат бус ба бие даасан шүүхээр хэргээ шийдвэрлүүлэх эрх) цугласан бөгөөд 14-р хэсэгт танилцуулсан өгөгдлөөс өөр гэдгийг онцолж тэмдэглэх нь зүйтэй. Тодруулбал, тухайн өгөгдөл нь шүүх хуралдааны шатанд хамаарах бол дор танилцуулж буй өгөгдөл шүүхийн өмнөх шатанд хамаарч байгаа болно.

Мөн уншиж ойлгоход илүү дөхөм, хялбар, агуулгын хувьд оновчтой болгох зорилгоор энэ хэсэгт тухайн эрх эзэмшигчийг яллагдагч (холбогдогч) гэх нэрээр үргэлжлүүлээд ашиглаж байгааг анхаарах нь зүйтэй юм. Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 14-р Бүлгийн Хэсэг IV-т эрх эзэмшигчийг **сэжигтэн** гэх нэр томьёогоор илэрхийлсэн болно.

Энэ нь гэм буруу тогтоогдож, ял шийтгэл ногдуулсан шүүхийн албан ёсны эцсийн шийдвэр гараагүй байхад тэдний эрх зүйн байдлыг илэрхийлэх хамгийн зүй зохистой тодорхойлолт байхын зэрэгцээ ажиглагчдад ч гэсэн илүү ойлгомжтой байсан билээ.

15.1.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Шүүхийн өмнөх шатанд болон бүх шатанд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн нийт таван эрхээс шүүхийн өмнөх шатанд эдлэх халдашгүй чөлөөтэй байх эрх, хараат бус байх, тал үл харах байдал, цагдан хорих арга хэмжээ хууль ёсны эсэхэд гомдол гаргах эрхийн хэрэгжилтийн үнэлгээ нь шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картаар 100 хувийн оноотойгоор медиан “Маш сайн” гэсэн үнэлгээтэй байв. Гэхдээ үүнд өндөр оноотой 38 хэргийн кластер нөлөөлсөн юм. Энэ нь “Сайн”-аас эхлэн “Маш сайн” үнэлгээний хамгийн доод оноог авсан 19 хэргийг халхаж байв. Энэ доогуур оноо нь шүүгдэгчид цагдан хорих эсхүл таслан сэргийлэх бусад арга хэмжээ авсантай ямар нэг байдлаар холбогдолтой байв. Эдгээр хэргүүдийн үнэлгээ нь медиан “Маш сайн” үнэлгээний шатлалд багтаж байсан ч оноо нь 10 хувиар бууралттай 87.5 хувь байв.

15.1.2. Халдашгүй чөлөөтэй байх

20 яллагдагч (холбогдогч)-ыг шүүхийн өмнөх шатанд баривчилсан (саатуулсан) байна. Тэдний дунд, нэгээс бусдыг нь хуулийн дагуу баривчилсан (95 хувь) байв. **Дүрс 41**-д тайлбарласанчлан, яллагдагч (холбогдогч)-дад ихэнхдээ хуулийн дагуу шүүгчийн захирамжаар баривчлагдсан (15 хэргүүд буюу 60 хувь) эсхүл (7 хэрэг буюу 35 хувьд) баривчлах зөвшөөрлийг танилцуулаагүй ч гэсэн гэмт хэрэг үйлдэгдэх үед, үйлдэгдсэн даруйд эсхүл хохирогчоос гэмт хэргийн тухай дуудлага авсны дараа зэрэг шалтгааны улмаас баривчилсан байв. Харин нэг

зөрчлийн хэрэгт (5 хувь) шүүгдэгч (холбогдогч)-ийг баривчлах зөвшөөрлийг танилцуулах ёстой байсан ч танилцуулаагүй байна.

Дүрс 40: *Шүүхийн өмнөх шатанд баривчлагдсан шүүгдэгч (холбогдогч)-д баривчлах зөвшөөрлийг танилцуулсан байдал*

Монгол Улсын эрүүгийн (зөрчлийн хэрэгтэй харьцуулахад) хэрэгт прокурор хоёр төрлийн шийдвэр гаргах үүрэгтэй. Үүнд: мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон яллах дүгнэлт үйлдэх. Иймд ажиглагчдыг прокурорын дээрх үйл ажиллагааг ажиглах зорилгоор эдгээр шийдвэрийг гаргасан огноог тэмдэглэж бичихийг даалгасан билээ. Эрүүгийн хэргийн (зургаан хэрэг) гуравны нэгт яллагдагчийг тухайн хэргийг үйлдсэн даруйд баривчилсан байна. Тодруулбал, тухайн өдөр нь эсхүл дараагийн өдөр нь баривчилж, мөрдөн шалгах ажиллагааг цаг алдалгүй эхлүүлсэн ажээ. Үүний дараа яллах дүгнэлтийг 31-128 хоногийн дараа буюу медиан 62 хоногийн дараа үйлджээ.

Ихэнх эрүүгийн хэрэгт (66.7 хувь буюу 12 хэргүүд) сэжигтэн, яллагдагчийг хэрэг гарсны дараа шууд баривчлаагүй байна. Дийлэнх тохиолдолд (нийт эрүүгийн хэргийн 44.4 хувь буюу найман хэрэг) зөвхөн яллах дүгнэлт үйлдсэн огноог хавтаст хэрэгт тэмдэглэж үлдээсэн байх ба уг хугацаа нь хэрэг үйлдэгдсэнээс хойш 14 хоногоос 173 хоногийн хооронд буюу медиан 51 өдөр байна. Ийнхүү хугацааны хувьд өөр байгаа нь ерөнхийдөө мөрдөн шалгах ажиллагаанд хугацаа шаардагдсантай холбоотой гэж үзэж болно. Гэтэл ажиглагчдын тэмдэглэснээр дөрвөн хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар анх шийдвэрлэсэн огноо болон яллах дүгнэлт гаргасан огноо өөр өөр байсан байна. Эдгээр тохиолдолд хэрэг үүсгэж мөрдөн шалгах ажиллагаа явуулах тухай шийдвэр нь тухайн гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш 20-70 хоногийн дараа гарсан бол яллах дүгнэлт үйлдэхэд 17-64 хоног шаардагдсан байв.

Түүнчлэн Монгол Улсын хуулийн дагуу яллагдагч (холбогдогч)-ийг баривчилснаас хойш 48 цагийн дотор эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол үйлдэн танилцуулсны үндсэн дээр мөрдөн шалгах ажиллагааг явуулахаар заасан байна. Ихэнх эрүүгийн хэрэгт (11 хэргүүд буюу 61.1 хувь) энэ процессын шаардлагыг хангасан байна. Гэтэл таван хэрэгт яллагдагчийг баривчлаагүй тул ийнхүү мэдэгдэх шаардлага гараагүй. Нэг хэрэгт (5.6 хувь) ийнхүү тус тогтоолыг танилцуулаагүй бол өөр нэг хэрэгт энэ талаар мэдээгүй байжээ. Шүүгдэгчид эрүүгийн

II. Дүгнэлт | 15. Шүүхийн өмнөх болон бүх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх яллагдагч (холбогдогч)-ийн эрх

хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоолтой танилцах, хувийг авах эсхүл хуулбарлан авах боломжийг олгосон гэж ажиглагчид тэмдэглэсэн.

.

15.1.3. Хараат бус ба бие даасан байдал

Монгол Улсын хуульд зааснаар баривчлах зөвшөөрөл олгох, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах зөвшөөрөл олгох, талуудын гомдол эсхүл хүсэлт авах эсвэл улсын яллагчийн яллах дүгнэлтэнд үндэслэн хэргийг шүүхийн журмаар хянан шийдвэрлэхээр шүүх рүү шилжүүлэх зэрэг хүрээнд шүүгч шүүхийн өмнөх шатны процессын ажиллагаанд оролцож болно. Иймээс хэргийн шүүхийн өмнөх шатанд оролцсон шүүгчдийн хувьд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан эсхүл алагчилсан байж болох шинж тэмдэг бий эсэхэд үнэлгээ өгөхийг ажиглагчдад даалгасан байв. Дээрх асуудал нь огт ажиглагдаагүй эсхүл ажигласан хэрэгт хамааралгүй байсан гэж хариулсан юм. Харин нэг зөрчлийн хэрэг болон нэг эрүүгийн хэрэгт шүүхийн өмнөх шатанд шүүгч оролцогч талуудын нэгтэй зохисгүй харьцаж байсан гэж тайлагнасан.

15.1.4. Хууль бус цагдан хорих болон бусад таслан сэргийлэх арга хэмжээнд гомдол гаргах

Үйл ажиллагааны хүрээнд ажигласан 57 яллагдагчдын гуравны нэгээс дээш хувьд нь (20 яллагдагч буюу 35.1 хувь) шүүхийн өмнөх шатанд таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна. Эдгээр арга хэмжээг нийт 12 зөрчлийн хэрэгт, өөрөөр хэлбэл ажигласан бүх зөрчлийн хэргүүдийн 30.7 хувьд болон 8 эрүүгийн хэрэгт буюу ажигласан бүх эрүүгийн хэргүүдийн 44.4 хувьд авчээ. Хэдийгээр шүүхийн өмнөх шатанд олон төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой (жич. хувийн баталгаа гаргах, барьцаа авах, хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх, яллагдагч цэргийн албан хаагч бол цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулах) боловч түүвэрлэсэн хэргүүдэд баримт бичгийг хураан авах, эсхүл шүүхийн өмнөх шатанд цагдан хорих арга хэмжээ зэрэг цөөн тооны арга хэмжээ авч, шүүгдэгч (холбогдогч)-ийн үйлдэл, эсхүл албан үүргээ биелүүлэхийг хязгаарласан байна. 12 зөрчлийн болон 8 эрүүгийн хэрэгт ийм арга хэмжээ авсан ч хэдэн хэдэн шүүгдэгч (хохирогч)-ид олон төрлийн шийтгэл ногдуулсан байсныг тэмдэглэх нь зүйтэй. Авсан арга хэмжээнүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хүснэгтэд 12**-т оруулаа.

	Зөрчлүүд		Гэмт хэргүүд	
Хариуцлагын төрөл	**Шүүгдэгч (холбогдогч)-ийн тоо**	**Таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа**	**Шүүгдэгч (холбогдогч)-ийн тоо**	**Таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа**
Шүүгдэгч (холбогдогч)-ийн үйлдлийг эсхүл албан үүргээ биелүүлэхийг хязгаарласан, үүний дотор баримт бичгийг хураан авах	7	1-15 хоног (тодорхой байсан нь)	2	Тодорхойгүй
Шүүхийн өмнөх шатанд цагдан хорих	9	1-14 хоног (эрүүлжүүлэх байрыг оруулаад)	7	34-299 хоног (Медиан: 149 хоног)

		(Медиан:1 хоног)		

Хүснэгт 11: *Шүүхийн өмнөх шатанд яллагдагч (холбогдогч)-д авсан таслан сэргийлэх арга хэмжээ*

Хүснэгт 12-т харуулснаар зөрчлийн хэрэгт буруутгагдан шүүхийн өмнөх шатанд арга хэмжээ авагдсан нийт 12 хүний талаас дээш хувьд нь үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээ авсан байна. Түүнчлэн дөрөвний гуравт нь (9 холбогдогч) дунджаар нэг хоног (24 цаг)-ийн хугацаагаар саатуулах арга хэмжээг авсан байна. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн нь ГБХ үйлдэх шалтгаан болсон (Дээд талын **11.3-р Хэсэгт** тайлбарласан болно) гэж хохирогчид мэдүүлсэн тохиолдолд практик дээр холбогдогчийг эрүүлжүүлэх байранд 24 цагийн туршид саатуулдаг тул маш олон холбогдогчийг эрүүлжүүлэх байранд хонуулсан байх магадлалтай юм. Энэ тухай Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнд тэмдэглэл үйлдэх хэсэг оруулаагүй байсан тул ажиглагчид тодорхой бичээгүй болно. Харин эрүүгийн хэрэгт яллагдагчдын хувьд тэднийг шүүхийн өмнөх шатанд (87.5 хувь буюу 7 хэргүүд) дунджаар 149 хоног буюу бараг таван сар цагдан хорьсон байна.

Үүнээс гадна ажиглагчид шүүхийн өмнөх шатанд авах таслан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж шийдвэрлэхэд шүүгдэгч (холбогдогч), тэдгээрийн өмгөөлөгчид хэрхэн оролцож байгаа талаар үнэлгээ өгөхийг хичээсэн билээ. Ажиглагчид нийт 20 хэргээс ердөө 12 хэрэгт нь шүүгдэгч (холбогдогч), тэдгээрийн өмгөөлөгчдийн оролцоог тодорхойлж чадсан юм. Тухайн хэргүүдэд ажиглагчдын үзсэнээр, ихэнх яллагдагчид (холбогдогч) (есөн яллагдагч буюу 75 хувь) шууд буюу шууд бусаар өмгөөлөгчөөр дамжуулж мэдсэн бол гурав нь (25 хувь) огт мэдээгүй байна. Үүнээс гадна, таслан сэргийлэх арга хэмжээг авсан тухай мэдээгүй гурван яллагдагчийн хувьд шүүх эсхүл эрх бүхий албан тушаалтан ямар үндэслэлээр таслан сэргийлэх арга хэмжээ авах болсон тухайгаа хангалттай хэмжээнд тайлбарлаагүй байна. Гэвч таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хэргүүдийн 12-т (бүх хэргийн 60 хувь) нь холбогдох үндэслэлийг сайн тайлбарласан байсан ч үлдсэн дөрвөн хэрэгт (20 хувь) өгсөн тайлбар нь хангалтгүй байсан гэж ажиглагчид үзжээ.

15.2. Мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах шүүгдэгч (холбогдогч)-эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 15-р Бүлгийн Хэсэг IV-т цугласан өгөгдөлд тулгуурласан болно. (Мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах эрх) (**Хавсралт B**).

15.2.1. Шүүх эрх зүйн салбарын үйлчилгээний гүйцэтгэл

Ажигласан хэргүүдээс (49 хэрэг буюу 86 хувь) шүүхийн өмнөх шатанд эдлэх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхүүд дотор мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах эрхийн гүйцэтгэл хамгийн өндөр гарсан. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картын медиан “Маш сайн” байсан бөгөөд үүнээс зургаан тохиолдолд л доогуур үнэлгээ авсан байна: таван “Сайн”, нэг “Муу”.

Олон тооны хэргийн хувьд тухайн этгээдийг саатуулаагүй байсан бөгөөд уг эрх нь саатуулагдсанаар хөндөгддөг тохиолдолд хэрэгжилт нь өндөр үнэлгээтэй гарсныг тэмдэглэх нь зүйтэй. Дээр **12-р хэсэгт** дурдсанчлан, яллагдагчийг баривчилсан эсэхээс үл хамаарч Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүнийг хялбаршуулах, ажиглагчид үүсэж болох эргэлзээ, алдаа зэргийг хязгаарлах үүднээс энэ хэсгийг бүрэн гүйцэд бөглөх шаардлагатай байв. Ийм ч учраас өндөр оноо нь яллагдагч (холбогдогч)-ийг баривчлаагүй хэрэгт холбогдолгүй билээ.

15.2.2. Мэдээлэл

Шүүхийн өмнөх шатанд нийт 20 шүүгдэгч (холбогдогч)-д баривчлах арга хэмжээ авчээ (Дээд талын **15.1.2-р Хэсгийг** харна уу). Тэдгээрийн ихэнхэд нь (12 яллагдагч буюу 60 хувь) баривчлагдсаны дараах тэдэнд бичгээр мэдэгдээд, баривчлагдсан даруйд нь эрхийнх нь талаар тайлбарлаж байсан байна. Гэвч хоёр хэрэгт энэ ажиллагаа хийгдээгүй (10 хувь) бол өөр зургаан хэрэгт энэ хамааралгүй байв. Тодруулбал, энэ зургаан хэргүүдийн холбогдогч нар эрүүлжүүлэх байранд саатуулагдсан хэргүүд байна. Хэдийгээр энэ нь баривчлах ажиллагаанд багтах ч эдгээр холбогдогчид эдлэх эрхийг нь танилцуулсан мэдэгдлийн хувийг зохих ёсоор хүлээлгэж өгөх боломж байгаагүй байж болох юм.

Энэ хэсэгт шүүгдэгч (холбогдогч) өөрийнх нь сайн мэдэж ойлгодог хэлээр танилцуулсан эсэх, цаашлаад хэлмэрч/орчуулагч авах эрхийг танилцуулсан эсэхийг нэмэлт болгон асуусан байсан ч ажигласан хэргүүдэд хэлний бэрхшээлийн асуудал гараагүй болно.

15.2.3. Гадаад ертөнцтэй харилцах эрх

Ихэнх шүүгдэгч (холбогдогч)–ийг баривчлах арга хэмжээ авснаас хойш (17 буюу 85 хувь) хуульд заасан хугацаанд багтаан тэдгээрийн гэр бүлийн гишүүнд энэ тухай мэдэгдсэн байна. Эрүүгийн хэрэгт холбогдож баривчлагдсан нэг хүний гэр бүлийн гишүүнд энэ талаар мэдэгдээгүй бол өөр хоёр хэрэгт энэ нь хамаарахгүй байсан гэж ажиглагчид тэмдэглэжээ.

Цагдаагийн эрүүлжүүлэх байранд хоносон нэг шүүгдэгч (холбогдогч)-ид түүний хүсэлтээр эрүүл мэндийн тусламж үзүүлсэн ажээ.

15.3. Өмгөөлөгч авах, өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 16-р Бүлгийн Хэсэг IV-т цугласан өгөгдөлд тулгуурласан болно (Өмгөөлөгч авах, өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байх эрх) (**Хавсралт В**). Нэг талаараа энэ хэсэг нь ижил төстэй мэт боловч Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 11-р Бүлгийн Хэсэг III-т (Өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх) цугласан бөгөөд **14.6-р хэсэгт** танилцуулсан өгөгдлөөс ялгаатай гэдгийг онцолж тэмдэглэх нь зүйтэй. Тодруулбал,

тухайн өгөгдлийг шүүх хуралдааны шатанд эдлэх эрхэд хамааруулж ойлгох бол дор танилцуулж буй өгөгдөл шүүхийн өмнөх шатанд хамаарна.

15.3.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Ажиглалт хийсэн хэргийн хүрээнд яллагдагч (холбогдогч)-ийн шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч авах, өмгөөлүүлэхэд хүрэлцээтэй хугацаагаар хангагдах зэрэг эрхийн хэрэгжилт “Маш сайн” үнэлгээтэй буюу 100 хувь хангагдсан байна. Хэдий тийм боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шат дахь эрхийн хэрэгжилт дотроос сүүлээсээ хоёрт эрэмбэлэгдсэн билээ. Энэ эрхийн хэрэгжилт өндөр үнэлэгдэхэд нийт ажиглалт хийсэн 31 хэргийн багцалсан түүвэр үлэмж нөлөөлсөн билээ. Тухайлбал найман хэрэг дээр 62.5-75 хувийн хооронд оноо авч “Сайн” үнэлгээний интервалын хамгийн бага үзүүлэлтийг авсан бол ойролцоогоор нийт хэргийн гуравны нэг нь (18 хэрэг буюу 31.6 хувь нь) 87.5 хувийн оноо авсан нь “Маш сайн” гэсэн үнэлгээний интервалын дунд байна. Бага оноотой үнэлэгдэхэд яллагдагч (холбогдогч) өмгөөлөгчтэй байсан эсэх эсхүл яллагдагч (холбогдогч)-ийн хэрэг хөнгөн, хүнд байсан эсэх нь төдийлөн нөлөөлөөгүй бөгөөд энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өргөн хүрээг хамарсан алдаа дутагдлууд байгааг харуулж байна.

15.3.2. Үндсэн Эрх

Доор **42-р Дүрсэд** заасанчлан, баривчлагдсан 20 яллагдагч (холбогдогч)-дын 85 хувьд нь (17 хүн) цаг тухайд нь хууль зүйн туслалцаа авах эрхийнх нь талаар бичгэн мэдэгдэл болон тайлбарыг өгсөн бөгөөд мөн 85 хувьд (17 яллагдагч (холбогдогч)) тэдгээрийн дуугүй байх эрх буюу өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн талаар танилцуулжээ. Харин гурван яллагдагчдад энэ эрхүүдийн талаар ерөөсөө танилцуулаагүй (эрх тус бүрд өөр өөр гурван яллагдагч) эсхүл тухайн хэргүүдийн хавтаст хэрэгт энэ талаар тэмдэглэл үйлдээгүй байна.

Дүрс 42: *Яллагдагчийг баривчлахад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийн талаар танилцуулсан байдал*

15.3.3. Өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд хангалттай хугацаа, бололцоотой байх эрх

Ажиглагчдын тайлагнаснаар зөвхөн шүүхийн өмнөх шатанд баривчлагдсан төдийгүй бүх яллагдагч (холбогдогч)-дын хувьд, гурван яллагдагч (холбогдогч)-аас бусад шүүгдэгч (холбогдогч) ба тэдгээрийн өмгөөлөгчид шүүхийн өмнөх шатанд (94.7 хувь) хавтаст хэрэгтэй танилцаж, тэмдэглэл үйлдэх боломжтой байв. Үлдсэн гурван хэрэгт тухайн эрхийн талаар танилцуулаагүй, тэд мэдээгүй байсан эсэх талаар ямар нэгэн тэмдэглэл, хэлэлцсэн зүйл байхгүй байна. Яллагдагч (холбогдогч)-дын дөрөвний гуравт нь (43 хүн буюу 75.4 хувь) хавтаст хэргийн материалын хувь, хуулбарыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн өгсөн эсхүл хэдэн ч хувь хамаагүй хуулбарлан авахыг зөвшөөрсөн боловч 14 яллагдагчдад (24.6 хувь) энэ боломжийг олгосон эсэх эсхүл тэдэнд тухайн эрхийн талаар танилцуулаагүй, тэд мэдээгүй байсан эсэх талаар ямар нэгэн тэмдэглэл, хэлэлцсэн зүйл байхгүй байна.

Яллагдагч (холбогдогч)-ийн холбогдсон хэргийн нарийн түвэгтэй байдал, хэргийн хөнгөн, хүнд төрөл болоод шинжлэн судлах шаардлагатай материалын их бага хэмжээг үл харгалзан бараг бүх шүүгдэгч (холбогдогч) (хэргүүдийн 91.2 хувь) шүүхийн өмнөх шатанд өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээ хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй хугацаа, бололцоотой байсан гэж ажиглагчид үнэлгээ өгсөн болно. Гэвч таван хэрэгт шүүгдэгч (холбогдогч) энэ эрхээ эдлээгүй байна.

15.3.4. Шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгч аваагүй шүүгдэгч (холбогдогч)

Ихэнх яллагдагч (холбогдогч) (32 хүн буюу 56.1 хувь) өмгөөлөгч авах хүсэлт гаргах эрхээсээ татгалзсан гэж тайланд тусгасан байна. Ингэхдээ тэдний бараг тал хувьд нь (15 хүн буюу 46.9 хувь) төлбөрийн чадваргүй бол үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхтэй талаар танилцуулсан ч уг эрхээсээ татгалзжээ. 13 яллагдагч (холбогдогч) (40.6 хувь) үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийн шалгуурыг хангахгүй байв.

Харин үлдсэн дөрвөн яллагдагч (холбогдогч) энэ боломжийн талаар мэдээгүй байсан нь (12.5 хувь) уг мэдээллийг холбогдох албан тушаалтнууд өгөөгүй байсантай холбоотой гэж ажиглагчид тэмдэглэсэн билээ. Гэхдээ өмгөөлөгч авах эрхээсээ татгалзсан 32 яллагдагч (холбогдогч)-ийн аль нь ч хуулийн дагуу заавал үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлж буй өмгөөлөгчтэйгөөр шүүх хуралдаанд оролцох этгээдэд багтаагүй байжээ.

Өмгөөлөгч аваагүй зургаан яллагдагч (холбогдогч)-дын 67 хувь нь өмгөөлөгч авах эрхээсээ татгалзсан бол бусад яллагдагч (холбогдогч)-дын талаар хавтаст хэргээс болон шүүх хуралдааны явцад олж мэдэх боломжгүй байв. Нэг талаас үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийн шалгуурыг хангаагүй, нөгөө талаас өмгөөлөгч авах эрхээсээ татгалзахын өмнө ийнхүү үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийнх нь талаар танилцуулсан байж болох юм. Үүнээс гадна, өмгөөлөгч аваагүй зургаан шүүгдэгч (холбогдогч)-ийн хувьд заавал өмгөөлөгчтэйгөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох этгээд биш байсан.

15.3.5. Шүүхийн өмнөх шатанд өмгөөлөгчтэй оролцсон шүүгдэгч (холбогдогч)

Өмгөөлөгч авсан яллагдагч (холбогдогч)-дын хувьд, нэг хэрэгт яллагдагч (холбогдогч) өмгөөлөгч авах хүсэлтээ илэрхийлээд, өмгөөлөгч нь ирээгүй байхад нь холбогдсон хэргийнхээ

талаар мэдүүлэг өгсөн байна. Энэ жишээнээс бусад тохиолдолд өмгөөлөгчтэйгөө хувиараа жич уулзаж зөвлөлдөхтэй холбоотойгоор өөр ямар нэгэн зөрчил гараагүй ажээ.

15.4. Мөрдөн шалгах явцад эдлэх яллагдагч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 17-р Бүлгийн Хэсэг IV-т цугласан өгөгдөлд тулгуурласан болно (Мэдүүлэг авах үед эдлэх эрх) (**Хавсралт В)**

15.4.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Шүүхийн өмнөх шатны мэдүүлэг өгөх үеийн яллагдагч (холбогдогч)-ийн эрх нь ажигласан шүүхийн өмнөх шатны бүх эрхүүд дунд хамгийн муу оноотой нь байсан юм. Тэгсэн ч шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картын медиан “Маш сайн” үнэлгээг авсан. Нийт 28 хэргүүдийн медиан оноо 85.7 хувь бөгөөд 78.6-85.7 хувийн оноотойгоор “Маш сайн” үнэлгээний доод түвшинд хүрч байв. Мөрдөн шалгах явцад эдлэх эрхтэй холбоотойгоор зөрчлийн хэргүүдийн гүйцэтгэл эрүүгийн хэргүүдээсээ харьцангуй муу байсан юм. Хэдийгээр зөрчил болоод эрүүгийн хэргүүд дээр медиан “Маш сайн” үнэлгээг авсан ч эрүүгийн хэргийн медиан оноо нь 92.9 хувь байсан бол зөрчлийн хэргийн 10 хувиар бага буюу 78.6 хувь байв.

15.4.2. Мэдүүлэг авах үед эдлэх эрх

Яллагдагчдын дийлэнхэд нь (98.2 хувь) мэдүүлэг өгөхөөс өмнө энэ эрхийнх нь талаар тайлбарласан байсан ч эрүүгийн хэрэгт холбогдсон нэг яллагдагч (холбогдогч) энэ тайлбарыг хийгээгүй ажээ. Үүнээс гадна мэдүүлэг авах үеэр бүх яллагдагчдын талаас дээш хувь (31 яллагдагч буюу 54.4 хувь) нь дуугүй байх, өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ хэрэгжүүлж, асуултад хариулаагүй байна.

Доор **43-р Дүрсэд** харуулсанчлан, зөвхөн 10 яллагдагч (холбогдогч) (17.5 хувь) өмгөөлөгчийг байлцахад мэдүүлэг өгч байжээ. Өөр хоёр яллагдагч (холбогдогч)-тай (3.5 хувь) өмгөөлөгч нь байлцах ёстой байсан боловч ирээгүй байна. Ажиглагчдын тайлагнаснаар холбогдогчийн холбогдсон хэрэг нь бага хэмжээний зөрчил байжээ. Харин Налайх дүүрэгт болсон нөгөө хэрэгт шүүгдэгч нь Монгол хэлээр сайн ярьдаггүй байсан ч гэсэн ажиглагчдын үзсэнээр зайлшгүй хэлмэрч/орчуулагч авах шаардлагатай байх хэмжээний хэлний бэрхшээл байгаагүй гэнэ. Бүх яллагдагч (холбогдогч)-ийн үлдсэн дөрөвний гурав нь (45 хүн буюу 78.9 хувь) өмгөөлөгчгүйгээр мэдүүлэг өгсөн ба ийнхүү мэдүүлэг өгөх нь хуульд нийцэж байсан ажээ.

Дүрс 41: *Шүүгдэгч (холбогдогч)-ийн шүүхийн өмнөх шатны байцаалтын үеэр өмгөөлөгч байлцуулсан байдал*

Зөвхөн хоёр яллагдагчаас (20 хувь) мэдүүлэг авах үеэр өмгөөлөгчид нь байлцсан байна. Яг энэ хоёр хэргийн яллагдагч насаар нь хорих ял шийтгүүлэх гэмт хэрэг үйлдсэн байсан тул зайлшгүй өмгөөлөгч авах шаардлагатай байлаа.

Бүх хэрэгт мэдүүлэг өгөх хуульд заасан хугацааг дагаж мөрдсөн байна. **44-р Дүрсэд** харуулж байгаачлан, зөрчлийн хэрэгт авсан мэдүүлгүүд нь 10-90 минут хүртэл үргэлжилсэн байна. Мэдүүлгийн хугацаа медиан 25 минут байсан буюу мэдүүлгийн үргэлжлэх хугацаа нь 10-30 минутаар багцлагдаж байв. Эрүүгийн хэрэгт өгсөн мэдүүлгийн үргэлжлэх хугацаа нь медиан 45 минут байв. Гэхдээ эрүүгийн хэрэгт мэдүүлэг авсан хугацааны дотор харилцан адилгүй байдал ажиглагдсан бөгөөд хамгийн багадаа 10 минут байсан бол уртдаа 20 гаруй удаа 236 минут (3 цаг 56 минут) хугацаатай байжээ.

Дүрс 424: *Байцаалтын ажиллагаа үргэлжилсэн хугацаа*

Ажигласан хэргүүдийн алинд нь ч яллагдагч (холбогдогч)-ийг гэм буруугаа хүлээхийг шаардсан заналхийлэл, хүчирхийлэл буюу эрүүдэн шүүлт ажиглагдаагүй байна. Хоёроос бусад бүх хэрэгт яллагдагч (холбогдогч)-ид байцаалтын тэмдэглэлтэй уншиж танилцуулсан эсхүл тэдэнд уншиж танилцуулсан тухай тэмдэглэлийг үйлдсэн байна. Хэргүүдийн талаас илүү хувьд нь (32 хэрэг

II. Дүгнэлт | 15. Шүүхийн өмнөх болон бүх шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх яллагдагч (холбогдогч)-ийн эрх

буюу 56.1 хувь) яллагдагчдад байцаалтын тэмдэглэлд засвар хийх, нэмэлт мэдээлэл оруулах боломжийг олгосон байв. Гэвч үлдсэн хэргүүдэд (25 хэрэг буюу 43.9 хувь) хавтаст хэрэгт энэ талаар тэмдэглэл үйлдээгүй байсан тул энэ эрхээ эдэлсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байжээ.

15.5. Хүнлэг нөхцөлөөр хангуулах ба эрүүдэн шүүлтээс ангид байх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх

Энэ хэсэг нь Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүний 18-р Бүлгийн Хэсэг IV-т цугласан өгөгдөлд тулгуурласан болно (Хүнлэг нөхцөлөөр хангуулах ба эрүүдэн шүүлтээс ангид байх эрх) (**Хавсралт В**).

15.5.1. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний гүйцэтгэл

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд хүнлэг нөхцөлөөр хангуулах ба эрүүдэн шүүлтээс ангид байх яллагдагч, шүүгдэгч (холбогдогч)-ийн эрх нь шүүхийн өмнөх шатанд болон бүх шатанд шалгаж үзсэн эрхийн дотор хэрэгжилтээрээ эхний хоёрт эрэмбэлэгдсэн байна. Шүүхийн шударга ёсны үйлчилгээний үнэлгээний онооны картын медиан “Маш сайн” буюу 100 хувийн оноо авсан билээ. 52 хэргийн хувьд хамгийн өндөр оноо авсан бол зөвхөн таван хэрэгт “Маш сайн” үнэлгээнээс бага оноо авсан байна. Үүнд: “Сайн” үнэлгээ авсан хоёр хэрэг (75 хувийн оноо) ба “Муу” үнэлгээ авсан гурван хэрэг (50 хувийн оноо) хамаарч байна. Ихэнх хэргүүд нь (4 хэрэг буюу 80 хувь) зөрчлийн хэргүүд байсан.

15.5.2. Хүнлэг нөхцөлөөр хангуулах ба эрүүдэн шүүлтээс ангид байх эрх

Ажиглалт хийгдсэн 57 хэргүүдийн алинд нь ч яллагдагч (холбогдогч)-ийг баривчилж саатуулах үед сэтгэл зүйн эсхүл бие махбодын албадлага, эрүүдэн шүүлт, хэрцгий хандлага, албадлага, заналхийлэл, хууран мэхлэлт эсхүл бусад хууль бус хандлага ажиглагдаж бүртгэгдээгүй байна.

Хамгийн дээд оноо авсан таван хэргийн хувьд шүүгдэгч (холбогдогч)-ид баривчилж саатуулсантай холбоотой гомдол гаргах эрхийг нь танилцуулаагүй эсхүл энэ эрхээ эдлэх эсэхийг нь тэднээс асуугаагүй нийтлэг дүр зураг харагдаж байна. Эдгээр шүүгдэгч (холбогдогч)-ийн хоёрт нь энэ эрхийн талаар шүүх хуралдааны шатанд ч гэсэн мэдэгдэж танилцуулаагүй байна. Гэвч дээр дурдсанчлан, ийм нөхцөл үүссэн тухай мэдэгдэхүйц зүйлс байхгүй байсан тул шүүхүүд тухайн хэрэгт ийнхүү танилцуулаагүй байж болзошгүй билээ. Хүнлэг нөхцөлөөр хангуулах болон эрүүдэн шүүлтээс ангид байх шүүгдэгч (холбогдогч)-ийн эрхтэй холбоотойгоор өөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил ажиглагдаагүй болно.

Бүлэг III. Зөвлөмж ба чадавх бэхжүүлэх үйл ажиллагааны үр дүн

16. Зөвлөмжүүд (сэдэв тус бүрээр)

Тэмдэглэл: Энэ хэсэгт төслийн өгөгдөлд суурилж гарсан зөвлөмжийг сэдэв тус бүрээр нь ангилж оруулсан. Мөн байгууллага тус бүрт зориулсан зөвлөмжийг **Хавсралт А** тусгасан. Үүнээс гадна ажиглагчдын өөрсдийнх ажиглалт, үзэл бодол дээр үндэслэн гарсан зөвлөмжийг **Хавсралт Б-ээс** танилцана уу.

Дээр 3-р хэсэгт дурдсанчлан, уг үйл ажиллагаа нь дор заасан дараах хоёр зорилттой юм:

2. Шинэчлэл	**ГБХ-ийн бүх хэлбэрээс хамгаалах Монгол Улсын эрх зүйн шинэчлэлийг системийн хэмжээнд сайжруулахад чиглэсэн өгөгдөлд суурилсан зөвлөмж боловсруулах**

Үүний дагуу энэхүү үйл ажиллагаагаар цуглуулсан өгөгдлөөс авч шууд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр системийн сайжруулалтын талаарх зөвлөмжийг дор харуулав. Үүнээс гадна, эдгээр зөвлөмжүүдэд НҮБ-ын Хүний эрхийн төлөв байдлыг хянан хэлэлцэх ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг (UPR)-ийн Монгол Улс дахь байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлээс Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн зөвлөмжүүдийг дурдсан болно.

Энэхүү үйл ажиллагааны оролцогч талуудын нэг болох ШЕЗ нь энэхүү үйл ажиллагаанаас Монгол Улсад гэр бүлийн төрөлжсөн шүүх байгуулах төлөвийн талаар санал өгөхийг хүссэн юм. Үүнийг дор дурдсан зөвлөмжүүдэд тодорхой хэмжээгээр авч үзсэн болно. Гэсэн хэдий ч энэхүү асуудал нь тус үйл ажиллагааны цар хүрээнээс хальсан тул гэр бүлийн шүүхийн төрөл бүрийн загварыг харьцуулсан тусдаа судалгаа хийх нь зүйтэй юм. Үүнээс гадна энэ үйл ажиллагаагаар зохих журмын дагуу буюу шударга шүүхээр шийдвэрлэж буй эсэх талаар цуглуулсан өгөгдөл нь гэр бүлийн шүүхийн тусдаа буюу дагнасан загвар байх нь шүүн таслах ажиллагааг илүү сайн үр дүнд хүргэх эсэх асуудлыг тогтооход хязгаарлагдмал хамааралтай байв. Тиймээс доорх зөвлөмжүүдээс энэ талаарх дүгнэлт гарах боломжгүй байна. Гэсэн хэдий ч гэр бүлийн мэргэшсэн шүүхийн асуудалд хамааралтай байж болох цуглуулсан өгөгдлөөс зөвлөмжүүдэд тусгасан болно.

Эцэст нь энэ үйл ажиллагааны үнэлгээ хийх үеэр ажиглагчид тухайн үйл ажиллагааны талаарх өөрсдийн туршлага болон авч үзэхүйц системийн сайжруулалтын талаар хэлэлцсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Ажиглагчид 13 өргөн хүрээний зөвлөмж санал болгосон бөгөөд тэдгээрийн нарийвчилсан санал, тайлбар зөвлөмжийг дээр дурдсанчлан **Хавсралт Б-д** тусгасан бөгөөд энэ нь ялангуяа ГБХ-ийн тохиолдлуудын бодит байдлын талаар баялаг, хэрэгтэй ойлголтуудыг агуулсан болно. Гэсэн хэдий ч ажиглагчдын саналууд нь хувь хүний туршлага дээр үндэслэсэн, харин доорх зөвлөмжүүд үйл ажиллагааны дизайны дагуу өгөгдөлд суурилсан зөвлөмж боловсруулах гэсний дагуу өгөгдлийн дүн шинжилгээн дээр үндэслэн гарсан билээ. Гэсэн хэдий

ч **Хавсралт** Б-т байгаа ажиглагчдын санал нь хууль тогтоомж, бодлого боловсруулагчдад нэмэлт санаа өгч болох юм.

a. Хохирогчийн эрх

Зөвлөмжийн үндэслэл бүхий хэсэг	Ажиглалтын өгөгдөлд үндэслэн ГБХ-ийн хэргийн шүүн таслах ажиллагааны талаар өгөх зөвлөмж
Хохирогчийн аюулгүй байдлын үнэлгээ (**Хэсэг 13.1**)	**Цагдаад:** • Шаардлагатай хэрэг бүрд ГБХ-ийн эрсдэлийн үнэлгээг хийх Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн зөвлөмж 116.129-116.130 ба 116.132,[21]-дагуу бүх ГБХ-ийн хэрэгт эрсдэлийн үнэлгээг хийх, хохирогч төвтэй аюулын зэргийн үнэлгээг хэрхэн үр дүнтэй хийх талаар чадавх бэхжүүлэх сургалтыг хийх **Нийгмийн ажилтанууд:** • Бүх өндөр эрсдэлтэй хэрэгт ГБХ-ийн нөхцөл байдлын үнэлгээг хийх, Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн зөвлөмж 116.133[22] дагуу бүх ГБХ-ийн хэрэгт эрсдэлийн үнэлгээг хийх, хохирогч төвтэй аюулын зэргийн үнэлгээг хэрхэн үр дүнтэй хийх талаар чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах **Холбогдох тусламж, үйлчилгээ үзүүлэгчдэд:** • Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн дараах зөвлөмж 116.128 ба 116.133[23] дагуу хохирогчдод шүүхийн өмнөх шатанд сэтгэл зүйн тусламж үзүүлэх чадавхыг бэхжүүлэх **Шүүгчдэд, прокурор, хохирогчийн өмгөөлөгчдөд ба цагдаад:** • Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн дараах зөвлөмж 116.128 and 116.133[24] -ийн дагуу шаардлагатай тохиолдолд хохирогчийг хамгаалахын тулд аюулгүй байдлын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг

[21] **UPR зөвлөмж 116.129:** “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх арга хэмжээ авах, үүний дотор цагдаагийн алба хаагчдыг хохирогч төвтэй аюул заналхийллийн үнэлгээг хэрхэн үр дүнтэй хийх талаар сургаж дадлагажуулах” (Дани);
UPR зөвлөмж 116.130: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хүчин чармайлтаа үргэлжлүүлэх, ялангуяа хууль сахиулах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх ажил зохион байгуулах, хөрөнгө хуваарилах, түүнчлэн хүчирхийллээс амьд үлдсэн хүмүүсийн хамгаалалт болон үйлчилгээ авах нөхцөл боломжийг сайжруулах” (Канад);
UPR зөвлөмж 116.132: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах, гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдийн онцгой хэрэгцээний талаарх хууль сахиулах байгууллагын ажилтнууд, хуульчид, шүүгчдийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авах” (Фижи);

[22] **UPR зөвлөмж 116.133:** “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод зохих дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хамгаалалтын механизмыг улам бэхжүүлэх” (Филиппин);

[23] **UPR зөвлөмж 116.128:** “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түгээмэл хэлбэр, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, хохирогчдод зохих дэмжлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх” (Чех);
UPR зөвлөмж 116.133: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод зохих дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хамгаалалтын механизмыг улам бэхжүүлэх” (Филиппин);

[24] **UPR зөвлөмж 116.128:** “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түгээмэл хэлбэр, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, хохирогчдод зохих дэмжлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх” (Чех);
UPR зөвлөмж 116.133: “Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод зохих дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хамгаалалтын механизмыг улам бэхжүүлэх” (Филиппин);

Зөвлөмжийн үндэслэл бүхий хэсэг	Ажиглалтын өгөгдөлд үндэслэн ГБХ-ийн хэргийн шүүн таслах ажиллагааны талаар өгөх зөвлөмж
	лавлах, үүнийг ялангуяа өндөр эрсдэлтэй хэрэг гэж тооцсон хэрэгт хохирогч энэ талаар хүсэлт тавиагүй хэдий ч харгалзаж үзэх; • Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн зөвлөмж 116.131[25] дагуу өндөр эрсдэлтэй хэрэгт холбогдогч (яллагдагч)-ийг хохирогчийн тухай мэдээлэл (жишээлбэл, тэдний одоогийн оршин суугаа хаяг)-ийг тухай хавтаст хэргээс олж авахаас урьдчилан сэргийлэх; • Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн дараах зөвлөмж 116.128 and 116.133[26] дагуу хохирогчийг шаардлагатай бол шүүхээс өмнөх шатанд сэтгэл зүйн тусламж үйлчилгээнд холбон зуучлах; • Хохирогчийг буруутгах, тэдэнтэй жендерийн хэвшмэл ойлголтоор хандахаас татгалзах. Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн зөвлөмж 116.132[27]-ийн дагуу хохирогчийг буруутгах хандлага, тэдэнтэй жендерийн хэвшмэл ойлголтын талаар чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах **Шүүгчдэд:** Шүүх хуралдаанд хохирогчийг буруутгах, жендерийн хэвшмэл ойлголтоор хандахаас урьдчилан сэргийлэх; Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн зөвлөмж 116.132[28] -ийн дагуу хохирогчийг буруутгах хандлага, тэдэнтэй жендерийн хэвшмэл ойлголтын талаар чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулах • Гэр бүлийн гишүүдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийн тухай бүх хохирогчдод мэдээлэх; Монгол Улсын дэмжиж хэрэгжүүлэхээ илэрхийлсэн UPR-ийн зөвлөмж 116.128, 116.130, ба 116.133[29]--ийн дагуу өндөр эрсдэлтэй хэрэгт хохирогчийг шүүх хуралдааны танхимаас холбогдогч (шүүгдэгч)-оос 15 минутын өмнө гарах явдлыг баталгаажуулж, мөрдүүлэх. **ШЕЗ:**

[25] **UPR зөвлөмж 116.131: "**Бэлгийн дарамтад өртсөн хохирогчдын хувийн нууцыг хамгаалах хууль, эрх зүйн орчин бий болгож, хохирогчдыг нөхөн сэргээх зорилгоор аюулгүй орон байраар хангах, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог бүрдүүлэх" (Эстони)

[26] **UPR зөвлөмж 116.128:** "Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түгээмэл хэлбэр, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл болон бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлж, хохирогчдод зохих дэмжлэг, тусламж үйлчилгээ үзүүлэх" (Чех);

UPR R зөвлөмж 116.133: "Гэр бүлийн хүчирхийлэл болон жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчдод зохих дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн хамгаалалтын механизмыг улам бэхжүүлэх" (Филиппин);

11	**ГБХ-ээс урьдчилан сэргийлэх арга замууд**	Гэр бүлийн хүчирхийллийн хүчин зүйл, шалтгаан, зан үйлийг албадан өөрчлөх сургалтын үр дүнд үндэслэн ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах арга замыг тодорхойлох шаардлагатай байна. Жишээлбэл, эрэгтэйчүүд сэтгэл зүйн стрессээс болж ГБХ үйлдэх боломжтой эсэхийг судлах.

12	**Гэр бүлийн дагнасан шүүхийг судлах**	Одоогийн байдлаар шүүхүүд ГБХ-ийн хэргийг хөнгөвчлөн бусад зөрчлийн хэргүүдтэй нэгэн адил богино хугацаанд хянан шийдвэрлэж байгаа тул **гэр бүлийн асуудлаар дагнасан шүүх байгуулах боломжийг судлах шаардлагатай** байна.
13	**Урьдчилан сэргийлэхэд бусад оролцогч талуудыг татан оролцуулах**	Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-д, баг/хорооны удирдлага, ИНБ-ууд, ахмад хуульчдыг ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах явдал бол эерэг үр дүнд хүргэх болно.

Дэлгэрэнгүй санал, зөвлөмж

Санал, зөвлөмж	**1: Шүүхийн байрны аюулгүй байдал** Шүүх хуралдааны танхимын аюулгүй байдлыг хангах явдал бол гагцхүү ГБХ-ийн хохирогчид төдийгүй бүх талуудад онц ач холбогдолтой байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Шүүхийн байранд ямар хамгаалалт байдаг болохыг тодорхой болгох хэрэгтэй байна. Хохирогч сэтгэл зүйн хувьд асар их дарамтад орж, айж эмээсэн байдаг. Хохирогчийг шүүх хуралдааны танхимын гадна шүүх хуралдааны бусад талуудтай удаан хугацааны турш сэтгэл түгшсэн байдалтай хүлээлгэдэг. Шүүх хуралдааны дараагаар хохирогч шүүхээс ямар ч хамгаалалтгүйгээр гарч явдаг. Миний ажигласан шүүх хуралдааны хохирогч эмчилгээ хийлгэсний дараагаар эмнэлгээс гарахдаа гэртээ очихоосоо эмээж, ахынхаа гэрт тэнхрэхээр явсан. Эмчилгээний зардлын нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлээгүй хэвээр байв. • **Ажиглагч:** Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хуралдаан 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн 15 цагийн орчимд болж, хүмүүс хоорондын хангалттай зайтай томоохон өрөөнд болж, яллагдагчийг тусгайлсан хаалтын цаана байрлуулсан байв. Гэвч гэрч, хохирогч, хамаатан садан, яллагдагчийг шүүхийн танхим руу нэг хаалгаар оруулж байсан. Шүүх хуралдааны завсарлагааны үеэр хохирогч, иргэдийн төлөөлөгч, гав зүүсэн яллагдагч, прокурор нь аюулгүй байдлын үүднээс эрсдэлтэй байдлаар нэг коридорт зогсож хүлээсэн. Энэ үеэр хохирогч прокурортой үг солилцоход яллагдагч сэжигтэй байдлаар түүн рүү харж байсан. Хэдийгээр цагдаа нарын зүгээс яллагдагчид гав зүүлгэн хяналтад байлгаж байсан ч хэргийн ноцтой байдлаас хамааран ажиглагчдад аюулгүй байдлын арга хэмжээ дутагдалтай мэт санагдсан. Шүүх хуралдааныг нэг долоо хоногоор хойшлуулж, 2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр шүүх хуралдааныг дахин явуулахад шүүх хуралдааны танхим маш бага хэмжээтэй байсан. Шүүх хуралдааны үеэр прокурор, иргэдийн төлөөлөгч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, хохирогч, яллагдагч нарын хоорондох зай хэт бага, бие биедээ хэт ойр байсан бөгөөд яллагдагч гавгүй байсан. Цагдаагийн албан хаагч иргэний үнэмлэхийг шалгаж, шүүхийн хуралдааны танхимд ороход температурыг хэмжиж байсан боловч үүнээс өөр	• **Ажиглагч:** Хохирогчийг бусад оролцогчдоос тусдаа хүлээлгийн өрөөнд байхыг зөвшөөрч, тэдэнд туслалцаа үзүүлэхэд сэтгэл зүйчийг бэлэн байлгах. Хүлээлгийн өрөөнд хүлээж байх хугацаанд хохирогч сэтгэл зүйч, өмгөөлөгчөөс зөвлөгөө авах боломжтой юм. • **Ажиглагч:** 1. Шүүхийн байр, шүүх хуралдааны танхимд зориулсан аюулгүй ажиллагааны стандарт боловсруулагдсан бол энэ стандартыг дагаж мөрдөх. Хэрэв аюулгүй байдлын стандарт байхгүй бол үүнийг боловсруулах. Энэ үйл ажиллагаанд төрөөс санхүүжилтийг олгуулах ажлыг зохион байгуулах. 2. Цагдаагийн байгууллагын зүгээс хамгаалалт үзүүлэгчийн хувьд бүх оролцогчдын аюулгүй байдлыг хангах үүднээс шүүх хуралдаанд оролцогчдыг (гэрч, хохирогч, хүчирхийлэгч г.м) аливаа зэвсэг, хурц үзүүртэй зүйл байгаа эсэхийг шалгах зорилгоор зэвсэг илрүүлэх хэрэгслийг шүүхэд нэвтрэх хаалганы дэргэд бэлэн байлгах шаардлагатай байна. • **Ажиглагч:** Тахарын албыг дахин сэргээх нь шүүхийн аюулгүй байдал, хохирогчдын аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байна. • **Ажиглагч:** Ихэнх шүүхүүд өөр өөр орох, гарах хаалгатай байдаг тул эдгээрийг олон Улсын стандартад нийцүүлэн ашиглах. • **Ажиглагч:** 1. Шүүхийн байрны аюулгүй байдлыг хангах аюулгүй ажиллагааны журмыг шинэчлэн батлах 2. Шүүхийн байранд орж буй бүх хүмүүсийн үнэмлэхийг шалгаж, оролцогчдыг металл илрүүлэгчээр

ямар нэгэн үзлэг шалгалт хийгээгүй байна. Энэ нь цагдаагийн зүгээс зэвсэг, хутга зэргийг шалгаж болох байсан тул аюулгүй байдал сул байсныг илтгэж байна. • **Ажиглагч:** Шүүхийн хамгаалалтын албан хаагчийн зүгээс шүүх хуралдааны талуудын аюулгүй байдлыг хангах үүднээс үзлэг шалгалт хийгээгүй байна. • **Ажиглагч:** Хохирогч шүүх хуралдаанд оролцоогүй хэдий ч хохирогчдод зориулсан тусгайлсан орох хаалга байхгүй байгаа нь ажиглагдсан. Үүний оронд хохирогчид ихэвчлэн хүчирхийлэгчтэй нэг коридорт зогсон хүлээдэг.	оруулж, цүнхийг шалгах. 3. Хохирогч, хүчирхийлэгч болон гэрчийг байлгах тус тусдаа хүлээлгийн өрөөг зохион байгуулах.

Санал, зөвлөмж	**2: Шүүхийн хуралдааны хуваарь** Шүүхийн вэбсайт, шүүх хуралдааны хуваарийг оновчтой болгож, хэлбэрийг нь сайжруулах; шүүх бүрд өөр өөр вэбсайт, шүүх хуралдааны товыг зарлах өөр хэлбэртэй байх, зөрчлийн хэрэг шийдвэрлэх хуралдааны товыг зарлахгүй байх явдал зэрэг нь шүүхүүдэд олон нийтэд нээлттэй байх, олон нийтийн хяналтыг хангахад бэрхшээлтэй болгож байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Шүүх хуралдааны тухай зарыг вэбсайт дээр тавиагүй тул заавал шүүх дээр очиж тодруулах шаардлагатай байсан. ГБХ-ийн зөрчлийн хэргийн хувьд цагдаагийн алба хаагчийн зүгээс шүүгчийг холбогдогчийн тооноос хамаарч хуваарь гаргахыг хүссэн байна. Тухайн өдөр цагдаагийн газарт 20 холбогдогч шүүх хуралдаанд оролцохоор хүлээж байв. • **Ажиглагч:** Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нэг байранд байрлаж байсан. Иймд шүүх бүрийн вэбсайт дээрх зарууд 9 үзүүлэлт бүхий нэг ижил хэлбэртэй хүснэгттэй байв. Гэвч үзүүлэлт тус бүрийг өөр өөр үгээр илэрхийлж, заримыг нь товчлолоор яарч бичсэн тул уншихад ойлгомжгүй байсан. 2. 2020 оны 9 дүгээр сарын 3-ны өдрийн өглөө Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр очиход ГБХ-ийн зөрчлийн хэрэгтэй холбоотой зар байхгүй байсан бөгөөд зөрчлийн хэргийн шүүх хуралдаан болох эсэх нь тодорхойгүй байсан. Өмнөх өдөр нь миний зүгээс шүүхийн нарийн бичгийн дарга руу утасдаж зарын тухай лавласан боловч мэдээлэл байхгүй байсан бөгөөд маргааш өглөө ирэхэд ГБХ-ийн зөрчлийн хэргийн шүүх хуралдаан болох эсэх нь тодорхой болно гэж хэлсэн. Шүүхийн нарийн бичгийн дарга өглөө нь шүүхийн танхимд ГБХ-ийн зөрчлийн хэргийн шүүх хуралдааныг Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн газартай цахимаар явуулах тухай мэдээлсэн. Шүүх хуралдааны ажиглагчид, шүүгч, шүүх хуралдааны нарийн бичгийн даргатай хамт шүүх хуралдааны танхимд суусан бол холбогдогчид, прокурор болон бусад эрх бүхий хүмүүс цагдаагийн газраас холбогдож байсан. Ийм байдлаар ГБХ-ийн зөрчлийн хэргийн 2 шүүх хуралдааныг ажигласан. • **Ажиглагч:** Хохирогчийн аюулгүй байдлыг хангасны дараагаар ГБХ үйлдэгчийг оролцуулах. • **Ажиглагч:** Шүүх хуралдааны хуваарь байхгүй байсан тул бидний зүгээс шүүх хуралдаанд оролцохын тулд хурал	• **Ажиглагч:** ГБХ-ийн зөрчлийн хэрэгтэй холбоотой шүүх хуралдааны хуваарийг гаргах, вэбсайтад зар тавих, оролцогчдод 3 хоногийн өмнө мэдэгдэх. • **Ажиглагч:** 1. Шүүхийн вэбсайтыг сайжруулах, шүүх хуралдааны хуваарийг уншихад хялбар тодорхой форматыг ашиглах. 2. Гэрч, хохирогчийг хамгаалах цогц удирдамж, үйл ажиллагааны журам, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх (Тахарын алба?) 3. ГБХ-тэй холбоотой зөрчлийн хэргийн хуваарийг гаргах, олон нийтэд нээлттэй мэдээлэх. • **Ажиглагч:** Шүүхээс шүүх хуралдааны хуваарь гаргах, мэдээлэх (хэрхэн, хэзээ, хэнд мэдээлэх) асуудлыг олон нийтийн хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгааг харгалзан үзсэний үндсэн дээр зохион байгуулах. • **Ажиглагч:** ГБХ-ийн зөрчлийн хэргийн шүүх хуралдааныг урьдчилан зарлах ажлыг зохион байгуулах.

болохоос өмнө 4 цаг хүлээх шаардлагатай байсан. Шүүхийн танхимын гадаах хүлээлгийн хэсэгт сандал байхгүй тул хананд налан зогсох шаардлагатай байв. Мөн тус коридороор олон хүмүүс байнга ийш тийшээ холхиж, их зай багатай байсан. • **Ажиглагч:** ГБХ-ийн зөрчлийн хэргийн шүүх хуралдааны тухай зарыг хэзээ ч мэдээлдэггүй байв. Шүүх хуралдааны ажиглагчид энэ зарыг олж авахын тулд заавал шүүх дээр очих шаардлагатай байв. Зөрчлийн хэргийн шүүх хуралдааныг хугацаа товлолгүй, ар араас нь дараалуулж явуулдаг байна.	

Санал, зөвлөмж	**3: Шүүхийн байрны орчин нөхцөл** Шүүх хуралдааны танхим болон шүүхийн ажилтнуудын өрөөний ажиллах нөхцөлийг шаардлагын дагуу сайжруулах хэрэгтэй байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Хохирогчийг тусгайлсан өрөөнд байрлуулах. • **Ажиглагч:** Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд 8 дугаар сарын 25, 9 дүгээр сарын 3,10,16,21-ний өдрүүдэд ажиглалтын дадлагыг хийх, үүний дараагаар албан ёсны ажиглалтыг гүйцэтгэх, мөн хавтаст хэргийн материалтай танилцахаар очиход зарим шүүхийн өрөөнүүд том байсан бол зарим нь хэтэрхий жижиг хэмжээтэй байсан тул шүүхийн танхимын стандарт байдаг эсэх нь эргэлзээтэй байв. Хэрэв шүүх хуралдааныг олон оролцогчтой жижиг өрөөнд явуулах бол нэмэлт сандлуудыг оруулж ирж байсан боловч чөлөөтэй явах зайгүй болдог байв. Ажиглалт хийсэн шүүх хуралдаан 10 оролцогчтой байсан бөгөөд бүгдийг нэг өрөөнд байлгасан. Хавтаст хэргийн материалтай танилцах ажлыг шүүхийн ажилтнуудын өрөөнд хийсэн бөгөөд тус өрөө маш бага багтаамжтай байв. Энэ өрөөнд сейф, хавтаст хэргийн материалуудыг хайрцагтай нь ширээний доор байрлуулсан байв (нууц мэдээллийг хадгалахад тийм ч найдвартай газар биш болно). • **Ажиглагч:** Шүүхүүд хохирогчдод зориулсан тусгайлсан өрөө, хохирогчийн мэдүүлэг авах технологиор тоноглогдоогүй байна. • **Ажиглагч:** Шүүх хуралдааныг жижиг өрөөнд явуулсан. Хохирогч, хүчирхийлэгч, прокурор нь бие биенээсээ 1 алхам зайтай байв. Нэмэлт сандал тавих зай байгаагүй болно. • **Ажиглагч:** Шүүх хуралдааны танхимын хүрэлцээ бол асуудал дагуулж байв. Шүүх хуралдаанд оролцогчид буюу түүний дотор өмгөөлөгч, прокурор хүлээлгийн тусдаа өрөөгүй, коридорт хүлээж байв. Тэд өмнөх шүүх хуралдаан дуусахтай зэрэгцэн (өрөөн доторх агаарыг цэвэршүүлэхгүйгээр) шүүхийн танхимд орж байв. Зарим тохиолдолд шүүгчид үдийн цайны завсарлагыг үл харгалзан шүүхийн танхим байгааг ашиглан шүүх хуралдааны танхимд дараалан 3 шүүх хуралдааныг явуулж байв. • **Ажиглагч:** Хохирогч, хүчирхийлэгч шүүх хуралдаан эхлэхийг хамаатан садан, найз нөхдийн хамт нэг өрөөнд хүлээж байна. Энэ нь аль ч талд сэтгэлзүйн дарамттай таагүй орчныг бий болгодог. Иймд шүүх хуралдааныг дуусахад хохирогч,	• **Ажиглагч:** Шүүхийн байр, шүүх хуралдааны танхимын аюулгүй ажиллагааны стандарттай байх. Хэрэв ийм стандарт байгаа бол стандартыг дагаж мөрдүүлэх. Шүүхийн захиргааны ажилтнуудын ажиллах нөхцөлийг сайжруулах, нотлох баримт, нууц мэдээллийг хадгалах, тоон мэдээлэлд шилжүүлэх цогц шийдлийг нэвтрүүлэх. Хэрэв нууц баримт бичиг, нотлох баримтыг хадгалах стандарт байгаа бол ажилтнуудыг эдгээр стандартыг дагаж мөрдүүлэх. • **Ажиглагч:** Одоо байгаа өрөөнүүд хэт жижиг хэмжээтэй байгаа тул шүүх хуралдааны танхим болон шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын өрөөг шаардлагад нийцүүлэн сайжруулах, шинэчлэх. • **Ажиглагч:** Зөрчлийн хэргийн шүүхийг байгуулах хэрэгцээ шаардлагыг судалж, хэрэгцээ шаардлагыг шийдвэрлэх.

хүчирхийлэгч тус тусдаа өрөөнд хүлээж, тус тусдаа гарцаар гарч явах механизмыг бий болгох нь чухал байна.	

Санал, зөвлөмж	**4: Процессын эрхүүд** Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан процессын эрхүүдийг хангуулах. Энэ хоёр хуульд заасан эрхүүд бол өөр өөр бөгөөд эрхийн талаарх мэдээлэлгүй байх явдал бол хохирогч болон холбогдогч (яллагдагч)ийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг олгодоггүй байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** ГБХ-ийн зөрчлийн хэргүүдэд 2 ба түүнээс дээш удаа давтагдсан үйлдлүүд ордог. Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, хариуцлагыг тооцох арга хэмжээний талаар мэдээлэл өгөх сургалтад насанд хүрсэн хүүхдүүдтэй гэр бүлүүдийг хамруулах. Хохирогчид бол цагдаагийн бай болдог хүмүүс байна. Тэднийг цагдаагийн хэлтэст удаа дараа дууддаг бөгөөд хохирогчид стресс ихтэй байдаг байна. • **Ажиглагч:** Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хохирогчийн эрхийн тухай 9 заалт /2.1-2.9/, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлд хохирогчийн эрхийн тухай 15 заалт /1.1-1.15/ байдаг. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр ажиглалт хийсэн шүүх хуралдаанд хохирогч болон хүчирхийлэгч өөрсдийн эрхээ мэдэхгүй байсан. Жишээлбэл: 1. Эрүүгийн хэргийн хохирогч Б.О. завсарлагаанаар прокуророос 2.7 сая төгрөгийн өртөг бүхий зардлыг нотлох баримттай тул эмчилгээний төлбөрийг хэрхэн яаж барагдуулахыг асуусан. Хангалттай цаг хугацаа өнгөрсөн хэдий ч энэ нөхөн төлбөрийг огт авч үзээгүй байна. Хохирогчийн зүгээс хүчирхийлэгчийн эгч нь түүнийг “Чамаас болж шоронд орсон хүнээс чи яаж 1.5 сая төгрөгийг нэхэмжилж чадаж байна. Чамаас болж шүүх хуралдаан хойшлогдсон. Чи эрүүл болоод л ийш тийшээ яваад байгаа биз дээ” гэж хэлснийг дурдсан. Хохирогч мөн прокуророос өмгөөлөгч авах боломжтой эсэх, хэрхэн өмгөөлөгч авах талаар асуусан байна. 2. ГБХ-ийн зөрчлийн хэрэгт хохирогчид оролцоогүй, мөн тэднийг төлөөлөн өмгөөлөгчийг оролцуулаагүй байна. Холбогдогчид шүүх хуралдаанд оролцсон боловч өмгөөлөгчгүй байсан. Шүүх хуралдааны үеэр шүүгчийн зүгээс бүх эрхийг уншиж, холбогдогчоос зөвшөөрч байгаа эсэхийг асуусан. Холбогдогчдын зүгээс толгой дохиж, танилцуулсан нотлох баримттай холбоотой тайлбар өгөөгүй, асуулт асуугаагүй байна. Шүүх хуралдаан шуурхай болж, холбогдогч гэм буруугаа хурдан хүлээж, түүний зүгээс шүүх хуралдаан дуусгавар болохыг хүлээж байсан нь илт байв. 3. ГБХ-ийн зөрчлийн нэг хэрэгт холбогдогч 3 настай хүүгийнхээ толгой, хөлийг цохиж биед нь гэмтэл учруулсан. Мөн холбогдогч согтуу байх үедээ эхнэрээ зодсон байна. Шүүх эмнэлгийн шинжилгээний хуудсанд хүүхдийн эзэж нь “Хүүхэд ил харагдах гэмтэлгүй, нэхэмжлэл гаргуулахгүй” гэж бичсэн байсан. Шүүгчийн зүгээс нотлох баримтыг хүлээн авч, зөрчлийн хэрэгт эхнэрийг нь цорын ганц хохирогч болохыг хүлээн зөвшөөрч шийдвэрлэсэн явдал бол хүүхдийг гэмт хэргийн хохирогч болохыг үл	• **Ажиглагч:** Хороодод сургалт зохион байгуулж, хүчирхийлэл болон ГБХ-тэй холбоотой асуудлаар зөвлөгөө өгөх. • **Ажиглагч:** Хохирогч, хүчирхийлэгчээс мэдүүлэг авахдаа тэднийг гарын үсгийг зуруулах, эрх, үүргийг жагсаасан баримт бичигт гарын үсгийг нь зуруулах явдал бол чухал биш юм. Үүний оронд тэдэнд жишээ, тайлбар өгөх, нөхцөл байдлыг бүрэн дүүрэн ойлгох, тайван байдлаар шийдвэр гаргахад тэдэнтэй харьцах нь илүү чухал байна. Энэ байдлаар хохирогч, хүчирхийлэгч өөрсдийн хандлагыг өөрчилж, нөхцөл байдлыг шийдвэрлэх эерэг хандлагатай болно. Мэдүүлэг авч байгаа албан тушаалтан мэдүүлгийн эхлэх, дуусах цагийг бүртгэх явдал бол сайн хэрэг боловч тухайн албан тушаалтан хохирогч, хүчирхийлэгчийн сэтгэлзүйн байдал (айсан, цочирдсон)-ыг харгалзан үзэх, мэдүүлгийн маягтын бүрэн байдлыг шалгах шаардлагатай байна. Сэтгэлзүйн хүнд байдалд орсон хүмүүстэй хэрхэн харьцах болон ярилцлага авахад ашиглах арга техникийн тухай тусгайлсан сургалтыг хохирогч, хүчирхийлэгчээс мэдүүлэг авч буй албан тушаалтнуудад зориулан явуулах шаардлагатай байна. • **Ажиглагч:** Хохирогчдод хуульд заасан эрхийн тухай зохих ёсоор танилцуулах, тайлбарлах. • **Ажиглагч:** Цагдаагийн газар бол хүчирхийлэгчид эрхийг тайлбарлах цорын ганц байгууллага биш болно. Хүчирхийлэгчид эрхийг нь ойлгуулахын тулд олон нийтэд зориулж боловсруулсан хууль эрх зүйн мэдлэг дэлгэрүүлэх мэдээллийг нэмэлтээр ашиглаж болно.

тоомсорлосон явдал болсон. Энэ нь хүүхдийн эрх, эрүүл мэндийг зөрчиж байгаа мэт санагдсан. • **Ажиглагч:** Нотлох баримтыг авч үзэхэд хүчирхийлэгч эрхээ мэдэхгүй тул эрхээ эдлээгүй гэж ажиглагдаагүй болно. Эрхийг хэрэгжүүлэх асуудал болон хэрэгжүүлэх арга замууд тэнд байсан. • **Ажиглагч:** Эрүүгийн болон зөрчлийн хэрэгт заасан эрх, үүрэг нь ялын хэмжээнээс хамаарч өөр өөр байдаг. Гэвч эрхийг нэг баримт бичигт (эрүүгийн болон зөрчлийн хэргийн аль алинд) хэвлүүлж, тухайн баримт бичгийг хохирогч болон холбогдогч (яллагдагч)ид бүрэн эхээр, үр дүнтэй танилцуулах боломжтой байна. ГБХ-ийн зөрчлийн хэрэгт холбогдогчдын хувьд "баривчлах, цагдан хорих боловч удахгүй суллагдах болно" гэсэн тодорхой хүлээлт байдаг явдал бол тэдний зүгээс эрх, үүргийг тодорхой хэмжээнд үл тоомсорлоход хүргэдэг байна. Холбогдогчдын хувьд цөөн хоног цагдан хоригдох нь чухал болох нь ажиглагдсан.	

Санал, зөвлөмж	**5: Хууль зүйн туслалцаа** Төлбөрийн чадваргүй хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх, тэдний хууль зүйн туслалцаа авах эрхийг бүрэн хангаж өгөх. Төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Гэмт хэргийн хохирогчдод шаардлагатай тусламж үйлчилгээг тодорхой болгох. • **Ажиглагч:** Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр 2020 оны 8 дугаар сараас 10 дугаар сард ажигласан 3 шүүх хуралдаанд (1 эрүүгийн, 2 ГБХ-ийн зөрчлийн хэрэг) гурван хохирогчийн хэн нь ч өмгөөлөгчгүй байсан. Хавтаст хэргийн материал, хохирогчийн ажил эрхлэлт, орлогыг нарийвчлан судалж үзэхэд хохирогчдын зөвхөн нэг нь л ажилтай байсан боловч гэр бүлийн хүчирхийллийн улмаас авсан хүнд гэмтлээс болж хохирогч эмнэлэгт удаан хугацаагаар эмчилгээ хийлгэсэн тул дахин ажиллах боломжгүй болжээ. Нөгөө хоёр хохирогчдын хувьд ажилгүй бөгөөд гэр бүл, үр хүүхдүүдээ хардаг байна. • **Ажиглагч:** Хэрэгт хууль ёсны зохих журмуудыг мөрдсөн боловч хавтаст хэрэгт энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл оруулаагүй байна. • **Ажиглагч:** Шүүх, хуулийн салбарын оролцогчид (ГБХ-ийн зөрчлийн хэргийг мөрдөн байцаах ажилтан, прокурор, шүүгч) ГБХ-ийн зөрчлийн хэргийг нийгмийн сөрөг үр дагавартай ноцтой асуудал гэж авч үзэлгүй, нэр төдий авч үздэг байна. Шүүх хуралдааны ажиглагчийн хувьд миний зүгээс байгууллагууд ГБХ-ийн зөрчлийн хэрэг болон түүний шалтгааныг мөрдөн шалгах арга хэлбэрээ өөрчилж, урьдчилан сэргийлэх ажилд анхаарлаа төвлөрүүлбэл цаашид ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрсэн.	• **Ажиглагч:** ГБХ-ийн хэрэгт мэргэшсэн өмгөөлөгчөөр дамжуулан ГБХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх. • **Ажиглагч:** Төлбөрийн чадваргүй хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль тогтоомжид тусгах, хууль зүйн туслалцаа үзүүлэх зардлыг төрөөс хариуцуулах. Төлбөрийн чадваргүй хохирогчдод хууль зүйн туслалцаа үзүүлдэг өмгөөлөгчдийг магадлан итгэмжлүүлэх, хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хууль тогтоомжид мониторинг хийх явдлыг 2-3 жил тутамд явуулах тогтолцоог бий болгох. • **Ажиглагч:** Өмгөөлөгчдийн байгууллагын зүгээс төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх хууль тогтоомж, журмыг боловсронгуй болгох. Хууль зүйн туслалцаа үзүүлэх талаар харилцан уялдаатай хариу үйлдэл үзүүлэх шаардлагатай байна. • **Ажиглагч:** Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн төлбөрийн чадваргүй хохирогчдыг үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах боломжтой субъект болгон хуулийг шинэчлэн боловсруулах буюу "ГБХ-ийн төлбөрийн чадваргүй хохирогч хууль зүйн туслалцаа авахыг хүссэн бол" гэсэн нөхцөлийг "Гэмт хэрэгт сэжиглэгдсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх" гэсэн одоо

	үйлчилж байгаа хуулийн заалтад нэмж оруулах.

Санал, зөвлөмж	**6: Нөхөн төлбөр** Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчид учирсан хохирол, гэм хорыг, нэн ялангуяа ГБХ-ийн хохирогч болсон хүүхдүүд болон тэднийг хамгаалахад харгалзаж үзэх хэрэгтэй байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Мэргэжилтнүүдийг ГБХ-ийн чиглэлээр мэргэшүүлж, практик сургалт явуулж, тэдний арга барилыг өөрчлөх. Шүүгч, прокурор хохирогч, хүчирхийлэгчтэй харьцахдаа хандлагаа сайжруулах шаардлагатай байна. • **Ажиглагч:** Эрүүгийн хэрэгт хохирогч О.Б-д учирсан хохирлыг түүний өвчний түүх (хавтаст хэргийн 52-65 хуудас)-д үндэслэн нийт 1,588,404 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүх хуралдааныг нэг долоо хоногоор хойшлуулав. Гэвч шинэ нөхцөл байдал бий болж, хүчирхийлэгчийн цорын ганц хамаатан болох түүний эгч нь нөхөн төлбөрийг төлж чадаагүй тул хүчирхийлэгчээс нөхөн төлбөрийг төлөөгүй байна. Шүүгдэгч 7 жилийн хорих ял авсан байна. ГБХ-ийн зөрчлийн хэрэгт холбогдогч Д.Б. нь 3 настай хүүгийн толгойн ар талд 2 удаа, өгзөг рүү 3 удаа цохисон явдал бол түүний тархинд урт хугацаанд үргэлжлэх гэмтэл учруулсан байж болзошгүй юм. Гэвч шүүх хуралдааны үеэр хүүхдийн ээж шүүх шинжилгээний хуудсан дээр “Хүүхдийн биед ил харагдах гэмтэл байхгүй, нэхэмжлэл гаргахгүй” гэж бичсэн нь эхнэрийг цорын ганц хохирогчоор авч үзэх, анхаарлыг хандуулсан болохыг тэмдэглэжээ. Шүүхээс хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг үл тоомсорлосон шийдвэр гаргасан байна. Хавтаст хэрэгт хүүхдийн ээжид ямар нэгэн хууль зүйн зөвлөгөө өгсөн тухай нотлох баримт байхгүй байна. • **Ажиглагч:** Эрүүгийн болон зөрчлийн хэргүүдэд хүчирхийллийн үйлдлийн шалтгааныг нарийвчлан авч үздэг боловч хохирол, гэм хор, хүүхдийн эрхийн талаар хангалттай хэлэлцдэггүй байна.	• **Ажиглагч:** Шүүхийн шийдвэрийн дүгнэлтийн хэсэгт хохирогчид шаардлагатай тусламж, гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох талаар тодорхой дурдах. • **Ажиглагч:** 1. Хэдийгээр хохирол, гэм хорыг учирсан болохыг тогтоосон төлбөрийн хэмжээг заасан боловч хэрэв хүчирхийлэгч хохирлоо төлж чадахгүй бол энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй хэвээр байна. Үүний дараагаар хохирогч эрүүл мэнд, санхүүгийн хувьд дахин хохирогч болдог. Хууль зүйн хувьд энэ төрлийн асуудлыг шийдвэрлэх шийдэл байх ёстой байна. 2. ГБХ-ийн хэрэгт хүүхдийн эрх зөрчигдөж байгааг хүлээн зөвшөөрч, энэ асуудлыг зохицуулах шийдлийг гаргаж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь чухал байна. • **Ажиглагч:** Шүүх хуралдаанд хохирол болон гэм хорын асуудлыг авч үзэхэд цаг гаргаснаар хохирогчийн эрхийг хамгаалах.

Санал, зөвлөмж	**7: Шүүхийн шийдвэрт хохирогчийг хамгаалах асуудал** Шүүхийн шийдвэрт хохирогчийг хамгаалах, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид үзүүлэх сэтгэлзүйн болон эмнэлгийн тусламжийг үзүүлэх зэрэг асуудлыг тусгах хэрэгтэй байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох нэгдсэн стандарт, хөтөлбөр байхгүй тул хохирогч дахин хохирогч болдог. Шүүхийн шийдвэрт гагцхүү хохирогчийн хохирлыг барагдуулах тухай заасан боловч хохирлыг хэрхэн, ямар хугацаанд барагдуулахыг тайлбарладаггүй байна. Хохирогчид түүний авсан хүнд гэмтлээ эмчлүүлэх эмчилгээний зардлыг нөхөн төлөх төлбөрийг хэзээ олгох вэ гэдэг нь тодорхойгүй байна.	• **Ажиглагч:** Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх. Нотлоход бэрхшээлтэй сэтгэлзүйн хохирол зэрэг хохирлыг бас нөхөн төлөх шаардлагатай байна. • **Ажиглагч:** Хохирогчийн хамгаалалт, сэтгэлзүйн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай дэлгэрэнгүй

• **Ажиглагч:** Х нь өмнө нь эрүүгийн болон зөрчлийн шинжтэй 2 хэрэгт холбогдож, 7 жилийн хорих ял эдэлсэн байна. ГБХ-ийн зөрчлийн хэргийн холбогдогч Y нь 2015 онд эхнэр Z-г зодож, 2 жилийн тэнсэн харгалзах ял авсан (Эрүүгийн хуулийн 99.2 дугаар зүйл). Хүчирхийлэгч А нь 30 настай, өндөр боловсролтой, технологич мэргэжилтэй бөгөөд Шинэ Яармаг цогцолборт барилгачнаар ажиллаж байсан ба эхнэр, хүүхдүүдтэйгээ амьдардаг (5 ам бүлтэй) байна. Тэрээр дагавар хүүтэй бөгөөд шүүхийн шийтгэвэрт дурсанаар тэрээр өмнө нь эхнэрээ зоддог байсан тул энэ нь давтан үйлдлийг харуулж байна. Дээрх хэргүүдийн шүүхийн шийдвэрт эмнэлгийн болон сэтгэлзүйн туслалцааны талаар огт дурдаагүй болно. Хүчирхийлэгчийн хувьд түүний зан үйлийн өөрчлөлтийн үр нөлөө, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, зан үйлийг өөрчлөх сургалт эерэг өөрчлөлт авчирсан эсэхийг олж тогтоох нь сонирхолтой асуудал байна. • **Ажиглагч:** Шүүхийн шийдвэрт хохирогчийн нөхцөл байдлыг гагцхүү хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохтой холбогдуулан дурдсан бөгөөд хохирогчийн хамгаалалт, сэтгэлзүйн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар хангалттай мэдээлэл байхгүй байна. • **Ажиглагч:** Шүүхийн шийдвэрт хохирогчийг хамгаалах, хохирогчийг дахин хохирохоос урьдчилан сэргийлэх, сэтгэлзүйн болон эмнэлгийн туслалцаа үзүүлэх тухай асуудал байхгүй байна.	мэдээллийг шүүхийн шийдвэрийн стандартад оруулах шаардлагатай байна. • **Ажиглагч:** Шүүхийн шийдвэртэй холбоотой зохицуулалт, журмын талаар мэдэхгүй тул энэ талаар тайлбар өгөх, сайжруулах санал, зөвлөмжийг өгөхөд хэцүү байна.

Санал, зөвлөмж	**8: ГБХ-ийн асуудлаар мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх** ГБХ-д хариу үйлдэл үзүүлэх хууль зүйн салбарын оролцогчдын мэргэшлийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Цагдаа, прокурор, шүүгч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс гэрч, хохирогчтой харьцах илүү сайн арга барилыг авч үзэх хэрэгтэй байна. Дүрэм, журам боловсруулж, хэрэгжүүлснээр хохирогч, бага насны хүүхдүүдийг хамгаалах чиглэлээр эдгээр мэргэжилтнүүдийг сургах.	• **Ажиглагч:** Дүрэм, журмыг дагаж мөрдсөнөөр нөхцөл байдал сайжрах боломжтой юм. • **Ажиглагч:** ГБХ-д хариу үйлдэл үзүүлэх чиглэлээр ажилладаг хууль зүйн салбарын оролцогчдын мэргэшлийн ур чадварын хөгжил нь хүний эрхийг хангах байдалтай уялдсан тогтолцоог бий болгох. ○ ГБХ-ийн асуудлаар мэргэшсэн сургалтыг хуульчдын дунд явуулах шаардлагатай байна. ○ Илүү олон тооны сэтгэл зүйчдийг бэлтгэх, тэдэнд ГБХ-ийн асуудлаар ажиллах боломжийг бүрдүүлэх. ○ ГБХ-ийн зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэрүүд нь хохирогч, холбогдогчийн эрхийг хамгаалах талаарх хүрч болох үр дүнг тусгах шаардлагатай байна. Түүнчлэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих шаардлагатай байна. ○ Прокурор, шүүгчийн ГБХ-ийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх.

	○ Дээр дурдсан асуудлаар шүүхийн шийдвэрт туслалцаа үзүүлэх тухай тусгахад шүүхэд эрх бүхий байгууллагуудаас туслалцаа үзүүлэхийг хүсэх. ○ ГБХ-ийн зөрчлийн хэрэгт дийлэнхдээ 15-30 хоног баривчлах ялаар шийтгэдэг байна. Гэвч давтан зөрчлийн хэрэг үйлдэх магадлал өндөр байгаа явдал бол холбогдогчдын зан үйлийг албадан өөрчлөх хөтөлбөр нь хангалтгүй болохыг харуулж байна. Зан үйлийг албадан өөрчлөх сургалтыг стандартад нийцүүлэх, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх асуудлыг багтаах болон сургалтын үнэлгээг тестээр авснаар сургалтыг сайжруулах нь чухал байна. • **Ажиглагч:** Сургалт зохион байгуулснаар хяналтыг хэрэгжүүлэх, бусдын эрхийг зөрчиж байгаа хүмүүст сануулга өгөх. Гүйцэтгэл, үр дүнд хяналтыг хэрэгжүүлэх.

Санал, зөвлөмж	**9: Маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлэх** ГБХ-ийн хэрэгт маргаан шийдвэрлэх бусад үр дүнтэй аргыг нэвтрүүлэх боломжийг авч үзэх, тухайлбал, эвлэрүүлэн зуучлах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, зан үйлийг өөрчлөх сургалт г.м.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** СХД-ийн ЭХ-ийн анхан шатны шүүх дээр зөрчлийн болон эрүүгийн хэргийг ажиглах явцад ГБХ үйлдсэн нь хохирогч цагдаа дуудсанаар эхэлж, цагдаа газар дээр нь очоод баривчлах, саатуулах гэвэл процессууд явагдаж байна гэж ажигласан. Холбогдогч/ сэжигтэн албадан саатуулах байранд хоноод өглөө гараад явах, хожим хэд хоногийн дараа хэрэг бүрдэлт хийгдэж, прокурорын дүгнэлт гарсны дараа шүүх хурал хийж яллах гэсэн дараалал ажиглагдсан. Энэ хугацаанд хохирогчийг хамгаалах асуудал анхаарлын гадуур орхигдож, онц ноцтой бус хэрэгт хохирогчийг хамгаалахын тулд ямар арга хэмжээ авдаг болохыг мэдэх нь чухал байдаг. Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх дээр хянагдсан ГБХ-ийн зөрчлийн хоёр хэрэг 8 дугаар сарын 21, 27-ны өдрүүдэд тус тус үйлдэгдсэн боловч шүүх хуралдаан 9 дүгээр сарын 3-ны өдөр болсон. Шүүх хуралдааныг хүлээсэн 7-10 хоногийн хугацаанд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, эвлэрүүлэн зуучлах үйлчилгээ үзүүлэх бүрэн боломжтой байсан. Хавтаст хэрэгт эвлэрүүлэн зуучлах, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, зан үйлийг өөрчлөх сургалтад хамруулах ямар нэгэн алхам авсан тухай дурдаагүй байна. Хавтаст хэрэгт гагцхүү хоёр талын мэдүүлэг байв. • **Ажиглагч:** Анхааруулга, зөвлөгөө өгөх, барьцаа авах зэрэг янз бүрийн аргыг ашиглан нөхцөл байдлыг эхэн үед шийдвэрлэх боломжтой байсан нь ажиглагдсан. Эцсийн үр дүнд бол зөрчлийг шүүхээс гадуур шийдвэрлэхийг хичээх явдал юм.	• **Ажиглагч:** Эвлэрүүлэн зуучлал. ГБХ хэрэгт холбогдсон талууд буюу хохирогч, хүчирхийлэгчийн тухайн асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, нөхцөл байдлыг тайван горим руу шилжүүлэх, мэргэжлийн багийн зүгээс мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх зэргээр сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, бие биетэйгээ харилцах харилцааны сургалтыг явуулах шаардлагатай байна. Хэрэв ийм үйлчилгээний стандарт байгаа бол стандартыг мөрдүүлэх. • **Ажиглагч:** Маш хатуу ёс зүйн дүрмийг баримтлан мэргэжлийн туслалцааг зохион байгуулах, гүйцэтгэлийг хэмжих, сургалтын үр дүнг үнэлэх. • **Ажиглагч:** Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зөвлөмж өгөх.

• **Ажиглагч:** ГБХ-ийн зөрчлийн хэрэгт баривчлах захирамж гаргаснаар холбогдогчийг өшөө хорсloор дүүрэн үлдээж, үүний дараагаар гэр бүл салдаг болох нь ажиглагдсан.	

Санал, зөвлөмж	**10: Олон улсын эрх зүй** ГБХ-ийн хэргийг шийдвэрлэхэд олон Улсын конвенц, пактын зүйл заалтыг хэрэглэх.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** 1.Манай баг СХД-ийн ЭХ-ийн анхан шатны шүүхийн удирдлагуудтай 2020 оны 8 сарын 25-ны 11 цагт уулзаж, ажиглалт хийх төлөвлөгөө ярилцахад Ерөнхий шүүгчийг орлон гүйцэтгэгч Г.Мөнхзул, шүүгч Урангуа, Батаа нар оролцсон бөгөөд энэ үед олон Улсын гэрээ конвенц, пактын асуудлаар хөндөж яригдсан. Батаа шүүгчийн хувьд ХЭҮК-д ажиллаж байсан туршлагатай гэж дурдагдсан. 2. 2020 оны 9 сарын 3-нд болсон сэжигтэн/яллагдагч Б.У-ийн Эрүүгийн хэргийн шүүх хурлын үеэр шүүх бүрэлдэхүүнд оролцсон шүүгч Батаа НҮБ-ын Хүний Эрхийн Зөвлөлийн зөвлөмжөөс дурдаж байсан. • **Ажиглагч:** Эрүүгийн болон зөрчлийн хэргийг шийдвэрлэхэд олон Улсын конвенц болон хүний эрхийн пактыг хэрэглэх явдал үгүйлэгдэж байсан. • **Ажиглагч:** ГБХ-ийн хэрэгт олон Улсын конвенц, пактыг хэрэглэх явдал гараагүй байна.	• **Ажиглагч:** ГБХ хэргийг шийдвэрлэхэд олон Улсын конвенц, пактыг хэрэглэхийг зөвлөх. • **Ажиглагч:** Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах, эсхүл зөрчлийн хэргийг шийдвэрлэх мэргэшсэн шүүгчдийг сургах. Мэргэшсэн шүүгчид ГБХ-ийн зөрчил, маргааныг шийдвэрлэх хэрэгтэй байна.

Санал, зөвлөмж	**11: ГБХ-ээс урьдчилан сэргийлэх арга замууд** Гэр бүлийн хүчирхийллийн хүчин зүйл, шалтгаан, зан үйлийг албадан өөрчлөх сургалтын үр дүнд үндэслэн ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах арга замыг тодорхойлох шаардлагатай байна. Жишээлбэл, эрэгтэйчүүд сэтгэл зүйн стрессээс болж ГБХ үйлдэх боломжтой эсэхийг судлах.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** СХД-ийн ЭХ-ийн анхан шатны шүүхийн Ажиглалт хийсэн зөрчлийн болон эрүүгийн хэргүүдийн шалтгаан нөхцөлийг харахад архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ үйлдсэн, мөн гурвуулаа ГБХ-ийг давтан үйлдэж байгаа болох нь хавтаст хэргийн материалаас харагдаж байна. Энэ нь албадан сургалтын чанар, үр дүн шаардлага хангахгүй байгааг харуулах үзүүлэлт байхыг үгүйсгэхгүй гэж харж байна. • **Ажиглагч:** ГБХ-ийн шалтгаан нөхцөлийг судлан багасгах, хамгийн гол нь урьдчилан сэргийлэх, мэдээлэх, ухуулан таниулах ажиллагаа хангалтгүй байгаа нь ажиглагдсан. • **Ажиглагч:** Н нь гэр бүлийн хамаарал бүхий этгээд эхнэр Ү-тай маргалдан, газар унагаж 4-5 удаа өшиглөж гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчилд "Хөдөө олон хоног ажлаар яваад гэртээ амарч хэвтэж байхад нь эхнэр нь үглэснээс болж" дээрх зөрчил үйлдэгдсэн байсан.	• **Ажиглагч:** ГБХ-ийн зөрчлийн хэрэгт дийлэнхдээ Х хоногоор баривчлах болон 15-20 цагийн хугацаатай албадан сургалтад хамруулах ялын шийтгэл оногдуулдаг байдаг. Гэвч холбогдогч өөрийн үйлдлийг давтан үйлдэж байгаа нь эдгээр зан үйлийг өөрчлөх сургалтын чанар ямар байна вэ гэсэн асуултыг асуухад хүргэж байна. Зан үйлийг албадан өөрчлөх сургалтын чанар, арга зүй болон боловсон хүчний чадавхыг ажиглах судалгаа хийх шаардлагатай байна. Бусад орны шилдэг туршлагыг судлах. ГБХ-ийн шалтгааныг судалж, үр дүнг зардал багатай хэрэгцээтэй урьдчилан сэргийлэх загвар/механизмыг бий болгоход ашиглах. Миний зүгээс зан үйлийг албадан өөрчлөх хөтөлбөрүүдэд хохирогчид болон өмнө нь хүчирхийлэгч байсан хүнийг хөтөлбөрийн сургагч багшаар сонгон шалгаруулж, туршилтаар нэвтрүүлэхийг

	санал болгож байна. Хөтөлбөрт мэдлэгийг дээшлүүлэх, сургалтыг үнэлэх, сургагч багш нарын гүйцэтгэлийг хэмжихэд практик болон оролцоонд тулгуурласан хандлагыг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Сургагч багш дээр анхаарлыг төвлөрүүлсэн, агуулгын хувьд уйтгартай тийм хөтөлбөрөөс татгалзахыг зөвлөж байна. Сургагч багшийн шалгуурыг тодорхой болгож, кредитийн системийг ашиглах шаардлагатай байна. Гэнэтийн цочрол, сэтгэлийн хямралд автсан хүчирхийлэгчийн хувьд бясалгал, эрх зүйн зөвлөгөө өгөх явдал бол тэдэнд үүнийг даван туулах хүсэл эрмэлзлийг нэмэгдүүлж, амьдралд итгэх итгэлийг нь сэргээж, тэдний орчин нөхцөл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид байх боломжийг олгоно. • **Ажиглагч:** Албадан сургалтын үр нөлөө, үр дүнг нэмэгдүүлэх. • **Ажиглагч:** Албадан сургалтад хамрагдсан хүчирхийлэгчид хүчирхийллийг давтан үйлдэгчид байдаг. Сургалтын чанар, арга зүй, үнэлгээг сайжруулах нь онц ач холбогдолтой байна. • **Ажиглагч:** Шаардлагатай бол ГБХ-ийн зөрчил, гэмт хэрэгт Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээ хийлгэдэг болох. Эсвэл бусад ТББ-аар шалтгаан нөхцөлийг тогтоох үндэслэл бүхий судалгаа хийлгэж, хувь нэмрээ оруулах боломжтой юм

Санал, зөвлөмж	**12: Гэр бүлийн дагнасан шүүхийг судлах** Одоогийн байдлаар шүүхүүд ГБХ-ийн хэргийг хөнгөвчлөн бусад зөрчлийн хэргүүдтэй нэгэн адил богино хугацаанд хянан шийдвэрлэж байгаа тул гэр бүлийн асуудлаар дагнасан шүүх байгуулах боломжийг судлах шаардлагатай байна.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** Гэр бүлийн шүүх байгуулагдсанаар шүүгч, прокурор, мөрдөн байцаагчид энэ чиглэлээр мэргэших боломжийг олгож, хүний эрхийн зөрчил буурах болно. • **Ажиглагч:** Сонгинохайрхан дүүргийн шүүх дээр болсон ГБХ-ийн зөрчлийн хэргийн шүүх хуралдаанууд цахимаар явагдсан бөгөөд 1 шүүх хуралдааны үргэлжлэх хугацаа 10-15 минут орчим байв. Шүүх хуралдаанд X шүүгч, Y прокурор, Z шүүх хуралдааны нарийн бичгийн дарга болон цагдаагийн албан хаагч оролцов. Хохирогчид ГБХ-ийн зөрчлийн хэргийн шүүх хуралдаанд оролцоогүй. Энэ богино хугацаанд холбогдогчид эрхийг нь уншиж танилцуулж, прокурор яллах дүгнэлтийг уншиж, холбогдогчоос нотлох баримтын талаар асууж, энэ талаар өгөх тайлбар байгаа эсэхийг лавлаж, үүний дараагаар шүүгч шүүх хуралдааныг өндөрлүүлсэн. • **Ажиглагч:** Хэдийгээр миний зүгээс шүүхээс ГБХ-ийн хэргийн асуудалд хуумгай хандаж байна гэж шүүмжлэхгүй ч эрүүгийн	• **Ажиглагч:** Гэр бүлийн маргаан бол бусад маргаанаас хохирогчийн хохирлын хувьд ялгаатай төдийгүй бие биенийгээ харилцан ойлголцох, бие биеийнхээ эрхийг хүндэтгэх асуудалтай холбоотой юм. Иймд харилцаагаа засаж, сайжруулахын тулд хүмүүсийг илүү олон тооны сургалтад хамруулах нь чухал байна. • **Ажиглагч:** Гэр бүлийн асуудал дагнасан шүүгч, шүүхийн ажилтнуудыг бэлтгэх, шүүх байгуулах ажлыг судлан хэрэгжүүлэхийг дэмжиж байна. Шүүгчид, өмгөөлөгчид нь сэтгэл засал, сэтгэл зүйчийн мэргэжлээр сургалтад хамрагдсан байх нь илүү үр дүнтэй байх магадлалтай.

гэмт хэрэгтнүүдээс ч бага хугацаанд шалгагдаж байгаа нь түүний цаадах гэр бүлийн гишүүдийн эрх ашигтай уялдаатай болохыг ойлгуулах хэрэгтэйг анзаарсан. • **Ажиглагч:** Зөрчлийг шалгаж байгаа цагдаагийн байгууллага, хянаж байгаа прокурорын байгууллага, шийдвэрлэж байгаа шүүх нь зөрчлийн нийгмийн аюулыг хэт хөнгөн, эсвэл хөнгөн гэж, хайхрамжгүй хандаж байгаа зүйл ажиглагдсан.	• **Ажиглагч:** Хохирогчийн хүний эрхийн байдлыг дордуулсан шийдвэр гаргахгүй байхад анхаарах. • **Ажиглагч:** Нийгмийн үндэс болсон гэр бүл, түүний гишүүдийг хамгаалсан эрх зүйн зохицуулалт бүхий дагнасан шүүхийг байгуулбал хууль, шүүхийн байгууллагын ажилтнууд мэргэших, асуудлыг ул суурьтай авч үзэх сайн талтай. • **Ажиглагч**: Үндэслэл бүхий судалгаа явуулж зөрчлийн шүүх байгуулах асуудлыг судалж, шийдвэрлэх шаардлага байна.

Санал, зөвлөмж	**13: ГБХ-ээс урьдчилан сэргийлэхэд бусад оролцогч талуудыг татан оролцуулах** Сууц өмчлөгчдийн холбоо (СӨХ)-д, баг/хорооны удирдлага, ИНБ-ууд, ахмад хуульчдыг ГБХ-ээс урьдчилан сэргийлэх ажилд татан оролцуулах явдал бол эерэг үр дүнд хүргэх болно.
Зөвлөмжийн үндэслэл (ажиглагчдын өөрсдийн хийсэн ажиглалт дээр үндэслэсэн)	**Үйл ажиллагааны зөвлөмж ба хэрэгжүүлэх бусад боломжууд**
• **Ажиглагч:** СӨХ-ийн дарга нарын үүргийг хуулийн дагуу тодорхойлох нь ГБХ-ээс урьдчилан сэргийлэхэд эерэг алхам болно. Аймаг, багт ИНБ-ууд болон ахмад хуульчдыг оролцуулах нь ГБХ-ээс урьдчилан сэргийлэхэд ихээхэн хувь нэмэр болно. • **Ажиглагч:** Хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг өргөн хүрээнд хэрэгжүүлэх ёстой болох нь харагдаж байна. • **Ажиглагч:** Эрүүгийн болон зөрчлийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаа ба урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд сэтгэл зүйчид, СӨХ, баг, хороо, ИНБ-ууд, ахмад хуульчдыг хамруулах явдал бол үр дүнтэй байдаг. Ялангуяа аймгуудад хохирогчдын аюулгүй байдлыг хангахад тэдний оролцоо чухал байна.	• **Ажиглагч:** Бүх иргэнд ГБХ-ийн тухай мэдээлэх, хуулиар өөрийгөө хамгаалах боломжийг олгох. • **Ажиглагч:** Сууц өмчлөгчдийн холбоодын дарга нарыг ГБХ-ийн хариу үйлдлийг хариуцуулах, татан оролцуулах. ИНБ-ууд, багууд болон ахмад хуульчдын чөлөөт цаг, мэдлэг ур чадвар хэрэгцээтэй байдаг. Сургалтын хэрэгцээг тодорхойлоход үндэслэн тэднийг сургах шаардлагатай байна. • **Ажиглагч:** Эдгээр хүмүүсийн урамшуллын асуудлыг тооцон, төрийн байгууллагаар нэг мөр шийдвэрлүүлэх. Идэвх санаачилгатай, үр дүнтэй ажилласан баг хамт олон, хувь хүмүүсийг урамшуулах, гавьяа шагнал олгон энэ төрлийн үйл ажиллагаанд иргэдийг идэвх санаачилгатай оролцох нөлөөллийн арга хэмжээ авах хэрэгтэй. • **Ажиглагч:** Миний зүгээс СӨХ, баг, хороо, ИНБ-ууд, ахмад хуульчдыг хамруулсан урьдчилан сэргийлэх ажлыг дэмжиж байна.

Хавсралт В. Шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн

In partnership with Canada

IDLO

Mongolia DV Trial Monitoring Tool (Logbook) / Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (Бүртгэлийн хуудас)

Case Code / Хэргийн код		Team Code / Багийн код	

DV Trial Monitoring Tool (Logbook) / Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (Бүртгэлийн хуудас)

I – BASIC INFORMATION / ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ 3

Part / Бүлэг 1. Basic Information / Үндсэн мэдээлэл 3

II – VICTIMS RIGHTS / ХОХИРОГЧИЙН ЭРХ 12

Part / Бүлэг 2. Safety Assessment / Аюулгүй байдлын үнэлгээ 12

Part / Бүлэг 3. Right to Relevant Information Concerning Violations and Reparation Mechanisms / Хэрэг шалгах явц дахь зөрчил болон арга хэмжээний механизмуудын талаарх мэдээлэл авах хохирогчийн эрх эрмэлзлийг нөхөн сэргээх арга механизмтай холбогдох мэдээлэл авах эрх 20

Part / Бүлэг 4. Right to Equal and Effective Access to Justice / Хууль, шүүхийн байгууллагад үр нөлөөтэй, тэгш хандах эрх 23

Part / Бүлэг 5. Right to Adequate, Effective, and Prompt Reparation for Harm Suffered / Учруулсан хохирлыг хангалттай хэмжээнд, үр дүнтэй арга замаар, шуурхай нөхөн төлүүлэх эрх 31

III – ACCUSED'S RIGHTS (TRIAL & APPEAL) / ЯЛЛАГДАГЧ/ХОЛБОГДОГЧИЙН ЭРХ (АНХАН БОЛОН ДАВЖ ЗААЛДАХ ШАТ) 33

Part / Бүлэг 6. Right to a Trial by a Competent, Independent, and Impartial Tribunal Established by Law / Хуульд заасны дагуу байгуулагдсан, хараат бус, тал үл харах шүүхээр хэрэг хянан шийдвэрлүүлэх эрх 33

Part / Бүлэг 7. Right to a Public Hearing / Нээлттэй шүүх хуралдаанаар хэрэг хянан шийдвэрлүүлэх эрх 36

Part / Бүлэг 8. Right to Be Presumed Innocent, and Not to Be Compelled to Testify or Confess Guilt / Гэм буруутай нь адилхан тогтоох хүртэл гэмт бурууг үйд тооцогдох, өөрийнхөө гэм бурууг хүлээхийг тулгах шаардлагаас ангид байх эрх 38

Part / Бүлэг 9. Right to Objective and Comprehensive Evaluation of Evidence / Нотлох баримтыг тал бүрээс нь бодитой, бүрэн гүйцэд үнэлүүлэх эрх 41

Part / Бүлэг 10. Equality of Arms / Тэгшлэн тагнуулах 48

Part / Бүлэг 11. Right to Defend Oneself in Person or Through Counsel / Өөрөө өөрийгөө өмгөөлөх болон өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх эрх 52

Part / Бүлэг 12. Right to a Public Judgment and Right to a Reasoned Judgment / Хэрэг үндэслэл бүхий шийдвэр, тогтоолоор шийдвэрлүүлэх эрх, шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй байх 58

Part / Бүлэг 13. Right to an Interpreter and to Translation / Орчуулагч/хэлмэрч авах эрх 64

IV – ACCUSED'S RIGHTS (PRE-TRIAL, ALL STAGES) / ЯЛЛАГДАГЧ/ХОЛБОГДОГЧИЙН ЭРХ (ШҮҮХИЙН ӨМНӨХ ШАТ, БҮХ ШАТ) 66

Part / Бүлэг 14. Right to Liberty, to Independence and Impartiality, and to Challenge the Lawfulness of Detention / Халдашгүй чөлөөтэй байх эрх, хараат бус байх, тал үл харах байдал, цагдан хорих арга хэмжээний хууль ёсны эсэхэд гомдол гаргах 66

Part / Бүлэг 15. Right to Information and to Access the Outside World / Мэдээлэл авах болон гадаад ертөнцтэй харилцах эрх 70

Part / Бүлэг 16. Right to Legal Counsel; and to Adequate Time and Facilities to Prepare a Defense / Өмгөөлөгч авах, өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхэд хорогдуулах хангалттай хугацаа, боломжоор хангуулах эрх 72

Mongolia DV Trial Monitoring Tool (Logbook) / Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (Бүртгэлийн хуудас)

Case Code / Хэргийн код		Team Code / Багийн код	

Part / Бүлэг 17. Rights During Interrogation / Мөрдөгдөж авах үед эдлэх эрх 76

Part / Бүлэг 18. Rights to Humane Conditions and Freedom From Torture / Хүнлэг нөхцөлөөс хангуулах, эрүүдэн шүүлтээс ангид байх эрх 78

V – JUSTICE SECTOR SERVICE DELIVERY SCORECARD / ШҮҮХИЙН ШУДАРГА ЕСНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ОНООНЫ КАРТ 80

Part / Бүлэг 19. Justice Sector Service Delivery Scorecard / Шүүх эрх мэдлийн салбарын үйлчилгээний онооны карт 80

In partnership with Canada

IDLO Creating a Culture of Justice International Development Law Organization

Page 2

Mongolia DV Trial Monitoring Tool (Logbook) / Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (Бүртгэлийн хуудас)

Case Code / Хэргийн код		Team Code / Багийн код	

Brief description of case (50 words or less) / Хэргийн талаарх товч мэдээлэл (50-аас богино үгтэй)	
Case File No. / Хэргийн дугаар №	

I – BASIC INFORMATION / ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Part / Бүлэг 1. Basic Information / Үндсэн мэдээлэл

CASE DETAILS / ХЭРГИЙН ТУХАЙ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ						NOTES / ТЭМДЭГЛЭЛ
1.1. Method of Selecting Case to Monitor / Ажиглалт хийх хэрэг сонгох арга зүй	Court Schedule / Шүүх хурлын тов *Select one from below / Доорхоос нэгийг л сонгоно уу*		Other Source of Information / Мэдээллийн бусад эх сурвалж *Select one from below / Доорхоос нэгийг л сонгоно уу*			
	☐ On website / Вебсайтнас ☐ Displayed in court / Шүүхийн зэрэг		☐ Judge / Шүүгч ☐ Prosecutor / Прокурор	☐ Court officer / Шүүхийн ажилтан ☐ CSO staff / ИНБ-ын ажилтан	☐ Victim lawyer / Хохирогчийн өмгөөлөгч ☐ Defense lawyer / Шүүгдэгчийн өмгөөлөгч	
1.2. Type of Crime Charged / Яллагдаж буй гэмт хэрэг *(Select all that apply / Хамаарах харгуулахыг сонгоно уу)*	DV Breach / Гэр бүлийн хүчирхийллийн зөрчил		DV Crime / Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг	Crimes that involve DV or treat DV as an aggravating factor / Гэр бүлийн хүчирхийлэл бүхий эсхүл гэр бүлийн хүчирхийлэл хүндрүүлэх нөхцөл болох нь		Other Charge(s) / Бусад ерөнхлөгдөгдөл
	☐ 5.4.1. Failure to notify DV / ГБХ-ийн тухай зүүлэр сунгасан мэдэгдэх үүрэг биелүүлээгүй ☐ 5.4.2. Entering temporary shelter / Тур хамгаалах байранд зөрчин нэвтэрсэн ☐ 5.4.3. Changing purpose of temporary shelter or using it for different purposes / Тур хамгаалах байрны зорилгыг өөрчлөх, өөрөө өөр зорилгоор ашигласан ☐ 5.4.4.1. Beating person with family relationship / Гэр бүлийн хамаарал бүхий хүрээлэгдэгчийг зодсон ☐ 5.4.4.2. Forcing person with family relationship to do/not do something against their will / Гэр бүлийн хамаарал бүхий хүрээлэгдэгчийг хүний эрх, хүсэлтийг нь эсрэг тодорхой үйлдэл хийх, зогсоох, өөрөөр болгосон		☐ 11.7.1.1. Regularly beating person with family relationship / Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг байнга зодсон ☐ 11.7.1.2. Regularly subjecting person with family relationship to cruel treatment, aggressive behavior and torture / Гэр бүлийн хамаарал бүхий хүнтэй харгис хэрцгий хандах, дарлах, доромжлох, тарчлаасан ☐ 11.7.1.3. Regularly infringing person with family relationship's property rights / Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг өд, хөрөнгө эзэмших, ашиглах, захирах эрхэд халдсан	**Crimes with DV as an aggravating factor / Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн нь хүндрүүлэх нөхцөл, гэмтсэн гэмт хэрэг** ☐ 10.1. Murder / Хүний алах - 10.1.2.8. DV aggravating factor / ГБХ үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл ☐ 11.1. Intentional serious damage to a person's health / Эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан - 11.1.2.1. 10.1.2.8. DV aggravating factor / ГБХ үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл ☐ 11.4. Intentional infliction of less serious harm to a person's health / Эрүүл мэндэд хүнд биш хохирол санаатай учруулсан - 11.4.2.1. 10.1.2.8. DV aggravating factor / ГБХ үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл	☐ Other charge(s) outside the trial monitoring scope / Ажиглалт хийх гэмт хэргээс өөр хэрэг ялгагдсан эсэх	

Mongolia DV Trial Monitoring Tool (Logbook) / Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (Бүртгэлийн хуудас)

Case Code / Хэргийн код		Team Code / Багийн код	

	☐ 5.4.4.3. Restricting person with family relationship from communicating with others / Гэр бүлийн хамаарал бүхий хүрээлэгдэгчийг бусдтай харилцахыг хязгаарласан ☐ 5.4.4.4. Infringing person with family relationship's property rights / Гэр бүлийн хамаарал бүхий хүрээлэгдэгчийг хүний өд, хөрөнгө эзэмших, ашиглах, захирах эрхэд халдсан	☐ 11.7.2.1. Domestic violence against a child, a pregnant woman, a senior citizen or a person with disability / Хүүхэд, хөгшчүүл, эмгэгтэй, жирэмсэн, хөгшин насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй эсрэг үйлдсэн ☐ 11.7.2.2. Domestic violence by an officer of a care service institution / Асрамжийн үйлчилгээ хүлээн авагчдыг ажилтан үйлдсэн ☐ 11.7.2.3. Domestic violence against a person trying to stop violence / Таслах зөвлөсөн гэсэн хүнтэй эсрэг үйлдсэн	☐ 11.6. Infliction of minor harm/injury to a person's health / Эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулсан - 11.6.2. 10.1.2.8. DV aggravating factor / ГБХ үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл ☐ 12.1. Rape / Хүчиндэх - 12.1.2.3. DV aggravating factor / ГБХ үйлдсэн нь хүндрүүлэх нөхцөл **(Secondary focus) Crimes that may involve DV / Хоёрдогч гэмт хэргүүд (Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдох гэмт хэргүүд)** ☐ 10.4. Causing person to commit suicide / Амиа хорлох нөхцөлд байдалд хүргэсэн ☐ 12.2. Satisfaction of sexual desire in unnatural manner / Ердийн бус хэлбэрээр бусдаар хангах	
1.3. Stage / Шат	☐ First Instance / Анхан шатны шүүх	☐ First Appeal / Давж заалдах шатны шүүх	☐ Final Appeal / Хяналтын шатны шүүх	
1.4. Location / Байршил	☐ UB / УБ ☐ Aimag / Аймаг	1.5. Court Name / Шүүхийн нэр		

1.6. Hearing Details / Шүүхийн хэлэлцүүлгийн тухай мэдээлэл	Hearing 1 / Хэлэлцүүлэг 1	Hearing 2 / Хэлэлцүүлэг 2 *(If applicable / хэрэв хэрэгтэй бол)*	Hearing 3 / Хэлэлцүүлэг 3 *(If applicable / хэрэв хэрэгтэй бол)*	Hearing 4 / Хэлэлцүүлэг 4 *(If applicable / хэрэв хэрэгтэй бол)*
	Date / Огноо __/__/____	Date / Огноо __/__/____	Date / Огноо __/__/____	Date / Огноо __/__/____
	Start / Эхлэх __:__	Start / Эхлэх __:__	Start / Эхлэх __:__	Start / Эхлэх __:__
	End / Дуусах __:__	End / Дуусах __:__	End / Дуусах __:__	End / Дуусах __:__

1.7. Hearing Postponements/ Suspension / Хэлэлцүүлэг хойшлогдох) хэргийг тудгалзуулах	Hearing 1 / Хэлэлцүүлэг 1	Hearing 2 / Хэлэлцүүлэг 2 *(If applicable / хэрэв хэрэгтэй бол)*	Hearing 3 / Хэлэлцүүлэг 3 *(If applicable / хэрэв хэрэгтэй бол)*	Hearing 4 / Хэлэлцүүлэг 4 *(If applicable / хэрэв хэрэгтэй бол)*
	Was the hearing postponed/suspended? / Хэлэлцүүлэг хойшлогдсон/ хэргийг тудгалзуулсан уу?	Was the hearing postponed/suspended? / Хэлэлцүүлэг хойшлогдсон/ хэргийг тудгалзуулсан уу?	Was the hearing postponed/suspended? / Хэлэлцүүлэг хойшлогдсон/ хэргийг тудгалзуулсан уу?	Was the hearing postponed/suspended? / Хэлэлцүүлэг хойшлогдсон/ хэргийг тудгалзуулсан уу?
	☐ Yes / Тийм ☐ No / Үгүй	☐ Yes / Тийм ☐ No / Үгүй	☐ Yes / Тийм ☐ No / Үгүй	☐ Yes / Тийм ☐ No / Үгүй

Mongolia DV Trial Monitoring Tool (Logbook) / Монгол улс дахь ГБХ-ийн хэргийн шүүх хуралдааны ажиглалтын хэрэглэгдэхүүн (Бүртгэлийн хуудас)

Case Code / Хэргийн код | Team Code / Багийн код

	If yes, at which party's request? / Хэрэв тийм бол аль талын хүсэлтээр?	If yes, at which party's request? / Хэрэв тийм бол аль талын хүсэлтээр?	If yes, at which party's request? / Хэрэв тийм бол аль талын хүсэлтээр?	If yes, at which party's request? / Хэрэв тийм бол аль талын хүсэлтээр?	
